НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

Си Эс Си И Си & Ай Юу И Консорциум

АУДИ ХХК

“ШИНЭ ТОЙРОГ АВТО ЗАМ” ТӨСЛИЙН УРЬДЧИЛСАН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

2025 он

“БАЯСАХ СУРВЭЙ” ХХК

1:500-НЫ МАСШТАБЫН БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Төлөв	Нэр	Албан тушаал	Гарын үсэг	Огноо
Боловсруулсан:	М.Бөхсанаа	Ерөнхий инженер		2025.06.10
Хянасан:	Б.Болормаа	Мэргэшсэн инженер		2025.06.10
Хянасан:	Ж.Алтанцэцэг	Зөвлөх инженер		2025.06.10
Баталсан:	Д.Түмэннаст	Гүйцэтгэх захирал		2025.06.10

АГУУЛГА

1. **ЕРӨНХИЙ**
   - 1.1. Зорилго
   - 1.2. Компанийн товч танилцуулга
     - 1.2.1. Тодорхойлолт
     - 1.2.2. Үйл ажиллагааны үндсэн чиглэл
     - 1.2.3. Хийж гүйцэтгэсэн болон гүйцэтгэж байгаа төсөл хөтөлбөрүүд
     - 1.2.4. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
     - 1.2.5. Тусгай зөвшөөрөл
   - 1.3. Дагах стандарт, норм дүрэм
   - 1.4. Нэр томъёоны тайлбар
   - 1.5. Хураангуйлсан үг
2. **ИНЖЕНЕР ГЕОДЕЗИЙН СУДАЛГАА**
   - 2.1. Инженер геодезийн хайгуул, судалгаа
   - 2.2. Хиймэл дагуулын технологиор том машстабын байр зүйн зураглалын үндэслэлийг байгуулах, боловсруулалт хийх
3. **1:500-НЫ МАСШТБАБЫН БАЙР ЗҮЙН ДЭВСГЭР ЗУРАГЛАЛЫН АЖИЛ**
   - 3.1. Урьдчилан төлөвлөсөн трассын эхний хувилбарын дагуу таних цэгүүдийг газарт байгуулж, тэмдэглэх
   - 3.2. Замналуудаар нисч зураг авах
   - 3.3. Өндрийн болон гадаргын тоон загвар үүсгэх, засварлах
   - 3.4. Ортофото засвар хийх, ортофото зүймэл зураг үүсгэх
   - 3.5. Том масштабын байр зүйн зураглал үйлдсэн тухай

4. **БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ**

4.1. Хэмжилтэнд ашигласан багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт

4.2. Багажийн баталгаажуулалт

5. БОЛОВСРУУЛАЛТАД АШИГЛАСАН ПРОГРАМ ХАНГАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

6. ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ

6.1. Инженер техникийн ажилчдын жагсаалт

6.2. Мэргэжлийн диплом сертификат

7. ХАВСРАЛТ

7.1. Шинээр суулгасан цэг тэмдэгтийн хувийн хэрэг

7.2. Нивелирдлэгийн III ангийн шууд хэмжилтийн журнал

7.3. Хр0139-ГЦТ0076 хүртэлх нивелирдлэгийн III ангийн шууд, урвуу хэмжилтийн журнал

1. ЕРӨНХИЙ

1.1. ЗОРИЛГО

Нийслэлийн засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/720 дугаартай захирамжийн дагуу Нийслэлийн засаг даргын тамгын газрын захиалгаар хийгдэх буй “Шинэ тойрог авто зам” төслийн урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт шинээр байгуулах Их тойруугийн гудамжны /Туулын хурдны шинэ зам-Яармагийн шинэ гүүр- Баян хошуугийн тойрог-6 буудал- Дүнжингаравын уулзвар-Туулын хурдны зам/ 27 км урт авто замын трассын урьдчилан төлөвлөж буй хувилбарын дагуу 1:500-ны масштабын 0.5 м үеийн өндөр бүхий байр зүйн тоон зураглал үйлдэх, боловсруулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.2. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.2.1. Тодорхойлолт

Хүснэгт-1

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Оноосон нэр	Баясах Сурвэй
2	Аж ахуйн нэгжийн хэлбэр	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
3	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар	9011210057, 5336384
4	Үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ - 16 жил
5	Аж ахуйн нэгжийн албан ёсны хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сувд төв, 302 тоот
6	Холбоо барих утасны дугаар, и-мэйл хаяг	Утас: **99032682** , **99070460** **info@bayasakhsurvey.mn**
7	Үүсгэн байгуулсан огноо	2009.10.29

1.2.2. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

- Барилгын геодезийн иж бүрэн хэмжилт, хяналт шалгалт, мониторинг
- Авто ба төмөр замын геодезийн иж бүрэн хэмжилт, хяналт шалгалт, мониторинг
- Инженерийн шугам сүлжээний геодезийн ажлууд
- Төрөл бүрийн масштабын зураглал, боловсруулалт
- Кадастрын зураглал
- Дроны нислэг, зураглал, фото зургийн боловсруулалт, бичлэг

1.2.3. Хийж гүйцэтгэсэн болон гүйцэтгэж байгаа төсөл, хөтөлбөрүүд

Хүснэгт-2

№	Хамтран ажилласан компанийн нэр	Төслийн мэдээлэл	Гүйцэтгэсэн огноо
1	"Эм Си Эс Проперти" ХХК	Оюу Толгой гүний уурхайн чухал барилга байгууламжийн төсөл, -1344 түвшний хацарт бутлуур, Ore bin сигмент угсралтын хэмжилт.	2016
		Оюу Толгой гүний уурхай 1300 машин механизмийн заварын булангуудын бүх civil ажил, бүх гүүрэн болон дүүжин краны метал хийц тохируулгын хэмжилт.	2016-2017
		Оюу Толгой гүний уурхай 5D төсөл, 1202 түвшин Bin11 civil ажилууд, хацарт бутлуур, 110м туузан дамжуургын тохируулга метал хийцийн хэмжилт тохируулга.	2017-2019
		Оюу Толгой гүний уурхай материал тээвэрлэлтийн төсөл үндсэн баялаг зөөх 1100 м урт туузан дамжуургын геодезийн сүлжээний хэмжилт, үндсэн түнээлийн laser scan хэмжилт боловсруулалтын ажил, дүүжин туузан дамжуургын хэмжилт тохируулгын ажил хийж гүйцэтгэсэн.	2019-2020
2	"Бодь Интернэшнл" ХХК	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн P1/Суурь бүтэц/,P2/Шилэн кабел/,P3/Барилга угсралт/,P4/Цахилгаан дамжуулах агаарын шугам/ багцуудын геодезийн хяналт баталгаажуулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлэн 4 дэх жилдээ амжилттай ажиллаж байна.	2020-2023
3	"Бодь Интернэшнл" ХХК	Тавантолгой-Гашуусухайт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын	2021-2022

		төслийн суурь бүтцийн геодезийн хяналт баталгаажуулалтын зөвлөх үйлчилгээг амжилттай хийж гүйцэтгэсэн.	
4	"Бодь Интернэшнл" ХХК	ТаванТолгойн Нүүрс Ачих Логистикийн Төв/ТНАЛТ/ Төсөл-ийн геодезийн хяналт баталгаажуулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлэн 3 дах жилдээ амжилттай ажиллаж байна.	2022-2024
5	“Цэцэнс Майнинг Энд Энержи” ХХК	Бөөрөлжүүтийн 300МВт-ын Цахилгаан станц, Нүүрсний уурхай, Цахилгаан дамжуулах агаарын шугам, Оффис барилга, Ажилчдын байр, Спорт цогцолбор, Автозам, Төмөр замын бүтээн байгуулалтын цогц төслийн захиалагчийн геодезийн хяналтын үйлчилгээг үзүүлэн 2 дах жилдээ амжилттай ажиллаж байна.	2023-2024
6	"Монкон Констракшн" ХХК	Газар доорх усны эх үүсвэрийн худгууд болон дамжуулах хоолойн барилга угралтын төслийн геодезийн бүх шатны ажлыг хийж гүйцэтгэж байна.	2024-2025
7	"М Си Эс Интернэйшнл" ХХК	Ус дамжуулах систем, ДЦС-3, ДЦС-4 ТӨХК дээрх өөрчлөлтийн ажлууд, СКАДА системийн барилга угсралтын төслийн бүх шатны геодезийн хяналтын үйлчилгээг гүйцэтгэж байна.	2024-2025
8	“Трийбтех ауфберейтунгсистеме ГМБХ” ХХК	Эрдэнэт үйлдвэрийн “Мөчлөгт урсгалт тээврийн технологийн бутлуурын байгууламж” төсөл	2024-2025
9	“Нийслэлийн засаг даргын тамгын газар”	“Шинэ тойрог зам” төслийн ТЭЗҮ хийхэд шаардагдах байрзүйн зураг	2025
10	“Хан-Алтай Ресурс” ХХК	“Хөгжил төсөл”	2025

1.2.4. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ

Зураг-1

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000216032

2009.10.29 / Бүртгэсэн он,сар,өдөр /

9011210057 / Хувийн хэргийн дугаар /

5336384 / Регистрийн дугаар /

Баясахсурвэй

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр / шийдвэрийн нэр /

001 / дугаар /

2009.10.29 / он, сар, өдөр /

5629	Цайны газар
5621	Кофе шоп
4610	Гадаад худалдаа

/ Код/ / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа /

1 / гишүүдийн тоо /

1,000.00 / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, н.содном, 50, 17 тоот, Утас1: 99070460, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ
/албан тушаал/

Д.ГАНГАМӨРӨН
/гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2023 он 01 сар 13 өдөр

Зураг-2

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Далайбаатар овогтой Түмэннаст-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.01.13	Д.Гангамөрөн
2	Дахин гэрчилгээ олгов.	2021.01.13	Д.Гангамөрөн
3	Улаанбаатар, Сухбаатар, 8-р хороо, н.содном, 50, 17 тоот Утас1: 88768811, Утас2: 99039682, Факс: хаягийг шинээр бүртгэв.	2022.11.09	Л.Хишигжаргал
4	Хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.11.09	Л.Хишигжаргал
5	Эцсийн өмчлөгч 2 ирсэн бүртгэв.	2022.11.09	Л.Хишигжаргал
6	4610 Гадаад худалдаа үйл ажиллагаа хассаныг бүртгэв. 46100 Төлбөр зээлэн гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2022.11.09	Л.Хишигжаргал

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

0002160 32

1.2.5. Тусгай зөвшөөрөл

Зураг-3

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: **2023/02/09/007**

Монгол улсын Геодези, зураг зүйн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн ***“Баясахсурвэй” ХХК*** */5336384/-д* ***“Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх”*** *тусгай зөвшөөрлийг* ***2023*** *оны* ***03*** *дугаар сарын 02-ны өдрөөс* ***3*** *жилийн хугацаатай олгов.*

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй.

САЙД Ц.ДАВААСҮРЭН

Улаанбаатар хот
2023 он

1.3. ДАГАХ СТАНДАРТ, НОРМ ДҮРЭМ

Монгол улсад мөрдөгдөж буй дараах норм дүрмүүдийг баримталж ажилласан.

Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол.
- Навигацийн хиймэл дагуул (GNSS) -ын технологиор Монгол улсын геодезийн сүлжээ байгуулах дүрэм. БНбД 11-13-22;
- Монгол улсын өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах дүрэм. БНбД 11-121-19;
- Геодезийн цэг, тэмдэгтийн хайгуул, судалгааны ажлын заавар MNS:3951-20 Геодези, зураг зүй. Ерөнхий нэр томьёо, тодорхойлолт
- “1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил” /БД 11-06-08/
- “1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай зургийн томьёолсон тэмдэг” УГЗЗГ
- Авто зам болон төмөр замын геодезийн ажил. /БД 11-114-14/
- “Геодезийн ажлын аюулгүй ажиллагааны техникийн дүрэм” УГЗЗГ, 1976 он.
- "Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр агаарын зураглал ба газрын зураг гүйцэтгэх ажил" БД 11-125-21.
- Агаар, сансрын зураглалын ажил БНБД 11-14-23
- MNS:6925-11:2021 Газар зүйн мэдээлэл. Орто-зураглалын орон зайн өгөгдлийн үзүүлэлт

1.4. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- **Геодезийн байнгын цэг, тэмдэгт:** Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр утга нь тодорхойлогдсон, газрын гадарга, хэвлий, барилга байгууламж зэрэг хөдөлгөөнгүй биетэд бэхлэгдсэн төв болон түүний гаднах тэмдэглээсийг хэлнэ.
- **Геодезийн сүлжээ:** Цэгийн ямар утга тодорхойлох хэмжилт хийхээс хамааран байрлалын /триангуляци, полигонометр/, өндрийн / I, II, III, IV анги/, гравиметрийн, GNSS-ийн сүлжээ гэж ангилдаг.
- **Байрлалын сүлжээ:** GNSS-ийн хэмжилтээр дэлхийн гео-төвт 3 хэмжээст тэгш өнцгийн ITRF болон геодезийн солбицлын тогтолцоонд байрлалыг, геометрийн нивелирдлэгээр ортометрийн өндрийг, гравиметрийн хэмжилтээр хүндийн хүчний утгыг тодорхойлсон цэгүүдийн олонлог.
- **Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээ:** Нутаг дэвсгэрийн хэмжээнд өндрийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд батлан хамгаалах, дэд бүтэц, шинжлэх ухааны салбарт хэрэглэгддэг бүх төрлийн масштабын байр зүйн зураглалын ажлын өндрийн үндэслэл болдог.
- **Геодезийн үндэслэл:** Байр зүйн зураглал хийхэд зориулсан улсын, зураглалын болон бусад геодезийн сүлжээний цэг, тэмдэгтийн тогтолцоо.
- **Дэлхийн навигацийн хиймэл дагуулын систем (GNSS):** Объектын орон зайн байрлал, хөдөлгөөний чиглэл, шилжилтийг тодорхойлох зорилгоор байгуулсан хиймэл дагуулын систем. Тайлбар: Америкийн GPS, Оросын GLONASS, Европын GALILEO, Хятадын COMPASS/Bei-Dou, Японы QZSS, Энэтхэгийн IRNSS зэрэг навигацийн хиймэл дагуулын системүүд, тэдгээрийн засварыг дамжуулах зорилгоор нэмэлтээр байгуулсан Америкийн WAAS, Оросын SDCM, Европын EGNOS, Японы MTSAT, Энэтхэгийн GAGAN хиймэл дагуулын систем хамаарна.

- **Байнгын Ажиллагаатай Суурин Станц (БАСС):** Навигацийн хиймэл дагуулын мэдээг тасралтгүй хүлээн авч, гурван хэмжээст солбицол ба засварыг түгээдэг тоног төхөөрөмж, програм хангамжийн цогц бүрдэлюм.
- **Бодит агшны хөдөлгөөнт хэмжилт (RTK-Real Time Kinematic):** Суурь станцаас тухайн агшинд илгээсэн засварын мэдээллийг хөдөлгөөнт станц хүлээн авч өөрийн солбицлыг шууд тодорхойлох хэмжилтийн арга.
- **Геоид:** Далайн нам тайван тэнцвэртэй нөхцөлд байх үеийн гадаргуун шугамыг эх газарт үргэлжлүүлэн татахад үүссэн Дэлхийн хэлбэрийг хэлнэ.
- **Ханын репер, марк:** Барилгын хана, багана, бетон гүүрэнд бэхэлсэн улсын өндрийн сүлжээний цэг.
- **Хэмжилтийн нарийвчлал:** Тухайн хэмжиж байгаа хэмжигдхүүний бодит байдалд ойртох утгыг харуулах хэмжилтийн үзүүлэлтийг хэлнэ.
- **Тэгшитгэн бодолт:** Геодезийн хэмжилтийн үр дүнгийн боловсруулалтаар хэмжиж буй хэмжигдхүүний эсвэл түүний функцийн бодит утгыг тодорхойлно.
- **Дундаж квадрат алдаа:** Хэмжилтийн үр дүнгийн нарийвчлал, чанарын үзүүлэлт.

1.5. ХУРААНГУЙЛСАН ҮГ

- МУ – Монгол Улс
- БНМАУ- Бүгд Найрамдах Монгол Ард Улс
- АНУ – Америкийн Нэгдсэн Улс
- БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- ГЗЗГ – Геодези, зурагзүйн газар
- ГУГК – Главное управление геодезии и картографии
- ГЗЗГЗЗЕГ – Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн ерөнхий газар
- БНбД – Барилгын норм ба дүрэм

- БД – Барилгын дүрэм
- MNS – Mongolian National Standatd
- ITRF- International Terrestrial Reference Frame
- БАС – Байнгын ажиллагаатай суурин станц
- УГС – Улсын геодезийн сүлжээ
- ННТ – Нисгэгчгүй нисэх төхөөрөмж
- GSD – Ground Sampling Distance
- SGO – South geomatics office
- UTM – Universal Transverse Mercator
- GNSS – Global Navigation Satellite System
- UB 01 – Улаанбаатар хотын байнгын ажиллагаатай суурин станц
- Tuv 1 – Төв аймгийн байнгын ажиллагаатай суурин станц
- ГЦТ – Геодезийн цэгийн төв
- ГЦХ – Геодезийн цэгийн хэлбэр
- Хр – Ханын репер

2. ИНЖЕНЕР ГЕОДЕЗИЙН СУДАЛГАА

2.1. ИНЖЕНЕР ГЕОДЕЗИЙН ХАЙГУУЛ, СУДАЛГАА

“Шинэ тойрог авто зам” төслийн хүрээнд засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар” -ын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн веб портал “Геопортал”-ын https://nsdi.gov.mn цахим хуудаснаас Улаанбаатар хотын Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдийн Улсын геодезийн байрлалын сүлжээний 51 цэг тэмдэгтийн, өндрийн сүлжээний II ангийн 3 репер, ханын маркийн мэдээллийг авч инженер геодезийн хайгуул судалгааг хийсэн.

Геопортал орон зайн дэд системээс геодезийн цэг тэмдэгтийн мэдээлэл авах тухай зааварчилгааг оруулав.

“Геопортал” орон зайн өгөгдлийн дэд бүтцийн цахим системд нэвтрэх

Зураг-4



Монгол улсын геодезийн сүлжээний цэгүүд

/Төсөл хэрэгжил талбайн ойролцоох геодезийн цэг тэмдэгтийн судалгаа/

Зураг-5



Төслийн хэрэгжих талбайд ойролцоох цэг тэмдэгтийг олох

/Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийг нэгдсэн сангаас худалдаж авах/

Зураг-6



“Геопортал” Орон зайн өгөгдлийн дэд бүтэцийн цахим системээс худалдан авсан цэг тэмдэгтийн мэдээлэл бүртгэлтэй төхөөрөмж болон мэйл хаягаар ирнэ.

Зураг-7

Баясах Сурвэй ХХК
(ААН-ын нэр)

Геодезийн цэгийн солбицол, өндрийн утга
(мэдээлэлийн утга)

2025.02.07

Д/д	Аймгийн нэр	Сумын нэр	Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	N_UTM	E_UTM	Өндөр
1	Улаанбаатар	Баянзүрх	ПЦ 0047	47 56 55.737	106 56 31.722	5312436.69	645015.701	1406.120
2	Улаанбаатар	Чингэлтэй	ПЦ 0166	47 57 53.067	106 53 37.35	5314116.643	641355.733	1421.436
3	Улаанбаатар	Сонгинохайрхан	ПЦ 0163	47 56 35.089	106 50 44.977	5311622.661	637839.357	1446.711
4	Улаанбаатар	Сонгинохайрхан	ПЦ 3321	47 56 35.115	106 50 8.134	5311605.243	637075.132	1385.932
5	Улаанбаатар	Сонгинохайрхан	ПЦ 0252	47 55 55.947	106 50 44.839	5310414.198	637865.414	1410.381
6	Улаанбаатар	Сонгинохайрхан	ПЦ 0122	47 56 17.16	106 49 8.965	5311021.843	635860.872	1326.537
7	Улаанбаатар	Баянзүрх	164	47 55 00.93	106 57 55.19	5308936.4	646837.2	1314.5992
8	Улаанбаатар	Хан-Уул	515	47 52 10.40	106 49 06.30	5303402.5	635985	1293.4148
9	Улаанбаатар	Хан-Уул	227	47 52 37.34	106 50 53.00	5304286.9	638181.5	1286.4336

ГБЗЗМэдээллийн сангийн мэргэжилтэн Геодези, зураг зүйн мэдээллийн үйлчилгээ /С.Нарангэрэл/

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар – Салбарын архивын хэлтэс

“Шинэ тойрог авто зам” төслийн 1:500 масштабтай байрзүйн зураглалын ажлын ерөнхий төлөвлөлтийн схем:



Цэг тэмдэгтийн судалгааны явцад хайж олсон цэгүүдийн төвийг цаасан дээр барлаж авсан. Хайгуул судалгааны ажлыг Геодезийн инженер-1, Геодезийн техникч-1, Жолооч-1 зэрэг 3 хүний бүрэлдэхүүнтэй 5 баг буюу нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй хийсэн болно. Цэг тэмдэгтүүдийн байрлал, өндрийн жагсаалтыг **Хүснэгт-3** -д үзүүлэв.

Хүснэгт-3

№	Цэгийн нэр	UTM тэгш өнцгийн солбицол, м		Цэгийн өндөр, м	Тайлбар
		x	y		
1	478	5304338.205	637103.147	1271.697	Устаагүй цэгүүд
2	БНМАУ-0051	5308036.218	636797.796	1275.545	
3	Microraion	5309194.806	636717.296	1326.610	
4	ГТЦ-0252	5310414.198	637865.414	1410.381	
5	ГТЦ-0122	5311021.843	635860.872	1326.537	
6	ГЗЗГ-3321	5311605.243	637075.132	1385.932	
7	ГТЦ-0163	5311622.661	637839.357	1446.711	
8	ГТЦ-0230	5313686.690	635798.342	1379.453	
9	ГТЦ-0394	5314529.361	639935.343	1580.386	
10	ГТЦ-0463	5313241.744	640267.229	1501.184	
11	ГТЦ-0297	5313698.427	641039.178	1527.638	
12	ГТЦ-0166	5314116.643	641355.733	1421.436	
13	ГТЦ-0393	5314530.967	641714.795	1480.295	
14	Чингэлтэй ам	5314147.209	642157.520	1437.566	
15	ГУГК-8723	5313941.522	642574.311	1442.072	
16	ГТЦ-0216	5314533.775	644153.606	1353.229	
17	ГТЦ-0047	5312436.690	645015.701	1406.120	
18	ГТЦ-0040	5311459.398	646735.879	1415.323	

19	ГТЦ-0068	5306562.827	636821.783	1273.341	Устсан цэгүүд
20	ГТЦ-0414	5308647.791	636832.362	1287.590	
21	ГТЦ-0024	5309808.893	637525.381	1363.779	
22	ГТЦ-0016	5309938.642	636719.806	1361.756	
23	ГТЦ-0255	5310355.356	636905.896	1379.192	
24	ГТЦ-0337	5310872.377	637205.569	1418.131	
25	Maanit	5310948.384	637771.987	1454.476	
26	ГТЦ-0352	5311716.762	637222.057	1395.074	
27	ГТЦ-0437	5312565.620	638780.389	1460.052	
28	ГТЦ-0039	5314688.069	641281.416	1511.202	
29	ГТЦ-1120	5314392.722	642739.762	1365.705	
30	ГТЦ-1121	5314430.126	643127.399	1354.552	
31	ГТЦ-1122	5314657.554	643082.984	1356.795	
32	ГТЦ-6111	5313837.432	643094.978	1350.981	
33	ГТЦ-0461	5313908.810	643676.861	1334.212	
34	ГТЦ-0391	5314553.103	643712.620	1339.748	
35	ГТЦ-0018	5314531.839	644000.575	1340.631	
36	ГТЦ-0113	5313768.319	644329.212	1343.676	
37	ГТЦ-0145	5312970.598	644397.838	1331.411	
38	ГТЦ-0398	5311054.147	646332.990	1414.343	
39	ГТЦ-0174	5310892.873	647278.289	1437.665	
40	karr	5310421.367	646305.434	1420.449	
41	rels	5309709.473	646646.376	1341.655	
42	ГТЦ-0062	5309728.104	647125.853	1338.955	
43	ГТЦ-0575	5309760.890	647186.500	1335.238	Устсан цэгүүд
44	ГТЦ-0467	5308946.209	646140.234	1306.058	
45	ГТЦ-0051	5308916.653	646451.674	1309.691	

46	ГТЦ-0010	5308870.444	646912.058	1311.046	
47	ГТЦ-0225	5308866.114	647164.874	1311.723	
48	ГТЦ-0404	5307881.626	646638.808	1297.274	
49	ГТЦ-0485	5307847.248	645927.043	1294.619	
50	okrug	5307883.728	647199.174	1298.266	
51	10031	5307841.085	647487.336	1298.605	

Цэг тэмдэгтийн хайгуул судалгааны үеийн хэмжилтийг **Зураг-8**, цэгийн төвийг барласан байдлыг **Зураг-9** -д үзүүлэв.

Зураг-8

Зураг-9



Хайгуул, судалгааны үр дүнд нийт 51 цэгээс устсан цэг-32 , хэмжилт хийх нөхцөл алдагдсан цэг-1 , хэмжилт хийх боломжтой цэг-18 байна.

Трассын дагуух геодезийн сүлжээний цэгүүдийн хувийн хэргийг бүрдүүлэн оруулав.

1	**Цэгийн нэр:**	ГТЦ	**2**	**Марк реперийн дугаар:**	0047
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Баянзүрх дүүрэг 27 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 56 55.737	106 56 31.722	5312436.69	645015.701

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: 127 дугаар дунд сургуулийн баруун урд зүгт байрлах сүлжээний антентай уулын антены баруун талд овооны урд

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: Д.Мөнхцэцэг

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГТЦ	**2**	**Марк реперийн дугаар:**	0394
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 22 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 58 7.551	106 52 29.369	5314529.362	639935.343

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Мобиком сүлжээний антенаас баруун хойш 60м зайд овооны урд

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: Д.Мөнхцэцэг

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГТЦ	**2**	**Марк реперийн дугаар:**	0216
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг 16 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 58 4.324	106 55 52.712	5314533.775	644153.606

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Сүхбаатар 16 дугаар хорооны байрнаас зүүн тийш 50м зайд

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: Д.Мөнхцэцэг

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГТЦ	**2**	**Марк реперийн дугаар:**	0297
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 22 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 57 39.779	106 53 21.598	5313698.427	641039.177

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 22 дугаар хорооны хайлааст завсар1 автобусны буудлаас ургаш 600м зайд байрлах уул

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: Д.Мөнхцэцэг

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГТЦ	**2**	**Марк реперийн дугаар:**	0040
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 31 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 56 22.69	106 57 53.408	5311459.398	646735.879

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 31 дугаар хороо монелын 656 тоотын хашаанд

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: Д.Мөнхцэцэг

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГЦТ	**2**	**Марк реперийн дугаар:**	0163
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 8 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 56 35.089	106 50 44.977	5311622.661	637839.357

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Гүнжийн нүдэн нуурааc зүүн урагш 900м соёмботой толгойгоос зүүн хойш 400м

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	TR	**2**	**Марк реперийн дугаар:**	Microraion
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	Тригиуляц
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 23 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 55 17.356	106 49 48.138	5309194.806	636717.296

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Эрчим төвөөс зүүн хойш 450м

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

Цэгийн судалгаа нэмэлт тэмдэглэл: Хэмжилт хийх нөхцөл алдагдсан

1	**Цэгийн нэр:**	ГЦТ	**2**	**Марк реперийн дугаар:**	0393
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 15 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 58 6.193	106 53 55.149	5314530.967	641714.796

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Хайласт усан сан (УСУГ) зүүн хойш 20м

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГЦТ	**2**	**Марк реперийн дугаар:**	0166
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 16 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 57 53.067	106 53 37.35	5314116.642	641355.733

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос

Холоос

8. Байршлын тухай тэмдэглэл: Хайласт Сод монгол клонкоос хойд зүгт 400м

9. Байршлын тойм зураг:

10. Төв цэгийн хэлбэр:



11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГЦТ	**2**	**Марк реперийн дугаар:**	0252
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 31 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 55 5.947	106 50 44.839	5310414.199	637865.414

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Соёмботой толгой урагш 500м сүлжээний антены хажууд

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГУГК	**2**	**Марк реперийн дугаар:**	8723
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 15 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 57 46.425	106 54 35.878	5313941.522	642574.312

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Сүлжээний антены зүүн тийш 10м овооны хажууд

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГЗЗГ	**2**	**Марк реперийн дугаар:**	3321
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 8 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 56 35.115	106 50 8.134	5311605.242	637075.132

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Гүнж нүдэн нуур БУ 900м

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	ГТЦ	**2**	**Марк реперийн дугаар:**	0463
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлттэй дүүрэг 21 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 57 25.606	106 52 43.855	5313241.744	640267.229

7. Цэгийн гэрэл зураг:

Ойроос	**Холоос**

8. Байршлын тухай тэмдэглэл: Улаанбаатар Чингэлттэй дүүрэг 21 дугаар хорооны Ананд супермаркетийн баруун хойно байрлах уул

9. Байршлын тойм зураг:	**10. Төв цэгийн хэлбэр:**
	

11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	БНМАУ	**2**	**Марк реперийн дугаар:**	0051
3	**Трапецийн дугаар:**	M-48-142	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 17 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 54 39.789	106 49 50.686	5308036.296	636797.675

7. Цэгийн гэрэл зураг:



8. Байршлын тухай тэмдэглэл: 32-ын гүүрэн дээр

9. Байршлын тойм зураг:

10. Төв цэгийн хэлбэр:



11. Хөрсний шинж байдлын тухай:

12. Огноо: 2025-01-24

14. Хувийн хэрэг хөтөлсөн: М.Бөхсанаа

15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

1	**Цэгийн нэр:**	Чингэлттэй	**2**	**Марк реперийн дугаар:**	Ам
3	**Трапецийн дугаар:**	L-48-10	**4**	**Сүлжээний төрөл:**	GNSS
5	**Байршил: (аймаг, сум, дүүрэг, хороо)**	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 15 дугаар хороо			
6	**Солбицол:**	47 57 53.417	106 54 16.033	5314147.209	642157.52

7. Цэгийн гэрэл зураг:

8. Байршлын тухай тэмдэглэл: 0280 тоотын хашаанд уулын орой дээр

9. Байршлын тойм зураг:

10. Төв цэгийн хэлбэр:



11. Хөрсний шинж байдлын тухай:
12. Огноо: 2025-01-24**14. Хувийн хэрэг хөтөлсөн:** М.Бөхсанаа
15. Байгууллага: Баясах Сурвэй ХХК

Хайгуул судалгаа хийж цэгийн төвийн дугаарыг барласан байдал:

<table>
<tr>
<td> </td>
<td>  </td>
</tr>
<tr>
<td> </td>
<td>  </td>
</tr>
</table>


0252
0297
ГТ4 0297
0393
0463



2.2. ХИЙМЭЛ ДАГУУЛЫН ТЕХНОЛОГИОР ТОМ МАСШТАБЫН БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛЫН ҮНДЭСЛЭЛИЙГ БАЙГУУЛАХ, БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ

Байрлалын сүлжээ байгуулсан тухай:

Солбицлын тогтолцоо. Хэмжилт, зураглалын ажлыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэж байгаа геодезийн хэмжилт, зураглалын ажилд олон улсын геодезийн солбицлын 2008 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн эрин бүхий ITRF2020 тогтолцоо, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, газрын зураглалд дэлхийн хөндлөн меркаторын "UTM" тусгагт хийсэн.

Цэг тэмдэгт. “Шинэ тойрог зам” төслийн хүрээнд төлөвлөсөн трассын дагуу зураглалын үндэслэлийн “ГЦХ-11”, , “ГЦХ- 12”, “ГЦХ-13”, “ГЦХ-14”, “ГЦХ-15”, “ГЦХ-16”, “ГЦХ-17”, “ГЦХ-18”, “ГЦХ-19”, “ГЦХ-20”, “ГЦХ-76” дугаар бүхий 11 төв цэг шинээр суулгаж, УБ хотын кадастрын зураглалд зориулсан сүлжээний 2 цэг буюу ГЦТ 0478, “БНМАУ-0051” цэгүүдийг ашиглан трассын дагуух тулгуур сүлжээг нийт 13 цэгтэй байгуулсан.

Шинээр суулгасан цэг тэмдэгтийг өндөрлөг товгор, эрж олоход хялбар, аюулгүй, хиймэл дагуулын мэдээлэл хаах ойр байхгүй байх, замын хөдөлгөөнд саад учруулахгүй, удаан хугацаанд геодезийн тоон өгөгдлийг хөдөлгөөнгүй хадгалах чадвартай, бат бэх чанарыг агуулах нөхцөлийг бүрдүүлэн ГЦХ 6 төрлийн цэгийг бэлтгэн газарт суулгасан. ГЦХ 6 цэг нь зураглалын сүлжээ, авто болон төмөр зам зэрэг инженерийн барилга байгууламж барих, ашиглалтын үед хяналт хийх зориулалттай. Цэгийг 60 мм-ийн хөндлөн огтлолтой, 100 мм урт зэвэрдэггүй ган хоолой дээр төвийг гагнаж бэлтгэсэн. Цэгийг суулгах газар шорооны ажлыг энгийн механик дриллээр, газраас доош 1.5 м гүн ухаж нүхийг ухаж, нүхний ёроолд ус чийгнээс хамгаалсан 20 см зузаан элс дэвсэж, нягтруулсны дараа цэгийг нүхэнл суулгаж, хөдөлгөхгүйн тулд зангуу хийж бэхлээд бетон цутгасан. Цэгийн доод цутгамал хэсгийн бетон суурийг 10 Х 40 Х 40 см хэмжээтэй модон хэв хийж, бетон зуурмагийг БД 11-104-19-д заасан орцын дагуу бэлтгэж цутгасан. Цэгийг эрж олох, удаан хугацаанд хадгалах, хэмжилт хийх нөхцөлийг алдагдуулах, гэмтээхгүйн тулд гадна талд нь бетон цутгаж, хамгаалалтын шуудуу ухсан. **Зураг 10, 11** - д үзүүлэв.

Зураг-10 Цэгийн суурийн хэв, бетон зуурмаг бэлтгэх үе:



Зураг-11 Цэгийг газарт суулгаж, гадна талд хамгаалалт хийсэн байдал. /1-цэгийн төрөл, бичиглэл ГЦХ, 2 – төвийн дугаар, 007, 012/

Хэмжилт. Зураглалын сүлжээг геодезийн харьцангуй аргаар солбицол тодорхойлох зарчимаар, зураглалын үндэслэл хоорондоо дундажаар 2-3 км, цэг хоорондын харилцан байрлалын дундаж квадрат алдаа 3 см, талын уртын харьцангуй алдаа 1:20000-аас багагүй нарийвчлалтайгаар геодезийн орон зайн байгууламжаар байгуулсан. Зураглалын сүлжээний байрлал, хамаарах дүүрэг зэргийг өндрийн тоон загвар дээр **Зураг 12** -д, сэлгэцийн бүдүүвчийг **Зураг 13** -д тус тус үзүүлэв.

Зураглалын С ангийн 3-р зэргийн сүлжээний хэмжилтийг АНУ-ын TRIMBLE фирмийн R8 маркийн 2, 3, 4 дүгээр загваруудын 2 долгионы 7 ширхэг GNSS хүлээн авагчуудаар 2 ээлжийн /сеанс/ хэмжилт хийсэн.

Хиймэл дагуулын геодезийн хэмжилт хийх ээлжийн тоог дараах томъёогоор бодож олсон. Үүнд:

$$N=(S-O)/(R-O) =(13-1)/(7-1)=12/6=2$$

энд: N- ээлжийн тоо,

O-Цэгийн тоо,

R-Хэмжилт хийх багажийн тоо,

O-Нэг ээлжийн хэмжилтэнд давхцах цэгийн тоо.

Хэмжилтэнд ашиглаж буй хиймэл дагуулын кодолсон дохиог 2 долгионы L1/L2/L5 суваг дээр хүлээн авч, багажны хэмжилзүйн баталгаажуулалтаас дундаж квадрат алдааг илэрхийлэх томъёоны нэгдэх гишүүн нь үнэмлэхүй утгаараа 5 мм-ээс ихгүй, хүлээн авагчийн антенны фазын төвийн үнэлгээ нь IGS (олон улсын GNSS-ийн сервис)-ээр баталгаажуулагдсан.

Статик хэмжилт эхлэхийн өмнө зураглалын сүлжээний цэг дээр GNSS-ийн багажийг түүний оптик төвлөрүүлэгчээр 1 мм-ийн нарийвчлалтай төвлөрүүлж, тэгшилсэн.

Багажийн удирдлагын блокт дараах тохиргоо хийсэн. Үүнд:

- Хиймэл дагуулын байрлалын хавтгайд үүсгэх бага хамгийн бага өнцөг -10 градус;
- Хэмжилтийн ажилд нэгэн зэрэг ажиглах хиймэл дагуулын тоо - 4
- Хиймэл дагуулын дохио хүлээн авах интервал - 30 сек
- PDOP (геометрийн үзүүлэлт) зөвшөөрөгдөх хэмжээ – 4



Зураг-12 Зураглалын сүлжээг газрын гадаргуугийн тоон загвар дээр үзүүлсэн байдал.



Зураглалын С ангийн 3-р зэргийн байрлалын сүлжээний бүдүүвч			
"Баясах Сурвэй" ХХК геодезийн инженер	Төслийн нэр	Байршил	Огноо
Т.Дэлгэвин	" Шинэ тойрог зам"	" Улаанбаатар хот "	2025-05-29
"БАЯСАХ СУРВЭЙ" ХХК			

Зураг-13 Зураглалын сүлжээний бүдүүвч

Хэмжилт эхлэхийн өмнө “Хиймэл дагуулын геодезийн хэмжилтийн журнал”-ыг цэг тус бүр дээр хөтөлсөн. Хэмжилтийн журналын загварыг **Хүснэгт-6** -д үзүүлэв.

Хиймэл дагуул (GPS/Glonass)-ын геодезийн сүлжээний хэмжилтийн журналд дараах үзүүлэлтүүдийг харуулсан. Үүнд:

- Цэгийн нэр: ГЦХ. Төвийн дугаар -011;
- Аймаг, сумын нэр. – Улаанбаатар, СХД;
- Тухайн хэмжилтэнд хамаарах трапецын дугаар М-48-10;
- Хэмжилт эхлэсэн, дууссан цаг;
- Багажийн марк Trimble R8, модел;
- Антенн, удирдлагын блдкын дугаар;
- Цаг агаарын үзүүлэлтүүд ;
- Антенны өндөр хэмжсэн байдал зэрэг болно.

Хүснэгт-6

Хүлээн авагчийн төрөл 2 долгионы	**Давталт 1**		**Давталт 2**	
	эхэлсэн	**дууссан**	**эхэлсэн**	**дууссан**
Огноо	2025.05.29	2025.05.29		
Хэмжилт хийсэн цаг	12:17	15:17		
Антенны өндөр, см-ээр	130.6	130.6		
Антенны дугаар	5318436450			
Удирдлагын блокын дугаар				
Агаарын температур, С	14℃			
Агаарын даралт, гПа	863	863		
Агаарын чийгшил, %	21	21		
Хөрвүүлгийн элементийг тодорхойлсон байдал			Хэмжилтийн үеийн нэмэлт мэдээлэл	

Нэг ээлжээр гүйцэтгэх геодезийн хэмжилтэнд аль болох нэг төрлийн олон хүлээн авагчуудыг ашиглана гэсэн зааврыг баримтлан 7 ширхэг TRIMBLE R8 GNSS, багажуудыг ГЦТ0478-ГЦХ 015 дугаартай 7 цэг дээр эхний ээлж хэмжилтийг статик горимоор, хиймэл дагуулын нөлөөлөл багатай цагийг сонгож, нэг цэг дээрх хэмжилтийн үргэлжлэх хугацааг 1 цаг+20 мин км бүрт гэсэн томъёогоор бодож гарган цэг тус бүр дээр тасралтгүй 3 цагийн турш үргэлжлүүлэн хийсэн. 1 дүгээр ээлжийн хэмжилт дууссаны дараа 2 дугаар ээлжийг ГЦХ 015 -ГЦХ 076 дугаартай 7 цэг тус бүр дээр 3 цагийн тасралтгүй хэмжилтийг хийсэн.

Хэмжилтийн ажил дууссаны дараа хэмжилт тус бүр дээр хэмжилтийн өгөгдлийн чанарын шалгалтыг хийсэн.

Хэмжилтийн өгөгдлийн чанарын шалгалт. Сүлжээний цэгүүд дээрх GNSS-ийн статик хэмжилтийн өгөгдлийн чанарыг TEQC программ хангамжаар шалгасан. Чанарын шалгалтын хувьд олон замын алдаа L1 долгионы хувьд 0.7м, L2 долгионы хувьд 0.7м шаардлага хангасан байсан. Трассын дагуу суулгасан нийт 13 цэгийн хэмжилтийн өгөгдлийн чанарыг шалгахад олон замын алдаа нь L1 долгионы MP1 хамгийн ихдээ 0.58м, L2 долгионы хувьд MP2 нь 0.61м байгаа тул чанарын шаардлагыг хангаж байна. Хэмжилтүүдийн чанар нь 73-94 хувь үүнээс хамгийн бага ГЦТ 0051 цэг дээр 73% байна. Тус цэг “Хархорин” захын хойд талын хөдөлгөөний эрчим их автозамын дунд талын тусгаарлах зурвас дээр байрлаж байгаа тул хиймэл дагуулын хэмжилтийн чанарт нөлөөлсөн байна. Чанарын шалгалтын үзүүлэлтүүдийг **Хүснэгт-7** -д үзүүлэв.

Хүснэгт-7

Цэгийн дугаар	%	MP1	MP2
019	94%	0.54	0.59
013	87%	0.40	0.41
076	76%	0.38	0.28
0478	90%	0.29	0.27
020	88%	0.30	0.29
018	87%	0.48	0.42

011	76%	0.35	0.34
014	87%	0.41	0.34
0051	73%	0.58	0.61
016	88%	0.47	0.51
017	87%	0.48	0.49
015	87%	0.47	0.49

Тэгшитгэн бодолт. Трассын дагуу байгуулсан тулгуур сүлжээг Олон улсын GNSS-ийн албаны /IGS/, ULAB, IRKT, BJFS, XIAN, LHAZ, URUM, TSKB станцын өгөгдөл, мөн МУ-ын Байнгын ажилагаатай UB 01 суурин станцын өгөгдөлд тулгуурлан Массачусетсийн технологийн дээд сургуулийн боловсруулж хөгжүүлсэн GAMIT/GLOBK/ програм хангамж ашиглан хийсэн. **Зураг-14** -д үзүүлэв.



Зураг-14 Олон улсын GNSS-ийн албаны суурин станцын байрлал





.

Зураг-15 Байнгын ажиллагаатай суурин станц UB 01 зураг, ULAB мэдээлэл

Антенны фазын төвийн үнэлгээг https://igs.org/wg/antenna/ сайтнаас татаж авч ашигласан. Антенны өгөгдөл татаж авах хаягийг **Зураг-16** -т, өгөгдлийн файлын загварыг **Зураг-17** -т үзүүлэв.

Зураг-16



IGS INTERNATIONAL GNSS SERVICE

NETWORK PRODUCTS DATA DOCUMENTS PARTICIPATE ABOUT CONTACT US

ANTEX (igs20.atx.gz)	Antenna calibrations- absolute IGS phase center corrections for satellite and receiver antennas; to be used with the ITRF2020 terrestrial reference frame.
ANTEX Format Description (antext14.txt)	ANTEX: The Antenna Exchange Format, Version 1.4
Naming Convention (rcvr_ant.tab)	IGS naming conventions for GNSS equipment (receivers, antennas, radomes, satellite antennas); only valid names to be used in IGS site logs, RINEX headers, SINEX files, etc.
Reference points and Dimensions (antenna.gra)	antenna reference point (ARP) definition, north reference point (NRP) definition, physical antenna dimensions

Зураг-17 Антенны файл



https://files.igs.org/pub/station/general/rcvr_ant.tab?_gl=1*1cu0myy*_ga*MTM2OD

	BDS B1/B2/B3 integrated rec/ant Maxwell 7
TRIMBLE R780-2	GPS L1/L2/L5 GLO L1/L2/L3 GAL E1/E5ab/E6
	BDS B1/B2/B3 integrated rec/ant dual Maxwell 7
TRIMBLE R8	L1/L2+L2C integrated receiver/antenna w/ Maxwell-5
TRIMBLE R8 GNSS	L1/L2+L2C/L5 GLO L1/L2 integrated receiver/antenna with Maxwell-5 + SBAS
TRIMBLE R8 GNSS3	L1/L2+L2C/L5 GLO L1/L2 integrated receiver/antenna with Maxwell-6 + SBAS
TRIMBLE R8-4	L1/L2+L2C/L5 GLO L1/L2/L3 SBAS L1/L5 GAL E1/E5A/E5B BDS B1/B2/B3 w/Maxwell-6 integrated receiver/antenna
TRIMBLE R8S	L1/L2+L2C/L5 GLO L1/L2/L3 SBAS L1/L5 GAL E1/E5a/E5b BDS B1/B2 w/Maxwell-6 integrated receiver/antenna (scalable: track types dependent on purchase options)



```
TRMR8_GNSS
TRMR8_GNSS3
TRMR8-4

          . . - -===- - . .
       . - / /- - - - - - -\ \ - .
     /   | |               | |   \
     ====|=|===============|=|====          <--  0.0552  Center
     \   |O|     .- = -.    |0|   /                      of bumper
      |        (       )        |
      :         `- = -'         :
       \=[]=\======x======/====/             <--  0.0000  BAM=ARP
                                                         MMI=NRP
     <--         0.1820        -->
```

Зураг-18 Антенны загвар, нэршил

Тэгшитгэн бодолтын үр дүнг **Хүснэгт-8** -д үзүүлэв.

Хүснэгт-8

№	Цэгийн дугаар	Солбицлууд	
		x	y
1	ГЦТ0478	5304338.205	637103.147
2	ГЦХ012	5310198.256	637067.945
3	ГЦХ013	5312369.003	636532.190
4	ГЦХ014	5312968.512	638907.668
5	ГЦХ015	5313013.638	640762.403
6	ГЦХ016	5313038.56	643002.603
7	ГЦХ017	5312961.975	645188.458
8	ГЦХ018	5312926.873	646567.883
9	ГЦХ019	5311252.859	647718.204
10	ГЦХ020	5311198.586	647996.157
11	ГЦТ0076	5306694.580	649400.949

ТОМ МАСШТАБЫН БАЙРЗҮЙН ЗУРАГЛАЛЫН ӨНДРИЙН ҮНДЭСЛЭЛИЙГ III АНГИАР БАЙГУУЛАХ, ТЭГШИТГЭН БОДОЛТ ХИЙХ

Трассын дагуу байгуулсан өндрийн тулгуур сүлжээг МУ-ын өндрийн сүлжээг өтгөрүүлэх зарчимаар байгуулсан. Өндрийн үндэслэлийг нивелирийн дан сэлгэцээр, дээд ангийн буюу өндрийн II ангийн 30 болон 38 дугаар полигоны Хр-0139, Хр-515 дугаартай ханын маркуудад тулгуурлан нивелирдлэгийн III ангиар, байрлал, өндрийн сүлжээний цэгүүд давхцаж байхаар 13 цэгтэй байгуулсан.

(Жич: Байрлалын сүлжээний цэгүүдэд нивелирдлэгийн III ангиар өндөр дамжуулсан.)

Улсын өндрийн сүлжээний II ангийн ханын марк Хр-0139, Хр-515 өндрийг утгыг **Хүснэгт-9** -д үзүүлэв.

Хүснэгт-9

№	Цэгийн нэр	UTM тэгш өнцгийн солбицол, м		Цэгийн өндөр,Н, м	Тайлбар
		x	y		
1	Хр-515	530405.225	635985.704	1293.4148	II ангийн цэг
2	Хр-0139	5308624.100	648916.000	1313.4548	III ангийн цэг

Нивелирдлэгийг өндрийн II ангийн Хр 515, Хр 0139 ханын маркуудад тулгуурлан 13 репер цэг бүхий задгай сэлгэц байгуулан шууд ба урвуу чиглэлд 33,25 км сэлгэцийн нийт урт 66.5 км байхаар тооцож төлөвлөн хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нивелирдлэгийн хэмжилтийг шууд чиглэлд Хан-Уул дүүргийн 11-р хороонд байрлах 41-р сургуулийн хананд суулгасан Хр 515 марканд тулгуурлан төлөвлөж буй трассын дагуу шинээр байгуулсан репер цэгүүд болон трассын дагуу шинээр суулгасан болон УБ хотын кадастрын зураглалын сүлжээний цэгүүдийг дайруулан нивелирдэж, трассын төгсгөлийг “Авто засвар” ХХК-ийн барилгын урд талын ханан дээр суулгасан Хр 0139 ханын марканд холбосон. Урвуу чиглэлийн

хэмжилтийг Хр 0139 ханын маркаас Хр 515 марк хүртэл хэмжилтийг хийсэн. Тулгуур цэгүүдийг **Зураг-19**, **Зураг-20** -д тус тус үзүүлэв.

Зураг-19 41-р сургуулийн хананд суурилуулсан Хр 515 ханын марк



Зураг-20 “Авто засвар” ХХК-ийн барилгын урд талын ханан дээр суулгасан Хр 0139 ханын марканд

Төлөвлөж буй трассын дагуу өндрийн сүлжээ байгуулахад 1 км-т зогсох зогсоолын тоо олон, уулархаг, нугачаа ихтэй, хэмжилт хийх хугацаа багатай байсан

тул ажлын III зэргийн тодорхойлолтын дагуу Талбайн 1 багт **Геодезийн мэргэшсэн инженер-1**, **Геодезийн инженер -1**, **Геодезийн техникч - 4** хүний бүрэлдхүүнтэй нийт 5 баг хийж гүйцэтгэсэн.

Нивелирдлэгийн III ангийн хэмжилтийн ажлыг 1 км сэлгэцэд өндөржилтийг 3 мм-ээс багагүй алдаатай тодорхойлох нивелирээр шууд ба урвуу чиглэлд хийж гүйцэтгэсэн. Нивелирдлэгийн III ангийн задгай сэлгэцийг байгуулахад доор дурьдсан шаардлагуудыг мөрдөж хэмжлээ. Үүнд:

- Нивелирдлэгийн мөрийн урт (багажаас рейк хүртэлх зай) 100м-ээс хэтрэхгүй байх;
- Зогсоол дээр мөрийн зөрүү 2м-ээс , мөрийн зөрүүгийн хуримтлал 10м-ээс илүүгүй байх;
- Харах тэнхлэгийн өндөр газраас дээш 0.3 м-ээс багагүй байх ;
- Рейкийг башмак дээр, эсвэл гадсан дээр тавина. Дугуй тэгшлүүрээр тэгшилж барина.

Хээрийн ажлын үед дараах шалгалтуудыг хийсэн. Үүнд:

- Дугуй тэгшлүүрийн шалгалтыг өдөр бүр ажил эхлэхийн өмнө хийнэ.
- Тангенсын (i) алдааг өдөр бүр ажил эхлэхийн өмнө шалгаж тодорхолсон. Хэмжилт зөвшөөрөгдөх алдаанаас их болсон тохиолдолд хяналтын хэмжилт хийж шалгасан.

Өндрийин сүлжээний бүдүүвчийг **Зураг-21**, Хэмжилтийн явцыг **Зураг-22** -т үзүүлэв.



	Нивелирдлэгийн 3-р ангийн өндрийн сүлжээний бүдүүвч			
"БАЯСАХ СУРВЭЙ" ХХК	"Баясах Сурвэй" ХХК геодезийн инженер	Төслийн нэр	Байршил	Огноо
	Т.Даллхан	" Шинэ тойрог зам"	" Улаанбаатар хот "	2025-04-20

Зураг-21

Зураг-22

Нивелирдлэгийн III ангийн сүлжээг тэгшитгэж бодохын өмнө олон өнцөгтүүдэд нивелирдлэгийн алдаа тодорхой зөвшөөрөгдөх хэмжээндээ байгаа эсэхийг шалгасан. Шууд ба урвуу нивелирдлэгийн өндөржилтийн нийлбэрийг тус тусад нь хоорондох зөрүүгээр нь алдааг бодсон. Нивелирдлэгийн III ангид энэ зөрүү нь 3 мм-ээс ихгүй юм. Ийнхүү шалгаж дууссаны дараагаар нивелирдлэгийн ажлыг тэгшитгэн бодсон.

Хэмжилтийн зөвшөөрөгдөх алдааг дараах томъёогоор бодсон. Үүнд:

$$\text{зөв}f = \pm 10 \text{ мм}\sqrt{L}, \text{км}$$

Хос хэмжилтийн нарийвчлалын үнэлгээг Бесселийн томъёогоор бодсон. Үүнд:

$$m = \sqrt{\frac{[d^2]}{n-1}}$$

Хээрийн хэмжилтийн журналыг **Хүснэгт-10** -д, Хр-515-ээс Хр-0139 хүртлэх тэгшитгэн бодолтын үр дүнг **Хүснэгт-11**, нарийвчлалын үнэлгээг **Хүснэгт-12** -т тус тус харуулав.

Хүснэгт-10

Нивелирдлэгийн III ангийн журнал					
Хэмжилт: ГЦТ-0478-аас ХР-0139			Хэмжилт хийсэн. Т.Дөлгөөн		
Хэмжилт эхэлсэн :2025-04.20			Хэмжилт дууссан: 2025-04.30		
Харагдалт :			Цаг агаар:		
Журнал хөтөлсөн:			Д. Саранчимэг		
Зогсоолын дугаар	Харсан цэгийн дугаар	Зай,м	Рейкнээс авсан тоолол, м		Хэмжсэн өндөржилт, м
			арын	өврийн	
1	ГЦТ-0478	44.493	1.1599		
	x1	44.485		1.3204	-0.1605
		0.01			
2	x1	45.221	1.3804		
	x2	45.284		1.0975	0.2829
		-0.06			
3	x2	39.464	1.8750		
	x3	39.210		1.3178	0.5572
		0.25			
4	x3	33.400	1.9923		
	x4	33.738		0.5807	1.4116
		-0.34			
5	x4	8.677	2.3927		
	x5	8.149		0.8628	1.5299
		0.53			
6	x5	34.374	1.0727		
	x6	35.499		2.0899	-1.0172
		-1.13			
7	x6	44.713	0.6581		
	x7	44.214		1.7170	-1.0589
		0.50			
8	x7	28.927	1.4025		
	x8	28.827		1.2540	0.1485
		0.10			
9	x8	26.335	1.5025		
	x9	26.320		1.1630	0.3395
		0.02			
10	x9	27.919	1.9385		
	x10	27.527		0.7075	1.2310
		0.39			

Хүснэгт-11

Геометрийн нивелирдлэгийн III ангийн тэгшитгэн бодолтын хүснэгт

д/д	цэгийн дугаар	Зай,м	өндөржилт, м				засварласан өндөржилт, м	Цэгийн өндөр, м
			шууд,м	урвуу,м	дундаж,м	засвар,м		
	ГЦТ-0478							1271.598
1		23.687	0.109	-0.111	0.11	0.001	0.111	
	ГЦХ-0011							1271.709
2		19.691	3.779	-3.78	3.779	0.001	3.781	
	ГЦТ-0051							1275.490
3		26.164	95.833	-95.806	95.819	0.001	95.821	
	ГЦХ-0012							1371.310
4		18.372	-44.791	44.806	-44.798	0.001	-44.797	
	ГЦТ-0122							1326.513
5		20.693	25.858	-25.852	25.855	0.001	25.857	
	ГЦХ-0013							1352.370
6		31.775	162.357	-162.357	162.357	0.001	162.358	
	ГЦХ-0014							1514.728
7		38.974	-101.997	101.978	-101.987	0.001	-101.986	
	ГЦХ-0015							1412.742
8		30.881	-74.823	74.84	-74.831	0.001	-74.83	
	ГЦХ-0016							1337.912
9		25.218	28.857	-28.887	28.872	0.001	28.873	
	ГЦХ-0017							1366.785
10		20.274	59.693	-59.679	59.686	0.001	59.687	
	ГЦХ-0018							1426.472
11		26.252	-26.741	26.736	-26.739	0.001	-26.737	
	ГЦХ-0019							1399.735
12		34.631	-46.862	46.847	-46.854	0.001	-46.853	
	ГЦХ-0020							1352.882
13		15.91	-39.433	39.426	-39.429	0.001	-39.428	
	RP0139							1313.454
∑		**33.252**	**41.839**	**-41.84**	**41.839**	**0.017**	**41.856**	

онолын өндөржилт, м	41.8558
хэмжилтийн алдаа	-0.0165
зөвшөөрөгдөх алдаа, мм	57.6647
засвар, м	0.0013

Геометрийн нивелирдлэгийн III ангийн тэгшитгэн бодолтын нарийвчлалын үнэлгээ хийсэн хүснэгт

Хүснэгт-12

Д/д	Шууд (м)	Урвуу (м)	Зөрүү d (м)	Зөрүү d(mm)	d^2(mm)
1	0.1087	-0.1108	-0.002	-2.1	4.41
2	3.7786	-3.7799	-0.001	-1.3	1.69
3	95.8062	-95.8062	0.000	0	0
4	-44.7911	44.8057	0.015	14.6	213.16
5	25.8584	-25.8524	0.006	6	36
6	162.357	-162.3566	0.000	0	0
7	-101.9968	101.9778	-0.019	-19	361
8	-74.8225	74.8395	0.017	17	289
9	28.8876	-28.8866	0.001	1	1
s10	59.6925	-59.6793	0.013	13.2	174.24
11	-26.7413	26.7362	-0.005	-5.1	26.01
12	-46.8619	46.8469	-0.015	-15	225
13	-39.4326	39.4258	-0.007	-6.8	46.24
∑	**41.8424**	**-41.83993**	**0.00250**	**2.5**	**1377.75**

m 10.2947 мм

m_x 5.147348 мм

энд: m-хэмжилтийн дундаж квадрат алдаа,

m_x-нэгж хэмжилтийн дундаж квадрат алдаа,

d- хос хэмжилтийн ялгавар

III ангийн нивелирдлэгийн үр дүнгээс харахад сэлгэцийн зөвшөөрөгдөх алдаа 57.7 мм, хэмжилтийн алдаа 16.5 мм, хэмжилтийн дундаж квадарат алдаа 10.3 мм байгаа тул БД 11-121-19 дүрмийн шаардлагыг хангаж байна.

3. 1:500 МАСШТАБЫН БАЙРЗҮЙН ДЭВСГЭР ЗУРАГЛАЛЫН АЖИЛ

3.1. УРЬДЧИЛАН ТӨЛӨВЛӨСӨН ТРАССЫН ЭХНИЙ ХУВИЛБАРЫН ДАГУУ ТАНИХ ЦЭГҮҮДИЙГ ГАЗАРТ БАЙГУУЛЖ, ТЭМДЭГЛЭХ

1:1000-ны масштабын 0.5 м үеийн өндөр бүхий байр зүйн тоон зураглал үйлдэх, боловсруулах үйлдэх ажлыг нийт 1080 га талбайд, үүнээс онцлох талбай буюу гуу жалга бүхий 20 га талбайд агаарын зураглалын аргаар хийж гүйцэтгэв. Нислэг зураглалын ажлыг 2025 оны 2 дугаар сарын 06-наас 2025 оны 2 дугаар сарын 14 хүртэл 9 хоног буюу өдөрт дундажаар 80 га талбайд зураг авсан. Энэ ажлыг Монгол улсад мөрдөж байгаа “1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил” (БД 11-106-08) болон бусад холбогдох зааврууд ыг баримтлан ITRF 2020 солбицлын ба Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд гүйцэтгэсэн болно.

Төлөвлөж буй авто замын трассын тэнхлэгээс 2 тийш 200, 200 м зурвасаар буюу 400, гуу жалга бүхий ус хагалбар, ус цуглуулах талбай бүхий газарт 600 м өргөн зурвасын дагуу агаарын зураглалыг ННТ-өөр хийсэн.

Нислэг,зураглалын ажлын технологийн схемийн дагуу хийж гүйцэтгэсэн. Технологийн схемийг **Зураг-23** -д үзүүлэв.



Зураг-23

Агаарын зургийг геодезийн солбицол, өндрийн тогтолцоонд холбохын тулд газар дээрх солбицол, өндөртэй 170 цэгүүдийг агаарын зурагт таниулсан. Агаараас зураг авах параметрүүдийн сонголтыг дараах байдлаар хийлээ. Үүнд:

- GSD-ийн утга нь байр зүйн зургийн масштаб, түүний нарийвчлалаас хамаарах тул 1:100-1:1000 масштабын зураглалд 0.01≤GSD≤0.05 (м) буюу GSD= 3 см утгыг сонгосон.
- Нислэгийн өндөр. Хэмжилтэнд ашиглаж байгаа Тоон камер DJIL1 үндсэн үзүүлэлтийг 5 дугаар, нислэгийн өндрийг 6 дугаар хүснэгтэнд харуулав.

  Нислэгийн өндрийг дараах томъёогоор бодож олсон Үүнд:

  H=10*GSD*f/Pxl (1)

  Энд: H-нислэгийн өндөр, м

  GSD-Агаарын зургийн зэрэгцээ 2 пикселийнтөв хоорондох зайны газар дээрх зайг илэрхийлэх утга, см

  f – фокусын зай, м

  Pxl- камерын пикселийн бодит хэмжээ, мкм

Хүснэгт-13

Тоон камер DJIL 1 – Үндсэн үзүүлэлт

Камерын нэр	Фокусын зай, мм	Камерын пиксел
DJIL1 тоон камер	8.8мм/24 мм (эквивалент)	19.96 mega pixels
DJIL1 лидар	--	--

Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн техник, тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг дараах байдлаар харуулав. Үүнд:

Брэнд: DJI

Загвар: Zemnuse P1,L1

Тоног төхөөрөмжийн үзүүлэлт

Мэдрэгчийн хэмжээ- 1inch

Пиксел-20MP

Зургийн хэмжээ: 5472*3078 (16:9); 4864*3648 (4:3); 5472*3648 (3:2)

Нисэх үеийн орчны температур (хамгийн ихдээ) - -20^0 ооc $+50^0$C

Зургийн формат:JPEG

Хэмжилтийн нарийвчлал: (RMS 1o)^2 - 100м-т 3см

<u>Дагалдах хэрэгсэл:</u>

- *Zemnuse P1*

- *Zemnuse L1*

Тоон камер болон лидарын үзүүлэлт: **Зураг-24**

Хүснэгт-14

Камерын GSD -ээс хамаарсан нислэгийн өндөр, м

№	Фокусын зай, мм	Сенсорын хэмжээ,мм	Зургийн хэмжээ, пиксель	GSD, см	Дагуу давхцал %	Хөндлөн давхцал %	Нислэгийн өндөр, м
1	8.8	13.2x8.8	5472x3648	3	70	60	109

- Холболтын болон хяналтын цэгийг газарт дараах хэмжээгээр тэмдэглэсэн. Үүнд: дотор хүрээ- R=2xGSD=6см, гадна хүрээ R=4xGSD=12см бүхий 15-20 см дугуй тэмдэглээсийг газарт зураглах талбайн гадаргаас ялгарах өнгийг сонгоно гэсэн зааврын дагуу улаан өнгийн будгаар будсан. Агаарын зургийн холболтын болон хяналтын таних цэгүүдийн хоорондох зайг шугаман нислэг үйлдэж байгаа учраас 250-350 м байхаар төлөвлөсөн. Агаар, сансрын зураглалын ажил гүйцэтгэх барилгын норматив баримт бичгийн заалтын дагуу газрын таних цэгүүдийг хамгийн багадаа агаарын зургийн хамрах талбайн булан ба төв хэсэгт төлөвлөнө гэсэн заалтыг баримталж ажилласан.
- Байрлал-өндрийн холболтын болон хяналтын цэгүүдийн байрлалыг 0.01м, өндрийг 0.02 м нарийвчлалтайгаар нислэг үйлдэхийн өмнө МУ-ын Үндсэн сүлжээний А ангийн байнгын суурин UB 01 станцын өгөгдөлд тулгуурлан Улаанбаатар хотын 2018 оны геоидийн загвар “mongeoid-ub2018.grd” ашиглаж хэмжсэн. GNSS-ийн бодит агшины “контрол” горимоор 30 секундын хугацаагаар хэмжсэн. Газарт байгуулсан таних цэгүүд болон түүн дээрх хэмжилтийг **Зураг-25**, агаарын зураг дээрх таних цэгүүдийн байрлалыг **Зураг-26** зурагт үзүүлэв.

Газарт байгуулсан таних цэгүүд болон түүн дээрх хэмжилт: **Зураг-25**

Агаарын зураг дээрх таних цэгүүдийн байрлал: **Зураг-26**



3.2. ЗАМНАЛУУДААР НИСЧ ЗУРАГ АВАХ

Агаарын зураглал үйлдэх талбайн геодезийн сүлжээний цэгүүдийн судалгааг суурин аргаар хийж, зураглалын үндэслэлд зориулан геодезийн сүлжээг С ангийн 3-р зэргээр 7 цэгтэйгээр төлөвлөж хэмжсэн.

Төслийн трассын дагууд инженер-геологи, геотехникийн судалгааны 18 цооног, гидрогеологийн судалгааны зорилготой 1 цооног тус тус өрөмдсөн. Инженер геологийн судалгааны цооногуудад дараах байдлаар гүний ус илэрсэн байна /Хүснэгт II-29/.

Хүснэгт II-29 Газар доорх ус илэрч, тогтсон гүн /2025/05/16-2025/05/27-ны байдлаар/

Цооногийн дугаар	Цооногийн байршил	Газрын доорх усны түвшин, м	
		илэрсэн	тогтсон
Ц-1	Гүүр-1	6.8м,27.2м	6.0 м
Ц-2	Гүүр-1	6.2м	4.5м
Ц-3	Гүүр-1	4.2м	4.0м
Ц-4	Гүүр-1	2.2м	2.2м
Ц-6	Гүүр-2	8.4м	6.0м
Ц-7	Гүүр-2	6.0м	6.0м
Ц-10	Гүүр-3	3.0м	2.0м
Ц-12	Гүүр-4	4.4м	2.0м
Ц-13	Гүүр-4	2.0м	0.6м
Ц-14	Гүүр-5	2.8м	2.8м
Ц-16	Гүүр-5	9.0м	6.0м
Ц-17	Гүүр-5	9.0м	6.0м
Ц-18	Гүүр-6	9.0м	9.0м



Зураг II-5 Улаанбаатар хотын Гидрогеологийн зураг

“Шинэ Тойрог Авто Зам 1” трассын дагууд Гидрогеологийн нөхцлийн хувьд Улаанбаатар хотын баруун, зүүн болон хойд хэсгээр өрөмдөгдөж буй цооногууд нь усжилт харьцангуй бага, инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтын шатанд газрын доорх уснаас үзүүлэх хүндрэл харьцангуй бага байх боломжтой зэргийг үндэслэн Ц-1 дугаартай цооногийг гидрогеологийн туршилт-шавхалт хийх, үндсэн чулуу хүртэл өрөмдөх зорилготойгоор төлөвлөсөн /*Зураг II-6*/. Тухайн байршил нь баруун талаар Мах комбинатын эх үүсвэр, зүүн урд талаар Үйлдвэрийн эх үүсвэр зэрэг ихээхэн ундаргатай Улаанбаатар хотын усан хангамжийн эх үүсвэрүүдтэй ойр байрлана. Тухайн цэг орчим нь трассын дагуу дахь хамгийн өндөр шүүрэлтийн итгэлцүүртэй мөн зузаан уст давхаргатай зэрэг хүндрэлүүдийг Улаанбаатарт хийгдэж байсан гидрогеологийн ажлуудын тайлангуудтай танилцан сонгосон.

Зураг II-6 Гидрогеологийн судалгааны цооногийн байршил

Инженерийн гидрогеологийн өрөмдлөгийн ажлыг дэс дараалсан системээр гүйцэтгэж, дараах асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: Гидрогеологийн өрөмдлөг хийсэн тухайн цэгийн геологийн зүсэлтийн гүний бүтэц, түүний литологи-чулуулаг зүйн бүрэлдэхүүн болон судалгааны талбайн геологийн тогтоц, давхарга зүйн байдал, гидрогеологийн байгалийн үндсэн нөхцлийг нарийвчлан судалж, өрөмдлөгийн явцад

илэрсэн тодорхой насны хурдас, чулуулгийн зузаалгийг тэдгээрийн литологи-чулуулаг зүйн бүрэлдэхүүний өвөрмөц онцлогоор нь ялгаж ангилсан болно.

Цооногийг өрөмдөхдөө АНУ-н Canterra CT550 маркын өрмийн машинаар хийн цохилтын аргаар хийж гүйцэтгэсэн. Судалгааны цооног нь 219 мм-н яндан шүүрийн цувааг суулгаж тоноглон шавхалтын ганцаарчилсан цооногийн хэлбэрээр гүйцэтгэж мэдээлэл бүрдүүлэх зорилтыг хангахаар төлөвлөсөн.

Зураг II-7. Мониторингийн цооног өрөмдлөгийн ажлын явц

Өрөмдлөгийн явцад нэг метр тутмаас шаламын дээжлэлт хийж цооногийн гүний чулуулаг зүйн бүрэлдэхүүн болон уст үе усжсан бүсийн зузааныг тодорхойлсон. Өндөр ундаргаар туршилт-шавхалтын ажлыг гүйцэтгэсэн мэдээллээр уст үе давхаргын параметрүүдийн бодит нөхцлийг зөв тодорхойлон тооцох боломжийг бүрдүүлсэн. Шавхалтын цооногт 219 мм-н ган хоолойг 20 см-ын урт, 3 мм-ын өргөн зүсэлтээр цуулбарлан зүсэж бэлтгэсэн ба шүүрүүдийн ажлын уртыг цооногуудын төрөл, уст үеүдийн зузаанд уялдуулан дээрх дурдсан хэмжээгээр сонгож аргачлалын дагуу уст үеүдийг бүрэн хэмжээгээр хамруулан тоноглосон.

Зураг II-8 Цооногт тоноглосон шүүрийн хийц

Гидрогеологийн цооногт шаардлагатай гүнд яндан-шүүрийн цуваг суулгаж, зохих төрлийн шавхалтыг явуулж, гидрохимийн дээжлэлт, гидрогеологийн ажиглалт, шаардлагатай хэмжилтийг гүйцэтгэх боломжийг бүрдүүлж, түүнчлэн гидрогеологийн холбогдох туршилт-шавхалтын ажилбартай шууд холбоотой багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглолыг тухайн өрөмдсөн цооногт байршуулж угсарч бэлтгэсэн.

Нэг түвшний бууралттай ганцаарчилсан туршилт-шавхалтын үр дүнгээр тухайн цооногийн гидрогеологийн анхан шатны өгөгдлийг (ундарга, түвшний бууралт, усны хөдөлгөөнт ба тогтонги түвшний гүний байршил зэрэг) хээрийн тусгайлан тоноглосон туршилт-шавхалтын иж бүрэн тоноглолоор хийсэн ба ундаргыг зориулалтын тоолууpаар хэмжиж баталгаажуулан хяналтын хэмжилтийг түвшин хэмжигчээр хийж мэдээллийг тодорхойлсон /*Зураг II-9*/. Нэг түвшний бууралттай ганцаарчилсан цооногийн шавхалтыг 24 цаг явуулсан болно.

Зураг II-9 Ундарга тодорхойлох тоолуур Б. Шавхалтын тэмдэглэл үйлдэж буй явц

Туршилт-шавхалтын үед татаж буй усыг баруун тийш 200 метрийн зайд байрлах үерийн далан бүхий толгойт гол руу цутгасан ба энэ нь шавхалтын явцад туршилт-шавхалтын цооног руу чиглэсэн усны нэвчилт байхгүй хийгдэж байгаа юм.

Зураг II-10 Туршилт-шавхалтын ус хаялга

Туршилт-шавхалтын төгсгөлд дээж авах, тээвэрлэхдээ “Унд ахуйн хэрэгцээний, үйлдвэрийн ус хангамжийн зориулалттай ус. Химийн шинжилгээний дээж авах аргачлал” MNS 3934:1986, Гүний уснаас дээж авах зөвлөмж” MNS ISO 5667-11:2000 стандартын дагуу 1.5 л багтаамжтай цэвэр усны саванд авсан. Дээж авахдаа дээжийн савыг туршилт-шавхалтын усаар 2 удаа зайлж, савыг дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн явцад сэгсрэгдэх, хүчил төрөгчтэй тухайн дээж харилцан үйлчлэлд орохыг хязгаарлана. Дээжийг харанхуй, сэрүүн нөхцөлд хүйтэн баригч саванд хадгалж тээвэрлэсэн болно.

Судалгааны талбайд тархсан газар доорх ус нь химийн бүрэлдэхүүнээрээ:

- Цооног-1: Сульфатийн ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу, шим бохирдолтой булингар ихтэй ус байна.
  Усний найрлагын томьёо: $M_{2.2}\ \underline{SO_4^{-2}33HCO_3^{-}32Cl^{-}26}$
  $Ca^{2+}59+Mg^{2+}25Na^{+}+K^{+}14$
- Цооног-7: Сульфатийн ангийн, холимог бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу, шим бохирдолтой булингар ихтэй ус байна.
  Усний найрлагын томьёо: $M_{2.2}\ \underline{SO_4^{-2}50HCO_3^{-}26Cl^{-}18}$
  $Na^{+}4+K35CA^{2+}33Mg^{+}32$

- Цооног-12: Гидрокарбонат ангийн , кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, маш хатуу, шим бохирдолтой, булингар ихтэй ус байна.
  Усний найрлагын томьёо: $M_{0.8}$ $\underline{HCO_3^-39SO_4^{2-}28Cl^-25}$
  $Ca^{2+}59Mg^{2+}25Na^{+}+K^{+}14$
- Цооног-13: Гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар, шим бохирдолтой, булингар ихтэй ус байна.
  Усний найрлагын томьёо: $M_{0.6}$ $\underline{HCO_3^-64SO_4^{2-}17Cl^-15}$
  $Ca^{2+}49Mg^{2+}27Na^{+}+K^{+}23$

Зураг II-11 Туршилт-шавхалтын цооногийн усны дээж

Гидрогеологийн судалгааны үе шатанд илрүүлсэн харьцангуй өндөр усжилттай дөрөвдөгчийн настай аллювийн гаралтай сэвсгэр хурдас чулуулгийн зузаалаг дахь нүх сүвийн усжсан бүсийн гидрогеологийн тооцооны үндсэн параметр (шүүрлийн итгэлцүүр, ус дамжуулалт, усны түвшин өөрчлөлтийг дамжуулах чадварын итгэлцүүр)—ийг нарийвчлан тогтоох шаардлагатай юм. Дээрх харьцангуй өндөр усжилттай бүсийн гидрогеологийн тооцооны үндсэн параметрүүдийг нарийвчилан тогтоосноор гидрогеологийн цооногт ашиглалтын хугацааны төгсгөлд түвшний тооцооны бууралт буюу ус олборлолтын үйл ажиллагааны ачаалал даах чадамжийг үнэлж тогтоох гол үзүүлэлтүүд болно.

Туршилт-шавхалтын түвшний хэмжилт, цооногийг хийц болон уст үеийн мэдээллийг ашиглан Aquifer Test Pro программ хангамж болон Дюпюигийн дараах аналитик тэгшитгэлээр шүүрэлтийн итгэлцүүрүүдийг тооцсон.

$$К = \frac{0.73Q \cdot LgR_0/r_0}{(2H - S_0)S_0}$$

К – усжсан бүсийн шүүрлийн итгэлцүүр, м/хон.

Q - дээжлэлтийн болон туршилт-шавхалтын үед тогтоосон гидрогеологийн цооногийн ундарга, $м^3$/хон /2760 м3/хоног./

r_0 – гидрогеологийн цооногийн радиус, /0.1 м/

S_0 - гидрогеологийн судалгааны цооног дахь усны түвшний бууралт, м /1.72 м/

Н – гидрогеологийн тухайн цооногт илэрсэн уст үе давхаргын зузаан, м /2760 м/

R_0 – газрын доорх усны шүүрэх хөдөлгөөний тогтонги горимын нөхцөлд гидрогеологийн цооногт үүсэх боломжтой шавхалтын нөлөөллийн шилжүүлсэн радиус, м. Лавлахын мэдээллээр түрлэггүй чөлөөт гадаргуутай газрын доорх усанд 150-200 м-ээр авдаг. Манай нөхцөлд 150 м-ээр шууд сонгон авсан.

$$K = \frac{0.73*2760}{(2x22.85-1.72)\times 1.72} lg\frac{150}{0.1} = 84.59 \text{ м/хон.}$$

II.8. Гидрологийн нөхцөл

Төслийн талбай нь Толгойт голын хөндий болон Сэлбэ голын хөндийг дайран өнгөрч байгаа /*Зураг II-12*/.



Зураг II-12 Автозамын трассын дагууд байгаа Гидрологи буюу гадаргын усан сүлжээний байршил

Монгол орны гол, мөрний урсцын горимын онцлог хаврын шар усны үер дууссаны дараа 5-6 сард богино хугацаанд гачиг үе үргэлжлээд зуны хур борооны үе эхэлдэг. Туул гол болон түүний цутгал голууд ба зарим хөндий дэх сайрууд нь зөвхөн зуны хур борооны гаралтайгаар үерлэдэг.

Улаанбаатар хот орчмын уулсаас эх авсан жижиг гол, гуу жалга, сайруудын ус цуглуулах талбайд хайрга чулуу, хайрганаас шавранцар мөхлөг бүхий хурдас тархсан бөгөөд Монгол орны уруйн үер хүчтэй болж өнгөрөх мужид хамрагддаг байна. Байгалийн гамшигт үзэгдлүүдийн нэг болох усны үер Туул гол болон түүний цутгалуудад жил болгон тохиолддог.

Харин хэдийд ямар хэмжээний үер болохыг урьдчилан мэдээлэх нь төвөгтэй бөгөөд нарийн судалгаа шаардагдана. Хур борооны үерийн хамгийн их урсцыг нарийн зөв тооцох нь эдийн засгийн болон усны барилга байгууламж, зам байгуулахад тооцооны чухал үндэс болдог. Иймд их урсцын тооцоо нь шинжлэх ухааны нарийн үндэслэлтэй үнэн бодит байх нь зүйтэй юм



Зураг II-13 Төслийн хамрах хүрээ ба геоморфологийн хэв шинж

Төслийн бүтээн байгуулалтад өртөгдөх байршлууд

Автозамын трассын дагуу 8 байршилд гадаргын усны урсац огтлолцох буюу үерийн эрсдэл үүсгэх боломжтой цэг байгааг сансрын тоон мэдээ болон гидрологийн тооцооллын ArcSWAT программ хангамжийг ашиглан тогтоосон.



Зураг II-14 Ус хурах талбайн тооцоолол

Дээрх байршлуудыг 8 хуваасан ба дугаарлалтын дагуу үерийн тооцооллын хэсэгт тусгасан болно.

Үерийн тооцоолол

Дээр дурдсан 8 үерийн эрсдэл бүхий амнуудыг доорх хүснэгтэд нэр, трасстай огтлолцох цэгийн байршил болон ус хурах талбайг үзүүллээ.

Хүснэгт II-30 Үерийн эрсдэл бүхий байршлууд

№	Нэршил	Байршил		Ус хурах талбай, га
		Уртраг	Өргөрөг	
1	Ханын материалын эцсийн ам	5311003	636282	38.17
2	Баянхошууны ам 1	5312845	638524	39.04
3	Баянхошууны ам 2	5312978	639385	65.37
4	Дэнжийн 1000 ам	5312909	640871	179.39
5	Хайлаастайн ам	5312891	642422	496.99
6	Сэлбэ гол	5312959	643809	27158.73
7	Ганц худгийн ам	5313466	646031	812.86
8	Монелийн ам	5311397	647181	255.97

Ханын материалын эцсийн ам

Энэхүү ам нь автозамын трассын дээр 38.17 га талбайгаас ус цуглуулах ба 1%-н хангамшилтай үед 6.17 $м^3$/сек, 5%-н хангамшилтэй үед 4.1 $м^3$/сек, 10%-н хангамшилтэй үед 3.3 $м^3$/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй.

Зураг II-15 Байршил 1 Ханын материалын эцэс орчмын ам

Байршлын зургаас харахад тухайн байршлын ус хурах талбай нь ихээхэн хэмжээгээр газрын гадарга хөндөгдсөн байгаа нь үерийн үед үерээс илүүтэйгээр том хэмжээний

хурдас агуулсан уруй үүсэх эрсдэлтэй байна. Иймд тухайн байршлын өнгөрөлтийг зохицуулах автозамын хоолой гүүрний дээд хэсэгт хэд хэдэн том хэмхдэст хурдсыг саатуулах хөндлүүрүүдийг хийж өгөх нь замын эвдрэл гэмтлээс сэргийлэх юм.

Баянхошууны ам 1

Энэхүү ам нь автозамын трассын дээр 39.04 га талбайгаас ус цуглуулах ба 1%-н хангамшилтай үед 6.30 $м^3$/сек, 5%-н хангамшилтэй үед 4.2 $м^3$/сек, 10%-н хангамшилтэй үед 3.3 $м^3$/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй.

Зураг II-16 Байршил 2 Баянхошуу-1

Тухайн байршилд автозамын трассын дагуу туннелийн байгууламжийн баруун амыг төлөвлөж өгсөн байгаа нь харагдаж байгаа ба тухайн байршилд үерийн ус өнгөрүүлэх инженерийн байгууламж төлөвлөж өгөх шаардлагатай. Тус үерийн далан эсвэл гүүр хоолойг үерийн тооцоололд тааруулан сонгох нь зүйтэй.

Баянхошууны ам 2

Энэхүү ам нь автозамын трассын дээр 65.37 га талбайгаас ус цуглуулах ба 1%-н хангамшилтай үед 13.9 $м^3$/сек, 5%-н хангамшилтэй үед 5.4 $м^3$/сек, 10%-н хангамшилтэй үед 4.3 $м^3$/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй.

Зураг II-17 Байршил 3 Баянхошуу-1

Тухайн байршилд автозамын трассын дагуу өөр автозамтай огтлолцож байгаа ба замын уулзвар хэсэгт хоолой гүүр зайлшгүй төлөвлөж өгөх шаардлагатай.

Дэнжийн 1000 байршлын ам

Энэхүү ам нь автозамын трассын дээр 179.39 га талбайгаас ус цуглуулах ба 1%-н хангамшилтай үед 13.4 $м^3$/сек, 5%-н хангамшилтэй үед 9.3 $м^3$/сек, 10%-н хангамшилтэй үед 1.4 $м^3$/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй.

Зураг II-18 Байршил 4 Баянхошуу-1

Тухайн байршилд мөн автозамын трассын дагуу өөр автозамтай огтлолцож байгаа ба замын уулзвар хэсэгт хоолой гүүр зайлшгүй төлөвлөж өгөх шаардлагатай.

Хайлаастын ам

Хайлаастын ам нь автозамын трассын дээр 496.99 га талбайгаас ус цуглуулах ба 1%-н хангамшилтай үед 25.7 м^3/сек, 5%-н хангамшилтэй үед 17.7 м^3/сек, 10%-н хангамшилтэй үед 9.2 м^3/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй.

Зураг II-19 Байршил-5 Хайлаастын ам

Хайлаастын ам нь томоохон ус хурах талбай бүхий үерийн эрсдэл өндөртэй ам юм. Гэвч тухайн байршилд гүүрэн байгууламж төлөвлөсөн байгаа нь үерийн эрсдэлээс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Сэлбэ гол

Сэлбэ голын дагууд олон тооны үерийн судалгаанууд хийгдэж байсан байдаг ба тухайн судалгаануудаас хамгийн сүүлд хийгдсэн нь "**Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө**" юм. Тухайн тайланд тусгаснаар автозамын байрлалтай хамгийн ойр байрлалд 0.1%-н хангамшилтай үед 626.8 м^3/сек, 1%-н хангамшилтай үед

401.8 м^3/сек, 5%-н хангамшилтэй үед 277.2 м^3/сек, 10%-н хангамшилтэй үед 221 м^3/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй гэж тооцоолсон байдаг байна.



Зураг II-20 Байршил 6 Сэлбэ гол

Сэлбэ гол нь маш том ус хурах талбай бүхий үерийн эрсдэл өндөртэй ам юм. Гэвч тухайн байршилд гүүрэн байгууламж төлөвлөсөн байгаа нь үерийн эрсдэлээс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Ганц худгийн ам

Энэхүү ам нь автозамын трассын дээр 812.86 га талбайгаас ус цуглуулах ба 1%-н хангамшилтай үед 23.22 м^3/сек, 5%-н хангамшилтэй үед 15.6 м^3/сек, 10%-н хангамшилтэй үед 12.4 м^3/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй.

Зураг II-21 Байршил 7 Ганц худгийн ам

Тухайн байршлын геоморфологийн зүй тогтлоос харахад уулсын хажуу ихээхэн налуутай, дээрээс уруй байнга үүсдэг болохыг харуулах ул мөр ихтэй үерийн өндөр эрсдэлтэй ам болох нь харагдаж байгаа тул гүүр хоолойг дээрх тооцооллын зарцуулгын 5%-н хангамшлаас багагүй байхаар төлөвлөж өгөх нь цаашид үүсэх эрсдэлээс сэргийлэх болно.

Монелын ам

Энэхүү ам нь автозамын трассын дээр 255.97 га талбайгаас ус цуглуулах ба 1%-н хангамшилтай үед 10.8 $м^3$/сек, 5%-н хангамшилтэй үед 7.4 $м^3$/сек, 10%-н хангамшилтэй үед 3.8 $м^3$/сек зарцуулга бүхий үерийн ус өнгөрүүлэх эрсдэлтэй.

Зураг II-22 Байршил 8 Монелын ам

Энэхүү ам нь налуу багатай усны хүчтэй урсгал үүсэх нь харьцангуй бага мэт боловч зарим тодорхой байршилд огцом налуу ихтэй. Ялангуяа автозам огтлолцох хэсэгт налуу ихэссэн байдалтай байгаа нь үерийн өнгөрөлт хүчтэй болох эрсдлийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж болзошгүй.

II.9. Олон жилийн цэвдэг

Судалгааны талбайд олон жилийн цэвдэг хөрс илрээгүй.

III. ТАЛБАЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ

III.1. Хээрийн өрөмдлөгийн ажил

Өрөмдлөгийн аргачлалын хувьд ISO 22475-1:2021 стандартын дагуу УГБ-1ВС, ПБУ-1, УГБ-50М, POWER-6000, SCHRAMM өрмөөр 219-110 мм-н диаметртэй хуурай, эргэлтэт өрмийн аргачлалаар хөрсний байгаль дээрх шинж чанарыг алдагдуулахгүй дээжлэн цооногийн тус бүрийн 10.0-42.0 м хүртэл өрөмдөн түүнээс цааших зорилтот гүний өрөмдлөгийг POWER-6000 өрмөөр PQ, HQ диаметртэй усаар угаалгатай, алмаазан эргэлтэт өрөмдлөгийн аргачлалаар өрөмдөн дээжлэлтийн ажлыг хийсэн болно. Өрөмдлөгийн ажлыг төлөвлөсөн цэгүүдэд ажлын талбай заасан, хөрсний дээжлэлтийг талбай дотор дэлгэн шаардлагатай бичиглэл, мэдээллүүдийг тэмдэглэн ажиллалаа. Үндсэн чулуулагт хүрсэн тохиолдолд 5 м-ээс доошгүй өрөмдлөг хийгдсэн //.

Зураг III-1 Өрөмдлөгийн ажлын явц /Power-6000/, УГВ-1ВС

Судалгааны талбайд нийт 439 тууш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн. Үүнээс сэвсгэр ул хөрсөнд 323.5 тууш метр, хагас хадан болон хадан ул хөрсөнд 115.5 тууш метр өрөмдөв.

III.2. Ул хөрсний дээжлэлт

Судалгааны талбайд тархсан ул хөрс, чулуулгийн дээжлэлтийн ажил нь хээрийн өрөмдлөгийн ажилтай зэрэгцээ явагдсан. БНбД-ийн 11-03-01-ийн заалтын дагуу мөн захиалагчийн хүсэлтийн дагуу ИГЭ тус бүрээс хөрсний зузаан, тогтоц, төлөв байдал, физик шинж чанараас хамааруулан, физик болон механик шинжилгээнд зориулсан эвдэрсэн бүтэцтэй 129 дээж авлаа /*Зураг III-2*/. Хээрийн өрөмдлөгийн нийт ажлын тоо хэмжээний 30%-тай тэнцэх дээжлэлт хийгдсэн.

Зураг III-2 Лабораторийн шинжилгээнд зориулсан ул хөрсний дээжлэлт

III.3. Стандарт пенетрацын туршилт

Судалгааны талбайд хөрсний бат бэхийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор Стандарт Пенетрацын туршилтыг 16 удаа хийсэн байна. Туршилтыг өрөмдлөгийн явцад цооногт илэрсэн хөрсний үе давхаргын тодорхой гүнд гүйцэтгэсэн бөгөөд туршилтад 63.5 кг жинтэй алхыг 760 мм өндрөөс чөлөөтэй унагаж, стандарт хэмжээтэй (гадаад диаметр 50.8 мм, дотоод диаметр 35 мм) цилиндр хэлбэрийн дээж авагчыг хөрсөнд нэвтрүүлнэ.

Дээж авагчийг хөрсөнд 450 мм гүнд нэвтрүүлэх бөгөөд үүнийг 3 үе шатад хуваана. Эхний 150 мм-ийн нэвтрэлтийг багажийг тогтвортой суулгах зориулалттай гэж үзэж, цохилтын тоог тооцоход оруулдаггүй. Харин дараагийн хоёр 150 мм нэвтрэлтийн нийт цохилтын тоог нэгдсэнээр **SPT N-утгыг** тодорхойлж тайланд ашиглалаа.

Хүснэгт III-1 Стандарт Пенетрацын Туршилтын анхдагч үр дүн

Цооногийн дугаар	**Гүн, м**	**Ул хөрсний нэр**	**N^15**	**N^30**	**N^45**	**N_{value}**
Ц-4	2.5	Элсэн чигжээстэй хайрга	51/8			51
Ц-2	12	Элсэнцэр чигжээстэй хайрга	51/10			51
Ц-4	16	Элсэнцэр чигжээстэй хайрга	51/10			51
Ц-16	21	Элсэнцэр чигжээстэй хайрга	51/11			51
Ц-17	9	Элсэнцэр чигжээстэй хайрга	51/15			51
Ц-12	1.2	Шавранцар	23/15	28/15	23/8	51
Ц-13	1.5	Хайргатай шавар	25/15	18/15	28/15	46
Ц-16	11.5	Хайргатай шавар	22/15	22/15	29/15	51
Ц-18	18	Хайргатай шавар	24/15	26/15	21/15	47
Ц-3	18	Шавранцар чигжээстэй хайрга	18/15	24/15	27/15	51
Ц-12	24	Шавранцар чигжээстэй хайрга	19/15	25/15	26/15	51
Ц-12	7	Шавранцар чигжээстэй хайрга	21/15	23/15	22/15	45
Ц-5	1.5	Хайргархаг шавранцар	15/15	18/15	28/15	46
Ц-6	15	Шавар чигжээстэй хайрга	18/15	31/15	20/8	51

Ц-13	7.5	Шавар чигжээстэй хайрга	21/15	25/15	26/11	51
Ц-11	4	Элсэн чулуу өгөршил	20/15	29/15	22/7	51

Туршилтын анхдагч үр дүнгийн боловсруулалтыг Хүснэгт III-2-д нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт III-2 Стандарт Пенетрацын туршилтын үр дүн

Цооногийн дугаар	Гүн, м	Ул хөрсний нэр	N	Нягтын индекс (%)	Дотоод үрэлтийн өнцөг, ϕ°	Эзэлхүүн жин (чийгтэй үе), kN/m^3	Нэг тэнхлэгийн шахалтын бат бэх, кПа	Эзэлхүүн жин (усаар ханасан), kN/m3	Тооцооны даралт, kPa	Нягтын үзүүлэлт
Ц-4	2.5	Элсэн чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-2	12	Элсэнцэр чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-4	16	Элсэнцэр чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-16	21	Элсэнцэр чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-17	9	Элсэнцэр чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-12	1.2	Шавранцар	51				>400	>20,4	>200	Маш хатуу
Ц-13	1.5	Шавар чигжээстэй хайрга	46	65-85	36-41	17,3-22,0				Нягт
Ц-16	11.5	Хайрга агуулсан шавар	51				>400	>20,4	>200	Маш хатуу
Ц-18	18	Шавранцар чигжээстэй	47	65-85	36-41	17,3-22,0				Нягт
Ц-3	18	Шавранцар чигжээстэй	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-12	24	Шавранцар чигжээстэй	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-12	7	Шавранцар чигжээстэй	45	65-85	36-41	17,3-22,0				Нягт
Ц-5	1.5	Шавранцар чигжээстэй	46	65-85	36-41	17,3-22,0				Нягт
Ц-6	15	Шавар чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-13	7.5	Шавар чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт
Ц-11	4	Элсэнцэр чигжээстэй хайрга	51	85-100	>41	>20,4				Маш нягт

III.4. Прессиометрийн туршилт

Судалгааны талбайд хээрийн нөхцөлд цооногт илэрсэн ИГЭ бүрд хөрсний хэв гажилтын модулийг 30 м хүртэлх гүнд цооногт хэвтээ чиглэлтэй статик ачааллын дор түргэн болон хурдавчилсан аргаар тодорхойлов. Энэ нь 50 мм-ийн голчтой 0.6 м-ийн урттай хэсэгт 30 м-ийн хийн болон ус дамжуулах хоолойн тусламжтайгаар азотын хийн даралтат нөлөөн дор үүсэх хөрсний хэв гажилтын модулийн утгыг авна. Хээрийн ажлын явцад прессиометрийн туршилтыг нийт 16 удаа хийгдсэн байна. Туршилтын үр дүнг Хүснэгт III-3-д нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт III-3 Прессиометрийн туршилтын үр дүн

№	Цооногийн дугаар	Туршилт хийгдсэн гүн, м	Хөрсний нэр	Прессиометрийн туршилт										
				P_0, кПа	P_f, кПа	K_h, МПа/м	V_o, см^3	V_f, см^3	σ_0, кПа	E_0, МПа	E, МПа	E_m, МПа	G_m, МПа	E_S, МПа
1	Ц-4	2.5	Элсэн чигжээстэй хайрга	-211	534	679	159.8	172	565	49.14	43.46	43.95	17.91	43.28
2	Ц-2	12	Элсэнцэр чигжээстэй хайрга	261	655	693.5	142.3	157	597	49.64	42.97	43.47	17.12	42.79
3	Ц-4	16.0	Элсэнцэр чигжээстэй хайрга	246	590	711.4	140.9	153.4	503	50.82	44.07	44.51	17.52	43.81
4	Ц-16	21.0	Элсэнцэр чигжээстэй хайрга	220	562	679.5	141	154	533	48.55	42.09	42.52	16.74	41.85
5	Ц-17	9.0	Элсэнцэр чигжээстэй хайрга	230	572	692.2	149.1	162	514	49.77	43.16	43.59	17.16	42.9
6	Ц-12	1.2	Шавранцар	208	548	182.4	88.1	135	330.5	12.66	11.92	12.4	4.37	10.92
7	Ц-13	1.5	Шавар чигжээстэй хайрга	182	524	151.1	88.3	145.5	379	10.53	9.83	10.32	3.63	9.08
8	Ц-16	11.5	Хайрга агуулсан шавар	205	645	225.1	113.7	164	521.8	15.97	15.02	15.64	5.51	13.77
9	Ц-18	18.0	Шавранцар чигжээстэй хайрга	289	577	461	138.8	155	428.8	32.92	28.47	28.83	11.35	28.38
10	Ц-3	18.0	Шавранцар чигжээстэй хайрга	308	747	486.8	139.6	163	565.8	34.89	30	30.56	12.03	30.07
11	Ц-12	24.0	Шавранцар чигжээстэй хайрга	213	695	550.6	122	144.4	484.8	38.9	33.46	34.07	13.41	33.53
12	Ц-12	7.0	Шавранцар чигжээстэй хайрга	199	593	466	122.9	144.6	524.9	32.94	28.35	28.85	11.36	28.39
13	Ц-5	1.5	Шавранцар чигжээстэй хайрга	136	574	217.7	106.5	158	505.9	15.37	13.51	14.1	5.3	13.25
14	Ц-6	15.0	Шавар чигжээстэй хайрга	193	436	389.8	138.9	155	367.9	27.84	24.64	24.96	9.6	24
15	Ц-13	7.5	Шавар чигжээстэй хайрга	170	659	360.9	88.1	122	468.6	24.92	22.21	22.86	8.59	21.48
16	Ц-11	4	Элсэнцэр чигжээстэй хайрга	269	618	556.3	139.7	156	549.9	39.76	34.38	34.82	13.71	34.27

Туршилтын утгуудын тайлбар:

E_0 – Хэв гажилтын модуль (МПа)

E – Уян модуль (тогтворжоогүй) (МПа)

E_m – Даралтын модуль (МПа)

P_o – Анхны даралтын модуль

V_o – Анхны даралтын эзлэхүүний хэв гажилт

P_f – Түр зуурын уян даралт

V_f – Эзлэхүүний хэв гажилт дах түр зуурын уян даралт (ст3)

σ_0 – суурийн хүлцэх ачаалал

μ – Пауссоны коэффициент

a – Бүх төрлийн хөрсний нүх сүвийн даралтын коэффициент (туршилтын утга)

элс	*0*
шавар	*0.1-0.2*
өлөн шавар	*0.15-0.25*
лаг шавар	*0.25-0.5*

III.5. Динамик зондын туршилт

DCP (Dynamic Cone Penetrometer) туршилт нь 8 кг жинтэй алхыг 575 мм өндөрөөс чөлөөтэй унагаж, 20 мм диаметртэй ган конусыг хөрсөнд нэвтрүүлэн, нэг цохилтоор нэвтрэх гүнийг мм-ээр хэмжиж хөрсний нягтрал, даацын үзүүлэлтийг талбай дээр хурдан тодорхойлох хээрийн туршилт юм. Энэхүү туршилтыг судалгааны талбайд нийтдээ 16 удаа хийсэн байна. /Хавсралт-1/

IV. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИ, ГЕОТЕХНИКИЙН НӨХЦӨЛ БА ХӨРС, ЧУЛУУЛГИЙН ФИЗИК - МЕХАНИК ШИНЖ ЧАНАР

Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудаас техноген гаралтай асгамал хөрсний дооройс Плейстоцен-Голоцены настай (Q_{1-2}) бор шаргал өнгөтэй, чийгтэйгээс усаар ханасан элсэн чигжээстэй хайрга; бор шаргал өнгөтэй, хатуугаас уян налархай урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр чигжээстэй хайрга; бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар; бор шаргал, улаан хүрэн өнгөтэй, хатуугаас агилуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй хайрга агуулсан шавар; бор шаргал өнгөтэй, уян налархай урсамтгайн үзүүлэлттэй хайрга агуулсан элсэнцэр; бор шаргал, бор хүрэн өнгөтэй, хатуугаас агилуун, агилуунаас зөөлөн уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавранцар чигжээстэй хайрга; бор шаргал, бор хүрэн өнгөтэй, хатуугаас агилуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрга; элюви-делювийн (*edQ*) гаралтай, бор шаргал, ногоон саарал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр, шавранцар чигжээстэй хайрга болтлоо өгөршсөн элсэн чулуу; бор хүрэн, ногоон саарал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар чигжээстэй хайрга болтлоо өгөршсөн элсэн чулуу; Карбоны настай, Алтан-Овоо формацын элсэн чулуу илэрсэнийг инженер геологийн 10 элемент ангилан Хүснэгт IV-1-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-1 Инженер геологийн элемент

№	Хөрсний нэр	Байгалийн чийг/Урсамтгайн үзүүлэлт	ИГЭ-ийн дугаар	
Плейстоцен-Голоцены гаралтай хөрс-Q_{1-2}				
1	Элсэн чигжээстэй хайрга	чийгтэй/-	ИГЭ-1	1а
		усаар ханасан/-		1б
2	Элсэнцэр чигжээстэй хайрга	-/хатуу	ИГЭ-2	2а
		-/уян налархай		2б
3	Шавранцар	-/хатуу	ИГЭ-3	
4	Хайрга агуулсан шавар	-/хатуу	ИГЭ-4	4а
		-/агилуун		4б
5	Хайрга агуулсан элсэнцэр	-/уян налархай	ИГЭ-5	
6	Шавранцар чигжээстэй хайрга	-/хатуу	ИГЭ-6	6а
		-/агилуун		6б
		-/зөөлөн		6в
7	Шавар чигжээстэй хайрга	-/хатуу	ИГЭ-7	7а
		-/агилуун		7б
Элюви-делювийн гаралтай хөрс – edQ				
8	Элсэнцэр чигжээстэй хайрга	-/хатуу	ИГЭ-8	
9	Шавранцар чигжээстэй хайрга	-/хатуу	ИГЭ-9	

Карбоны настай, Алтан-Овоо формац – C_{1ao}			
10	Элсэн чулуу		ИГЭ-10

БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ /50-01-16/

Судалгааны талбайд тархсан ИГЭ-үүдийг БНбД 50-01-16 стандартаар ангилж, механикийн үзүүлэлтүүд, хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн, тооцооны эсэргүүцэл болон овойлтын зэргийг тооцон өглөө.

Техноген гаралтай хөрс – tQ

Барилгын хог хаягдал агуулсан шавранцар чигжээстэй хайрган үүсгэмэл хөрсний R_0=150 кПа.

ИГЭ-1. Элсэн чигжээстэй хайрга

Бор шаргал өнгөтэй, чийгтэй, усаар ханасан элсэн чигжээстэй хайрган хөрсний ширхгийнбүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг Хүснэгт IV-2-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-2

Хөрсний нэр		Ширхгийн бүрэлдэхүүн, %		
		хайрга	элс	тоос / шавар
Элсэн чигжээстэй хайрга	1а	63.5	29.8	6.7
	1б	60.7	32.3	7.0

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-3-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-3

Хөрсний нэр		Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr
Элсэн чигжээстэй хайрга	1а	0.041	0.44
	1б	0.127	0.94

Элсэн чигжээстэй хайрган хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-4-т нэгтгэн үзүүллээ

Хүснэгт IV-4

Хөрсний нэр		Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
		г/см^3			*хувь*	*нэгжийн хувь*
	1а	2.67	2.23	2.14	23.79	0.248

Элсэн чигжээстэй хайрга	1б	2.68	2.22	1.97	32.04	0.361

Элсэн чигжээстэй хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-аар Хүснэгт IV-5-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-5

Хөрсний нэр		Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*		Тооцооны эсэргүүцэл, *кПа*
		C^{I}	$C^{н}=C^{II}$	φ^{I}	$\varphi^{н}=\varphi^{II}$	$E_{БНбД}$	$E_{пр}$	Ro
Элсэн чигжээстэй хайрга	1а	1.3	2	36	40	45	-	600
	1б	1.3	2	36	40	45	49.1	600

Элсэн чигжээстэй хайрган хөрсний стандарт пенетрацын туршилтын үр дүнг Хүснэгт IV-6-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-6

N value (SPT цохилт / 300 мм) [1 туршилт]					
Хөрсний нэр		Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Туршилтыг зогсоосон тоо[(a)]
Элсэн чигжээстэй хайрга	1б	51	51	51	1

a. Стандарт пенетрацын туршилтын үед 0.3 м-ээс бага нэвтэрсэн бөгөөд N_{value} 51 хүрсэн тул туршилтыг зогсоосон. Тухайн хөрс нь маш нягт болон маш хатуу инженер геологийн элесмент гэж тодорхойлогддог.

Элсэн чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн стандарт пенетрацын туршилтын үр дүнг Peck (1974) болон Bowles (1988)-ийн тооцооны утгуудаас Хүснэгт IV-7-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-7

Хөрсний нэр		Цохилтын тооны засварласан утга, $N_{1(60)}$	Нягтын индекс, %	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Шахалтын бат бэх, кПа	Эзэлхүүнжин (чийгтэй), кН/м^3	Нягтын байдал
Элсэн чигжээстэй хайрга	1б	37	85-100	>41	-	>20.4	Маш нягт

Элсэн чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн прессиометрийн туршилтын үр дүнг Хүснэгт IV-8-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-8

Хөрсний нэр		Хэв гажилтын модуль E_0, мПа			
		Туршилт хийгдсэн тоо	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
Элсэн чигжээстэй хайрга	1б	1	49.1	49.1	49.1

Элсэн чигжээстэй хайрган хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***710 Ом*м,*** усаар ханасан үед ***60 Ом*м*** байна.

Элсэн чигжээстэй хайрган хөрс нь байгалийн нөхцөлдөө ***овойлтгүй*** хөрсөнд нормчлогдоно.

Элсэн чигжээстэй хайрган хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - ***IV.***

ИГЭ-2. Элсэнцэр чигжээстэй хайрга

Бор шаргал өнгөтэй, хатуугаас уян налархай урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний ширхгийнбүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг үр дүнг Хүснэгт IV-9-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-9

Хөрсний нэр		Ширхгийн бүрэлдэхүүн, %		
		хайрга	элс	тоос / шавар
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	61.6	25.7	12.7
	2б	61.4	25.9	12.7

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр Хүснэгт IV-10, Хүснэгт IV-11-д тус тус нэгтгэн үзүүллээ.

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-10-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-10

Хөрсний нэр		Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	0.072	0.63
	2б	0.174	0.97

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-11-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-11

Хөрсний нэр		Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
		г/см³			*хувь*	*нэгжийн хувь*
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	2.70	2.21	2.07	23.41	0.306
	2б	2.69	2.13	1.81	32.44	0.480

Хатуугаас уян налархай урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний төлөв байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-12- д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-12

Хөрсний нэр		Урсалтын хязгаар дахь чийг, W_L	Имрэгдлийн хязгаар дахь чийг, Wp	Уян налархайн тоо, Jp	Урсамтгайн үзүүлэлт, I_L
		нэгжийн хувь			*нэгжийн хувь*
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	0.182	0.133	0.049	-1.34
	2б	0.185	0.138	0.047	0.77

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-аар Хүснэгт IV-13-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-13

Хөрсний нэр		Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*		Тооцооны эсэргүүцэл, *кПа*
		C^I	$C^н=C^{II}$	φ^I	$\varphi^н=\varphi^{II}$	$E_{БНбД}$	$E_{пр}$	Ro
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	11	16	38	44	46	49.6	450
	2б	4	6	38	44	45	-	400

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний стандарт пенетрацын туршилтын үр дүнг Хүснэгт IV-14-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-14

N value (SPT цохилт / 300 мм) [4 туршилт]					
Хөрсний нэр		Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Туршилтыг зогсоосон тоо[(a)]
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	51	51	51	4

а. Стандарт пенетрацын туршилтын үед 0.3 м-ээс бага нэвтэрсэн бөгөөд N_{value} 51 хүрсэн тул туршилтыг зогсоосон. Тухайн хөрс нь маш нягт болон маш хатуу инженер геологийн элесмент гэж тодорхойлогддог.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн стандарт пенетрацын туршилтын үр дүнг Peck (1974) болон Bowles (1988)-ийн тооцооны утгуудаас Хүснэгт IV-15-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-15

Хөрсний нэр		Цохилтын тооны засварласан утга, $N_{1(60)}$	Нягтын индекс, %	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Шахалтын бат бэх, кПа	Эзэлхүүн жин (чийгтэй), кН/м^3	Нягтын байдал
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	49	85-100	>41	-	>20.4	Маш нягт

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн прессиометрийн туршилтын үр дүнг Хүснэгт IV-16-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-16

Хөрсний нэр		Хэв гажилтын модуль E_0, мПа			
		Туршилт хийгдсэн тоо	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
Элсэнцэр чигжээстэй хайрга	2а	4	50.8	48.5	49.6

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***710 Ом*м*** байна.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрс нь байгалийн нөхцөлдөө

-ИГЭ-2а - D=5.36, S_r=0.63 ***сулавтар овойлттой***

-ИГЭ-2б - D=3.45, S_r=0.97 ***хүчтэй овойлттой*** хөрсөнд нормчлогдоно.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – ***IV***

ИГЭ-3. Шавранцар

Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар. Шавранцар хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг Хүснэгт IV-17 -д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-17

Хөрсний нэр	Ширхгийн бүрэлдэхүүн, %		
	хайрга	элс	тоос / шавар
Шавранцар	46.8	31.8	21.4

Шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр Хүснэгт IV-18, Хүснэгт IV-19-д тус тус нэгтгэн үзүүллээ.

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-18-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-18

Хөрсний нэр	Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr
Шавранцар	0.148	0.85

Шавранцар хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-19-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-19

Хөрсний нэр	Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
	г/см^3			*хувь*	*нэгжийн хувь*
Шавранцар	2.72	2.13	1.86	31.55	0.472

Хатуу урсамтгайн үзүүлэлттэй шавранцар хөрсний төлөв байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-20-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-20

Хөрсний Нэр	Урсалтын хязгаар дахь чийг, W_L	Имрэгдлийн хязгаар дахь чийг, Wp	Уян налархайн тоо, Jp	Урсамтгайн үзүүлэлт, I_L
	хувь			*нэгжийн хувь*
Шавранцар	0.278	0.179	0.099	-0.34

Шавранцар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-аар Хүснэгт IV-21-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-21

Хөрсний нэр	Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*		Тооцоон ы эсэргүүц эл, *кПа*
	C^I	$C^н=C^{II}$	φ^I	$\varphi^н=\varphi^{II}$	$E_{БНбД}$	$E_{ПР}$	Ro
Шавранцар	30	45	22	25	31	12.7	300

Шавранцар хөрсний стандарт пенетрацын туршилтын үр дүнг Хүснэгт IV-22-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-22

N value (SPT цохилт / 300 мм) [1 туршилт]				
Хөрсний нэр	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Туршилтыг зогсоосон тоо[(a)]
Шавранцар	51	51	51	1

a. Стандарт пенетрацын туршилтын үед 0.3 м-ээс бага нэвтэрсэн бөгөөд N_{value} 51 хүрсэн тул туршилтыг зогсоосон. Тухайн хөрс нь маш нягт болон маш хатуу инженер геологийн элесмент гэж тодорхойлогддог.

Шавранцар хөрсөнд хийгдсэн стандарт пенетрацын туршилтын үр дүнг Peck (1974) болон Bowles (1988)-ийн тооцооны утгуудаас Хүснэгт IV-23-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-23

Хөрсний нэр	Цохилтын тооны засварласан утга, $N_{1(60)}$	Эзэлхүүн жин (усаар ханасан), кН/м^3	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Шахалтын бат бэх, кПа	Тооцооны даралт	Нягтын байдал
Шавранцар	31	>20.4	-	>400	>200	Маш хатуу

Шавранцар хөрсөнд хийгдсэн прессиометрийн туршилтын үр дүнг Хүснэгт IV-24-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-24

Хөрсний нэр	Хэв гажилтын модуль E_0, мПа			
	Туршилт хийгдсэн тоо	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
Шавранцар	3	15	11	14

Шавранцар хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***80 Ом·м*** байна.

Шавранцар хөрс нь байгалийн нөхцөлдөө R_f=0.11 байгаа нь ***сулавтар овойлттой*** хөрсөнд нормчлогдоно.

Шавранцар хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - ***II***

ИГЭ-4. Хайрга агуулсан шавар

Бор шаргал, улаан хүрэн өнгөтэй, хатуугаас агилуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй хайрга агуулсан шавар. Хайрга агуулсан шавар хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг Хүснэгт IV-25-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-25

Хөрсний нэр	Ширхгийн бүрэлдэхүүн, %

		хайрга	элс	тоос / шавар
Хайрга агуулсан шавар	4а	13.7	49.8	36.5
	4б	19.0	46.5	34.5

Хайрга агуулсан шавар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр Хүснэгт IV-26, Хүснэгт IV-27-д тус тус нэгтгэн үзүүллээ.

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-26-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-26

Хөрсний нэр		Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr
Хайрга агуулсан шавар	4а	0.132	0.63
	4б	0.229	0.83

Хайрга агуулсан шавар хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-27-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-27

Хөрсний нэр		Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
		г/см^3			*хувь*	*нэгжийн хувь*
Хайрга агуулсан шавар	4а	2.72	1.96	1.74	36.30	0.570
	4б	2.72	1.91	1.56	42.78	0.748

Хатуугаас агилуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй хайрга агуулсан шавар хөрсний төлөв байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-28-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-28

Хөрсний Нэр		Урсалтын хязгаар дахь чийг, W_L	Имрэгдлийн хязгаар дахь чийг, Wp	Уян налархайн тоо, Jp	Урсамтгайн үзүүлэлт, I_L
		хувь			*нэгжийн хувь*
Хайрга агуулсан шавар	4а	0.361	0.179	0.182	-0.26
	4б	0.357	0.183	0.173	0.27

Хайрга агуулсан шавар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-аар Хүснэгт IV-29-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-29

Хөрсний нэр		Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*	Тооцооны эсэргүүцэл, *кПа*
		C^{I}	$C^{н}=C^{II}$	φ^{I}	$\varphi^{н}=\varphi^{II}$	$E_{БНбД}$	Ro
Хайрга агуулсан шавар	4а	52	78	18	21	27	600
	4б	33	50	15	17	18	300

Хайрга агуулсан шавар хөрсний стандарт пенетрацын туршилтын үр дүнг Хүснэгт IV-30-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-30

N value (SPT цохилт / 300 мм) [1 туршилт]					
Хөрсний нэр		Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Туршилтыг зогсоосон тоо[(a)]
Хайрга агуулсан шавар	4б	51	51	51	1

a. Стандарт пенетрацын туршилтын үед 0.3 м-ээс бага нэвтэрсэн бөгөөд N_{value} 51 хүрсэн тул туршилтыг зогсоосон. Тухайн хөрс нь маш нягт болон маш хатуу инженер геологийн элесмент гэж тодорхойлогддог.

Хайрга агуулсан шавар хөрсөнд хийгдсэн стандарт пенетрацын туршилтын үр дүнг Peck (1974) болон Bowles (1988)-ийн тооцооны утгуудаас Хүснэгт IV-31-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-31

Хөрсний нэр		Цохилтын тооны засварласан утга, N	Нягтын индекс, %	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Шахалтын бат бэх, кПа	Тооцооны даралт, кПа	Нягтын байдал
Хайрга агуулсан шавар	4б	41	-	-	>400	>200	Маш хатуу

Хайрга агуулсан шавар хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***50 Ом*м*** байна.

Хайрга агуулсан шавар хөрс нь байгалийн нөхцөлдөө

-ИГЭ-4а - R_f=0.17 ***сулавтар овойлттой***

-ИГЭ-4б - R_f=0.17 ***хүчтэй овойлттой*** хөрсөнд нормчлогдоно.

Хайрга агуулсан шавар хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – ***III***

ИГЭ-5. Хайрга агуулсан элсэнцэр

Бор шаргал өнгөтэй, уян налархай урсамтгайн үзүүлэлттэй хайрга агуулсан элсэнцэр. Хайрга агуулсан элсэнцэр хөрсний ширхгийнбүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг Хүснэгт IV-32-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-32

Хөрсний нэр	Ширхгийн бүрэлдэхүүн, %		
	хайрга	элс	тоос / шавар
Хайрга агуулсан элсэнцэр	17.7	65.4	16.9

Хайрга агуулсан элсэнцэр хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр Хүснэгт IV-33, Хүснэгт IV-34-д тус тус нэгтгэн үзүүллээ.

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-33-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-33

Хөрсний нэр	Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr
Хайрга агуулсан элсэнцэр	0.160	0.71

Хайрга агуулсан элсэнцэр хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-34-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-34

Хөрсний нэр	Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
	г/см^3			*хувь*	*нэгжийн хувь*
Хайрга агуулсан элсэнцэр	2.69	1.94	1.67	37.79	0.608

Уян налархай урсамтгайн үзүүлэлттэй хайрга агуулсан элсэнцэр хөрсний төлөв байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-35-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-35

Хөрсний Нэр	Урсалтын хязгаар дахь чийг, W_L	Имрэгдлийн хязгаар дахь чийг, Wp	Уян налархайн тоо, Jp	Урсамтгайн үзүүлэлт, I_L
	хувь			*нэгжийн хувь*
Хайрга агуулсан элсэнцэр	0.189	0.145	0.044	0.32

Хайрга агуулсан элсэнцэр хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-аар Хүснэгт IV-36-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-36

Хөрсний нэр	Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*		Тооцооны эсэргүүцэл, *кПа*
	C^{I}	$C^{н}=C^{II}$	φ^{I}	$\varphi^{н}=\varphi^{II}$	$E_{БНбД}$	$E_{П}$	Ro
Хайрга агуулсан элсэнцэр	9	14	21	24	20	-	300

Хайрга агуулсан элсэнцэр хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***70 Ом*м*** байна.

Хайрга агуулсан элсэнцэр хөрс нь байгалийн нөхцөлдөө R_f=0.10 байгаа нь ***сулавтар овойлттой*** хөрсөнд нормчлогдоно.

Хайрга агуулсан элсэнцэр хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - ***II***

ИГЭ-6. Шавранцар чигжээстэй хайрга

Бор хүрэн өнгөтэй, хатуугаас агилуун уян налархай, агилуунаас зөөлөн уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавранцар чигжээстэй хайрган хөрсний ширхгийнбүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг үр дүнг Хүснэгт IV-37-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-37

Хөрсний нэр		Ширхгийн бүрэлдэхүүн, %		
		хайрга	элс	тоос / шавар
Шавранцар чигжээстэй хайрга	6а	56.3	26.0	17.7
	6б	59.7	20.8	19.5
	6в	54.0	25.3	20.8

Шавранцар чигжээстэй хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр Хүснэгт IV-38, Хүснэгт IV-39-д тус тус нэгтгэн үзүүллээ.

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-38-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-38

Хөрсний нэр	Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr

Шавранцар чигжээстэй хайрга	6а	0.117	0.85
	6б	0.207	0.95
	6в	0.239	0.98

Шавранцар чигжээстэй хайрган хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-39-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-39

Хөрсний нэр		Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
		г/см^3			*хувь*	*нэгжийн хувь*
Шавранцар чигжээстэй хайрга	6а	2.72	2.21	1.98	27.21	0.374
	6б	2.72	2.06	1.70	37.35	0.597
	6в	2.73	2.03	1.64	39.96	0.666

Хатуугаас агилуун уян налархай, агилуунаас зөөлөн уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавранцар чигжээстэй хайрган хөрсний төлөв байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-40-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-40

Хөрсний нэр		Урсалтын хязгаар дахь чийг, W_L	Имрэгдлийн хязгаар дахь чийг, Wp	Уян налархайн тоо, Jp	Урсамтгайн үзүүлэлт, I_L
		нэгжийн хувь			*нэгжийн хувь*
Шавранцар чигжээстэй хайрга	6а	0.278	0.178	0.100	-0.61
	6б	0.285	0.180	0.105	0.26
	6в	0.283	0.178	0.105	0.58

Шавранцар чигжээстэй хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-аар Хүснэгт IV-41-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-41

Хөрсний нэр		Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*	Тооцооны эсэргүүцэл, *кПа*
		C^I	$C^н=C^{II}$	φ^I	$\varphi^н=\varphi^{II}$	$E_{БНбД}$	Ro
Шавранцар чигжээстэй хайрга	6а	17	25	36	41	39	450
	6б	8	12	39	45	30	450
	6в	5	8	32	37	18	400

Шавранцар чигжээстэй хайрган хөрсний стандарт пенетрацын туршилтын үр дүнг Хүснэгт IV-42-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-42

N value (SPT цохилт / 300 мм) [5 туршилт]					
Хөрсний нэр		Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Туршилтыг зогсоосон тоо[(a)]
Шавранцар чигжээстэй хайрга	6а	46	51	48	2
	6в	45	51	48	1

a. Стандарт пенетрацын туршилтын үед 0.3 м-ээс бага нэвтэрсэн бөгөөд N_{value} 51 хүрсэн тул туршилтыг зогсоосон. Тухайн хөрс нь маш нягт болон маш хатуу инженер геологийн элесмент гэж тодорхойлогддог.

Шавранцар чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн стандарт пенетрацын туршилтын үр дүнг Peck (1974) болон Bowles (1988)-ийн тооцооны утгуудаас Хүснэгт IV-43-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-43

Хөрсний нэр		Цохилтын тооны засварласан утга, $N_{1(60)}$	Нягтын индекс, %	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Шахалтын бат бэх, кПа	Эзэлхүүн жин (чийгтэй), кН/м^3	Нягтын байдал
Шавранцар чигжээстэй хайрга	6а	43	65-85	36-41	-	17.3-22.0	Нягт
	6в	45	65-85	36-41	-	17.3-22.0	Нягт

Шавранцар чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн прессиометрийн туршилтын үр дүнг Хүснэгт IV-44-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-44

Хөрсний нэр		Хэв гажилтын модуль E_0, мПа			
		Туршилт хийгдсэн тоо	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
Шавранцар чигжээстэй хайрга	6а	3	34.9	15.4	35.9
	6в	2	38.9	32.9	27.7

Шавранцар чигжээстэй хайрган хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***450 Ом*м*** байна.

Шавранцар чигжээстэй хайрган хөрс нь байгалийн нөхцөлдөө

-ИГЭ-6а - D=4.89, S_r=0.85 ***дунд зэргийн овойлттой***

-ИГЭ-6б - D=3.50, S_r=0.95 ***дунд зэргийн овойлттой***

-ИГЭ-6в - D=2.85, S_r=0.98 ***хүчтэй овойлттой*** хөрсөнд нормчлогдоно.

Шавранцар чигжээстэй хайрган хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – ***IV***

ИГЭ-7. Шавар чигжээстэй хайрга

Бор хүрэн өнгөтэй, хатуугаас агилуун уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрган хөрсний ширхгийнбүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг Хүснэгт IV-45-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-45

Хөрсний нэр		Ширхгийн бүрэлдэхүүн, %		
		хайрга	элс	тоос / шавар
Шавар чигжээстэй хайрга	7а	53.1	24.6	22.3
	7б	50.5	24.3	25.2

Шавар чигжээстэй хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр Хүснэгт IV-46, Хүснэгт IV-47-д тус тус нэгтгэн үзүүллээ.

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-46-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-46

Хөрсний нэр		Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr
Шавар чигжээстэй хайрга	7а	0.132	0.91
	7б	0.263	1.00

Шавар чигжээстэй хайрган хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-47-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-47

Хөрсний нэр		Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
		г/см^3			*хувь*	*нэгжийн хувь*
Шавар чигжээстэй хайрга	7а	2.73	2.22	1.96	28.36	0.396
	7б	2.73	2.01	1.59	41.83	0.719

Хатуугаас уян налархай урсамтгайн үзүүлэлттэй шавар чигжээстэй хайрган хөрсний төлөв байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-48- д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-48

Хөрсний нэр		Урсалтын хязгаар дахь чийг, W_L	Имрэгдлийн хязгаар дахь чийг, Wp	Уян налархайн тоо, Jp	Урсамтгайн үзүүлэлт, I_L
		нэгжийн хувь			*нэгжийн хувь*
Шавар чигжээстэй хайрга	7а	0.383	0.206	0.176	-0.42
	7б	0.385	0.208	0.177	0.31

Шавар чигжээстэй хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-аар Хүснэгт IV-49-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-49

Хөрсний нэр		Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*	Тооцооны эсэргүүцэл, *кПа*
		C^I	$C^н=C^{II}$	φ^I	$\varphi^н=\varphi^{II}$	$E_{БНбД}$	Ro
Шавар чигжээстэй хайрга	7а	21	32	30	35	32	450
	7б	11	17	38	44	20	450

Шавар чигжээстэй хайрган хөрсний стандарт пенетрацын туршилтын үр дүнг Хүснэгт IV-50-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-50

N value (SPT цохилт / 300 мм) [2 туршилт]					
Хөрсний нэр		Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Туршилтыг зогсоосон тоо[(a)]
Шавар чигжээстэй хайрга	7а	51	51	51	2

a. Стандарт пенетрацын туршилтын үед 0.3 м-ээс бага нэвтэрсэн бөгөөд N_{value} 51 хүрсэн тул туршилтыг зогсоосон. Тухайн хөрс нь маш нягт болон маш хатуу инженер геологийн элесмент гэж тодорхойлогддог.

Шавар чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн стандарт пенетрацын туршилтын үр дүнг Peck (1974) болон Bowles (1988)-ийн тооцооны утгуудаас Хүснэгт IV-51-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-51

Хөрсний нэр		Цохилтын тооны засварласан утга, $N_{1(60)}$	Нягтын индекс, %	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Шахалтын бат бэх, кПа	Эзэлхүүнжин (чийгтэй), кН/м^3	Нягтын байдал
Шавар чигжээстэй хайрга	7а	48	85-100	>41	-	>20.4	Маш нягт

Шавар чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн прессиометрийн туршилтын үр дүнг Хүснэгт IV-52-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-52

Хөрсний нэр		Хэв гажилтын модуль E_0, мПа			
		Туршилт хийгдсэн тоо	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
Шавар чигжээстэй хайрга	7а	2	27.8	24.9	26.3

Шавар чигжээстэй хайрган хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***450 Ом*м*** байна.

Шавар чигжээстэй хайрган хөрс нь байгалийн нөхцөлдөө

-ИГЭ-7а - D=5.96, S_r=0.91 ***дунд зэргийн овойлттой***

-ИГЭ-7б - D=3.35, S_r=1.00 ***хүчтэй овойлттой*** хөрсөнд нормчлогдоно.

Шавар чигжээстэй хайрган хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – ***IV***

Элюви-делювийн гаралтай хөрс - edQ

ИГЭ-8. Элсэнцэр чигжээстэй хайрга

Ногоон саарал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр чигжээстэй хайрга болтлоо өгөршсөн элсэн чулуу. Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний ширхгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнг Хүснэгт IV-53-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-53

Хөрсний нэр	Ширхгийн бүрэлдэхүүн, %		
	хайрга	элс	тоос / шавар
Элсэнцэр чигжээстэй хайрга	66.4	21.5	12.1

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр Хүснэгт IV-54, Хүснэгт IV-55 тус тус нэгтгэн үзүүллээ.

Хөрсний чийгийн үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-54-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-54

Хөрсний нэр	Байгалийн чийг, W	Чийглэгийн зэрэг, Sr

Элсэнцэр чигжээстэй хайрга	0.082	0.78

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний нягтын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-55-т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-55

Хөрсний нэр	Хатуу хэсгийн нягт, ρ_s	Байгалийн нягт, ρ	Эрдэслэг хэсгийн нягт, ρ_d	Сүвшил, n	Сүвшлийн коэффициент, e
	г/см^3			*хувь*	*нэгжийн хувь*
Элсэнцэр чигжээстэй хайрга	2.68	2.27	2.09	22.01	0.282

Хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний төлөв байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт IV-56т нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-56

Хөрсний Нэр	Урсалтын хязгаар дахь чийг, W_L	Имрэгдлийн хязгаар дахь чийг, Wp	Уян налархайн тоо, Jp	Урсамтгайн үзүүлэлт, I_L
	хувь			*нэгжийн хувь*
Элсэнцэр чигжээстэй хайрга	0.184	0.140	0.044	-1.51

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНбД 50-01-16-ээр Хүснэгт IV-57-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-57

Хөрсний нэр	Зууралдлын хүч, *кПа*		Дотоод үрэлтийн өнцөг, *градус*		Хэв гажилтын модуль, *МПа*	Тооцооны эсэргүүцэл, *кПа*
	C^I	$C^н=C^{II}$	φ^I	$\varphi^н=\varphi^{II}$	$E_{БНбД}$	Ro
Элсэнцэр чигжээстэй хайрга	17	15	25	29	58	400

Элювийн гаралтай элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний өгөршлийн коэффициент болон өгөршлийн зэргийн үнэлгээг Хүснэгт IV-58-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-58

Хөрсний нэр	Туршилт хийсэн хөрс (өгөршил)	Туршилтын нөхцөл	Өгөршлийн коэффициент, $K_{вк}$	Хайрганы агуулага, %		Өгөршлийн зэрэг
		өмнө	0.83	K_0	0.51	

Элсэнцэр чигжээстэй хайрга	Нийт дээжийн дундаж үзүүлэлтүүд	дараа		K_1	3.01	хүчтэй өгөршсөн

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний стандарт пенетрацын туршилтын үр дүнг Хүснэгт IV-59-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-59

N value (SPT цохилт / 300 мм) [1 туршилт]				
Хөрсний нэр	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Туршилтыг зогсоосон тоо[(a)]
Элсэнцэр чигжээстэй хайрга	51	51	51	1

a. Стандарт пенетрацын туршилтын үед 0.3 м-ээс бага нэвтэрсэн бөгөөд N_{value} 51 хүрсэн тул туршилтыг зогсоосон. Тухайн хөрс нь маш нягт болон маш хатуу инженер геологийн элесмент гэж тодорхойлогддог.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсөнд хийгдсэн стандарт пенетрацын туршилтын үр дүнг Peck (1974) болон Bowles (1988)-ийн тооцооны утгуудаас Хүснэгт IV-60-д нэгтгэн үзүүллээ.

Хүснэгт IV-60

Хөрсний нэр	Цохилтын тооны засварласан утга, N	Нягтын индекс, %	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Шахалтын бат бэх, кПа	Эзэлхүүн жин (чийгтэй), кН/м^3	Нягтын байдал
Элсэнцэр чигжээстэй хайрга	37	85-100	>41	-	>20.4	Маш нягт

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жишиг дундаж ***710 Ом*м*** байна.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрс нь байгалийн нөхцөлдөө D=5.95, S_r=0.78 байшаа нь ***сулавтар овойлттой*** хөрсөнд нормчлогдоно.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – ***V***

ИГЭ-9. Шавранцар чигжээстэй хайрга

Улаанбаатар хотын район *Сэлбэ* голын адагт байрладаг учир тус хотын нутаг дэвсгэрт тархсан голын гарал үүсэлтэй сэвсгэр хурдас нь хэдэн арван метр зузаантай байхаас гадна голын усны зөөвөрлөх үйл ажиллагаагаараа маш сайн ялгарч ангилагдсан байдаг онцлогтой юм. *Сэлбэ* голын хөндийд зуны улиралд намагжилт, өвлийн улиралд хөлдөлтийн овойлт бөөрөгүүд элбэгтэй байх ба халиа тошин бага үүсгэж татмаасаа нэг их гардаггүй.

Сэлбэ голын усны эрдэсжилт бага, гидрокарбонат кальцийн бүлэгт багтах бөгөөд ионы олон жилийн дундаж 65.9-210.1 мг/л хооронд хэлбэлзэнэ. Сэлбэ голын усны химийн найрлага нь бетонон эдлэлд идэмхий чанаргүй найрлагатай байдаг. Сэлбэ голын усны эрдэсжилт, ионы харьцаа Улаанбаатар хотын төвд гэр хороололын бохир ус голд хаягдсанаас доош гол ионы агууламж эрс нэмэгдэж өөрчлөгджээ. Тухайлбал Na+K ионы агууламж 4 дахин, хлор 6 дахин нэмэгдэж катионы харьцаа $Na^{+}+K^{+} > Ca^{2+} > Mg^{2+}$, анионых $HCO_3 > Cl > SO_4$ болж өөрчлөгджээ.

Голын усны түвшний байдал

Сэлбэ голын усны түвшин голын урсацын нэгэн адил хавар цас мөсний хайлбар ус урсах үед огцом нэмэгдэж огцом буурч харин хур бороо орж урсац нэмэгдэх үе хүртэл хамгийн бага хэмжээтэй болдог. Зуны хур борооны үерийн үед хэд хэд дахин их утгаа авч нэмэгддэг. Энэ үед хур борооны эрчимшилтээс шалтгаалж хэмжээ, хугацаа нь янз бүр байдаг. Үүний дараа усны түвшин аажмаар буурч өвлийн хамгийн бага түвшин хүрнэ.

Сэлбэ голын усны харуулын олон жилийн ажиглалтын материал болон бусад судалгааны материалаас үзэхэд 1948, 1959, 1964, 1966, 1982, 1985 онуудад зуны хур борооны үер ажиглагдаж Улаанбаатар хотын голын эргийн дагуух хэсэг усанд автаж байсан байна. Үүний дундаас 1982 оны үер нь онц аюултай байсан бөгөөд голын усны түвшин 2.5 метр хүрч өргөгдсөн ба усны урсгалын хурд 4-5м/сек болж байжээ. Энэ үед голын дагуу нийт уртад татам усанд автаж байжээ.

Тухай судалгааны хөнлүүрт тохиох янз бүрийн хангамж бүхий усны түвшинг хөндлүүрийн хөндлөн огтлолд зүсэлт байгуулж Шезийн аргачлалаар $Q=f(H)$ хамаарлын муруй байгуулж гаргалаа. Үүнд:

$$Q = v\,F$$

Энд: Q - үерийн их урсац / $м^3/с$ /

v - үерийн их урсацын хурд / м/сек /

F - усны огтлолын талбай / $м^2$ /

Үерийн урсацын үеийн хурдыг *Шези-Манингийн* аргачлалаар :

$$v=C\,(R\,I)^{1/2}$$

Энд: C - Шези-ийн итгэлцүүр / Адааршилаас хамаарна /

I - Усны түвшний хэвгий

R - Гидравлик радиус

Шези-ийн итгэлцүүрийг

$$C=1/n*(R)^{1/6}$$

Адааршлийн итгэлцүүрийг n=0.023 гэж авч үзэн тооцно.

САЙРУУДЫН ИХ УРСАЦЫН ТООЦОО

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт "Усзүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм "/БНбД 2.01.14-86/ болон аман судалгаанаас үзэхэд зуны хур борооны үер нь хаврын шар усны үерээс илүү эрчимшилттэй байдаг тул хур борооны үерийн хамгийн их урсацын тооцоог гаргав. Хур борооны үерийн их урсацын тооцоог гаргахын тулд хоногийн хамгийн их тунадасны хангамшлын тооцоог хийв.

Хоногийн хамгийн их тунадас түүний хангамшил

Хоногийн хамгийн их тунадасны статистик боловсруулалтыг хийхийн тулд сав газарт байгаа Улаанбаатар станцын цаг уурын ажиглалтын материал (хоногийн хамгийн их тунадас)-ыг авч ашиглан үзүүлэв. Ажиглалтын хугацаанд Улаанбаатарт хоногийн хамгийн их тунадас 1982 оны 8-р сард 100.3мм ажиглагдсан байна.

Хоногийн хамгийн их тунадас /Улаанбаатар станцаар/

Хүснэгт

Д/д	Он	Хоногийн их тунадас/мм/	Буурах дараалаар	P /%/
1	1938	30.2	74.9	1.7
2	39	27.8	74.1	3.3
3	1940	36.8	63.4	5.0
4	41	21.1	51.7	6.7
5	42	21.3	50.0	8.3
6	43	33.2	49.8	10.0
7	44	19.8	46.6	11.7
8	45	21.6	46.5	13.3
9	46	46.5	45.4	15.0
10	47	35.9	44.2	16.7
11	48	27.6	40.5	18.3
12	49	36.2	39.9	20.0
13	1950	26.2	39.7	21.7
14	51	25.5	38.0	23.3
15	52	39.7	37.2	25.0
16	53	23.8	36.8	26.7
17	54	50.0	36.2	28.3
18	55	19.9	34.4	30.0
19	56	29.4	34.2	31.7

20	57	63.4	33.2	33.3
21	58	30.9	32.1	35.0
22	59	22.7	30.9	36.7
23	1960	39.9	30.2	38.3
24	61	24.1	29.6	40.0
25	62	26.9	29.4	41.7
26	63	37.2	29.4	43.3
27	64	32.1	28.6	45.0
28	65	20.5	28.5	46.7
29	66	74.1	28.0	48.3
30	67	74.9	27.8	50.0
31	68	29.6	27.6	51.7
32	69	28.5	27.4	53.3
33	1970	20.4	26.9	55.0
34	71	28.6	26.2	56.7
35	72	15.8	26.0	58.3
36	73	20.1	25.5	60.0
37	74	19.3	24.7	61.7
38	75	20.8	24.1	63.3
39	76	16.5	23.8	65.0
40	77	28.0	23.0	66.3
41	78	29.4	23.0	68.7
42	79	19.0	22.7	70.0
43	1980	26.0	21.7	71.3
44	81	17.9	21.6	73.7
45	82	44.2	21.6	75.0
46	83	34.4	21.3	76.3
47	84	51.7	21.1	78.7
48	85	27.4	20.8	80.0
49	86	17.7	20.5	81.7
50	87	34.2	20.4	83.7
51	88	24.7	20.1	85.0
52	89	38.0	19.9	86.7
53	1990	23.0	19.8	88.3
54	91	23.0	19.3	85.0
55	92	45.4	19.0	86.7
56	93	46.8	17.9	88.3
57	94	40.5	17.7	90.0
58	95	49.8	16.5	91.7
59	96	21.7	15.8	93.3

Ажиглалтын эгнээнд моментийн аргаар статистик боловсруулалт хийж, хангамшлын муруй байгуулан 1%-ийн хангамшил бүхий хоногийн хамгийн их тунадасны хэмжээг тооцон гаргахад Улаанбаатарт 102.4мм байна. Харин

сүүлийн жилүүдэд барилга байгууламжийн тооцоонд хэрэглэж байгаа ("Барилгад хэргэлэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд" /УЦУХ 1994 он/ хуудас 136 зураг 29)-д дурдсанаар хоногийн хамгийн их тунадасны 1%-ийн *хангамж бүхий хэмжээг үг бүсэд* $H_{1\%}$=135 *мм гэж тодорхойлсноор цаашдын* тооцоонд хамруулан хэрэглэв.

1%-ийн хангамж бүхий хоногийн хамгийн их тунадасны хэмжээний мужлал



"Барилгад хэргэлэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд"
/УЦУХ 1994 он/ хуудас 136, 29-р зураг

Хамгийн их урсацын тооцоо

Тухайн сав газрууд нь Монгол орны уруйн үер /дунд зэрэг/ болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон бороонь улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой. Иймээс судалгаагүй сав газрын /гол, горхи, хуурай сайр/ хур бороонь үерийн усны хамгийн их урсацын тооцоог дараах аргачлалуудаар тооцож гаргав.

200 км^2-ээс бага ус хураах талбай бүхий гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсацын тооцоог ("Усзүйн тодорхойлолтуудыг тооцох норм ба дүрэм"

/БНбД 2.01.14-86./)-д заасны дагуу хур борооны эрчимшилтийн аргыг ашигласан болно.

$$Q_{1\%} = q_{1\%} * \varphi H_{1\%} * \delta * p_{\%} * F$$

Энд: $Q_{1\%}$ - үерийн их урсац / $м^3/с$ /

$q_{1\%}$ - үерийн их урсацын модуль / $л/с\ км^2$ /

φ - үерийн урсацын коэффициент

$H_{1\%}$ - 1% хангамжтай хоногийн хамгийн их тунадас / мм /

δ - нууршил, ой, намагшилтын коэффициент

$p_{\%}$ - 1%-ийн хангамшлаас шилжүүлэх коэффициент

F - ус цуглуулах талбай / $км^2$ /

Урсацын хамгийн их модулийг ($q_{1\%}$-ийг) тодорхойлоход шаардагдах гулдрилын хэлбэр зүйн тодорхойлолт ($Ф_г$)-ийг дараах томъёогоор тодорхойлов.

$$Ф_г = 1000*L / K_г * J_г * F^{1/4} * (\varphi * H)^{1/4}$$

Энд: $Ф_г$ - голын хэлбэр зүйн тодорхойлолт

L - хөндлүүр хүртэлх гулдрилын урт /км/

$K_г$ - гулдрил, татмын барзайлтын коэффициент

$J_г$ - голын дундаж хэвгий

Ус цуглуулах талбайн хажуу бэлээр үер урсах хугацааг ($t_{хб}$) тодорхойлоход шаардагдах хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолт ($Ф_{хб}$)-ийг дараах томъёогоор тодорхойлов.

$$Ф_{хб} = (1000*L_{хб})^{1/2} / n_{хб} * J_{хб}^{1/4} * (\varphi * H)^{1/2}$$

Энд: $Ф_{хб}$ - хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолт

$L_{хб}$ - ус цуглуулах талбайн хажуу бэлийн дундаж урт /км/

$J_{хб}$ - хажуу бэлийн дундаж хэвгий

$n_{хб}$ - хажуу бэлийн барзайлтын коэффициент

Үерийн урсацын коэффициентийг дараах томъёогоор тодорхойлов.

$$\varphi = C_2 * \varphi_0 / (F+1)^{n6} * (Jc*50)^{n5}$$

Энд: C_2 - эмпирик коэффициент

(ойн бүсэд 1.3, бусад бүсэд1.2-оор авна)

φ_0 - F=10 км^2, Jc=50% байх үеийн урсацын коэффициент

n_5 - хөрсний бүтцээс хамаарах коэффициент

n_6 - уур амьсгалын бүсээс хамаарах коэффициент

(ойн бүсэд 0.07, бусад бүсэд 0.11-ээр авна)

Хамгийн их эгэл урсацын модулийн томъёо

$$Q_{1\%}=q_{1\%}*F=B_{1\%}/(F+1)^{0.4}*\delta_1*\delta_2*F$$

Энд: $Q_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их урсац

$q_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их урсацын модуль

$B_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их эгэл урсацын модуль

δ_1 δ_2 - нууршил, ой, намагшилтын коэффициент

F - ус хураах талбай

Эдгээр аргачлалуудаар тооцсон тооцооны үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлэв.

Ус хураах талбайн зураг М1:25000 /1-р хувилбараар/

2025-08-02

1-р хувилбар

т	Байрлал	F (км²)	L_r (км)	J_r (‰)	$l_{хб}$ (км)		$H_{1\%}$ (мм)	$\Phi_{хб}$	$t_{хб}$ (мин)	Φ_r	$q_{1\%}$ (л/сек.км²)	$Q_{1\%}$ (м³/сек)	$Q_{2\%}$ (м³/сек)	$Q_{5\%}$ (м³/сек)
1	1+960	**0.766**	**3.104**	54.77	0.25	0.36	48.31	6.75	60.00	30.53	0.0690	**2.553**	**2.247**	**1.838**
2	3+820	**0.138**	**0.641**	78.04	0.22	0.52	69.74	4.38	30.00	7.85	0.1600	**1.538**	**1.353**	**1.107**
3	4+290	**0.216**	**0.934**	96.37	0.23	0.62	83.71	4.15	30.00	9.12	0.1600	**2.895**	**2.548**	**2.085**
4	4+480	**0.970**	**2.741**	69.32	0.35	0.44	59.01	6.66	60.00	22.36	0.0850	**4.868**	**4.284**	**3.505**
5	4+660	**0.055**	**0.385**	51.99	0.14	0.36	48.79	4.25	30.00	7.42	0.1600	**0.430**	**0.378**	**0.309**
6	5+020	**2.758**	**3.945**	55.76	0.70	0.33	45.19	10.69	150.00	28.48	0.0480	**5.983**	**5.265**	**4.307**
7	5+450	**0.302**	**0.864**	60.98	0.35	0.41	55.04	7.41	60.00	10.03	0.1100	**1.827**	**1.607**	**1.315**
8	5+960	**1.273**	**2.107**	56.946	0.60	0.36	48.67	9.57	120.00	17.99	0.0560	**3.469**	**3.052**	**2.497**
9	6+500	**0.066**	**0.416**	72.150	0.16	0.48	65.45	3.89	30.00	6.38	0.2200	**0.955**	**0.841**	**0.688**
10	6+660	**2.619**	**3.669**	71.303	0.71	0.42	56.61	9.65	150.00	23.38	0.0480	**7.117**	**6.263**	**5.125**
11	6+900	**0.163**	**0.751**	53.245	0.22	0.37	49.32	6.26	60.00	10.93	0.1100	**0.884**	**0.778**	**0.637**
12	7+960	**0.497**	**1.786**	128.792	0.28	0.79	63.73	5.21	30.00	13.77	0.1100	**3.485**	**3.067**	**2.509**
13	8+980	**0.126**	**0.874**	183.060	0.14	1.11	90.24	3.15	10.00	7.75	0.2200	**2.502**	**2.202**	**1.802**
14	9+320	**0.057**	**0.502**	199.238	0.11	1.21	98.06	2.93	10.00	5.17	0.2200	**1.233**	**1.085**	**0.888**
15	9+500	**0.353**	**0.828**	211.391	0.43	1.24	100.66	5.11	30.00	5.27	0.1800	**6.402**	**5.634**	**4.610**
16	9+950	**0.071**	**0.409**	219.927	0.17	1.32	107.03	3.46	10.00	3.78	0.2200	**1.668**	**1.468**	**1.201**
17	10+480	**0.029**	**0.210**	237.820	0.14	1.42	115.34	3.21	10.00	2.32	0.2200	**0.734**	**0.646**	**0.528**
18	11+100	**0.821**	**1.666**	132.030	0.49	0.79	63.78	7.55	60.00	11.24	0.1100	**5.761**	**5.070**	**4.148**
19	11+360	**0.070**	**0.424**	141.611	0.17	0.89	72.02	3.78	10.00	5.01	0.2200	**1.109**	**0.976**	**0.799**
20	11+660	**0.118**	**0.569**	105.445	0.21	0.68	54.97	5.28	30.00	6.97	0.1800	**1.167**	**1.027**	**0.840**

2025.08.02

21	11+850	**0.079**	**0.543**	147.334	0.15	0.92	74.57	4.16	30.00	6.10	0.1800	**1.057**	0.930	0.761
22	12+080	**0.061**	**0.349**	171.847	0.17	1.06	85.81	3.55	10.00	3.84	0.2200	**1.147**	1.010	0.826
23	12+300	**0.051**	**0.367**	108.988	0.14	0.70	57.01	3.90	30.00	5.43	0.2200	**0.643**	0.566	0.463
24	12+500	**0.029**	**0.213**	187.361	0.13	1.15	93.06	3.26	10.00	2.70	0.0410	**0.109**	0.096	0.079
25	13+240	**4.782**	**5.019**	85.668	0.95	0.47	63.43	9.62	150.00	25.17	0.0480	**14.559**	12.812	10.483
26	13+920	**0.433**	**1.312**	68.604	0.33	0.45	60.55	6.35	60.00	13.05	0.0520	**1.365**	1.201	0.983
27	14+500	**Булаг**												
28	14+960	**304.199**	**31.741**	21.738	Салба гол							**278.435**	192.223	157.273
29	15+250	**0.489**	**1.604**	99.766	0.30	0.63	50.68	6.12	30.00	14.31	0.1100	**2.724**	2.397	1.961
30	15+560	**0.045**	**0.417**	95.840	0.11	0.63	50.82	3.95	30.00	6.85	0.0410	**0.093**	0.082	0.067
31	15+960	**0.039**	**0.265**	113.23	0.15	0.73	59.08	4.69	30.00	4.11	0.0300	**0.069**	0.060	0.049
32	16+160	**0.085**	**0.703**	184.91	0.12	1.13	91.43	2.87	10.00	6.84	0.2200	**1.712**	1.506	1.232
33	16+380	**0.124**	**0.750**	173.38	0.16	1.06	85.95	3.45	10.00	6.89	0.2200	**2.337**	2.057	1.683
34	16+550	**0.614**	**1.946**	92.49	0.32	0.58	46.92	7.05	60.00	17.14	0.0850	**2.450**	2.156	1.764
35	16+920	**1.130**	**2.133**	89.07	0.53	0.54	43.99	9.43	90.00	16.60	0.0740	**3.678**	3.237	2.648
36	17+050	**0.070**	**0.374**	53.50	0.19	0.37	49.99	5.76	60.00	6.69	0.1400	**0.487**	0.429	0.351
37	17+250	**6.606**	**5.388**	55.68	1.23	0.31	41.76	13.52	200.00	31.90	0.0440	**12.138**	10.682	8.740
38	17+950	**0.786**	**1.173**	127.86	0.67	0.77	62.10	8.20	60.00	8.14	0.1400	**6.837**	6.016	4.923
39	18+200	**0.144**	**0.897**	100.37	0.16	0.65	52.45	4.75	30.00	10.75	0.1100	**0.829**	0.729	0.597
40	18+920	**0.189**	**0.516**	135.57	0.37	0.65	68.45	5.75	30.00	4.89	0.1400	**1.815**	1.597	1.307
41	19+200	**0.061**	**0.364**	109.84	0.17	0.71	57.35	4.65	30.00	5.13	0.1400	**0.492**	0.433	0.354
42	19+540	**2.040**	**2.460**	77.24	0.83	0.46	62.02	10.77	150.00	15.88	0.0620	**7.845**	6.903	5.648
43	20+180	**0.073**	**0.393**	76.43	0.19	0.51	68.89	4.46	30.00	5.70	0.1400	**0.703**	0.618	0.506
44	20+260	**0.784**	**1.655**	84.59	0.47	0.53	71.37	6.43	60.00	12.72	0.0850	**4.755**	4.184	3.423
45	20+480	**0.077**	**0.429**	116.46	0.18	0.75	60.36	4.69	30.00	5.53	0.1400	**0.652**	0.574	0.469
46	20+700	**0.078**	**0.633**	126.32	0.12	0.80	64.93	4.11	30.00	7.77	0.1400	**0.710**	0.625	0.511
47	20+920	**0.129**	**0.774**	90.41	0.17	0.59	47.81	4.66	30.00	10.10	0.1400	**0.864**	0.761	0.622

2025.08.02

48	21+180	***0.069***	***0.403***	149.05	0.17	0.93	75.43	3.76	10.00	4.65	0.2200	***1.144***	***1.007***	***0.824***
49	21+450	***0.150***	***0.788***	114.16	0.19	0.73	58.86	4.88	30.00	8.71	0.1400	***1.234***	***1.086***	***0.889***
50	21+880	***0.128***	***0.680***	44.14	0.19	0.31	41.80	5.28	60.00	11.63	0.0850	***0.456***	***0.401***	***0.328***
51	22+440	***0.289***	***1.110***	36.02	0.26	0.25	34.30	7.48	90.00	17.43	0.0680	***0.674***	***0.593***	***0.485***
52	23+400	***0.439***	***1.168***	18.56	0.38	0.14	16.66	13.22	200.00	14.36	0.0560	***0.459***	***0.404***	***0.331***

Ус хураах талбайн зураг М1:25000 /2-р хувилбараар/



2025-08-02

2-р хувилбар															
т	Байрлал	F (км²)	L_r (км)	J_r (‰)	$l_{хб}$ (км)		$H_{1\%}$ (мм)	$\Phi_{хб}$	$t_{хб}$ (мин)	Φ_r	$q_{1\%}$ (л/сек.км²)	$Q_{1\%}$ (м³/сек)	$Q_{2\%}$ (м³/сек)	$Q_{5\%}$ (м³/сек)
1	1+960	**0.766**	**3.104**	54.77	0.25	0.36	48.31	6.75	60.00	30.53	0.0690	**2.553**	**2.247**	**1.838**
2	3+820	**0.138**	**0.641**	78.04	0.22	0.52	69.74	4.38	30.00	7.85	0.1600	**1.538**	**1.353**	**1.107**
3	4+290	**0.216**	**0.934**	96.37	0.23	0.62	83.71	4.15	30.00	9.12	0.1600	**2.895**	**2.548**	**2.085**
4	4+480	**0.970**	**2.741**	69.32	0.35	0.44	59.01	6.66	60.00	22.36	0.0850	**4.868**	**4.284**	**3.505**
5	4+660	**0.055**	**0.385**	51.99	0.14	0.36	48.79	4.25	30.00	7.42	0.1600	**0.430**	**0.378**	**0.309**
6	5+020	**2.758**	**3.945**	55.76	0.70	0.33	45.19	10.69	150.00	28.48	0.0480	**5.983**	**5.265**	**4.307**
7	5+450	**0.302**	**0.864**	80.98	0.35	0.53	71.04	6.53	60.00	8.57	0.1100	**2.358**	**2.075**	**1.698**
8	5+960	**1.083**	**2.122**	57.70	0.51	0.37	49.72	8.70	150.00	18.68	0.0480	**2.585**	**2.275**	**1.861**
9	6+900	**0.418**	**1.184**	67.59	0.35	0.44	35.89	7.82	30.00	13.61	0.1100	**1.649**	**1.451**	**1.187**
10	7+300	**0.122**	**0.498**	40.14	0.24	0.28	38.40	7.52	60.00	9.11	0.1100	**0.513**	**0.452**	**0.370**
11	7+940	**0.141**	**0.636**	110.14	0.22	0.70	57.04	4.91	30.00	7.28	0.1600	**1.283**	**1.129**	**0.923**
12	8+340	**0.363**	**0.926**	86.38	0.39	0.55	44.95	7.33	30.00	9.62	0.1100	**1.794**	**1.579**	**1.292**
13	9+220	**0.734**	**1.468**	109.00	0.50	0.67	53.96	9.09	150.00	11.31	0.0690	**2.734**	**2.406**	**1.969**
14	9+520	**0.054**	**0.342**	87.73	0.18	0.58	46.88	5.00	60.00	5.62	0.2200	**0.560**	**0.493**	**0.403**
15	9+840	**0.041**	**0.278**	35.97	0.15	0.26	21.05	7.76	60.00	8.05	0.2200	**0.188**	**0.166**	**0.136**
16	10+380	**0.074**	**0.563**	142.18	0.13	0.89	72.25	3.67	30.00	6.55	0.2200	**1.180**	**1.039**	**0.850**
17	10+640	**1.593**	**2.490**	108.42	0.64	0.63	51.38	9.59	150.00	16.03	0.0480	**3.928**	**3.457**	**2.828**
18	10+740	**0.128**	**0.809**	123.56	0.16	0.78	63.34	3.94	30.00	8.90	0.1600	**1.295**	**1.139**	**0.932**
19	10+900	**0.092**	**0.538**	148.59	0.17	0.93	75.04	3.77	30.00	5.79	0.2200	**1.524**	**1.341**	**1.097**
20	11+140	**0.086**	**0.516**	116.26	0.17	0.74	60.21	4.15	30.00	6.47	0.2200	**1.141**	**1.004**	**0.821**
21	11+350	**0.063**	**0.336**	119.20	0.19	0.76	61.72	4.76	30.00	4.48	0.2200	**0.862**	**0.758**	**0.620**
22	12+240	**5.282**	**5.258**	83.68	1.00	0.46	36.92	12.95	200.00	29.68	0.0320	**6.241**	**5.492**	**4.493**

2025.08.02

23	12+540	0.045	0.530	94.32	0.09	0.62	50.09	3.55	30.00	8.76	0.2200	0.498	0.438	0.359
24	13+080	0.563	1.673	53.79	0.34	0.36	48.18	7.18	60.00	17.90	0.0850	2.304	2.027	1.659
25	13+480	Булаг												
26	13+820	304.199	31.741	21.738	Сэлбэ гол							278.435	192.223	157.273
27	14+160	0.113	0.781	89.66	0.15	0.59	79.21	3.36	30.00	9.30	0.0850	0.763	0.671	0.549
28	14+600	0.039	0.265	113.23	0.15	0.73	59.08	4.27	30.00	4.11	0.1100	0.252	0.221	0.181
29	14+880	0.050	0.402	149.10	0.12	0.93	75.60	3.83	30.00	5.03	0.1100	0.416	0.366	0.299
30	15+100	0.085	0.703	184.91	0.12	1.13	91.43	2.87	10.00	6.84	0.2200	1.712	1.506	1.232
31	15+290	0.124	0.750	173.38	0.16	1.06	85.95	3.45	10.00	6.89	0.2200	2.337	2.057	1.683
32	15+480	0.614	1.946	92.49	0.32	0.58	46.92	7.05	60.00	17.14	0.0850	2.450	2.156	1.764
33	15+840	1.130	2.133	89.07	0.53	0.54	43.99	9.43	90.00	16.60	0.0740	3.678	3.237	2.648
34	15+980	0.070	0.374	53.50	0.19	0.37	49.99	5.76	60.00	6.69	0.1400	0.487	0.429	0.351
35	16+180	6.606	5.388	55.68	1.23	0.31	41.76	13.52	200.00	31.90	0.0440	12.138	10.682	8.740
36	16+880	0.786	1.173	127.86	0.67	0.77	62.10	8.20	60.00	8.14	0.1400	6.837	6.016	4.923
37	17+140	0.144	0.897	100.37	0.16	0.65	52.45	4.75	30.00	10.75	0.1100	0.829	0.729	0.597
38	17+840	0.189	0.516	135.57	0.37	0.85	68.45	5.75	30.00	4.89	0.1400	1.815	1.597	1.307
39	18+120	0.061	0.364	109.84	0.17	0.71	57.35	4.65	30.00	5.13	0.1400	0.492	0.433	0.354
40	18+460	2.040	2.460	77.24	0.83	0.46	62.02	10.77	150.00	15.88	0.0620	7.845	6.903	5.648
41	19+140	0.073	0.393	76.43	0.19	0.51	68.89	4.46	30.00	5.70	0.1400	0.703	0.618	0.506
42	19+190	0.784	1.655	84.59	0.47	0.53	71.37	6.43	60.00	12.72	0.0850	4.755	4.184	3.423
43	19+390	0.077	0.429	116.46	0.18	0.75	60.36	4.69	30.00	5.53	0.1400	0.652	0.574	0.469
44	19+640	0.078	0.633	126.32	0.12	0.80	64.93	4.11	30.00	7.77	0.1400	0.710	0.625	0.511
45	19+840	0.129	0.774	90.41	0.17	0.59	47.81	4.66	30.00	10.10	0.1400	0.864	0.761	0.622
46	20+100	0.069	0.403	149.05	0.17	0.93	75.43	3.76	10.00	4.65	0.2200	1.144	1.007	0.824
47	20+380	0.150	0.788	114.16	0.19	0.73	58.86	4.88	30.00	8.71	0.1400	1.234	1.086	0.889
48	20+810	0.128	0.680	44.14	0.19	0.31	41.80	5.28	60.00	11.63	0.0850	0.456	0.401	0.328
49	21+350	0.289	1.110	36.02	0.26	0.25	34.30	7.48	90.00	17.43	0.0680	0.674	0.593	0.485

2025.08.02

50	22+320	***0.439***	***1.168***	18.56	0.38	0.14	18.66	13.22	200.00	14.36	0.0560	***0.459***	***0.464***	***0.331***

Үерийн ус өнгөрөөх байгууламжийн тооцоот чадвар

Замын зурвасын ус нэвтрүүлэх дугуй болон квадрат, тэгш өнцөгт хэлбэрийн төмөрбетонон хоолойн ус нэвтрүүлэх чадварыг түүгээр өнгөрөх усны шахагдсан огтлол дахь усны гүн мөн критик гүнээр уламжлан тооцоог гүйцэтгэдэг.

Дугуй болон тэгш өнцөгт огтлолтой ус гаргах барилгын тооцооны схем



Иймд ус зайлуулах хоолойн ёроолыг критик хэвгийтэй тэнцүү буюу түүнээс их байхаар авна. Авто замын ус нэвтрүүлэх байгууламжийн гидравлик тооцоог түрэлтгүй ус нэвтрүүлэх хоолойн зарчмаар дараах томъёогоор тооцов. Үүнд:

$$Q = \varepsilon\varphi\omega_0\sqrt{\frac{2g(H_0 - h_c)}{\alpha}}$$

Энд: ε – хажуугийн шахагдлын коэффициент

Дээрхи томъёог дараах хэлбэрт оруулбал:

Үүнд : $$Q = \varepsilon\varphi\sqrt{\frac{2g\cdot\omega_c\cdot(S_0 - K_{III})\cdot A}{\alpha}}$$, м3/с

Энд: Q - барилгаар өнгөрөх усны өнгөрөлт, м3/с
ε – хажуугийн шахагдлын коэффициент
φ - оролтын эсэргүүцлийг тооцох коэффициент
ω - усны урсгалын шахагдсан огтлол дахь талбай, м2
S_0 - хоолойгоор өнгөрөх усны дүүргэлтийн зэрэг
A- хоолойн өндөр, м
K_{1V}- шахагдсан огтлол тооцох коэффициент

Ус нэвтрүүлэх хоолойн ус оролтын хэсгийн хийцээс хамааруулж хажуугийн шахагдлын болон оролтын хэсгийн коэффициентийг сонгох ба тооцоонд раструб хийцтэй байхаар тооцож ε=0.9; φ=0.9 гэж тооцов.

А. Тооцоог шахагдсан огтлолоор гүйцэтгэх тохиолдолд дараах тооцоог гүйцэтгэнэ.

1. Хоолойн түрэлтийн зэрэг: $S_0 = \frac{H_0}{A}$; $S_0 < 1.0$ тооцоонд $S_0 = 0.8$ч0.9

2. Шахагдсан огтлолын харьцангуй гүн: $K_c = \frac{h_c}{H_0}$; h_c – шахагдсан огтлол дах усны гүн

3. Шахагдсан огтлол дахь усны хурд: $V_c = \varphi\sqrt{2gH_0}$

4. Шахагдсан огтлолын усны холбоос гүн h_c: $h_c'' = K_{1c}''A$

$Kc \cdot Kc^{II} \cdot \sqrt{Kc^{II}}$ -ийн холбогдлыг φ-ээс хамааруулан лавлахаас авна.

Түрэлттүй хоолойн хувьд дараах тооцооны хамаарлыг ашиглана.

$$h_a = K_{1C} \cdot A \text{ ; энд } K_{1C} = S_0 \cdot K_C$$

$$A = K_{2C}\frac{\alpha V^2}{g} \text{энд } K_{2C} = \frac{1}{2\varphi^2(S_0 - K_{C_1})}$$

Б. Тооцоог критик гүнээр тооцох тохиолдолд дараах тооцоог гүйцэтгэнэ.

1. Хоолойн түгэлтийн зэрэг: $S_0 = \frac{H_0}{A}$ $S_0 < 1.0$ тооцоонд $S_0 = 0.8$ч0.9

2. Усны критик гүн: $h_K = K_{1K} \cdot A$

3. Хоолойн өндрийг тооцох $A = K_{2C}\frac{\alpha V^2}{g}$ $A = K_{3K}\sqrt[4]{\frac{\alpha Q^2}{g\varepsilon^2}}$

4. Дээрх томъёонуудад орсон K_{1K} , K_{2K} , K_{3K} , K_{4K} коэффициентуудыг лавлахаас φ-ээс хамааруулан авна.

5. Хоолойн критик хэвгий: $i_K = \frac{K_{4K} \cdot gn^2}{\alpha\sqrt[3]{A}}$

Үерийн ус өнгөрөөх байгууламжийн тооцоот чадвар ($м^3$/сек)						
дугуй хоолой			дөрвалжин хоолой			
хоолойн овор	Ф1.00	Ф1.50	1.0x1.0	1.5x1.5	2.0x2.0	3.0x6.0
1 хос	1.688	3.446	1.978	4.427	7.034	31.692
2хос	3.376	4.711	3.957	8.854	14.068	63.385
3хос	5.064	7.066	5.935	13.281	21.102	95.077

2025.08.02

Гидравлик тооцооны үзүүлэлт, ус өнгөрүүлэх байгууламжийн овор хэмжээ 1-р хувилбар						
Д/д	Байрлал	F ($км^2$)	$L_г$ (км)	$Q_{1\%}$ ($м^3$/сек)	Хоолойн төрөл	Өнгөрөөх чадвар ($м^3$/сек)
1	1+960	0.766	3.104	2.553	Ф1.5x1	3.446
2	3+820	0.138	0.641	1.538	Ф1.5x1	3.446
3	4+290	0.216	0.934	2.895	Ф1.5x1	3.446
4	4+480	0.970	2.741	4.868	2.0x2.0x1	7.034
5	4+660	0.055	0.385	0.430	Ф1.0x1	1.453
6	5+020	2.758	3.945	5.983	2.0x2.0x1	7.034
7	5+450	0.302	0.864	1.827	Ф1.5x1	3.446
8	5+960	1.273	2.107	3.469	Ф1.5x1	3.446
9	6+500	0.066	0.416	0.955	Ф1.0x1	1.453
10	6+660	2.619	3.669	7.117	2.0x2.0x1	7.034
11	6+900	0.163	0.751	0.884	Ф1.0x1	1.453
12	7+960	0.497	1.786	3.485	Ф1.5x1	3.446
13	8+980	0.126	0.874	2.502	Ф1.5x1	3.446
14	9+320	0.057	0.502	1.233	Ф1.0x1	1.453
15	9+500	0.353	0.828	6.402	2.0x2.0x1	7.034
16	9+950	0.071	0.409	1.668	Ф1.5x1	3.446
17	10+480	0.029	0.210	0.734	Ф1.0x1	1.453
18	11+100	0.821	1.666	5.761	2.0x2.0x1	7.034
19	11+360	0.070	0.424	1.109	Ф1.0x1	1.453

2025.08.02

20	11+660	0.118	0.569	1.167	Ф1.0х1	1.453
21	11+850	0.079	0.543	1.057	Ф1.0х1	1.453
22	12+080	0.061	0.349	1.147	Ф1.0х1	1.453
23	12+300	0.051	0.367	0.643	Ф1.0х1	1.453
24	12+500	0.029	0.213	0.109	Ф1.0х1	1.453
25	13+240	4.782	5.019	14.559	2.0х2.0х2	14.068
26	13+920	0.433	1.312	1.365	Ф1.0х1	1.453
27	14+500	Булаг			2.0х2.0х2	
28	14+960	304.199	31.741	218.435	Гүүр	
29	15+250	0.489	1.604	2.724	Ф1.5х1	3.446
30	15+560	0.045	0.417	0.093	Ф1.0х1	1.453
31	15+960	0.039	0.265	0.069	Ф1.0х1	1.453
32	16+160	0.085	0.703	1.712	Ф1.5х1	3.446
33	16+380	0.124	0.750	2.337	Ф1.5х1	3.446
34	16+550	0.614	1.946	2.450	Ф1.5х1	3.446
35	16+920	1.130	2.133	3.678	2.0х2.0х1	7.034
36	17+050	0.070	0.374	0.487	Ф1.0х1	1.453
37	17+250	6.606	5.388	12.138	2.0х2.0х2	14.068
38	17+950	0.786	1.173	6.837	2.0х2.0х1	7.034
39	18+200	0.144	0.897	0.829	Ф1.0х1	1.453
40	18+920	0.189	0.516	1.815	Ф1.5х1	3.446
41	19+200	0.061	0.364	0.492	Ф1.0х1	1.453
42	19+540	2.040	2.460	7.845	2.0х2.0х1	7.034
43	20+180	0.073	0.393	0.703	Ф1.0х1	1.453
44	20+260	0.784	1.655	4.755	2.0х2.0х1	7.034
45	20+480	0.077	0.429	0.652	Ф1.0х1	1.453
46	20+700	0.078	0.633	0.710	Ф1.0х1	1.453
47	20+920	0.129	0.774	0.864	Ф1.0х1	1.453
48	21+180	0.069	0.403	1.144	Ф1.0х1	1.453
49	21+450	0.150	0.788	1.234	Ф1.0х1	1.453
50	21+880	0.128	0.680	0.456	Ф1.0х1	1.453
51	22+440	0.289	1.110	0.674	Ф1.0х1	1.453
52	23+400	0.439	1.168	0.459	Ф1.0х1	1.453

Гидравлик тооцооны үзүүлэлт, ус өнгөрүүлэх байгууламжийн овор хэмжээ 2-р хувилбар

Д/д	Байрлал	F (км²)	L_r (км)	$Q_{1\%}$ (м³/сек)		
					Хоолойн төрөл	Өнгөрөөх чадвар (м³/сек)
1	1+960	0.766	3.104	2.553	Ф1.5x1	3.446
2	3+820	0.138	0.641	1.538	Ф1.5x1	3.446
3	4+290	0.216	0.934	2.895	Ф1.5x1	3.446
4	4+480	0.970	2.741	4.868	2.0x2.0x1	7.034
5	4+660	0.055	0.385	0.430	Ф1.0x1	1.453
6	5+020	2.758	3.945	5.983	2.0x2.0x1	7.034
7	5+450	0.302	0.864	2.358	Ф1.5x1	3.446
8	5+960	1.083	2.122	2.585	Ф1.5x1	3.446
9	6+900	0.418	1.184	1.649	Ф1.5x1	3.446
10	7+300	0.122	0.498	0.513	Ф1.0x1	1.453
11	7+940	0.141	0.636	1.283	Ф1.0x1	1.453
12	8+340	0.363	0.926	1.794	Ф1.5x1	3.446
13	9+220	0.734	1.468	2.734	Ф1.5x1	3.446
14	9+520	0.054	0.342	0.560	Ф1.0x1	1.453
15	9+840	0.041	0.278	0.188	Ф1.0x1	1.453
16	10+380	0.074	0.563	1.180	Ф1.0x1	1.453
17	10+640	1.593	2.490	3.928	2.0x2.0x1	7.034
18	10+740	0.128	0.809	1.295	Ф1.0x1	1.453
19	10+900	0.092	0.538	1.524	Ф1.5x1	3.446
20	11+140	0.086	0.516	1.141	Ф1.0x1	1.453
21	11+350	0.063	0.336	0.862	Ф1.0x1	1.453
22	12+240	5.282	5.258	6.241	2.0x2.0x1	7.034
23	12+540	0.045	0.530	0.498	Ф1.0x1	1.453
24	13+080	0.563	1.673	2.304	Ф1.5x1	3.446
25	13+480	Булаг			2.0x2.0x2	
26	13+820	304.199	31.741	278.435	Гүүр	
27	14+160	0.113	0.781	0.763	Ф1.0x1	1.453
28	14+600	0.039	0.265	0.252	Ф1.0x1	1.453
29	14+880	0.050	0.402	0.416	Ф1.0x1	1.453
30	15+100	0.085	0.703	1.712	Ф1.5x1	3.446
31	15+290	0.124	0.750	2.337	Ф1.5x1	3.446
32	15+480	0.614	1.946	2.450	Ф1.5x1	3.446
33	15+840	1.130	2.133	3.678	2.0x2.0x1	7.034
34	15+980	0.070	0.374	0.487	Ф1.0x1	1.453

2025-08-02

35	16+180	6.606	5.388	12.138	2.0x2.0x2	14.068
36	16+880	0.786	1.173	6.837	2.0x2.0x1	7.034
37	17+140	0.144	0.897	0.829	Ф1.0x1	1.453
38	17+840	0.189	0.516	1.815	Ф1.5x1	3.446
39	18+120	0.061	0.364	0.492	Ф1.0x1	1.453
40	18+460	2.040	2.460	7.845	2.0x2.0x1	7.034
41	19+140	0.073	0.393	0.703	Ф1.0x1	1.453
42	19+190	0.784	1.655	4.755	2.0x2.0x1	7.034
43	19+390	0.077	0.429	0.652	Ф1.0x1	1.453
44	19+640	0.078	0.633	0.710	Ф1.0x1	1.453
45	19+840	0.129	0.774	0.864	Ф1.0x1	1.453
46	20+100	0.069	0.403	1.144	Ф1.0x1	1.453
47	20+380	0.150	0.788	1.234	Ф1.0x1	1.453
48	20+810	0.128	0.680	0.456	Ф1.0x1	1.453
49	21+350	0.289	1.110	0.674	Ф1.0x1	1.453
50	22+320	0.439	1.168	0.459	Ф1.0x1	1.453

Хувилбар тус бүрт сонгосон үерийн ус өнгөрүүлэх байгууламжийн тоо ширхэгийг харьцуулж үзүүллээ.

Хоолойн төрөл	1-р хувилбарт	2-р хувилбарт
Ф1.0x1	26	25
Ф1.5x1	13	14
2.0x2.0x1	9	8
2.0x2.0x2	3	2
Гүүр	1	1

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Тус замын дагуу газар нутагт хийгдсэн Фондын материалууд, тайлан

2. Барилгын норм ба дүрэм
   Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд
   (Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл)
   /БНбД 2.01.01-2004/

3. Барилгын норм ба дүрэм
   Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд
   (БНбД 2.01.01-93) 1994 он

4. Барилгын норм ба дүрэм
   Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм (БНбД 2.01.14-86)

5. В. А. Большаков
   Сборник задач по гидравлике. 1975г

6. Гидравлический расчёт малых мостов и речних русел. 1967г

7. Н. М. Константинов, Н. А. Петров, Л. И. Высоцкий
   Гидравлика, гидрометрия, гидрология 1987г

8. В. А. Крашников
   Пособие по определению основных гирологических характеристик 1984г

9. В. А. Крашников
   Пособие по определению расчётных характеристик максимального стока малых рек территории МНР при отсутсвии данных гидрологических наблюдений

10. К. П. Клибашев, И. Ф. Горошков
    Гидрологические расчеты 1970г

Хавсралт 4. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

“НЭГДҮГЭЭР ТОЙРОГ ЗАМ” ТЭЗҮ, концепц дизайн

Тайлбар бичиг Боть I. Инженерийн тайлан

Улаанбаатар хот

2025 он

“НЬЮГИДРО ПРОЕКТ” ХХК

“ШИНЭ ТОЙРОГ АВТОЗАМ” ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

“НЬЮГИДРО ПРОЕКТ” ХХК
Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн байгууллага

“ШИНЭ ТОЙРОГ АВТОЗАМ” ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН

БОЛОВСРУУЛСАН:
“НЬЮГИДРО ПРОЕКТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ **Ц. СОСОРБАРАМ**

НЬЮ ГИДРО ПРОЕКТ ХХК
HYDRO PROJECT LLC
УЛААНБААТАР ХОТ
ХТУ1038 5554071

УЛААНБААТАР 2025 он

АГУУЛГА

ОРШИЛ 6
НЭГ. ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ 7
1.1. Талбайн байршил 7
1.2. Физик газарзүй, ландшафт 10
ХОЁР. УУР АМЬСГАЛ 14
2.1. Улаанбаатар хотын цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд 14
2.1.1. Дулаан хүйтний горим 15
2.1.2. Нарны гийгүүлэл, цацраг 15
2.1.3. Хөрсний температур 15
2.1.4. Агаарын даралт 16
2.1.5. Чийгшлийн горим 16
2.1.6. Хур тунадас 17
2.1.7. Салхины горим 18
2.1.8. Нарны гийгүүлэл, цацраг 19
2.1.9. Хөрсний температур 19
2.2. Гамшигт үзэгдэл 20
2.3. Улаанбаатар хотын уур амьсгалын өөрчлөлт 20
ГУРАВ. АГААРЫН ЧАНАР, ФИЗИК БОХИРДОЛ 22
3.1. Түгээмэл агаар бохирдуулагчийн үүсэх процесс болон шинж чанар 22
3.2. Агаарын чанарын хяналтын суурин харуулуудын байршил, тэдгээрийн хэмжилт хийдэг үзүүлэлтүүд 22
3.3. Улаанбаатар хотын агаарын чанарын 2023 оны жилийн төлөв байдал 23
3.4. Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал (2021-2025 он) 31
3.5. Агаарын чанарын индекс 36
3.6. Физик бохирдол (Дуу шуугиан) 39
ДӨРӨВ. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ БА ГЕОМОРФОЛОГИ 42
4.1. Геологийн тогтоц 42
4.2. Геоморфологи 47
ТАВ. ГАДАРГЫН УС 53
5.1. Туул гол 53
5.1.1. Туул голын усны нөөц, горим, чанар 53
5.1.2. Туул голын усны нөөцийн хомсдол, барагдалт, чанарын өөрчлөлт 61
5.2. Сэлбэ гол 65
5.2.1. Сэлбэ голын усны нөөц, горим 65
5.2.2. Сэлбэ голын усны чанар 67
5.3. Дунд гол 68
ЗУРГАА. ГАЗРЫН ДООРХИ УС 69
6.1. Газрын доорх усны нөөц, горим 69
6.2. Гидрогеологийн нөхцөл 69
6.3. Газрын доорх усны нөөц 71
6.3.1. Нөхөн сэргээгддэг нөөц (Байгалийн нөөц) 71
6.3.2. Ашиглалтын баримжаат нөөц 72

6.4. Улаанбаатар хот орчмын Газрын доорх усны химийн найрлага, чанар 73
ДОЛОО. ХӨРСӨН БҮРХЭВЧ 76
7.1. Улаанбаатар хотын хөрсний ерөнхий хэв шинж 76
7.2. Хөрсний химийн ерөнхий шинжилгээ 77
7.3. Хөрсний хүнд металлын бохирдлын төвшин 77
7.3.1. Хөрсөн дэх хүнцэл (As)-ийн тархалт 79
7.3.2. Хөрсөн дэх хар тугалга (Pb)-ийн тархалт 80
7.3.3. Хөрсөн дэх хром (Cr)-ийн тархалт 82
7.3.4. Хөрсөн дэх кобальт (Co)-ийн тархалт 83
7.3.5. Хөрсөн дэх никель (Ni)-ийн тархалт 84
7.3.6. Хөрсөн дэх цайр (Zn)-ийн тархалт 85
7.3.7. Хөрсөн дэх зэс (Cu)-ийн тархалт 86
7.3.8. Хөрсөн дэх молибден (Mo)-ийн тархалт 87
7.3.9. Хөрсөн дэх ванади (V)-ийн тархалт 88
7.3.10. Хөрсөн дэх стронци (Sr)-ийн тархалт 89
7.4. Хөрсөн дэх хүнд металлын бохирдлын үнэлгээ 90
НАЙМ. УРГАМЛАН НӨМРӨГ 92
8.1. Ургамал газарзүйн мужлал 92
8.2. Судалгааны арга зүй 92
8.3. Ургамлан нөмрөгийн судлагдсан байдал 93
8.3.1. Ургамлын бүлгэмдэл, төрөл, зүйлийн бүрдэл 94
8.3.2. Ургамлын ангилал 100
8.4. Ургамлан нөмрөгийн ашиглалт, хамгаалалт, талхлагдлын өнөөгийн байдал 102
8.5. Ховор, нэн ховор ургамал хамгаалалтын өнөөгийн байдал 102
8.6. Товч дүгнэлт 103
ЕС. АМЬТНЫ АЙМАГ 104
9.1. Төсөл хэрэгжих орчны амьтны аймаг, зүйлийн бүрэлдэхүүн 104
АРАВ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ, ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛС ... 106
АРВАН НЭГ. ГАЗАР АШИГЛАЛТ 108
АРВАН ХОЁР. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ 111
12.1. Баянзүрх дүүрэг 111
12.2. Чингэлтэй дүүрэг 116
12.3. Сонгинохайрхан дүүрэг 119
12.4. Баянгол дүүрэг 123
12.5. Сүхбаатар дүүрэг 125
АШИГЛАСАН МАТЕРИАЛ 127

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны талбайд хамрагдах засаг захиргааны нэгж 8
Зураг 2. Шинэ тойрог автозамын трассын байршил 9
Зураг 3. Монгол орны физик газарүйн мужлал төслийн талбайд 10
Зураг 4. Байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлал 11
Зураг 5. Монгол орны байгалийн бүс, бүслүүр..... 13
Зураг 6. Улаанбаатар хотын орчмын уур амьсгалын климаграмм 14
Зураг 7. Жилийн хур тунадасны хуваарилалт болон харьцангуй чийгийн явц..... 17
Зураг 8. Буянт-Ухаа орчмын сүүлийн 5 жилийн зарим саруудын салхины чиглэлийн давтагдал, %..... 19
Зураг 9. Гамшигт үзэгдлийн тохиолдол, 2001-2022 20
Зураг 10. Цаг уурын Буянт-Ухаа станцын жилийн а) дундаж температур, (b) нийлбэр хур тунадасны олон жилийн явц, хандлага 21
Зураг 11. УБ хотын агаарын чанарыг хянах харуулуудын байршил 23
Зураг 12. Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж... 24
Зураг 13. Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 24 цагийн дундаж агууламж25
Зураг 14. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 25
Зураг 15. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламж..... 26
Зураг 16. Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж.... 26
Зураг 17. Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 24 цагийн дундаж агууламж 27
Зураг 18. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн жилийн дундаж агууламж .. 28
Зураг 19. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламж . 29
Зураг 20. Улаанбаатар хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу ислийн жилийн дундаж агууламж 29
Зураг 21. Улаанбаатар хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу ислийн 8 цагийн дундаж агууламж 30
Зураг 22. Улаанбаатар хотын агаар дахь озоны жилийн дундаж агууламж..... 30
Зураг 23. Улаанбаатар хотын агаар дахь озоны 8 цагийн дундаж агууламж 31
Зураг 24. 2024, 2025 оны 02 дугаар сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламж.... 32
Зураг 25. PM2.5 тоосонцрын 02 дугаар сарын дундаж агууламж, 2021-2025 он..... 32
Зураг 26. PM2.5 тоосонцрын 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр 33
Зураг 27. PM10 тоосонцрын 01 дүгээр сарын агууламж, 2021-2025 он 33
Зураг 28. PM10 тоосонцрын 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр 34
Зураг 29. Азотын давхар ислийн 02 дугаар сарын дундаж агууламж, 2021-2025 он 34
Зураг 30. Азотын давхар ислийн 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр ... 35
Зураг 31. Хүхэрлэг хийн 02 дугаар сарын дундаж агууламж, 2021-2025 он 35
Зураг 32. Хүхэрлэг хийн 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр 36
Зураг 33. Агаарын чанарын 2016-2023 оны жилийн индексийн түвшин, % 38
Зураг 34. 2023 оны агаарын чанарын индекс..... 38
Зураг 35. Улаанбаатар хотын дүүргүүдийн дуу шуугианы түвшин..... 40
Зураг 36. Дуу шуугианы дундаж түвшин, цагийн дунджаар..... 40
Зураг 37. Монгол улсын геологийн мужлал..... 42
Зураг 38. Геологийн тогтоц 46
Зураг 39. Төсөл хэрэгжих талбайн орчны геоморфологийн хэв шинж 48
Зураг 40. Судалгааны талбайн орчны өндөржилт 49
Зураг 41. Судалгааны талбайн орчны налуужилт..... 50
Зураг 42. Газар хөдлөлийн бичил мужлалын зураг 52
Зураг 43. Туул голын сав газар 53
Зураг 44. Ус зүйн сүлжээ 54
Зураг 45. Жилийн урсцын гидрограф, Туул гол-Улаанбаатар харуул 54
Зураг 46. Туул голын уртын дагуух урсцын алдагдал..... 56
Зураг 47. Жилийн дундаж урсцын хангамшлын муруй, Туул гол-Улаанбаатар харуул..... 56
Зураг 48. Туул голын хур бороонь их урсцын хангамшлын муруй, Туул гол –Улаанбаатар харуул..... 57
Зураг 49. Туул голын хамгийн бага урсцын хандлага, Туул гол –Улаанбаатар 58

Зураг 50. Туул голын усны хамгийн их температур 59
Зураг 51. Туул голын сав газар дахь голуудын мөсөн бүрхүүлтэй байх хоногийн тоо..... 60
Зураг 52. Туул голын дагуух зарим цэгийн усны цахилгаан дамжуулах чанар 62
Зураг 53. Усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч ($БХХ_5$)-ийн агууламж 63
Зураг 54. Усны аммоний азотын агууламж..... 63
Зураг 55. Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар 64
Зураг 56. Төв цэвэрлэх байгууламжийн жинлэгдэх бодис..... 64
Зураг 57. Сэлбэ голын сав газрын зураг 65
Зураг 58. Сэлбэ болон Багабаян голууд 66
Зураг 59. Гидрогеологийн зураг..... 70
Зураг 60. Туул голын сав газрын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц..... 72
Зураг 61. Улаанбаатар хот орчмын газрын доорх усны дундаж эрдэсжилт..... 74
Зураг 62. Улаанбаатар хот орчмын газрын доорх усны дундаж хатуулаг 74
Зураг 63. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх газрын доорх усны РН..... 75
Зураг 64. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч 77
Зураг 65. Улаанбаатар хотын хөрсөн дэх хүнцлийн агууламж..... 79
Зураг 66. Улаанбаатар хотын хөрсөн дэх хар тугалгын тархалт 81
Зураг 67. Улаанбаатар хотын хөрсөн дэх хромын тархалт..... 83
Зураг 68. Улаанбаатар хотын хөрсөн дэх кобальтын тархалт 84
Зураг 69. Улаанбаатар хотын хөрсөн дэх никелийн тархалт 85
Зураг 70. Улаанбаатар хотын хөрсөн дэх цайрын тархалт 86
Зураг 71. Улаанбаатар хотын хөрсөн дэх зэсийн тархалт..... 87
Зураг 72. Улаанбаатар хотын хөрсөн дэх молибдений тархалт 88
Зураг 73. Улаанбаатар хотын хөрсөн дэх ванадийн тархалт..... 89
Зураг 74. Улаанбаатар хотын хөрсөн дэх Стронцигийн тархалт 90
Зураг 75. Улаанбаатар хотын хөрсөн дэх хүнд металлын бохирдлын нэгдсэн үнэлгээ 91
Зураг 76. Монгол орны ургамал – газарзүйн мужлал 92
Зураг 77. Улаанбаатар хотын ургамалжилт..... 94
Зураг 78. Уулын хээрийн агь- хазаар өвст бүлгэмдэл 95
Зураг 79. Трассын дагуух тарьсан мод сөөг..... 96
Зураг 80. Сэлбэ голын татам 97
Зураг 81. Хуурай нугын татам 98
Зураг 82. Эвдэрсэн газрын төрх байдал..... 99
Зураг 83. Тусгай хамгаалалттай газар нутгийн байршил 107
Зураг 84.Шинэ тойрог автозамын трассын дагуух дүүргүүдийн газар ашиглалтын төрлүүдийн байршил..... 109

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Трассын талбайд хамаарах засаг захиргааны нэгж, хамрагдах газар нутгийн хэмжээ 7
Хүснэгт 2. Уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт, 1991-2020 он 14
Хүснэгт 3. Сарын дундаж температур, °C-ээр (2018-2022 он) 15
Хүснэгт 4. Жилийн дундаж температур (2018-2022) 15
Хүснэгт 5. Хөрсний уур амьсгалын бэсрэг мужийн үзүүлэлт 16
Хүснэгт 6. Агаарын чийгшлийн үзүүлэлтүүд 17
Хүснэгт 7. Сарын нийлбэр хур тунадасны хэмжээ, мм-ээр (2018-2022) 17
Хүснэгт 8. Жилийн дундаж салхины хурд 18
Хүснэгт 9. Сарын салхины дундаж хурд, м/с (2018-2022) 18
Хүснэгт 10. Салхины их хурд, м/с 18
Хүснэгт 11. Буянт-Ухаа станцын 2018-2022 оны салхины чиглэл, салхигүй үеийн давтагдал (%) 18
Хүснэгт 12. Хөрсний уур амьсгалын бэсрэг мужийн үзүүлэлт 19
Хүснэгт 13. Улирлын уур амьсгалын өөрчлөлт (1941-2023) 21
Хүснэгт 14. Агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламж, 2020-2023 он 23
Хүснэгт 15. Агаар дахь бохирдуулах бодисын 2024, 2025 оны 02 дугаар сарын дундаж агууламж 31
Хүснэгт 16. Агаарын чанарын индекс, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл 36
Хүснэгт 17. Агаарын чанарын индексийн жилийн ерөнхий үнэлгээ 37
Хүснэгт 18. Агаарын чанарын хяналтын харуулын индексийн нийт тоо 37
Хүснэгт 19. Улаанбаатар хотын дүүргүүдийн дуу шуугианы түвшин, өдрөөр (дбА) 40
Хүснэгт 20. Олон жилийн дундаж урсац 55
Хүснэгт 21. Сонгосон цэг, харуул хооронд урсац нэмэгдэх ба алдагдах хандлага, % 55
Хүснэгт 22. Янз бүрийн хангамшил бүхий олон жилийн дундаж урсац, $м^3/с$ 56
Хүснэгт 23. Хур борооны үерийн их урсац 57
Хүснэгт 24. Гачиг үеийн урсац, $м^3/с$ 58
Хүснэгт 25. Усны температур 59
Хүснэгт 26. Мөсний үзэгдлийн ажиглагдах хугацаа 60
Хүснэгт 27. Мөсний зузаан, см 60
Хүснэгт 28. Усны гол ионуудын агууламж 62
Хүснэгт 29. Усны биогенийн нэгдлүүдийн агууламж 62
Хүснэгт 30. Улаанбаатар хотын хаягдал бохир ус цэвэрлэх 4 байгууламжуудын биогенийн агууламж 63
Хүснэгт 31. Сэлбэ голын ай савын дүрс зүйн зарим үзүүлэлт 66
Хүснэгт 32. Сэлбэ голын ажиглагдсан жилийн дундаж урсац, $м^3/с$ 66
Хүснэгт 33. Олон жилийн дундаж урсац 67
Хүснэгт 34. Хур борооны үерийн их урсац 67
Хүснэгт 35. Дулааны улирлын 30 хоногийн хамгийн бага урсцын дундаж модуль, $л/с·км^2$ 67
Хүснэгт 36. Сав газрын ус агуулагч үе, бүрдэл болон бүсийн гидрогеологийн зарим үзүүлэлт . 71
Хүснэгт 37. Туул голын сав газар дахь газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц . 72
Хүснэгт 38. Улаанбаатар хотын хэмжээнд нөөц нь батлагдсан газрын доорх усны ордууд 73
Хүснэгт 39. Газрын доорх усан дахь хүнд металлын агууламж 75
Хүснэгт 40. Хөрсний химийн ерөнхий шинжилгээний дүн 77
Хүснэгт 41. Улаанбаатар хотын хөрсөн дэх хүнд металлын агууламж 78
Хүснэгт 42. Бичиглэл -1 95
Хүснэгт 43. Бичиглэл-2 97
Хүснэгт 44. Бичиглэл-3 98
Хүснэгт 45. Бичиглэл 4 99
Хүснэгт 46. Ургамлын ангилалзүй 100
Хүснэгт 47. Ургамлан нөмрөгийн доройтлын зэрэг 102
Хүснэгт 48. Зонхилох амьтны зүйлийн жагсаалт 104
Хүснэгт 49. Зургийн проекцийн өгөгдөл 108
Хүснэгт 50. Автозамын трассын дагуу байрлах нэгж талбарын тоо 110

ОРШИЛ

“Шинэ тойрог автозам” төслийн Байгаль орчны зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ (2025-03-13. Дугаар 25/02) болон төслийг хэрэгжүүлэх ажлын даалгавар (2024-06-19-ний өдрийн А/720 дугаартай захирамж)-т тусгагдсанаар төслийн БОННҮҮ-ний хүрээнд эхний үе шатанд хийгддэг Байгаль орчны төлөв байдлын тайлан боловсруулах ажлыг “Ньюгидро проект” ХХК 2025 оны 3-р сард хийж гүйцэтгэлээ.

Төслийн талбайн байгаль орчны төлөв байдлыг тодорхойлох ажлыг төслийн хүрээнд сонгож авсан автозамын трассын дагуух талбайд хээрийн хэмжилт судалгааг төслийн үйл ажиллагаанд нөлөөлөх дүүргүүдийг хамруулан явуулж, судалгааны талбайн хэмжээнд хийгдсэн өмнөх судалгааны үр дүнг ашиглан боловсруулалт хийсэн болно.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудад үндэслэн байгаль орчны үнэлгээ хийх талаар Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэг, мөн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 1-р хэсэгт заасан аргачлал, арга зүй зэргийг баримтлан боловсруулсан болно.

Энэхүү Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилго нь тухайн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдал тухайлбал, газарзүйн нөхцөл, геологийн тогтоц, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, мөн түүнчлэн төслийн нөлөөлөлд өртөх дүүрэг, хороодын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшингийн өнөөгийн төлөв байдлыг тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид, шинжлэх ухааны судалгааны аргазүйг ашиглан тодорхойлоход чиглэгдсэн.

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд урд хийгдсэн судалгааны материалуудыг цуглуулах, төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгээс Шинэ тойрог автозам барих трассын хувилбаруудаас эцсийн байдлаар сонгосон трассын дагуу маршрутын болон хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Судлаачдын баг Төлөвлөж буй шинэ тойрог автозамын трассын дагууд Улаанбаатар хотын цаг уур,уур амьсгалын болон агаарын чанарын сүүлийн үеийн мэдээ, 5 дүүргийн 30 хорооны нийгэм эдийн засгийн мэдээллийг цуглуулах, газар ашиглалтын төрлийн судалгаа, хөрсний агрохимийн болон бохирдолын дээж авах, гадаргын уснаас дээж авах, шаардлагатай цэгүүдэд ургамлын бичиглэл хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Төслийн талбайн байгаль орчны өнөөгийн төлөв байдлыг илтгэсэн энэхүү тайланд буй мэдээллүүд нь цаашид уг талбайд хэрэгжүүлэх төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн урдчилсан судалгаа хийж, тайлан боловсруулах ажлын суурь материал болох юм.

Төлөв байдлын судалгаанд оролцсон судлаач мэргэжилтнүүд:

1. Багийн ахлагч, “Ньюгидро проект” ХХК-ийн захирал, доктор Ц. Сосорбарам
2. Усны барилга байгууламжийн инженер Т.Гансүх
3. Цаг уурч, доктор Д. Мөнхжаргал
4. Хөрс судлаач Ш. Одбаатар
5. Ургамал судлаач, докторант Ч. Мөнгөнчимэг
6. Гидрогеологич Д. Болормаа
7. Газар зохион байгуулагч Б. Оюунтуяа
8. Экологич Э. Нандин-Эрдэнэ
9. Газар зүйч Д. Мөнх-Өлзий
10. GIS-ийн мэргэжилтэн Д. Очгэрэл
11. Жолооч М. Энхбаяр

НЭГ. ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

1.1. ТАЛБАЙН БАЙРШИЛ

Төлөвлөж буй шинэ тойрог автозамын трассын дагууд Улаанбаатар хотын 5 дүүргийн 30 хорооны нутаг дэвсгэрийн хэсэг хамрагдах ба нийт 25.31 км урттай, 50-60м өргөнтэй, 13 уулзвартай, 5 явган хүний гарцтай, 3 мал, амьтны гарцтай, 2 урсгал бүхий, 6 эгнээ зам баригдана.

Хүснэгт 1. Трассын талбайд хамаарах засаг захиргааны нэгж, хамрагдах газар нутгийн хэмжээ

Дүүрэг	Хороо	Замын трассын дайран өнгөрөх хороо, гудамжны нэр	Хамаарах замын урт, м
Баянгол	29-р хороо	БГД-ийн 29-р хороо буюу Үйлдвэрийн тойруу-Эрчим хүчний гудамжны уулзвараас Өнөр хорооолол- Москвагийн гудамжны уулзвар хүртэлх хэсэг	1464.0
Сонгино хайрхан	17, 23, 39, 6, 7, 40, 9, 10, 28-р хороо	СХД-ийн 17-р хороо буюу Өнөр хорооолол- Москвагийн гудамжны уулзвараас 1-р хорооллын арын зам руу эргэх хэсэг хүртэл, 23-р хорооны Чулуут-1 гудамж, Хангайн 16, 18, 19, 20, 22, 27 80, 82, 29, 37-р гудамжны хэсэг, 39-р хорооны Хангайн 35,47-р гудамж, Тоосгоны 51, 52-р гудамж, Хангайн 49, 50, 51, 52-р гудамж, 6-р хорооны Тоосгоны 33, 34а, 24а, 24-р гудамж, 7-р хорооны Баянхошууны 7-р гудам, Геологи 1-р гудамжнй хэсэг, 40-р хорооны 0119 цэргийн анги-2, 4, Баянхошуу 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40-р гудамжны хэсэг, Баруун салаа-Зүүн салаа-Баянхошууны замын уулзвар, 9-р хорооны Баруун баян уул-12, 13, 14, 15, 16-р гудамжны хэсэг, 10-р хорооны Зүүн баян уул-23, 16а, 15, 14-р гудамж, Оёдлын 1, 4-р гудамжны хэсэг, 28-р хорооны Ногоон чулуут -11, Сансар 12-р гудамжны хэсгийг дайран өнгөрнө.	8527.5
Чингэлтэй	20, 22, 21,13,14-р хороо	ЧД-ийн 20-р хорооны 149-р сургуулийн зүүн хойд хэсэгт байрших уулын энгэр, оройн хэсэг, 22-р хорооны Согоот 90-р гудамжны урд хэсгийн уулын бэл, хормой хэсэг, 21-р хорооны Булаг 19, 20-р гудамжны хэсэг, 13-р хорооны Сургууль 25, 24, 23-р гудамжны хэсэг, Хайлаастын авто зам, Сургууль 33, 41, 42-р гудамжны хэсэг, 14-р хорооны Хайлааст 12, 13-р гудамжны хэсэг	3958.7
Сүхбаатар	13-р хороо	СБийн 13-р хороо, Чингэлтэйн өргөн чөлөө гудамж Долоон буудлын зам, Рашааны 13, 14-р гудамжны хэсэг, Ногооны талбайн 2-р гудамжны хэсэг, Сэлбэ гол, голын эрэг орчмын хэсэг	1001.0
Баянзүрх	29, 21, 27, 31, 32, 19, 24, 17, 8, 38, 12, 37, 36, 26-р хороо	БЗД-ийн 29-р хороо, Сэлбэ голын эрэг орчмын хэсэг, Сэлбэ 39, 40-р гудамжны хэсэг, Дарь эхийн зам, 21-р хорооны Бага Дарь эх-4, 5, 13, 10, 13, 16, 18, 19, 26-р гудамжны хэсэг, Жамсран уулын ар 3, 2, 1-р гудамжны хэсэг, Монелийн зам, 27-р хорооны Монел 52, 51, 50, 49, 48-р гудамжны хэсэг, 31-р хорооны Баруун алтан өлгий гудамжинд зам дагуу байрших Аргал Ойл ШТС, Монел 39, 38, 37-р гудамжны хэсэг, 32-р хорооны Баруун алтан өлгий 36, Зүүн алтан өлгийн 11, 10, 9, 8-р гудамжны хэсэг, Цайз захын баруун хойд уулзвараас Цагаан дабааны эцэс хүртэлх замын хэсэг, 19-р хорооны Цайз 22а, 25а, 24а, 23а, Дэнжийн 3, 2, Жаргалантын 12а гудамжны хэсэг, 24-р хорооны Жаргалант 5,4, Газарчин 5, Овоот 5, 3, Хоршоолол 14, 13, 9, 11, 10, 6-р гудамжны хэсэг, Да хүрээ захын баруун хэсэг, Эрдэнэ толгой 6, 5, 4, 3, 2, 1-р гудамжны хэсэг, 17-р хорооны Хилчний гудамж-Да Хүрээ гудамжны уулзвар автозамын хэсэг, 8-р хорооны Эдэнэтолгой 36, 37, 38, 39, 40-р гудамжны хэсэг, Эрдэнтолгойгоор ДХИС руу уруудах замын хэсэг, 38-р хорооны Эрдэнэ толгойн 40-р гудамж, Улаанхуаран 26-р гудамжны хэсэг, Хилчний 1-р гудамж, 12-р хороо Цагдаагийн академийн өргөн чөлөө гудамж авто замын хэсэг, 37-р хорооны Жанжины 23, 22, 21, 20, 19, 29, 28, 26-р гудамжы хэсэг, 36-р хорооны төмөр зам, авто замын хоорондох хэсэг, 26-р хорооны Дүнжингарав худалдааны төвөөс Баянзүрхийн товчоо хүртэлх замын хэсэг	10364.0
Замын нийт урт, м			**25315.1**



Зураг 1. Судалгааны талбайд хамрагдах засаг захиргааны нэгж



Зураг 2. Шинэ тойрог автозамын трассын байршил

1.2. ФИЗИК ГАЗАРЗҮЙ, ЛАНДШАФТ

Физик газарзүйн мужлал

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн дэд муж болох Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрогт хамаарагдах эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм.



Зураг 3. Монгол орны физик газарүйн мужлал төслийн талбайд



Зураг 4. Байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлал

Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог (Х-9)-т Хэнтийн уулт өндөрлөгийн хажуу хэсгээр тохиолдох уулс хоорондын ховдол хотгороор тусгаарлагдсан хавтгай оройтой ихээхэн хэрчигдсэн дундаж өндөр уулс түгээмэл тархсан байна. Тухайлбал: Хэнтийн уулархаг орны зүүн хажууд Норов гатлын нуруу (2211 м), Дэлгэрхаан (211 м), Хужиртын шар нуруу (1712 м), Цоровхаан (1868 м), Хэнтийн баруун хажууд Ногоон нуруу, Манхат, Угтаал, Хөшиг зэрэг уулс, мөн түүнчлэн өмнөд хажуугийн Яргуйт (2069 м), Эрдэнэ (1830 м), Дугуй (1835 м) зэрэг хоорондоо ухаа гүвээгээр холбоотой буюу тусдаа орших уулс оршино. Энэ тойргын уулзүйг гадаргын төрх байдлаар нь 3 хэсэгт хувааж үзэж болох юм. Үүнд:

1. Арцат халзангийн тарамцагт уулс

Энэ хэсэгт орох уулсын үнэмлэхүй өндөр нь 2000- 2500 метр бөгөөд Их, Бага Хэнтийн нурууны ар болоод баруун хойт хажууд байрлана. Энд уулсын оройгоор хүйтний өгөршил эрчимтэй явагдаж улмаар тагийн дэнж үүсэх явц үргэлжилж гадарга нь тэгшрэх байдалтай болсон байна.

2. Уулт хөмбөний захаар орших ихээхэн хэрчигдсэн бэсрэг уулс

Энэ ангилалд Хэнтийн уулсын баруун хэсэгт Хараа, Ерөө голын урсгалын дунд хэсгээр орших уулс орно. Үнэмлэхүй өндөр нь 2000-2400 метр, харьцангуй өндөр нь 800-1000 метр ихэвчлэн хувирмал чулуулаг, боржин, эртний тунамал хурдаснаас бүрэлдэх бөгөөд эртний тэгшрэлийн гадаргын үлдэц уулс болно. Горхийн уулс. Хэнтийн уулт хөмбөний өмнөт хажууд орших бөгөөд ихэвчлэн боржингоос тогтсон учир боржинт тарамцаг гэж нэрлэдэг ч

тал бий. Боржингоос гадна тунамал бялхмал чулуулаг тархсан байна.Мөн уулзүйн гол гишүүдэд Халзан, Алтан-Өлгий, Булнай, Богд уул, Баянзүрх зэрэг уулс орох ба Налайхын хотгор гэх мэт буурц болон хөндийн маягийн хотгор нилээд түгээмэл байна.

3. Үлдэц уулс

Энд Хэнтийн уулт хөмбөний захаар байрласан уулс, тухайлбал: Ерөө голын дагуу орших Дулаанхаан, Хөхчулуутын уулс, Хараа голын урсгалын дунд үед орших Бургалтайн уулс, Туул голын их тохойн дагуу орших Заамарын уулс мөн Онон, Балж голын дагуу орших нам уулс багтана. Эндэхийн уулсын үнэмлэхүй өндөр 1000-2000 метр бөгөөд харьцангуй өндөр нь 600- 800 метр байна. Уулс ихэвчлэн эрт төрмөлийн эриний дээд галавын боржин, хувирмал чулуулгуудаас тогтсон байна. Уулсын хооронд цэрд, гуравдагч, дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар дүүргэгдсэн эртний хотгорууд элбэг байдаг. Гадаргынтөрх байдал ихээхэн хэрчигдсэнээс гадна заримд нь орон нутгийн чанартай тектоник хагарлаар мөргөцөг үүссэн ч тохиолдол байна.

Ландшафт, газрын гадарга

Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Хангай Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөссөн татам болон дэнж, Их Хэнтэйн нурууны баруун өмнөд салбар уулс, түүний дэд мужийн ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Горхи, Тэрэлж, Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг биеэ даасан өндөрлөг уулс, тэдгээриин салбар уулсаар Туул голын 1250-1345 м үнэмлэхүй өндөр бүхий тэвш маягийн хөндийн 2.5-4.0 км хүртэл өргөссөн татам, дээрх уулсын энгэр, бэл, хормой, дэнжид тархан оршдог.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хамгийн өндөр цэг нь Богдхан уулын ноён оргил Цэцээ гүн (2256 м) хамгийн нам нэг нь Туул голын хөндийд орших Шувуун фабрикийн район (1203 м) болно. Улаанбаатар хотын төвийн хэсгийн барилгажсан талбайн үнэмлэхүй өндөр нь Туул голын хөндий, татмын хэсэгт 1250-1345 м байдаг. Харин голын хөндийг хүрээлсэн Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх, Толгойт, Баянхошуу, Баянцогт, Хойд Баян, Цагдуулт зэрэг уулсын үнэмлэхүй өндрийн хэмжээ 1515- 1950 м, тэдгээрээс хамгийн өндөр оргил болох Богдхан уулын үнэмлэхүй өндөр нь 2265 м хүрдэг. Улаанбаатар хотын эргэн тойрны бэсрэг уулс болох Толгойт, Баян хошуу, Баянцогт, Хойт Баян, Цагдуулт зэрэг уулсын үнэмлэхүй өндөр нь дунджаар 1513-1831 м байх ба хажуу налуугийн хэвгий нь 15-20 хэм, зарим хэсэгтээ 30-35 хэм хүрдэг.

Байгалийн бүс, бүслүүр

Автозамын трассын талбай нь Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн **ойт хээрийн бүсэд** хамрагдаж байна Н.Өлзийхутаг (1989). Монгол орны нутаг дэвсгэр хойноосоо урагш чиглэлд өргөрөгийн өөрчлөлттэй холбоотойгоор хэд хэдэн босоо бүс бүслүүрийг үүсгэдэг онцлогтой. Энэ онцлогийн дагуу ургамалжилтийн доорхи бүс бүслүүрт хувааж үзсэн байдаг.

1. Өндөр уулын (тагийн) бүслүүр,
2. Уулт тайгын бүслүүр,
3. **Ойт хээрийн бүслүүр,**
4. Хээрийн бүс,
5. Цөлөрхөг хээрийн бүс,
6. Цөлийн бүс



Зураг 5. Монгол орны байгалийн бүс, бүслүүр

Ойт хээрийн бүс нь Төв Азийн хуурай хээр, цөлийн хамгийн хойд, Дорнод Сибирийн их хөвч тайгын хамгийн өмнөд хязгаар болох Хангай, Хэнтий, Алтайн нурууны салбар уулс, Орхон Сэлэнгийн сав газар, Монгол орны хамгийн зүүн хязгаарт орших Хянганы салбар уулст илэрнэ.

Ойт хээрийн бүсийн нэг өвөрмөц онцлог нь уулын ар хар мод голлосон сийрэгдүү ойгоор бүрхэгдсэн байхад өвөр тал нь уулын хээрийн байдалтай оршино. Энэ шинж нь ойн болон хээрийн амьтан ургамлын өвөрмөц хослолыг бүрдүүлдэг.

Ургамалжилтын хувьд нэг талаас Сибирийн тайгын нөгөө талаас Монголын хээрийн төлөөлөгчид бас Дагуурын зүйлүүд үзэгддэгээс гадна Алтай соёны өндөр уулын ургамлууд цөөнгүй тархана. Голдуу шилмүүст модтой холимог ой ургах бөгөөд энд алагтай өвс элбэг ургана.

ХОЁР. УУР АМЬСГАЛ

2.1. УЛААНБААТАР ХОТЫН ЦАГ УУР, УУР АМЬСГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улаанбаатар хотод цаг уурын ажиглалтын мэдээ цуглуулах Нисэхэд байрлах Буянт-Ухаа станц анх 1936 онд байгуулагдаж байсан бөгөөд одоогоор уг станцаас гадна Сонгинохайрхан дүүрэгт байрших Улаанбаатар станц, Тэрэлж станц болон цаг уурын ажиглалтын өртөө, харуулууд тасралтгүй ажиллаж байна. Нутаг дэвсгэрийн уур амьсгалын үндсэн нөхцөл, төлөв байдлыг Улаанбаатар хотын цаг уурын олон жилийн дундаж болон дээрх станцуудын сүүлийн 5 жилийн (2018-2022 он) хэмжилтийн мэдээнд суурилан дараах байдлаар тодорхойллоо.

Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай.

Төслийн талбай уур амьсгалын хувьд чийглэгдүү, сэрүүн, нэн хүйтэн мужид хамаарагддаг. Энд өвөл нь харьцангуй хүйтэн, цасархаг, зун нь сэрүүн чийглэг, хур тунадас элбэгтэй, салхи багатай байдаг. Энд намар эрт сэрүүсч, хавар хожуу дулаарч, цасан бүрхүүл хамгийн удаан хадгалагддаг. Энэ орчмын уур амьсгалын үндсэн нөхцөл байдал нь хоног, сар, жилийн температурын агууриг их, хур тунадасны хувиарлалт жигд бус, өвөлдөө их хүйтрэх зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалаар тодорхойлогдоно.

Хүснэгт 2. Уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт, 1991-2020 он

Үзүүлэлт	Саруул												Жил
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Тунадас, мм	1.6	2.2	4.1	7.6	21.2	44	68.9	62	24.5	7.8	4.9	2.5	251.4
Агаарын температур, °C	-23.1	-18.3	8.3	2.2	9.2	15.5	17.8	15.4	8.7	-1.1	-12.1	20.7	-1.3
Салхины хурд, м/с	1.6	2.1	2.9	3.9	4.4	3.5	3.1	2.6	2.9	2.6	2.0	1.6	2.8



Зураг 6. Улаанбаатар хотын орчмын уур амьсгалын климаграмм

2.1.1. Дулаан хүйтний горим

Улаанбаатарын районд сарын дундаж агаарын температур (Буянт-Ухаагаар) хүйтний улиралд -1.3...-23.5°C, хот дотор (Улаанбаатар станцаар) -3.9°..-19.2°C, өндөрлөг газраар (Тэрэлж орчмоор) -2.2…-23.5°C хүйтэн, дулааны улирлын сарын дундажийг 7 дугаар сараар авч үзвэл 15.5-18.5°C байна.

Эх газрын уур амьсгалын онцлогоос болоод жилийн хүйтэн улиралд агаарын температур газрын гадарга намсах тутам дулаарах, харин дулаан улиралд газар өндөрсөх тутам сэрүүсдэг байдал энд тодорхой харагдаж байна. Станцуудын сарын дундаж температурын сүүлийн 5 жилийн мэдээг 3-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Сарын дундаж температур, °C-ээр (2018-2022 он)

Станц	Сар											
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Улаанбаатар	-19.2	-15.4	-3.9	4.3	10.4	16.8	18.5	15.9	11.0	1.3	-10.7	-19.3
Буян-Ухаа	-23.5	-18.9	-5.7	3.2	9.7	16.4	18.0	15.3	9.7	-1.3	-12.2	-23.5
Тэрэлж	-23.5	-19.2	-8.6	1.2	6.8	12.9	15.5	13.1	6.1	-2.2	-15.2	-20.7

Эх үүсвэр: ЦУОШГ- Архив, мэдээллийн сангийн хэлтэс

Улаанбаатар станцын сүүлийн жилүүдийн агаарын температурыг цаг уурын өртөөдийн олон жилийн явцтай харьцуулахад өвлийн улиралд 3.5-4.5°C-ээр буурч, зуны улиралд 2.9-3.7°C-ээр нэмэгдэж олон жилийн дундажаас дулаарсан үзүүлэлттэй харагдаж байна. Уур амьсгалын дулааралтаас болоод жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа, хүйтний нөөц багасч, дулаан үеийн үргэлжлэх хугацаа уртасч, дулааны нөөц нэмэгдэж байна.

Хүснэгт 4. Жилийн дундаж температур (2018-2022)

Станц	Он					5 жилийн дундаж
	2018	2019	2020	2021	2022	
Улаанбаатар	1.0	1.7	0.0	1.4	0.9	1.0
Буянт-Ухаа	-1.1	-0.4	-1.7	-0.7	-0.9	-1.0
Тэрэлж	-2.9	-2.7	-3.2	-2.7	-2.6	-2.8

Эх үүсвэр: ЦУОШГ- Архив, мэдээллийн сангийн хэлтэс

Сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтээс авч үзвэл Улаанбаатар хотын жилийн дундаж температур хотын төвөөр 0.2-1°C хэм, хотын зах Тэрэлж, Нисэх орчмоор -1..-2.8°C хэм байна. Үүнийг өмнө олон жилийн дундажтай харьцуулвал Буянт-Ухаа орчмоор 2°C, хотын төвөөр 0.6°C хэмээр дулаарсан байна.

2.1.2. Нарны гийгүүлэл, цацраг

Нарны гийгүүлэл жилдээ 2636 цаг үргэлжилдэг нь боломжит хугацааныхаа 60 орчим хувийг эзэлдэг бөгөөд орчны уулс болон өглөө, оройн нарны халхлагдал, тухайн орчны үүлшил, агаарын булингаршил зэрэгтэй холбоотойгоор буурдаг. Нарны гийгүүлэл нь хоног, сар, жилийн хугацаагаар цэлмэг үед нэн тодорхой явцтай. Нэг өдөрт дунджаар 7-8 цаг нар гийгүүлэхдээ үүлшлээс хамаарч хэлбэлзэх боловч, зуны саруудад 8.5-9.5 цаг, өвлийн саруудад энэ хугацаа богиносож 5.5-6.5 цаг нартай байдаг. Нарны цацраг, нарны гийгүүлэл, үүлшил зэрэгтэй холбоотойгоор нарны өндрөөс ихээхэн хамаарч, нийлбэр цацраг жилдээ 4490 мДж/м^2, шулуун цацраг 2500 мДж/м^2 тус тус ирдэг. Нарны цацраг нарны өндөр ихэссэн, үүлшил бага байдаг 5, 6 дугаар саруудад хамгийн их, нарны өндөр хамгийн бага буюу 12 дугаар сар болон өвлийн саруудад бага байдаг.

2.1.3. Хөрсний температур

Газрын гадарга дээр тусч байгаа нарны цацрагийн зарим хэсэг хөрсөнд шингэж, туяат энергээс дулаан энергид шилжин хөрсний гүний давхаргуудыг халааж, хөрсөнд ургамлын амьдралыг тэтгэх физик химийн процессууд хөрсний температурын нөлөөгөөр явагддаг.

Энэхүү зарцуулагдсан дулааны хэмжээ нь хөрсний бүтэц, шинж чанар, өнгө, дулаан дамжуулах чадал, дулааны багтаамж, чийгшил, газрын гадаргын хотгор гүдгэр, налуугийн байдал зэргээс шалтгаална. Энэ орчинд жилийн дундаж хөрсний температур газрын гадарга дээр хасах 0.6°С-аас -1.1°С орчим байх бөгөөд газрын гүн рүү дулаарч байдаг. Харин хүйтэн, дулааны газрын гүнд нэвчих нэвчилтийн хувьд авч үзвэл 0.8-1.2 м-т ялихгүй хүйтэрснээ цааш гүн рүүгээ бүр дулаарч, 1.6-3.2 метрт 2.0°С -2.4°С болдог зүй тогтолтой байна.

Хүснэгт 5. Хөрсний уур амьсгалын бэсрэг мужийн үзүүлэлт

Хөрсний хөлдөлт			Хөрсний гэсэлт			0°С нэвчих гүн, см
Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног	
10.X	10.YI	220	20.IY	1.YII	80	400

Энд хөрс өнгөнөөсөө гүн рүү дунджаар 10 дугаар сарын 10-наас 6 дугаар сарын 10 хүртэл алгуур хөлдөж, нийт 220 хоногт хадгалагддаг. Хөлдөлт нь 250 см гүнд 0°С байх ба хөрсний хөлдөлт нь нэвчих гүнээс гадна хөрсний механик бүтцээс хамаарч байдаг. Хөрсний гэсэлт дунджаар 4 дүгээр сарын 20-ноос 7 дугаар сар хүртэл 80 хоногт зам талбай, газрын дорхи шугам сүлжээ зэрэгт гажилт үүсэх зарим тохиолдолд эвдрэл үүсэх нөлөөтэй байдаг.

Газрын гадаргад ирж буй нарны цацрагийн зарим хэсэг түүнээс буцаж ойж, зарим хэсэг нь шингэдэг бөгөөд хөрсний дулааны горим, халах, хөрөх явц нь газрын гадаргад шингэсэн нарны цацрагийн хэмжээ, туяаруулж алдах дулааны хэмжээ хоёроос шууд хамааралтай байна. Газрын гадаргад шингэсэн нарны цацраг туяат энергээс дулааны энергид шилжин хөрс, газрын гадарга орчны агаарыг халаахын дээр хөрсний гүнд нэвтэрнэ. Харин шөнө нь нарнаас ирэх цацраг байхгүй учир хуримтлуулсан дулаанаа туяаруулан алдаж хөрс хөрнө. Энэ үед орчны агаар газрын гүн рүү мөн хөрнө. Өөрөөр хэлбэл, өдрийн цагт нарны цацраг ирж буй үед хөрс халж, шөнийн туяаруулалтын үед хөрдөг байна. Хөрсний дулааны ийм орлого, зарлагыг хөрсний дулааны баланс гэнэ. Хөрсний дулааны баланс өдөр нь эерэг, шөнө сөрөг, мөн жилийн дулааны улиралд эерэг, хүйтэн улиралд сөрөг тэмдэгтэй байдаг. Хөрсний дулааны балансын горим, хэмжээгээр хөрсний температурын нөөц тодорхойлогдох бөгөөд энэ нь олон талын хэрэгцээ бүхий ач холбогдолтой. Хөрсний температур нь ургамлын амьдралын туршид, ялангуяа хөгжлийн эхний үе буюу үр соёолох, үндэслэх үед онцгой нөлөө үзүүлнэ. Хөрсний температурын горим нь газар зүйн өргөрөг, цаг агаарын байдлаас гадна хөрсний төрөл, бүтэц, шинж чанар, дулаан дамжуулах чадвар, дулаан багтаамж, чийг, хотгор гүдгэр, налуугийн байдлаас шалтгаална. Агаарын температур нь агаар мандлын хийн хөдөлгөөн, физик үзэгдлийн улмаас бүрэлддэг байхад хөрсний температур нь амьд бие-органик бодис-эрдсийн зүйлийн нийлэг систем болох хөрсөн дэх физик химийн үзэгдлийн дүнд буй болно.

2.1.4. Агаарын даралт

Агаарын даралтаас хамааран хүний бие махбод орчиндоо дасан зохицох хугацаа өөр өөр байна. Хүний артерийн даралт хэлбэлзэж, цаг агаарын хямрал болоход агаарын даралтын хоног хоорондын зөрөө 8 гПа ба түүнээс ихсэхэд сөргөөр нөлөөлж, архаг өвчтэй хүмүүсийн өвчин хууч хөдлөх, хүчилтөрөгчийн хангамж багассанаас агаар таарахгүй болох, бүгчимдэх зэрэг хямрал үүсэх нөлөөтэй.

Агаарын даралт жилдээ 844 гПа (633 мм мөнгөн усны баганы өндөртэй), зуны саруудад буурч (837-840 гПа), өвлийн саруудад тогтвортой ихэсдэг (845-847 гПа) байна.

2.1.5. Чийгшлийн горим

Үнэмлэхүй чийгшлийг агаар дахь усны уурын даралтаар илэрхийлнэ. Улаанбаатар хотод үнэмлэхүй чийгшил жилийн дундаж байдлаар 4.4-4.8 гПа байна. Усны уурын даралт агаарын температураас голчлон хамаарах тул өвөл Буянт Ухаад хамгийн бага, зун

Тахилтад их, түүний жилийн явцын хамгийн их утга зун 11.2-12.3 гПа, хамгийн бага нь өвөл 0.5-1.0 гПа байна (6-р хүснэгт).

Хүснэгт 6. Агаарын чийгшлийн үзүүлэлтүүд

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Үнэмлэхүй чийгшил, гПа	0.5	0.8	1.8	2.9	4.6	8.6	12.0	10.4	6.2	3.3	1.4	0.7	4.4
Харьцангуй чийгшил, %	75	73	66	50	47	56	65	65	64	65	72	75	64
Дутагдал чийгшил, гПа	0.2	0.4	1.3	4.1	7.1	9.4	8.4	7.4	4.8	2.7	0.8	0.2	3.9

Эх үүсвэр: Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн

Агаарын чийгшил нь дэд бүтцийн салбарт хамгийн их нөлөө үзүүлдэг уур амьсгалын гол үзүүлэлт юм. Улаанбаатар хот орчим харьцангуй чийгшил жилийн дундаж байдлаар 61-64% орчим байх ба Хүрэл тогоотод хамгийн бага, Буянт Ухаад хамгийн их болно. Жилийн дундаж дутагдал чийгшил 3.5-3.9 гПа байна. Өвлийн улиралд агаарын температур бага, ханасан байдалдаа ойр байх тул дутагдал чийгшил хамгийн бага, 0.2-0.5гПа орчим байснаа агаарын температур нэмэгдэх тутам ихэссээр 6 дугаар сард хамгийн их 7.7-9.4 гПа болно. Энэ үед агаарын температур өндөр ч хур борооны үе бүрэн эхлээгүй байна. Харин 7, 8 дугаар сард дулаан ч гэсэн хур бороо их болохоор дутагдал чийгшил 6 дугаар сарынхаасаа буурна.



Зураг 7. Жилийн хур тунадасны хуваарилалт болон харьцангуй чийгийн явц

2.1.6. Хур тунадас

Улаанбаатарын хур тунадасны олон жилийн явцыг аваад үзвэл сүүлийн жилүүдэд огцом багасч байгаа харагддаг. Тухайлбал: 1961-2006 оны байдлаар хур тунадасны хэмжээ 0.399 мм/жил-ийн хурдтай, 1981-2006 оны хооронд 1.357 мм/жил-ийн хурдтай, 1990-2006 оны хооронд 5.0 мм/жил-ийн хурдтай бууралт явагдаж байна. Уур амьсгалын дулааралтын дэвсгэр дээр энэ бүс нутагт хур тунадасны эрчим нэмэгдэж байна. 2018-2022 оны хур тунадасны мэдээг 7-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7. Сарын нийлбэр хур тунадасны хэмжээ, мм-ээр (2018-2022)

Станц	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жилийн нийлбэр
Улаанбаатар	1.2	2.7	3.5	9.9	17.4	55.3	71.1	78.9	36.8	5.5	4.9	2.1	289.3
Буянт-Ухаа	1.1	3.5	2.9	11.3	14.0	54.3	81.2	78.5	33.6	5.4	4.8	2.0	292.6
Сарын дундаж	1.1	1.3	5.8	7.5	16.3	39.3	72.0	56.1	28.3	8.2	5.9	1.7	-

Эх үүсвэр: ЦУОШГ- Архив, мэдээллийн сангийн хэлтэс

Улаанбаатар хотод 289-293 мм хур тунадас унах бөгөөд түүний 90 хувь нь жилийн дулаан улиралд (4-9 дүгээр сарын хооронд) орно. Жилийн хүйтэн улиралд хур тунадас тун бага унана.

2.1.7. Салхины горим

Улаанбаатарын районд хотын төвөөр жилийн дундаж салхины хурд 1.4-1.9 м/с, Буянт-Ухаа орчмоор 2.9-3.1 м/с байна.

Хүснэгт 8. Жилийн дундаж салхины хурд

Станц	2018	2019	2020	2021	2022	5 жилийн дундаж
Улаанбаатар	1.7	1.9	1.4	1.9	1.8	1.7
Буянт-Ухаа	3.1	3.0	3.0	3.0	2.9	3.0

Эх үүсвэр: ЦУОШГ- Архив, мэдээллийн сангийн хэлтэс

Хүснэгт 9. Сарын салхины дундаж хурд, м/с (2018-2022)

Станц	Сар											
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Улаанбаатар	0.9	1.3	1.8	2.3	2.5	2.4	2.1	1.9	2.1	1.7	1.3	0.9
Буян-Ухаа	1.6	2.1	3.0	4.0	4.6	4.0	3.4	3.1	3.3	3.0	2.2	1.6

Эх үүсвэр: ЦУОШГ- Архив, мэдээллийн сангийн хэлтэс

Хамгийн салхи ихтэй хаврын сарын салхины дундаж хурд 2.3-4.6 м/с байна. Янз бүрийн хурдтай салхины давтагдлыг аваад үзвэл өвлийн улиралд 0-1 м/с хурдтай салхи зонхилдог, хаврын улиралд 3-4 м/с-ийн хурдтай салхины давтагдал ихээхэн өсч зонхилох байдалтай болдог байх юм.

Хүснэгт 10. Салхины их хурд, м/с

	Он	Сар											
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Буянт-Ухаа	2014	14	14	19	20	19	16	16	18	21	15	14	10
	2015	14	14	15	19	24	20	23	22	22	17	13	13
	2016	12	15	19	20	19	16	15	16	15	17	14	11
	2017	13	17	15	19	20	24	17	17	17	13	13	14
	2018	11	14	18	19	22	17	17	15	17	14	16	12

Эх үүсвэр: ЦУОШГ- Архив, мэдээллийн сангийн хэлтэс

Буянт-Ухаа станц дээрх хамгийн их хурдыг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл 2015 оны 5 дугаар сар, 2017 оны 6 дугаар сард 24 м/с хүрсэн байна.

Хүснэгт 11. Буянт-Ухаа станцын 2018-2022 оны салхины чиглэл, салхигүй үеийн давтагдал (%)

Сар	Салхигүй	Х	ЗХ	З	ЗӨ	Ө	БӨ	Б	БХ
I	12.8	0.8	4.9	42.1	9.5	2.3	8.5	24.1	8.0
II	9.2	1.9	7.9	35.2	6.6	1.9	6.1	29.5	11.1
III	6.2	2.9	14.6	26.3	5.4	1.9	7.3	25.3	16.3
IV	6.1	5.6	14.2	18.6	5.6	3.1	6.6	25.4	20.8
V	4.8	5.3	13.6	17.0	6.0	2.5	8.5	21.6	25.4
VI	6.9	7.8	18.0	17.1	7.5	3.9	8.1	16.2	21.4
VII	9.8	6.7	19.6	20.9	10.6	4.2	7.9	13.5	16.7
VIII	6.0	4.3	18.9	23.3	7.3	4.2	8.4	14.7	18.9
IX	5.9	3.7	16.5	23.1	5.0	3.3	7.8	20.1	20.6
X	8.1	2.8	14.4	28.0	5.3	2.1	7.3	25.3	14.9
XI	9.6	1.2	9.7	42.4	8.6	2.8	5.8	19.2	10.3
XII	13.0	0.8	6.7	41.0	10.8	1.4	8.0	23.0	8.5
Жилийн дундаж	8.2	3.6	13.2	27.9	7.3	2.8	7.5	21.5	16.1

Эх үүсвэр: ЦУОШГ- Архив, мэдээллийн сангийн хэлтэс

Дээрх хүснэгтээс үзвэл Буянт-Ухаа орчимд жилийн дундаж байдлаар зүүн зүгийн салхи 27.9 %-ийн давтагдалтай зонхилох ба ялангуяа өвлийн улиралд энэ чиглэлийн салхины давтагдал илт давамгайлна. Энэ бол Туулын хөндий дагасан хажуугийн салхи юм. Өөрөөр хэлбэл агаарын температурын хүчтэй инверситэй үед хүйтэн агаар өндөрлөг газраасаа нам газар луугаа хүндийн хүчээр урсаж байгаа нь энэ юм. Туул гол дагасан зүүний зовхисын салхи давтагдал ихтэй юм.



Зураг 8. Буянт-Ухаа орчмын сүүлийн 5 жилийн зарим саруудын салхины чиглэлийн давтагдал, %

2.1.8. Нарны гийгүүлэл, цацраг

Нарны гийгүүлэл жилдээ 2636 цаг үргэлжилдэг нь боломжит хугацааныхаа 60 орчим хувийг эзэлдэг бөгөөд орчны уулс болон өглөө, оройн нарны халхлагдал, тухайн орчны үүлшил, агаарын булингаршил зэрэгтэй холбоотойгоор буурдаг. Нарны гийгүүлэл нь хоног, сар, жилийн хугацаагаар цэлмэг үед нэн тодорхой явцтай. Нэг өдөрт дунджаар 7-8 цаг нар гийгүүлэхдээ үүлшлээс хамаарч хэлбэлзэх боловч, зуны саруудад 8.5-9.5 цаг, өвлийн саруудад энэ хугацаа богиносож 5.5-6.5 цаг нартай байдаг. Нарны цацраг, нарны гийгүүлэл, үүлшил зэрэгтэй холбоотойгоор нарны өндрөөс ихээхэн хамаарч, нийлбэр цацраг жилдээ 4490 мДж/м^2, шулуун цацраг 2500 мДж/м^2 тус тус ирдэг. Нарны цацраг нарны өндөр ихэссэн, үүлшил бага байдаг 5, 6 дугаар саруудад хамгийн их, нарны өндөр хамгийн бага буюу 12 дугаар сар болон өвлийн саруудад бага байдаг.

2.1.9. Хөрсний температур

Газрын гадарга дээр тусч байгаа нарны цацрагийн зарим хэсэг хөрсөнд шингэж, туяат энергээс дулаан энергид шилжин хөрсний гүний давхаргуудыг халааж, хөрсөнд ургамлын амьдралыг тэтгэх физик химийн процессууд хөрсний температурын нөлөөгөөр явагддаг. Энэхүү зарцуулагдсан дулааны хэмжээ нь хөрсний бүтэц, шинж чанар, өнгө, дулаан дамжуулах чадал, дулааны багтаамж, чийгшил, газрын гадаргын хотгор гүдгэр, налуугийн байдал зэргээс шалтгаална. Энэ орчинд жилийн дундаж хөрсний температур газрын гадарга дээр хасах 0.6°С-аас -1.1°С орчим байх бөгөөд газрын гүн рүү дулаарч байдаг. Харин хүйтэн, дулааны газрын гүнд нэвчих нэвчилтийн хувьд авч үзвэл 0.8-1.2 м-т ялихгүй хүйтэрснээ цааш гүн рүүгээ бүр дулаарч, 1.6-3.2 метрт 2.0°С -2.4°С болдог зүй тогтолтой байна.

Хүснэгт 12. Хөрсний уур амьсгалын бэсрэг мужийн үзүүлэлт

Хөрсний хөлдөлт			Хөрсний гэсэлт			0°С нэвчих гүн, см
Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног	
10.X	10.YI	220	20.IY	1.YII	80	400

Энд хөрс өнгөнөөсөө гүн рүү дунджаар 10 дугаар сарын 10-наас 6 дугаар сарын 10 хүртэл алгуур хөлдөж, нийт 220 хоногт хадгалагддаг. Хөлдөлт нь 250 см гүнд 0°C байх ба хөрсний хөлдөлт нь нэвчих гүнээс гадна хөрсний механик бүтцээс хамаарч байдаг. Хөрсний гэсэлт дунджаар 4 дүгээр сарын 20-ноос 7 дугаар сар хүртэл 80 хоногт зам талбай, газрын доорх шугам сүлжээ зэрэгт гажилт үүсэх, зарим тохиолдолд эвдрэл үүсэх нөлөөтэй байдаг.

Газрын гадаргад ирж буй нарны цацрагийн зарим хэсэг түүнээс буцаж ойж, зарим хэсэг нь шингэдэг бөгөөд хөрсний дулааны горим, халах, хөрөх явц нь газрын гадаргад шингэсэн нарны цацрагийн хэмжээ, туяаруулж алдах дулааны хэмжээ хоёроос шууд хамааралтай байна. Газрын гадаргад шингэсэн нарны цацраг туяат энергээс дулааны энергид шилжин хөрс, газрын гадарга орчны агаарыг халаахын дээр хөрсний гүнд нэвтэрнэ. Харин шөнө нь нарнаас ирэх цацраг байхгүй учир хуримтлуулсан дулаанаа туяаруулан алдаж хөрс хөрнө. Энэ үед орчны агаар газрын гүн рүү мөн хөрнө. Өөрөөр хэлбэл, өдрийн цагт нарны цацраг ирж буй үед хөрс халж, шөнийн туяаруулалтын үед хөрдөг байна. Хөрсний дулааны ийм орлого, зарлагыг хөрсний дулааны баланс гэнэ. Хөрсний дулааны баланс өдөр нь эерэг, шөнө сөрөг, мөн жилийн дулааны улиралд эерэг, хүйтэн улиралд сөрөг тэмдэгтэй байдаг. Хөрсний дулааны балансын горим, хэмжээгээр хөрсний температурын нөөц тодорхойлогдох бөгөөд энэ нь олон талын хэрэгцээ бүхий ач холбогдолтой. Хөрсний температур нь ургамлын амьдралын туршид, ялангуяа хөгжлийн эхний үе буюу үр соёолох, үндэслэх үед онцгой нөлөө үзүүлнэ. Хөрсний температурын горим нь газар зүйн өргөрөг, цаг агаарын байдлаас гадна хөрсний төрөл, бүтэц, шинж чанар, дулаан дамжуулах чадвар, дулаан багтаамж, чийг, хотгор гүдгэр, налуугийн байдлаас шалтгаална. Агаарын температур нь агаар мандлын хийн хөдөлгөөн, физик үзэгдлийн улмаас бүрэлддэг байхад хөрсний температур нь амьд бие-органик бодис-эрдсийн зүйлийн нийлэг систем болох хөрсөн дэх физик химийн үзэгдлийн дүнд буй болно.

2.2. ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ

Улаанбаатар хот орчим, Туул голын сав газрын хэмжээнд 2001-2022 оны хооронд 9 төрлийн нийт 42 удаагийн гамшигт үзэгдэл тохиолдсон байна. Түүнээс аадар бороо, уруйн үер нийт тохиолдлын 24%, хүчтэй салхи (цасан болон шороон шуурга) 22% тус тус байна. Олон жилийн явцаас үзвэл гамшигт үзэгдлийн тоо буурах хандлагатай, харин аадар бороо, уруйн үерийн гамшигт үзэгдэл нэмэгдэх хандлагатай байна.



Зураг 9. Гамшигт үзэгдлийн тохиолдол, 2001-2022

2.3. УЛААНБААТАР ХОТЫН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээг хийхдээ түүхийн хугацаанд хамгийн урт ажиглалтын цуваатай цаг уурын станцын мэдээг ашиглан жилийн дундаж агаарын температур, жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явцыг гаргаж шугаман трендийн аргаар (өнцгийн коэффициентоор) үнэлэв.

Дараах зурагт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө харьцангуй сул байсан 1961-1990 оны суурь үетэй харьцуулсан тэдгээрийн хазайцын олон жилийн явцыг үзүүлэв. Улаанбаатар

хотод 1990-ээд оноос эхлэн харьцангуй дулаан жилүүд өнөөг хүртэл үргэлжилж байгаа бөгөөд дулаарлын эрчим 1940 оноос хойш 2.49^{0}C-аар нэмэгджээ. Жилийн нийлбэр хур тунадас мөн хугацаанд 6.6% нэмэгдсэн нь 1995-2010, 2013-2022 хур бороо багатай хуурай үе тохиолдсоныг Зураг 9-өөс харж болно.



Зураг 10. Цаг уурын Буянт-Ухаа станцын жилийн a) дундаж температур, (b) нийлбэр хур тунадасны олон жилийн явц, хандлага

Хүснэгт 13-д цаг уурын Буянт-Ухаа станцаар Улаанбаатар хотын улирлын уур амьсгалын өөрчлөлтийг суурь үетэй харьцуулсан дүнг температур (^{0}C), хур тунадасаар (%) үзүүлэв. Агаарын температурын өөрчлөлтийн эрчимшил өвлийн улиралд 4.1^{0}C, харин зуны улиралд 1.66^{0}C байгаа нь өвөл харьцангуй их эрчимтэй дулаарсан байна. Хур тунадасны хувьд зуны хур бороо голын сав газрын дунд, адаг орчим 10.8%-аар буурсан бол өвлийн цас голын эх орчимд 34.0%-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 13. Улирлын уур амьсгалын өөрчлөлт (1941-2023)

Станцын нэр	Температур, ^{0}C		Хур тунадас, мм	
	Өвөл	Зун	Өвөл	Зун
Буянт-Ухаа	4.1 (-22.5)	1.66 (15.4)	34.0 (5.1 мм)	1.7 (183.4 мм)

ГУРАВ. АГААРЫН ЧАНАР, ФИЗИК БОХИРДОЛ

Шинэ тойрог автозамын трасс нь Улаанбаатар хотын 5 дүүргийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрч байгаа тул Улаанбаатар хотын агаарын чанарын шинжилгээний мэдээгээр төлөв байдлыг тодорхойлов.

3.1. ТҮГЭЭМЭЛ АГААР БОХИРДУУЛАГЧИЙН ҮҮСЭХ ПРОЦЕСС БОЛОН ШИНЖ ЧАНАР

Хүхэрлэг хий: Хүхэрлэг хий (SO_2) нь хүхэр агуулсан түлшний шаталтаас үүсэх бөгөөд орчныг бохирдуулагч хортой хий. Хүхэрлэг хий нь нүүрс ашигладаг дулааны цахилгаан станц, үйлдвэр, металлург, гангийн үйлдвэр, нүүрс шатаадаг ахуйн зуух, тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүснэ. Хүхэрлэг хийний хоруу чанар нь өндөр концентрацитай үед амьсгал давчдах, хоолой хорсох гэх мэт шинж тэмдэг илэрдэг бөгөөд амьсгалын замын эрхтэний системийг гэмтээдэг.

Азотын давхар исэл. Азотын давхар исэл (NO_2) нь өндөр температуртай шаталтын үед дулаан шингэх урвалын үр дүнд үүсэх бөгөөд хүрээлэн байгаа орчныг бохирдлын бас нэг шалтгаан юм. Гол эх үүсвэр нь тээврийн хэрэгслийн шатахууны шаталт, дулааны цахилгаан станц гэх мэт. Газрын гадарга дээрх озон нь азотын давхар ислийн дам бүтээгдэхүүн бөгөөд хүчтэй исэлдүүлэгч тул озоны агууламж ихэсвэл амьтан ургамлын гаднах эд эсийг гэмтээдэг. Азотын исэлүүд нь амьсгалын замын цочмог үрэвсэл, багтраа бронхит үүсгэх нөлөөтэй.

Нүүрстөрөгчийн дутуу исэл: Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) нь ихэнхдээ шаталтын процессын завсрын бүтээгдэхүүн, ялангуяа стехиометрийн шаталтын нөхцөлд үүсдэг. Гэсэн хэдий ч шаталтаас ялгардаг CO-ийн хамаарал нь CO_2-тай харьцуулахад тийм ч өндөр биш юм. Дутуу шаталт явагдахад CO-ийн ялгаруулалт ихээхэн хэмжээгээр үүсч болно. Нүүрстөрөгчийн дутуу исэл нь хүчилтөрөгчийн дутагдал үүсгэдэг бөгөөд зүрх судасны системийг хэт ачаалдаг. Нүүрстөрөгчийн дутуу ислээр амьсгалсны дараа хүний толгой эргэх, толгой өвдөх цаашлаад хүнд хордлогын үед комд орж бүр үхэх аюултай.

Тоос тоосонцор: Хот суурин газрын агаарт янз бүрийн эх үүсвэрээс үүдэлтэй тоос тоосонцор байх ба тэдгээрийн аэродинамик хэмжээ, химийн найрлага, усанд уусах шинж чанар, гэрлийг шингээх, ойлгох, орчны агаар дахь агууламж зэргээс хамаараад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байдаг.

Дуу шуугиан, доргио: Шуугиан ба доргио нь хүрээлж буй орчинд хэлбэлзэх долгион хэлбэрээр тархаж, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Шуугиан ба доргионы тархалтын зүй тогтол нь ижил, байгаль орчин (хүн, амьтан, ургамал, хот, барилга байгууламж)-д үзүүлэх сөрөг нөлөө нь төстэй юм. Шуугиан ба доргионы үндсэн эх үүсвэр нь төрөл бүрийн аж үйлдвэрийн болон засварын газрууд, автотээврийн, агаарын ба төмөр замын тээврийн хэрэгслүүд юм.

3.2. АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН СУУРИН ХАРУУЛУУДЫН БАЙРШИЛ, ТЭДГЭЭРИЙН ХЭМЖИЛТ ХИЙДЭГ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улаанбаатар хотын хэмжээнд 19 байршилд агаарын чанарыг хянах зорилготой харуулууд ажиллаж байна. Харуулуудын байршлыг доорх зурагт үзүүлэв.



Зураг 11. УБ хотын агаарын чанарыг хянах харуулуудын байршил

3.3. УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Улаанбаатар хотын агаарын чанарыг 2023 онд гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 17 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3)-ы агууламжийг автомат багажаар тодорхойлсон байна.

Агаар бохирдуулах бодисын 2023 оны жилийн дундаж агууламжийг 2022 оны жилийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор ижил түвшинд, хүхэрлэг хий 7 мкг/м^3-ээр буюу 11%-аар, PM10 тоосонцор 6 мкг/м^3-ээр буюу 7 %-аар, азотын давхар исэл 1 мкг/м^3-ээр буюу 2 %-аар тус тус бага байна (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламж, 2020-2023 он

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Жилийн дундаж агууламж, мкг/м^3			
	Хүлцэх агууламж, мкг/м^3	2020 он	2021 он	2022 он	2023 он
PM2.5 тоосонцор	25	49	44	41	41
Хүхэрлэг хий, SO_2	20	47	66	63	56
PM10 тоосонцор	50	90	89	88	82
Азотын давхар исэл, NO_2	40	37	36	40	39

PM2.5 тоосонцор

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2023 оны жилийн дундаж агууламж 41 мкг/м^3 буюу 2022 онтой ижил түвшинд байна.

2012-2023 онд Агаарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.6-4.2 дахин их байсан ба хамгийн их агууламж нь 2012 онд, хамгийн бага агууламж нь 2022-2023 онд байна.

Сүүлийн 10 жилийн дүнгээс харахад PM2.5 тоосонцрын агууламж 2022, 2023 онд өмнөх жилүүдээс багассан буюу 2012 онтой харьцуулахад 2.5 дахин бага байна (Зураг 12).



Зураг 12. Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж

Дулааны улиралд PM2.5 тоосонцрын 24 цагийн дундаж агууламж агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан тохиолдол цөөн ажиглагддаг бол хүйтний улиралд хүлцэх агууламжаас ихэнх цэгт давсан бохирдолтой байна (Зураг 13).

PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж 2023 онд хүлцэх агууламжаас Баруун 4 зам (УБ-2) орчим 1.3, 1-р хороолол (УБ-3) орчим 2.1, Хайлааст (УБ-11) орчим 2.5, 5-н буудал (УБ-12) орчим 2.5, Налайх (УБ-15) орчим 1.5, Нисэх орчим 1.2, Толгойт орчим 1.4, Зурагт орчим 1.9, Амгалан орчим 1.2, Баянхошуу орчим 3.1 дахин тус тус их байна.

Харин 13-р хороолол (УБ-4), Богд хааны ордон музей (УБ-13) орчим жилийн дундаж агууламж нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Агаар дахь PM2.5 тоосонцрын хяналт шинжилгээг 2023 онд нийт 13 цэгт хийсэн ба 24 цагийн дундажаар 3985 удаа хэмжсэнээс 961 удаа буюу нийт хэмжилтийн 24%-д хүлцэх агууламжаас давсан ба энэ нь 2022 онтой харьцуулахад 85 %-иар их байна.

2023 онд хамгийн их агууламж Баянхошуу орчимд 510 мкг/м^3 хүрч байсан бол, 2023 онд мөн Баянхошуу орчимд 557 мкг/м^3 хүрч хүлцэх агууламжаас 11.1 дахин их, мөн өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 13. Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 24 цагийн дундаж агууламж

Хүхэрлэг хий-SO_2

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн 2023 оны жилийн дундаж агууламж 56 мкг/м^3 буюу 2022 онтой харьцуулахад 7 мкг/м^3-ээр буюу 11%-аар бага. 2000-2023 онд хүлцэх агууламжаас 1.1-3.3 дахин их байсан ба жилийн дундаж хамгийн их агууламж 2021 онд 66 мкг/м^3 байна (Зураг 14).

Зураг 14. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж

Хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламжийн явцаас харахад 2023 оны 4 дүгээр сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас бага буюу агаарын чанарын индексээр цэвэр, хэвийн түвшинд байна.

Харин хүйтний улирлын 1-4, 10-12 дугаар сард хүлцэх агууламжаас хяналтын бүх цэгт давж, агаарын бохирдол эрс ихэссэн байна. Хүхэрлэг хийн 24 цагийн дунджийн хамгийн их агууламж нь 2023 оны 12 дугаар сард илэрсэн байна (Зураг 15).

Хүхэрлэг хийн 2023 оны жилийн дундаж агууламжийг агаарын чанарын хяналт шинжилгээний харуул тус бүрээр харахад хүлцэх агууламжаас Мишээл экспо (УБ-1) орчим 1.3, Баруун 4-н зам (УБ-2) орчим 1.4, 1-р хороолол (УБ-3) орчим 4.6, Бөхийн өргөө (УБ-4) орчим 1.3, 100-н айл (УБ-5) орчим 1.8, Цахилгаан станц (УБ-7) орчим 1.1, Ургах наран хороолол (УБ-8) орчим 1.1, Хайлааст (УБ-11) орчим 2.9, 5-н буудал (УБ-12) орчим 2.9, Шархад (УБ-14) орчим 3.3, Налайх (УБ-15) орчим 2.7, Нисэх орчим 2.6, Толгойт орчим 4.8, Зураг орчим 4.7, Амгалан орчим 2.8, Баянхошуу орчим 6.9 дахин тус тус их, харин Зайсан (УБ-13) орчим хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Хүхэрлэг хийн хяналт шинжилгээг 2023 онд нийт 17 цэгт 24 цагийн дундажаар 5586 удаа хэмжилт хийснээс 1579 удаа буюу нийт хэмжилтийн 28%-д хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдсан ба энэ нь 2022 онтой харьцуулахад 28 %-иар бага байна. Хяналт шинжилгээний нийт дүнгээс харахад хүхэрлэг хийн 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баянхошуу орчимд 748 мкг/м^3 хүрч, хүлцэх агууламжаас 14.9 дахин их. Харин 2022 оны хамгийн өндөр агууламж Зурагт орчим 765 мкг/м^3 хүрч байсан бол 2023 онд хамгийн их агууламж 17 мкг/м^3-ээр бага байна.

Хүхэрлэг хий нь хүхэр агуулагдсан төрөл бүрийн нүүрс, сайжруулсан түлш автобензин зэрэг органик гаралтай түлшний шаталтаас голчлон үүсдэг ба жилийн хамгийн хүйтэн үед буюу 1-2, 11-12 дугаар саруудад түүхий нүүрсний хэрэглээ болон авто тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалттай хамааралтай ихэсдэг байна.



Зураг 15. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламж

PM10 тоосонцор

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 2023 оны жилийн дундаж агууламж 82 мкг/м^3 буюу 2022 онтой харьцуулахад 6 мкг/м^3-ээр буюу 7 %-аар бага. Хамгийн их агууламж 2012 онд, хамгийн бага агууламж 2023 онд байна. Сүүлийн 13 жилийн дүнгээс харахад PM10 тоосонцрын агууламж 2020-2023 онд өмнөх жилүүдээс 35-171 мкг/м^3-аар бага байна (Зураг 16).



Зураг 16. Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 24 цагийн дундаж агууламж дулааны улиралд Баянхошуу, Цахилгаан станц, Хайлааст, 100 айл орчимд, хүйтний улиралд Зайсангаас бусад нь агаарын чанарын стандартаас давсан байна.

Хүйтний улиралд нүүрсний шаталтаас ялгарч байгаа тоосонцор агаарыг бохирдуулж байгаа бол дулааны улиралд хавар, зуны хуурайшилт ихтэй үед салхиар дэгдэх сул шороо, авто зам, замын болон барилгын ажил зэргээс үүсэх тоосонцор агаарт их байгааг судалгаагаар тогтоосон байдаг.

Агаар дахь PM10 тоосонцрын өдөр тутмын агууламжаас харахад PM2.5 тоосонцор болон хүхэрлэг хийн агууламж шиг хүйтний улиралд эрс өсч, дулааны улиралд хүлцэх агууламжаас бага байдаг зүй тогтол харьцангуй сул ажиглагдаж байгаа нь харагдаж байна (Зураг 17).

Хүйтний улиралд түүхий нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шаталтаас үүсэх хаягдал утаа, хуурайшилт зэрэг улирлын онцгой нөлөөллүүд болон цаг агаарын төлөв байдал буюу агаарын температур, салхины хурд, инверс, тунадас зэрэгтэй холбоотойгоор тоосонцрын агууламж агаарт нэмэгдэх шалтгаан болдог байна.

PM10 тоосонцрын 2023 оны жилийн дундаж агууламжийг агаарын чанарын хяналт шинжилгээний харуул тус бүрээр харахад хүлцэх агууламжаас Мишээл экспо (УБ-1) орчим 1.2, Баруун 4-н зам (УБ-2) орчим 1.7, 1-р хороолол (УБ-3) орчим 2, Бөхийн өргөө (УБ-4) орчим 1.6, 100-н айл (УБ-5) орчим 2.2, Цахилгаан станц (УБ-7) орчим 2.2, Ургах наран хороолол (УБ-8) орчим 1.4, Хайлааст (УБ-11) орчим 1.8, 5-н буудал (УБ-12) орчим 1.6, Шархад (УБ-14) орчим 1.8, Налайх (УБ-15) орчим 1.3, Зурагт орчим 1.2, Амгалан орчим 1.5, Баянхошуу орчим 3.1 дахин тус тус их, харин Зайсан (УБ-13), Нисэх, Толгойт орчим агаарын чанарын хүлцэх агууламжаас даваагүй байна.

Агаар дахь PM10 тоосонцрын хяналт шинжилгээг нийт 17 цэгт хийсэн ба 24 цагийн дундажаар 2023 онд 5714 удаа хэмжилт хийснээс 1604 удаа буюу нийт хэмжилтийн 28%-д хүлцэх агууламжаас давсан ба энэ нь 2022 онтой харьцуулахад 20%-иар бага байна.

2023 онд PM10 тоосонцрын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баянхошуу орчимд 607 мкг/м^3 хүрч, хүлцэх агууламжаас 6 дахин их. Харин 2022 оны хамгийн өндөр агууламж мөн Баянхошуу орчим 684 мкг/м^3 хүрч байсан бол 2023 онд хамгийн их агууламж 77 мкг/м^3-ээр бага байна.



Зураг 17. Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 24 цагийн дундаж агууламж

Азотын давхар исэл, NO_2

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн 2023 оны жилийн дундаж агууламж 39 мкг/м^3 буюу 2022 онтой харьцуулахад 1 мкг/м^3-ээр буюу 2 %-аар бага. Сүүлийн 23 жилд Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн жилийн дундаж агууламж 2013 онд хамгийн их хэмжээнд хүрч агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжтай

харьцуулахад 2 дахин их байсан бол 2016-2023 онд хүлцэх агууламжаас хэтрээгүй байна (Зураг 18).

Зураг 18. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн жилийн дундаж агууламж

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламжаас харахад хүйтний улиралд буюу 1-4, 10-12 дугаар сард бохирдлын хэмжээ бусад сараас их ба томоохон төв автозамуудын орчимд бохирдол илүү байгаа нь Баруун 4 зам (УБ-2), 13-р хороолол (УБ-4) болон Цахилгаан станц (УБ-7) харуулын дүнгээс харагдаж байна (Зураг 19).

Азотын давхар ислийн 2023 оны жилийн дундаж агууламжийг агаарын чанарын хяналт шинжилгээний харуул тус бүрээр харахад хүлцэх агууламжаас Баруун 4-н зам (УБ-2) орчим 1.9, 1-р хороолол (УБ-3) орчим 1.3, Бөхийн өргөө (УБ-4) орчим 1, Цахилгаан станц (УБ-7) орчим 1, Шархад (УБ-14) орчим 1.1 дахин тус тус их.

Харин Мишээл экспо (УБ-1), 100-н айл (УБ-5), Ургах наран хороолол (УБ-8), Хайлааст (УБ-11), 5-н буудал (УБ-12), Зайсан (УБ-13), Налайх (УБ-15), Нисэх, Зурагт Амгалан орчим агаарын чанарын хүлцэх агууламжаас даваагүй байна.

Азотын давхар ислийн хяналт шинжилгээг 24 цагийн дундажаар нийт 5067 удаа хэмжилт хийснээс 1333 удаа буюу 26%-д хүлцэх агууламжаас давсан нь 2022 онтой харьцуулахад 19%-иар бага байна. 2023 оны 12 дугаар сард азотын давхар ислийн 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 100-н айл орчимд 243 мкг/м3 хүрч, хүлцэх агууламжаас 4.8 дахин их байна.

Агаарын бохирдлын эх үүсвэрүүдээс ялгарсан азотын нэгдлүүд нь тогтворгүй байдаг ба агаарт нарны гэрлийн нөлөөгөөр хүчилтөрөгчтэй фотохимийн урвалд орж гадарга орчмын буюу трофосферийн озоныг үүсгэдэг бөгөөд агаарын температур буурч цаг агаар хүйтрэх тусам агаар дахь азотын давхар ислийн агууламж ихэсч, озоны агууламж буурдаг зүй тогтолтой байдаг.



Зураг 19. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламж

Нүүрстөрөгчийн дутуу исэл, CO

Нүүрстөрөгчийн дутуу исэл нь бүх төрлийн дутуу шаталтаас агаарт ялгардаг бөгөөд богино хугацаанд хүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөөлөл учруулдаг бохирдуулах бодис юм.

Агаар дахь нүүрстөрөгчийн дутуу ислийн 2010-2023 оны жилийн дундаж агууламж 863-1410 мкг/м^3 байсан ба хамгийн их агууламж 2021 онд, хамгийн бага агууламж 2013 онд илэрсэн байна. 2023 онд нүүрстөрөгчийн дутуу ислийн жилийн дундаж агууламж 1241 мкг/м^3-д хүрч, 2022 онтой харьцуулахад 36 мкг/м^3-ээр буюу 3%-иар бага байна.



Зураг 20. Улаанбаатар хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу ислийн жилийн дундаж агууламж

2023 онд нүүрстөрөгчийн дутуу ислийг 8 цагийн дундажаар нийт 15829 удаа хэмжсэнээс агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас Баруун 4-н зам (УБ-2) орчим 3 удаа, 1-р хороолол (УБ-3) орчимд 13 удаа, 100-н айл (УБ-5) орчим 1 удаа, Хайлааст (УБ-11) орчимд 6 удаа, Шархад орчимд 6 удаа, Нисэх орчим 5 удаа, Толгойт орчимд 48 удаа, Зурагт орчимд 17 удаа тус тус давсан бөгөөд нийт 99 удаа буюу бүх хэмжилтийн 0.6%-д давсан байна.

Нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж хүйтний улиралд эрс ихэсдэг боловч хүрээлэн байгаа агаарт хүлцэх агууламжаас давах тохиолдол харьцангуй цөөн тохиолддог.



Зураг 21. Улаанбаатар хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу ислийн 8 цагийн дундаж агууламж

Озон, O_3

Агаарын бохирдлын эх үүсвэрүүдээс агаарт шууд хаягдаж байгаа бохирдуулах бодис (хүхэрлэг хий, азотын ислүүд, нүүрс устөрөгчид) нарны хэт ягаан туяаны нөлөөгөөр урвалд орж, гадарга орчмын озон үүсдэг ба халуун, хурц нартай өдрүүд үргэлжлэх зуны улиралд агаар дахь озоны агууламж ихэсдгээрээ бусад бохирдуулах бодисуудаас онцлог байдаг.

Озон нь нүүрстөрөгчийн дутуу ислийн адил богино хугацаанд хүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөөлөл учруулдаг бохирдуулах бодис юм. Иймд агаарын чанарын стандартад богино хугацааны буюу 8 цагийн дунджаар хүлцэх агууламжийг тогтоосон байдаг.

Агаар дахь озоны 2011-2023 оны жилийн дундаж агууламж 19-40 мкг/м^3 байсан ба хамгийн их агууламж 2017 онд, хамгийн бага агууламж 2012 онд илэрсэн байна. 2023 онд озоны жилийн дундаж агууламж 28 мкг/м^3-д хүрч 2022 онтой харьцуулахад 4 мкг/м^3-аар буюу 12 хувиар бага байна.



Зураг 22. Улаанбаатар хотын агаар дахь озоны жилийн дундаж агууламж

Озоны 8 цагийн дундажаар 2023 онд нийт 10068 удаа хэмжсэнээс агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас Нисэх орчимд 26 удаа, Толгойт орчимд 17 удаа, Зурагт орчимд 3 удаа, Амгалан орчимд 4 удаа буюу нийт 50 удаа давсан байна.

Дээр дурьдсан Улаанбаатар хотын хяналт шинжилгээний дүнгээс харахад агаар дахь түгээмэл бохирдуулах бодисуудын агууламж (озоноос бусад) нь хүйтний улиралд галлагаатай холбоотойгоор эрс нэмэгддэг байна. Иймд өнгөрсөн оны хүйтний улирлын буюу 2021-2023 оны 1-4, 10-12 дугаар сарын агаарын чанарын талаарх мэдээллийг энэхүү тайланд нэмэлтээр оруулаа.



Зураг 23. Улаанбаатар хотын агаар дахь озоны 8 цагийн дундаж агууламж

3.4. УЛААНБААТАР ХОТЫН ХҮЙТНИЙ УЛИРЛЫН АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ (2021-2025 ОН)

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 19 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг тасралтгүй хэмжилтийн автомат багажаар тодорхойлж байна.

Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын 2025 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад азотын давхар исэл (NO_2) нь 12 мкг/м^3-ээр буюу 18%-иар, хүхэрлэг хий (SO_2) нь 33 мкг/м^3-ээр буюу 28%-иар, PM2.5 тоосонцор 21 мкг/м^3-ээр буюу 24%-иар тус тус бага, харин PM10 тоосонцор 6 мкг/м^3-ээр буюу 6%-иар их байна.

Хүснэгт 15. Агаар дахь бохирдуулах бодисын 2024, 2025 оны 02 дугаар сарын дундаж агууламж

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 Хүлцэх агууламж, мкг/м^3	Сарын дундаж агууламж, мкг/м^3	
		2024 оны 02 дугаар сар	2025 оны 02 дугаар сар
PM10 тоосонцор	100	107	113
PM2.5 тоосонцор	50	86	65
Хүхэрлэг хий, SO_2	50	117	84
Азотын давхар исэл, NO_2	50	65	53

Эх үүсвэр: ЦУОШГ, www.tsag-agaar.gov.mn

Улаанбаатар хотын 2025 оны 02 дугаар сарын агаар бохирдуулах гол бохирдуулагч бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг доорх зурагт харууллаа (Зураг 24).



Зураг 24. 2024, 2025 оны 02 дугаар сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламж

Улаанбаатар хотын сүүлийн 5 жилийн хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт харуулав.

PM2.5 тоосонцор



Зураг 25. PM2.5 тоосонцрын 02 дугаар сарын дундаж агууламж, 2021-2025 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2025 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2 мкг/м^3-ээр буюу 3 %-иар их, 2022, 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 5-13 мкг/м^3-ээр буюу 7-17 %-иар бага, 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 21 мкг/м^3-ээр буюу 24%-иар бага байна. (Зураг 25).



Зураг 26. PM2.5 тоосонцрын 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр

2025 оны 02 дугаар сарын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж Мишээл экспо 45 мкг/м^3, 100-н айл 61 мкг/м^3, Цахилгаан станц 73 мкг/м^3, Ургах наран хороолол 43 мкг/м^3, 5-н буудал 97 мкг/м^3, Налайх 53 мкг/м^3, Яармаг 48 мкг/м^3 байна. Харин 2024 оны 02 дугаар сартай харьцуулахад Хайлааст АЧС-аас 77 мкг/м^3-ээр, Шархад 30 мкг/м^3-ээр, Нисэх 5 мкг/м^3-ээр, Зурагт 16 мкг/м^3-ээр, Амгалан 12 мкг/м^3-ээр, Баянхошуу 101 мкг/м^3-ээр, Дамбадаржаа 31 мкг/м^3-ээр тус тус бага, харин Баруун 4-н зам 9 мкг/м^3-ээр, 1-р хороолол 20 мкг/м^3-ээр, Бөхийн өргөө 4 мкг/м^3-ээр, Зайсан 5 мкг/м^3-ээр, Толгойт 34 мкг/м^3-ээр тус тус их байсан байна. (Зураг 26).

PM10 тоосонцор



Зураг 27. PM10 тоосонцрын 01 дүгээр сарын агууламж, 2021-2025 он

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 2025 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 15 мкг/м^3-ээр буюу 15 %-иар их, харин 2022, 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжаас 3-15 мкг/м^3-ээр бага буюу 2-12 %-иар бага, 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжаас 6 мкг/м^3-ээр буюу 6 %-иар их байна (Зураг 27).



Зураг 28. PM10 тоосонцрын 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр

2025 оны 02 дугаар сарын PM10 тоосонцрын дундаж агууламж Яармаг 82 мкг/м^3 байна. Харин 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 100-н айл 36 мкг/м^3-ээр, Хайлааст 59 мкг/м^3-ээр, 5-н буудал 60 мкг/м^3-ээр, Шархад 10 мкг/м^3-ээр, Налайх 18 мкг/м^3-ээр, Дамбадаржаа АЧС-аас 2 мкг/м^3-ээр тус тус бага, харин Мишээл экспо 25 мкг/м^3 -ээр, Баруун 4-н зам 45 мкг/м^3-ээр, 1-р хороолол 38 мкг/м^3-ээр, Бөхийн өргөө 35 мкг/м^3-ээр, Цахилгаан станц 57 мкг/м^3-ээр, Ургах наран хороолол 14 мкг/м^3-ээр, Зайсан 15 мкг/м^3-ээр, Нисэх 2 мкг/м^3-ээр, Толгойт 52 мкг/м^3-ээр, Зурагт 2 мкг/м^3-ээр тус тус их байна (Зураг 28).

Азотын давхар исэл (NO_2)



Зураг 29. Азотын давхар ислийн 02 дугаар сарын дундаж агууламж, 2021-2025 он

Азотын давхар ислийн (NO2) 2025 оны 02 дугаар сарын дундаж агууламж 2021 оны 02 дугаар сараас 12 мкг/м^3-ээр буюу 29 %-иар их. Харин 2022, 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2-7 мкг/м^3-ээр буюу 4-12 %-иар бага, 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 12 мкг/м^3-ээр буюу 18%-иар бага байна (Зураг 29).



Зураг 30. Азотын давхар ислийн 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр

2025 оны 02 дугаар сарын Азотын давхар исэл (NO_2)-ийн дундаж агууламж Мишээл экспо 27 мкг/м^3, Цахилгаан станц 58 мкг/м^3, Яармаг 54 мкг/м^3 байна. 2024 оны 02 дугаар сартай харьцуулахад Баруун 4-н зам АЧС-аас 20 мкг/м^3-ээр, Бөхийн өргөө 3 мкг/м^3-ээр, 100-н айл 37 мкг/м^3-ээр, Ургах наран хороолол 5 мкг/м^3-ээр, Хайлааст 7 мкг/м^3-ээр, Зайсан 5 мкг/м^3-ээр, Шархад 28 мкг/м^3-ээр, Налайх 21 мкг/м^3-ээр, Нисэх 12 мкг/м^3-ээр, Толгойт 25 мкг/м^3-ээр, Зурагт 3 мкг/м^3-ээр тус тус бага, 5-н буудал ижил түвшинд, харин 1-р хороолол 3 мкг/м^3-ээр их байна (Зураг 30).

Хүхэрлэг хий (SO_2)



Зураг 31. Хүхэрлэг хийн 02 дугаар сарын дундаж агууламж, 2021-2025 он

Агаар дахь хүхэрлэг хийн (SO_2) 2025 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг 2021-2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 27-55 мкг/м^3-ээр буюу 24-39 %-иар бага, өмнөх оны мөн үе буюу 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 33 мкг/м^3-ээр буюу 28%-иар бага байна (Зураг 31).



Зураг 32. Хүхэрлэг хийн 02 дугаар сарын дундаж агууламж харуул тус бүрээр

2025 оны 02 дугаар сард хүхэрлэг хий (SO_2)-н дундаж агууламж Яармаг 55 мкг/м^3, харин 2024 оны 01 дүгээр сартай харьцуулахад Мишээл экспо 9 мкг/м^3-ээр, 1-р хороолол 77 мкг/м^3-ээр, 100-н айл 47 мкг/м^3-ээр, Цахилгаан станц 5 мкг/м^3-ээр, Хайлааст 7 мкг/м^3-ээр, 5-н буудал 10 мкг/м^3-ээр, Шархад 81 мкг/м^3-ээр, Налайх 62 мкг/м^3-ээр, Толгойт 29 мкг/м^3-ээр, Баянхошуу 132 мкг/м^3-ээр тус тус бага, харин Баруун 4-н зам 8 мкг/м^3-ээр, Бөхийн өргөө 8 мкг/м^3-ээр, Ургах наран хороолол 9 мкг/м^3-ээр, Зайсан 3 мкг/м^3-ээр тус тус их байна (Зураг 32).

3.5. АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКС

Хүснэгт 16. Агаарын чанарын индекс, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Агаарын чанарын индекс	Агаарын чанарын ангилал	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0-50	Цэвэр	Хүний эрүүл мэндэд сөрөл нөлөө үзүүлэхгүй.
51-100	Хэвийн	Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно. Тухайлбал: озон, нарийн ширхэглэгт тоосонцрын нөлөөллийн улмаас хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.
101-250	Бага зэргийн бохирдолтой	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
251-400	Дунд зэргийн бохирдолтой	Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
401-500	Их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл илэрнэ.
500<	Маш их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ.

Эх сурвалж: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А-327 тоот тушаалын 1 дүгээр хавсралт, Хүснэгт 1

Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын харуулуудын 2016-2023 оны агууламжийг индексээр үнэлэн дараах хүснэгт болон зургаар харууллаа.

Тухайн агаарын чанарын хяналт шинжилгээний харуулын агаар бохирдуулах бодис тус бүрээр тооцсон үнэлгээний хамгийн өндөр тоон утгыг тухайн үеийн агаарын чанарын индекс гэж тогтоодог.

Агаарын чанарын индексийг тухайн харуулын агаар дахь түгээмэл тархалттай 3-аас доошгүй үндсэн бохирдуулах бодисоор тооцдог. Зарим тохиолдолд тухайн харуул дээр өдөрт 3-аас бага бохирдуулах бодис тодорхойлсон бол индекс тооцох боломжгүй юм.

Агаарын чанарын индексийн жилийн үнэлгээгээр 2023 онд индексийн нийт үзүүлэлт 2022 онтой харьцуулахад цэвэр түвшин нэмэгдсэн байна. Харин хэвийн, бага бохирдолтой түвшин багассан үзүүлэлттэй. Нийт харуулын агаарын чанарын индексийн үнэлгээний 39% нь “Бага бохирдолтой” түвшинд хүрсэн буюу 2022 онтой харьцуулахад 20%-иар бага, 2016-2019 онтой харьцуулахад 23-26%-иар багассан байна. Харин 2016-2022 онтой харьцуулахад 2023 оны цэвэр түвшин өссөн, харин “Их бохирдолтой”, “Маш их бохирдолтой” түвшин буурсан байна. (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Агаарын чанарын индексийн жилийн ерөнхий үнэлгээ

Агаарын чанарын ангилал	Агаарын чанарын индексийн жилийн үнэлгээ, %							
	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Цэвэр	8	9	13	17	23	24	26	35
Хэвийн	25	25	23	24	29	28	25	22
Бага зэргийн бохирдолтой	53	54	51	51	46	45	49	39
Дунд зэргийн бохирдолтой	8	7	8	5	2	3	3	3
Их бохирдолтой	3	3	3	2	0	0	0	0.6
Маш их бохирдолтой	3	2	2	1	0	0	0	0.4

Хүснэгт 18. Агаарын чанарын хяналтын харуулын индексийн нийт тоо

Агаарын чанарын ангилал	Агаарын чанарын индексийн жилийн үнэлгээ, 17 харуулаар							
	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Индекс тооцох боломжгүй	813	595	856	344	666	570	505	79
Цэвэр	253	289	498	695	865	1170	1277	2147
Хэвийн	794	851	880	952	1077	1359	1241	1365
Бага зэргийн бохирдолтой	1693	1849	1916	2073	1709	2198	2395	2405
Дунд зэргийн бохирдолтой	254	247	308	210	71	152	141	174
Их бохирдолтой	103	114	102	70	4	18	23	29
Маш их бохирдолтой	105	70	70	36	0	8	11	17



Зураг 33. Агаарын чанарын 2016-2023 оны жилийн индексийн түвшин, %

Улаанбаатар хотын агаарын чанарын индекс 2023 онд 35% цэвэр, 22% хэвийн, 39% бага бохирдолтой, 3% бохирдолтой, 0.6% их бохирдолтой, 04% маш их бохирдолтой түвшинд байсан байна.



Зураг 34. 2023 оны агаарын чанарын индекс

Дүгнэлт:

Улаанбаатар хотын 2023 оны жилийн дундаж агууламжийг 2022 оны жилийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор ижил түвшинд, хүхэрлэг хий 7 мкг/м^3-ээр буюу 11%-аар, PM10 тоосонцор 6 мкг/м^3-ээр буюу 7 %-аар, азотын давхар исэл 1 мкг/м^3-ээр буюу 2 %-аар тус тус бага байна.

Харин 2022-2023 оны хүйтний улирал буюу 2022 оны 10-12 сар, 2023 оны 1-4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 4 мкг/м^3-ээр буюу 6%, PM10

тоосонцор 15 мкг/м^3-ээр буюу 12%-аар, азотын давхар исэл 1 мкг/м^3-ээр буюу 2%-аар, хүхэрлэг хий 9 мкг/м^3-ээр буюу 9%-аар тус тус бага байлаа.

Агаарын чанарын индексийн жилийн үнэлгээгээр 2023 онд индексийн нийт үзүүлэлт 2022 онтой харьцуулахад цэвэр түвшин нэмэгдсэн байна. Харин хэвийн, бага бохирдолтой түвшин багассан үзүүлэлттэй. Нийт харуулын агаарын чанарын индексийн үнэлгээний 39% нь “Бага бохирдолтой” түвшинд хүрсэн буюу 2022 онтой харьцуулахад 20%-иар бага, 2016-2019 онтой харьцуулахад 23-26%-иар багассан байна. Харин 2016-2022 онтой харьцуулахад 2023 оны цэвэр түвшин өссөн, харин “Их бохирдолтой”, “Маш их бохирдолтой” түвшин буурсан байна.

PM2.5 тоосонцрын агаарын чанарын индексийн дүнгээс харахад гэр хороолол орчим 1-3, 10-12 дугаар сард бохирдол нэмэгдэж “Бага бохирдолтой” түвшнээс “Маш их бохирдолтой” түвшинд, томоохон автозам орчимд 1-3, 11-12 дугаар сард “Бага бохирдолтой”, “Бохирдолтой” түвшинд, гэр хорооллоос хол байрлах цэгт 1, 12 дугаар сард “Бага бохирдолтой” түвшинд хүрсэн байна.

3.6. ФИЗИК БОХИРДОЛ (ДУУ ШУУГИАН)

Дуу чимээ, шуугиан. Шуугиан ба доргио нь хүрээлж буй орчинд хэлбэлзэх долгион хэлбэрээр тархаж, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Шуугиан ба доргионы тархалтын зүй тогтол нь ижил, байгаль орчин (хүн, амьтан, ургамал, хот, барилга байгууламж)-д үзүүлэх сөрөг нөлөө нь төстэй юм.

Хот суурин газрын шуугиан ба доргионы үндсэн эх үүсвэр нь төрөл бүрийн аж үйлдвэрийн болон засварын газрууд, автотээврийн, агаарын ба төмөр замын тээврийн хэрэгслүүд юм.

Шуугиан ба доргионы үндсэн параметрууд. Шуугиан чимээний хүрээлж буй орчин, хүн, амьтан, ургамалд үзүүлэх хор хөнөөлийг тооцоолж, үнэлж дүгнэхдээ дараах үзүүлэлтүүдийг авч үздэг:

- Дуу шуугианы өндөр намыг түүний хэлбэлзлийн давтамжаар (Гц) тодорхойлно.
- Чанга сулыг нь децибел (Дб)-ээр илэрхийлж, түүний орчинд нөлөөлөх норматив хэмжээг тогтоодог байна. “ДбА“гэсэн тэмдэглэл нь децибелийн (шумомерийн) хэмжүүрийн заалт юм.
- Доргио ба шуугиан орчинд долгион хэлбэрээр тархдаг. Иймээс дуу чимээ, доргио тархана гэдэг нь орчинд энерги шилжих (тархах) процесс явагдаж буй хэрэг юм. Нэгж хугацаанд дууны тархалтын чиглэлд нормаль 1м^2 гадаргууд харгалзах энергийн хэмжээг дууны эрчим (хүч) гэж нэрлэдэг. Энэ нь Вт/м^2-аар хэмжигдэнэ. Хүний чих дуу чимээг мэдэрч эхлэх хамгийн бага дууны эрчим нь 10^{-12} Вт/м^2 байх ба түүнийг сонсголын босго гэх бөгөөд энэ үед дууны төвийн “0“ Дб байна. Шуугианы эрчим 10Вт/м^2 хүрэхэд түүний түвшин 130 Дб-д хүрч хүнд гэмтэл, өвчлөлт үүсгэх бөгөөд түүнийг өвчлөлтийн босго гэнэ.

Эрүүл ахуйн нормативээр орчныг шуугианы түвшингээр нь дараах байдлаар ангилдаг:

а. Хэмжүүрийн заалтаар орчны шуугианы түвшин 80 ДбА -аас өндөр байвал тааламжгүй орчин гэнэ. 80-130 ДбА-д гэмтэл учруулах аюултай, 130 ДбА-с дээш байвал гэмтэл учруулах онц аюултай гэж үздэг байна.

б. 60-80 ДбА байвал харьцангуй тааламжгүй орчин гэнэ. Шуугианы түвшин 60 ДбА-д хүрвэл хүнд цочроох үйлчлэл үзүүлэх бөгөөд 70 ДбА-д хүрвэл яриа далдалж, 80 ДбА-аас давбал эрсдэлд хүргэж болно.

в. 40-60 ДбА байвал харьцангуй тааламжтай орчин гэнэ. Энгийн орчинд нам буюу ердийн дуугаар ярилцах боломжтой юм.

г. 40 ДбА-ээс бага байвал тааламжтай орчин гэнэ. Гадны шуугианы нөлөөлөлгүй байр сууцанд шуугианы түвшин 20 ДбА байдаг.

Улаанбаатар хотын суурьшлын орчны дуу шуугианы түвшин эрүүл ахуйн үнэлгээ

2012 онд Хөдөлмөрийн Нөхцөл, Мэргэжлийн Өвчин Судлалын Үндэсний Төв. АҮШУИС, ЭМЯ А.Цэнгэлмаа1, Ч.Өнөрцэцэг2, Б.Цэцэгсайхан нарын судалгааны үр дүнгээс үзэхэд:

Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 12 цэгт, 3 цагийн давтамжтайгаар нэг долоо хоногийн туршид (нийт 637 удаагийн шууд хэмжилтээр) шуугианы түвшинг тооцоолон гаргасан. Улаанбаатар хотын дуу шуугианы дундаж түвшинг дүүргээр нь авч үзэхэд БГД (70,6 дбА) хамгийн өндөр, харин ХУД (62,2 дбА) хамгийн бага байсан.



Зураг 35. Улаанбаатар хотын дүүргүүдийн дуу шуугианы түвшин

Хүснэгт 19. Улаанбаатар хотын дүүргүүдийн дуу шуугианы түвшин, өдрөөр (дбА)

№	Хэмжилт хийсэн өдөр	Дуу шуугианы түвшин, дбА
1	Даваа	67.1
2	Мягмар	66.35
3	Лхагва	65.7
4	Пүрэв	67.76
5	Баасан	68.28
6	Бямба	67.9
7	Ням	68.5
8	Дундаж	67.37

Тайлбар: Дуу шуугианы түвшин ажлын болон амралтын өдрөөс үл хамааран өндөр байна.



Зураг 36. Дуу шуугианы дундаж түвшин, цагийн дунджаар

Улаанбаатар хотын дуу шуугианы дундаж түвшин **67.3 дбА** байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж болон Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2001 стандартаас (ЗДХ 60 дбА) **7.3 дбА-ээр** их байна. Хэвийн хэмжээнээс хэтэрсэн дуу шуугиан нь хүний сонсгол болон тархины эд эсүүдийг гэмтээж, төв мэдрэлийн ситемд нөлөөлснөөр түргэн ядрах, анхаарал сулрах, нойргүйтэж улмаар зүрх судасны үйл ажиллагаанд өөрчлөлт орж, даралт ихсэх, зүрхний шигдээс өвчний эрсдлийг нэмэгдүүлэх, бодисын солилцоо болоод ходоод гэдэсний хэвийн ажиллагаа алдагдах зэргээр хүний эрүүл мэндэд олон сөрөг нөлөө үзүүлдэг.

- Улаанбаатар хотын суурьшлын орчны дуу шуугианы дундаж түвшин БГД (70,6 дбА)-т хамгийн өндөр, харин ХУД (62,2 дбА)-т хамгийн бага байлаа. Мөн ажлын болон амралтын өдрөөс үл хамааран шуугианы түвшин өндөр байна.

- Улаанбаатар хотын суурьшлын орчны дуу шуугианы дундаж түвшин 67,3 дбА (ЗДХ 60 дбА-ээс 7,3 дбА-ээр их) байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж болон Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2001 стандартын шаардлагад нийцэхгүй байна.

Дуу шуугианы хэмжилтийг дараах байршлуудад хийсэн. Үүнд:

- Сүхбаатарын талбай оройн 18 цагийн үед — 70дЦб -80 орчим
- Сүхбаатарын талбайн 4-н замын уулзвар — 80–105 ДцБ хүртэл
- Хотын төвийн Coffee Shop — 70–85 ДцБ хүртэл
- Music Lounge — 72–85 ДцБ
- Жазз клуб 80–88 ДцБ
- Уулын орой, ойд 50–54 ДцБ
- Ажлын байр — 60–75 ДцБ

ДӨРӨВ. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ БА ГЕОМОРФОЛОГИ

4.1. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ

Манай орны нутаг дэвсгэрийн геологийн тогтоц нь нийлмэл, нилээд нарийн төвөгтэй бөгөөд геологийн янз бүрийн эрин зууны үе шатанд бий болсон атираат систем юм.

Энэхүү атираат систем нь Сибир ба хойд Хятадын тавцангийн хооронд байрлах ба хойноосоо аажмаар намсах бөгөөд өмнө зүгийг чиглэсэн нум хэлбэртэй орших уулсын системийг үүсгэдэг. Тохооост-атираат структурууд нь эртний далайн янз бүрийн морфоструктур (арлан нум, аккрецийн шаантаг)-ийн үлдцүүд элбэгтэй, нэн нийлмэл тогтоцтой учир өчүүхэн бага талбайд ч ихээхэн өөрчлөгдөж байдаг.

Эдгээр атираат системийн дүр төрх сав газрын хэмжээнд тодоор тусгалаа олсон байгаа бөгөөд ай савын геологийн тогтоц нь нэн төвөгтэй, өөр хоорондоо гүний хагарлаар тусгаарлагдсан каледоний (хойд хэсэг нь) ба герцений (өмнөд хэсэг нь) атираат системд хамрагддаг болно. Герцений атираат системийн тогтолцооны үед уулсын хоорондох одоогийн гүн хонхор, хотгорууд үүсэж бий болж улмаар дунд ба шинэ төрмөлийн тунамал хурдас чулуулаг хуримтлагдан, гуравдагч-дөрөвдөгч галвын сэвсгэр хурдсаар хучигдсан байдаг.



Зураг 37. Монгол улсын геологийн мужлал

Дээрх зургаас харахад Шинэ тойрог автозам төслийн трассын талбай нь Монгол улсын нутаг дэвсгэрийн структурын дүүрэгчлэлээр Хангай-Хэнтийн мужид хамаарагдаж байна.

Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрийн геологийн тогтоц

Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрийн геологийн тогтоцын хувьд карбон, цэрд, девоны настай тунамал хурдас, триас, юрийн настай интрузив чулуулаг, неоген, дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаас бүрдэнэ.

Доод-дунд девоны Горхийн формац (D1-2)

Яармагийн баруун хойно, зүүн болон зүүн урд хэсгээр доод-дунд девоны настай тунамал хурдас өргөн төрхсан. Энэ хурдас нь зүүн хойш чиглэлийн суналтай, голдуу босоо байрлалтай атрианд хүчтэй орсон онцлогтой бөгөөд девон болон карбоны хурдсын үе давхрагууд өөр хоорондоо ихэвчлэн тектоникийн эгц уналттай хагарлуудаар тусгаарлагдана. Карбоны настай хурдас гол төлөв элсэн чулуу, алевролит, аргиллит, шаварлаг занар хааяа гравелит, хөрзөнгийн үеүдийн салаавчлалаас тогтсон турбидит юм. Уг хотгорыг тунаш хуримтлалаар тэжээсэн угаагдлын эх үүсвэр нь зэрэгцээ үүссэн оршсон захын өргөгдлүүд байсан байна.

Алевролит занарын салаавчлал зонхилсон нарийн үе бүхий элсжин, алевро-элсжин, кварц суурилаг эффузивын ховорхон мэшил үеүд. Хурдсын зузаан 1500-2000м.

Доод карбоны Алтан овоо формац (C1-2)

Доод карбоны чулуулгууд Богд уулын хойд хажуу, Туул голын хойд хэсгийн уулсын геологийн тогтоцыг бүрдүүлж өгнө. Энэ насны чулуулгуудад алевролит, элсэн чулуу, конгломерат, гравелит, яшма маягийн цахиурлаг чулуулгууд зонхилон оролцоно. М.А.Анфилов, Ю.С.Желубовский нарын судалгаагаар элсэн чулуу-алевролитын доод ба элсэн чулууны дээд гэсэн хоёр зузаалаг болон ангилагджээ.

Улаанбаатарын хойд хэсэг болон Богд уулын ар хажуу орчмоор бараан өнгөтэй, цахиурлаг-шаварлаг найрлагатай алевролит, нарийн ширхэгтэй элсэн чулуу, яшма ба туффитын багц үеүд өөр хоорондоо салаавчлан дэс дараалсан байдлаар илэрнэ.

Дээд болон дунд карбоны Олгойч уулын формац (C2-3)

Олгойч уулын формац Яармагийн зүүн болон зүүн хойд хэсгээр тархсан. Туул голын хоёр хажуугаар өргөн тархалттай. Энэ нь янз бүрийн ширхэгтэй элсэн чулуунаас бүрдэх ба 20-30м-ийн зузаантай үелсэн байдалтай байрлах бөгөөд дунд хэсэгтээ занар агуулна. Занарын литологи нь доод-дунд карбоны занартай төстэй.

Доод цэрдийн чулуулаг (K1)

Доод цэрдийн хурдас Налайхын хотгор дахь нүүрсний орд, Толгойт дахь туйпууны шаврын ордын судалгаатай уялдан урьд өмнө нилээд сайн судлагдсан. Доод цэрдийн хурдас Налайхын хотгор, Толгойт, Хамбын овооны орчимд тогтоогдсоноос гадна Бөхөгийн голын сав газарт Тахилт уулын орчимд агаарын гэрэл зургийн тайлалт болон баганат өрөмдлөгийн үр дүнд шинээр тогтоогдсон болно.

Толгойтын тоосгоны материал эрж хайх явцад доод цэрдийн чулуулаг нэлээд сайн судлагдаж литологийн найрлагаар нь дээд, доод гэсэн 2 горизонт болгон ангилжээ. Доод горизонтын зүсэлтэнд конгломерат зонхилон орж уг горизонтын онцлогийг тодорхойлж өгдөг байна. Конгломерат нь харьцангуйгаар сайн мөлгөржсөн тод саарал, ногоовтор өнгөтэй жижиг ширхэгт элсэн чулуу, бараан саарал, бараг хар өнгөтэй филлит маягийн занар, ногоовтор буурал өнгөтэй серицит-хлориттай занар, кварцын порфир, роговик, сүүн цагаан өнгөтэй кварц зэрэг чулуулгийн хайргаас тогтоно.

Конгломератууд цагаан, цайвар саарал, бараан саарал өнгөтэй, шавраар сулавтар цементлэгдсэн байх ба заримдаа эдгээр шавар нь төмрийн ислээр нэвчигдсэнээс харилцан адилгүй байх ба конгломерат нь том хайргаас жижиг хайргатай салаавчлан байрласан үеүд үүсгэнэ.

Дээд давхаргын зүсэлтэнд конгломерат, элсэн чулууны үеүдийн засвар 0.2-2.0 м хүртэл зузаантай шаврын үеүд байрлаж нийт зүсэлтийн төрхийг өвөрмөц онцлогтой болгоно. Шавар нь цагаан, цайвар саарал, ногоон саарал, бараан саарал, шаргал саарал өнгөтэй,

маш нягт, аргиллит маягтай, заримдаа нимгэн хуудсархагаас хавтан маягийн хэсэглэлийг үүсгэнэ. Зүсэлтийн доторхи элсэн чулуу, алевролит, шаврын дунд амьтан, ургамлын үлдэгдэл элбэг тохиолдоно. Доод цэрдийн чулуулгууд дороо орших доод карбоны чулуулгуудын угаагдлын гадаргуу дээр өнцгийн үл нийцлэгээр бараг өргөргийн дагуу чиглэлтэй суналыг үүсгэж 15-20 орчим өнцгөөр налж байрлана. Доод цэрдийн чулуулгийн зузааныг өрөмдлөг ба геофизикийн судалгаагаар 200 м орчим болохыг тодорхойлжээ.

Неогены хурдас (N)

Неогены хурдас Туул голын грабены хэмжээнд доод цэрдийн чулуулгийн дээр байрлаж тархах бөгөөд газрын гадарга дээр Тасган овоо, Наран, Мааньтын овоо, Толгойт, Улаанхуаран, Шар хад зэрэг газраар ил гарч ирдэг. Эдгээр газруудад плиоцены улаан, улаан хүрэн өнгийн хурдас тархахдаа нилээд өвөрмөц бөгөөд газрын гадаргууд ихэвчлэн илрэхгүй боловч томоохон голын хөндий, хотгорын эрэг, ирмэг, мөрөгцөгт дөрөвдөгчийн хурдасны дороос цухуйх маягаар ялгарах нь олонтаа.

Эдгээр хурдас нь сул барьцалдсан хөрзөн, элсэн чулуу, ихэвчлэн улаан хүрэн заримдаа цоохор өнгийн шавар зэргээс тогтсон элсэрхэг болон шаварлаг хурдас бөгөөд хэмхдэс чулуулаг ямагт 50%-аас дээш хэмжээгээр оролцоно.

Толгойтын “Найрамдал” карьерт хийсэн судалгаанаас үзэхэд неогены зүсэлт хоёр зузаалгаас тогтдог байна. Доод зузаалаг нь хүрэн өнгөтэй, төмрийн исэл бүхий конкрец агуулсан конгломератын үеийг уландаа агуулах ба түүний дээд талаар шаравтар саарал өнгөтэй дунд ширхэгт элсэн чулуу, гравелитын нимгэн үе агуулсан тод цайвар өнгийн тоосорхог шаврын үеүд 16 м хүртэл зузааныг үүсгэж байрлана. Улаанхуаранд илэрч тархсан неогены хурдсын бүрэлдэхүүнд хайр, хайрга агуулсан улаан өнгийн шавар, шавранцар зонхилно. Өрөм ба геофизикийн судалгаагаар зузаан нь 70 м гэж тодорхойлогджээ. Энэ хурдсанд хийсэн тоосонцорын шинжилгээний үр дүнд неогены настай нуур-пролювийн хурдас болох нь тогтоогдсон.

Дөрөвдөгчийн галавын хурдас (Q)

Яармаг орчимд дөрөвдөгчийн хурдас нилээд өргөн тархалттай бөгөөд томоохон голуудын хөндий, тэдгээрийн салаа, цутгалангийн төвийн хэсгүүд болон уулс хоорондын хөндий, тэдний хажуу хормой бэлийг хучиж тогтсон байдаг. Насны хувьд доод плейстоценоос голоцен настай хурдас тархсан ба гарал үүслийн хувьд гольдролын, гольдрол-хормойн, хормой-хажуугийн, нуурын болон салхины гэж ялгаж болохоос гадна техноген хурдсыг ч ялгаж болох юм.

Доод дөрөвдөгч буюу плейстоцен

Энэ насны хурдас зөвхөн Туулын хөндийн зарим хэсэгт үлдэгдэл маягаар хоцорсон бөгөөд тогтоогдсон буюу маш бага тархалттай гэж болно. Тухайлбал Туулын гол, Налайхын горхины уулзвар бэлчрийн зааг дээр өргөссөн хэсэгт нилээд үлдэж хоцорчээ. Ер нь энэ орчимд Туул голын I-III дэнжүүд харьцангуй нилээд тод ялгагдах онцлогтой бөгөөд I дэнж (3-5м өндөр) болон II дэнж (10-12м өндөр)-үүд нь элс, хайрга бүхий гольдролын хурдаснаас тогтоно. Эдгээр нь харьцангуй залуу юм. Харин доод плейстоцend хамаарах III дэнж нь голын түвшнээс 35-40м өндөр байрлах ба уг хурдаснаас зам, барилга, байгууламжийн зорилгоор 3 хэсэг газраас элс уурхайлан авч томоохон ухдас бий болгосон ба одоо ч ашигласаар байна. Энэ орчим эдгээр ухдаст сэдэвчилсэн судалгаа явуулсан нь уг районы төдийгүй Монгол орны хэмжээнд плейстоцены хурдасны тулгуур зүсэлт болсон юм.

Дээд дөрөвдөгч-голоцены хурдас

Дээд дөрөвдөгч-орчин үеийн хурдас нь сэвсгэр хурдасны тухайд хамгийн өргөн тархалттай бөгөөд томоохон голын хөндий, тэдгээрийн салаа цутгалангуудын төв болон хажуу хормой бэлд нилээд тэгш хэмтэй байдлаар тархсан байна.

Ялангуяа Туулын голын хөндийд хамгийн их талбайд тархсан төдийгүй хамгийн зузаан хуралдах нөхцөл бүрдсэн байна. Энэ насны хурдсыг гарал үүслийн хувьд хуралдаж үүссэн нөхцөл, харилцан байршил зэргийг харгалзан гольдрол-хормойн хурдас, хажуугийн, хормойн гэж ангилан ялгаж болох юм. Гольдрол-хормойн хурдас нь талбайд томоохон болон дунд зэргийн голуудын хөндийн төвийн хэсгийг эзлэн тархсан төдийгүй ялангуяа Улаанбаатарын хотгорын хэмжээнд уг хурдсаар Туулын хөндий дүүргэгдсэн байдаг. Дээд плейстоцен-голоцены хурдсыг Ю.Кригер судалсан бөгөөд Улаанбаатарын хөндийн хурдсыг дээд буюу хайрга, хайрганцар элсний зузаалаг (30м хүртэл), доод буюу гольдрол татмын далайц бүхий зузаалагт (10-12м) хувааж үзсэн юм. Мөн Улаанбаатарын орчимд дөрөвдөгчийн хурдасны усжилтыг нарийн судалсан ПНИИИС мөн ийм 2 свитэд ялгасан байна. Гол төлөв гольдролын хайрга, хайрганцар, элсэнцэрээс тогтох нь хурдас Туулын хөндийд өргөн тархалттай бөгөөд Улиастай орчимд 3км өргөн байснаа Амгалан орчимд нарийсч 1.5км болох ба Махкомбинат орчимд 4.5км болтол өргөссөнөө Яармагт 6.5км өргөнтэй болно. Гольдролын хурдасны нийт зузаан нь 5-65м-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд голын урсгалын дээрээс доод чиглэлд голын хөндийд хажуугаас төв хэсэг рүү, хөндийн өргөссөн хэсгээс нарийссан чиглэлд зузаан нь нэмэгддэг онцлогтой юм. Доод зузаалаг буюу свит нь ихэвчлэн 1м-ээс 5-8м зузаантай элс, элсэнцэр, шавранцар мэшил юмуу, үерэнцэр бүхий элс, шавар дүүргэгчтэй бул чулуу, хайрга, хайрганцрын бүрдлээс тогтоно.

Интрузив чулуулаг

Улаанбаатарын дүүрэгт интрузив чулуулгийн тархалт маш бага. Зөвхөн Богд уулын хойд хэсэгт түрүү мезозойн настай боржин тархсан. Массивын захын хэсгээр гранит-порфир, төвийн хэсэгт том ба жижиг ширхэгтэй ягаавтар саарал өнгөтэй гипидиоморф структуртай боржин тохиолдоно. Энэ массив купол маягийн хоёр фазад лейкократборжин тус тус үүсчээ. Ус хангамжийн системийн барилга байгууламж барихаар сонгон авсан талбайд доорхи 3 төрлийн хурдас чулуулаг тархсан байна. Үүнд:

1. Дунд дээд дөрөвдөгчийн настай аллювийн гаралтай, цайвар бор, бор шаргал өнгөтэй, элсэн чигжээстэй, бул чулуу ховроор агуулсан, сайр, сайрган хөрс (aQ_{III-IV}), хөрс Туул голын хөндий, татмын хэсгээр хуримтлагдан энэ төрлийн хөрсний давхарга үүссэн.

2. Дунд дээд дөрөвдөгчийн настай делюви-пролювийн гаралтай, цайвар бор, бор шаргал өнгөтэй, элсэнцэр ба шавранцар чигжээстэй, бул чулуу ховроор агуулсан, хайр, хайрган хөрс ($dp\text{-}Q_{II-IV}$)8 хөрс хадан гаршнуудын хоорондын сул зайг дүүргэх, өргөгдлийн хотос, сайр, гуу жалгыг дүүргэж хуримтлагдан энэ төрлийн хөрсний үелэл үүссэн. Хурдасны зузаан 1.0-15.0м хүрнэ.

3. Карбоны настай тунамал чулуу (C_{1-2}). Карбоны настай тунамал чулуу Ц-1, Завсрын бүсийн хэмжээнд сэвсгэр хурдасны дооройс илэрч тархсан. Уг хурдас нь ан цавлаг жижиг дунд ширхэгтэй цахиржсан элсэн чулуу, занарын зузаалгаас бүрдэнэ.



Зураг 38. Геологийн тогтоц

Дээрх зурагт үзүүлсэнээр трассын зүүн урд төгсгөлийн хэсэгхэн талбай нь QIII-IV – Дээд плейстоцен-голоцен, ангилагдаагүй формацын хажуугийн (делюви-солифлюкцийн, делюви-пролювийн, коллювийн), хайрга, хайрганцар, дайрга, дайрганцар, үйрмэг агуулсан шавранцар, элсэнцэр, элс, нуур пролювийн элсэнцэр, шавранцар, шавар, мараа хурдас чулуулагтай байна.

Харин трассын ихэнх талбай нь $C_{2\text{-}3}$ ou Оргочин уул формацын элсжин, гравелит, ховроор алевролит, хөрзөн хурдас чулуулагтай байна.

4.2. ГЕОМОРФОЛОГИ

Геоморфологийн мужлалын хувьд Хангай, Хэнтийн уулархаг их мужид хамаарах ба Шинэ тойрог автозамын талбай нь Орхон сэлэнгийн бэсрэг уулсын муж (VI)-ийн Туулын (2)-ын дэд мужид хамаарна. Геоморфологийн үндсэн элемент нь уул нурууд, тэдгээрийн хоорондох судаг, ам, хоолой, голын хөндийнүүд болдог.

Туул голын сав газрын эх нь Хэнтийн нурууны уулархаг хэсэгт далайн түвшнээс дээш 2600 м үнэмлэхүй өндөрт бүрэлдэж байхад голын адаг хэсэг болох Орхон-Туулын бэлчирт үнэмлэхүй өндөр нь 800 м орчим болж, голын хөндий өргөсдөг.

Тус сав газрыг хүрээлэн буй уулс нь газрын доорх усны тэжээгдлийн бүс, Улаанбаатарын хотгор нь хуримтлал, зөөгдөл, хөлийн бүс болдог. Туул голын хөндий нь өргөссөн, нарийссан хэсэг ээлжилсэн тогтоцтой бөгөөд өргөссөн хэсэг нь газрын доорх усны хуримтлалын бүс, нарийссан хэсэг нь шахагдсан хөлийн бүс болсон шинжтэй байдаг.

Улаанбаатар хот нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтаргад нам, дунд өндөрлөгтэй уулсаар хүрээлэгдсэн Туул голын грабен хөндий, түүний цутгал голуудаар хэрчигдсэн хэсэгт байрлана. Хотын урд хэсгээр дунд өндөрлөгтэй Богд уул хашиж байрлах ба түүний хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 2256.3 м өндөр өргөгдсөн эртний тэгшрэлийн гадаргуугийн үлдэгдэл болох ширээ хэлбэрийн тэгш тавцан үүсгэсэн Цэцээ гүн оргил. Богд уулын орой нь бул чулуун асгатай, харьцангуй тэгш гадаргуутай. Уулнаас тал бүр рүү V хэлбэрийн амнууд эх авах ба эдгээрээс Шашин хурах, Төр хурах, Чулуут, Их тэнгэр, Түргэн зэрэг амаар горхи булгууд урсаж, Бөхөг, Түргэн, Хөлийн голтой нийлнэ.

Хотын дэвсгэр нутгийн баруун талд Сонгино хайрхан (2562м), зүүн талд Баянзүрх уул (1833м), хойт талаар Чингэлтэй хайрхан (1949м) тус тус оршино. Сонгино хайрхан, Баянзүрх уул нь модгүй нүцгэн, энгэр нь харьцангуй бага идэгдсэн, булаг шанд байхгүй. Эдгээр уулс эгц хажуунууд, хурц шовх орой, хяруудыг үүсгэсэн байна. Харин Чингэлтэй уул нь хойт талаараа ойгоор хучигдсан олон салбар амнуудтай. Амнуудын эхэнд намагшил ихтэй тэдгээрээс олон тооны горхи, булаг эх авна.

Улаанбаатарын баруун урд хэсэг Яармагийн тэгшивтэр гадаргатай дэнж, нам өндөртэй Морин уул (1513.0 м)-ын толгодорхог хэсэгт аажим шилжинэ. Улаанбаатар хотыг хойд талаараа хүрээлэх уулс нь Сэлбэ, Улиастай, Толгойт голын тектоник гаралтай грабен маягийн хөндийнүүдээр хэрчигджээ.

Улаанбаатар хотын төв хэсгээр Туул голын хөндий уртрагийн дагуу байрлана. Уг хөндий Сонгино, Баянзүрх уулын орчим 0.5-1км хүртэл нарийсч V хэлбэртэй болох ба харин эдгээрийн хооронд 5-6км өргөнтэй хайрцаг хэлбэртэй болно. Туул голын гольдрол нь олон салаалсан бөгөөд өргөн нь 40-70 м, зарим газар 100 м хүрнэ.

Яармаг орчмын газрын гадаргын үнэмлэхүй өндөр нь 1321-ээс 1247 м болох ба харьцангуй өндрийн зөрүү 74 м, харьцангуй өндрийн унал 2.5 м/км хүрнэ. Усан хангамжийн барилга байгууламж (гүний худаг, ус дамжуулах хоолой, насос станц, усан сан г.м) байрлах талбай нь Богд уулын баруун салбар уулсын нэг болох Яргайтын уулын (1842.0м) баруун салааны Арцатын амны зүүн товгороос (1564,5м) Яармаг орчмын Туул голын татмын хэсэгт хүрнэ.



Зураг 39. Төсөл хэрэгжих талбайн орчны геоморфологийн хэв шинж

Шинэ тойрог автозамын трассын талбай нь Тэгширмэл газар, уулс хоорондын ба уулан дундах хотгор, голын хөндий дэх хурмал хурдаст хотос гадарга (N-Q, Q)-ын голын хурдаст тал (15) болон, уулт-атираат өргөгдлийн элэгдэл-тектоникийн гаралтай гадарга (N-Q)-ын дундаж өндөр уул, нурууд, гадаргуугийн хэлбэр дүрсийн хувьд 973-2729 м-ийн өндөржилттэй, трассын дагууд ихэнх талбайд $0\text{-}6^0$-ийн налуутай хэсэг, бага зэргийн талбайд $6\text{-}10^0$-ийн налуутай хэсэг (зураг 40, 41)-т хамаарах ба гарал үүслээрээ зөөгдөл-хуримтлал, элэгдлийн хэв шинжид хамаарагдана.



Зураг 40. Судалгааны талбайн орчны өндөржилт



Зураг 41. Судалгааны талбайн орчны налуужилт

Газар хөдлөл

Барилга хот байгуулалтын яамны захиалгаар Одон орон геофизикийн хүрээлэнгээс Улаанбаатар хотын төв, гэр хорооллууд – 57’435 га, Налайх дүүрэг – 8212 га, Багануур дүүрэг – 6469 га, Багахангай дүүрэг – 3833 га, Эмээлт – 3079 га талбайг хамруулан 2012.11.27-2014.03.30-ны хооронд 1:10000 масштабтай газар хөдлөлийн бичил мужлалын зургийг хийсэн байна.

Судлагдсан байдал

Улаанбаатар хотын талбайн бичил мужлалын ажил 1969, 2006 (2010 онд 2006 онд хийгдсэн 25000 масштабтай зургийг 10000 болгон хил хязгаарыг тодотгосон) онуудад хийгдэж байсан бөгөөд Налайх, Багануур, Багахангай, Эмээлтийн талбайд бичил мужлалын ажил хийгдэж байгаагүй байна. Улаанбаатар хот орчмын хагарлын судалгааг 2012 оны засгийн газрын хөрөнгөөр Монгол- Франц-ОХУ-Португалын эрдэмтэд хамтран хийсэн байна.

1971 оны Улаанбаатар хотын бичил мужлал. Улаанбаатар хотын хувьд 1967 онд болсон Булган аймгийн могод суманд болсон 7,5 магнитудтай газар хөдлөлтийн хүч нь хотын талбайд 4-6 баллаар мэдэгдэж байсан. Уг газар хөдлөлтийн дараа буюу 1971 онд манай эрдэмтэд ЗХУ-ын эрдэмтэдтэй хамтарч Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг зохиосон нь барилгын норм дүрэмд саяхныг хүртэл хэрэглэж байсан. Энэхүү зурагт Улаанбаатар хотын Туул болон Сэлбэ голын дагуу 8 балл, хадан хөрс 6 балл, үлдсэн хэсэг нь 7 балл болгон бүсчилсэн байдаг.

2006 онд (2010) хийсэн Улаанбаатар хотын газар хөдлөлтийн аюулын үнэлгээ. 2000-2006 онд Улаанбаатар хотын газар хөдлөлтийн аюулын үнэлгээний ажлыг Франц улсын эрдэмтэдтэй хамтран судалгааг хийсэн. Уг судалгааны үр дүнгээр Улаанбаатар хотын талбайг 7-8 баллын бүсэд хуваасан 1:25000 масштабтай зураг хийсэн байдаг. Энэхүү судалгааны ажлын явцад Улаанбаатар хотын орчим Хустай, Эмээлт, Гүнж, Авдар, Шархай, Дэрэн зэрэг газар газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд байгааг тогтоосон боловч тухайн үед хагарлын судалгааг нарийвчлан тодорхойлоогүй. Харин 2010 онд энэхүү зургийн хилийг нарийвчлан 1:10000 масштабтай болгох ажлыг Нийслэлийн захиалгаар хийсэн байдаг.

Ажлын үр дүн

Газар хөдлөлийн идэвхжил ба горимын судалгаа*:* Улаанбаатар хотын бүс нутгийн газар хөдлөлийн идэвхжилийн судалгаагаар бүс нутгийн хүчтэй газар хөдлөлийн голомтын бүсүүдийг тогтоож, эдгээр бүс нутгийн газар хөдлөлийн горимын гол параметрүүдийг тодорхойлсон байна.

Улаанбаатар хот орчмын идэвхтэй хагарлын судалгаа: Урьд хийгдсэн Улаанбаатар хот орчмын идэвхтэй хагарлууд дээр геофизикийн (сейсмик, георадар) болон геологийн (маршрут, тренч) судалгааг оруулсан. Мөнгөнморьтын хагарлын судалгааг энэхүү төслийн хүрээнд гүйцэтгэсэн. Эмээлт , Хустай, Гүнж, Мөнгөнморьт, Шархай, Авдар уулын хагарлын байрлал, давтагдах хугацаа болон харгалзах магнитудыг тодорхойлсон байна. Урьд өмнө хийгдэж байсан судалгаануудаас ялгагдах давуу тал нь газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд дээр газар хөдлөлтийн насыг тогтоож өгсөн, бүс нутгийн газар хөдлөлтийн идэвхтэй хагарлын зураглал хийсэн байна.

Газар хөдлөлийн долгионы замхралын судалгаа: Монгол орны хувьд өөрийн замхралын хууль үгүй тул олон улсад хэрэглэгдэх 17 замхралын хуулиас өөрийн орны мэдээллийн санд хуримтлагдсан мэдээлэлтэй харьцуулах замаар хамгийн ойрхон дөхсөн замхралын хуулийг сонгон хэрэглэсэн байна.

Синтетик сейсмограм: Газар хөдлөлт болсон тохиолдолд үүсэх газар хөдлөлтийн долгионыг Стохаустик Гриний функцийн аргаар хагарал бүрээс судалгааны талбайн 1 км бүрд тооцооллыг хийсэн байна.

Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ: Газар хөдлөлтийн аюулын үнэлгээг суурь үнэлгээний (детерминистик) болон магадлалт (probabilistic) аргаар тооцоолон хадан хөрсний хувьд ирж болзошгүй газар хөдлөлтийн долгионы хамгийн их хурдатгалыг тодорхойлсон байна. Суурь үнэлгээний аргаар болон магадлалт үнэлгээний аргаар Улаанбаатар болон түүний дагуул дүүргүүдийн хадан хөрсөнд ирэх газар хөдлөлтийн хүчийг үнэлсэн байна.



Зураг 42. Газар хөдлөлийн бичил мужлалын зураг

Ажлын үр дүнгээр хийгдсэн газар хөдлөлийн бичил мужлалын зурагт автозамын трассыг буулгасан зураг (зураг 42)-аас харахад трассын дагуух ихэнх талбай нь VII баллын, үлдсэн талбай нь VIII баллын талбайд хамаарч байна.

ТАВ. ГАДАРГЫН УС

Нийслэл Улаанбаатар хот нь усгүйн хувьд Хойд мөсөн далайн ай савын Туул голын ай савд багтана. Туул голын сав газар нь өндөр, дундаж, нам уулс, гүвээт тэгш тал, элэгдлийн гаралтай ухаа гүвээ, тэгш тал, уулс хоорондын хотгор хөндий, пролювийн хурдаст талыг багтаасан хосолмол шинжтэй учраас гадаргын урсац бүрдэх өвөрмөц нөхцөлийг бүрдүүлнэ. Туул голын сав газарт Хийд, Хаг, Баруун баян, Тэрэлж, Галттай, Хөл, Гачуурт, Улиастай, Сэлбэ, Бөхөг, Гуна, Халиуч, Бад, Тарнай, Харбух зэрэг олон гол горхи багтах ба сав газрын физик газар зүй, газрын бүрхэвчийн нөхцөлөөс шалтгаалан дүрс зүйн үзүүлэлтүүд болон усны горим, нөөцийн хувьд өөр хоорондоо ялгаатай.

Туул голын сав газарт 1-р эрэмбийн сайр-горхи 226, тэдгээрийн дундаж урт 2.3 км, ус хурах дундаж талбай 6.3 км2, 2-р эрэмбийн горхи 320, гол 64, 4-р эрэмбийн горхи 14, 5-р эрэмбийн гол 4 байна.[1]



Зураг 43. Туул голын сав газар

5.1. ТУУЛ ГОЛ

5.1.1. Туул голын усны нөөц, горим, чанар

Туул бол 6 дугаар эрэмбийн гол юм. Туул голын голдрилын дундаж өндөр 1,160 м, ус хагалбарын шугамын урт 2,056 км, дундаж өндөр 1,719 м, голын сүлжээний нягт 0.16 км/км2, ус хурах талбайн өндөр 1,300 м, хөндийн гүн дунджаар 559 м, ус хурах талбайн дундаж өргөн 56.1 км, суналтын зэрэг хамгийн их 16.5, ус хагалбарын тахиршлын зэрэг 2.6, хажуугийн хэрчигдтэл бага 0.58, Хортон-Страхлерын хуулиар голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.28, 3.05, 5.57 байна.

[1] *Г.Даваа., Монгол орны гадаргын усны горим, нөөц, 2015*



Зураг 44. Ус зүйн сүлжээ

Туул голын усны тэжээлийн онцлог бол түүний урсцын харьцангуй бага хувийг газрын доорх ус ба улирлын цасны ус эзэлдэгт оршино. Голын урсцын 25%-ийг ул хөрсний ус, 6%-ийг хайлсан цасны ус, 69%-ийг хур бороony ус эзэлнэ. Үүнээс үзэхэд Туул гол усны горимын хэв шинжээрээ хаврын шар усны болон зуны хур бороony үерийн горимтой голд хамаарна. Голын урсцыг бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл нь зун намрын хур бороо учраас усны түвшин дулааны улиралд ихээхэн тогтворгүй байдаг. Хаврын шар усны үер 4-р сарын сүүлч 5-р сарын эхээр ажиглагдах боловч үргэлжлэх хугацаа, урсцын хэмжээгээрээ хур бороony хэмжээнээс бага байна. Хаврын шар усны үерийн дараа үерийн богино хугацаатайгаар зуны гачиг үе ажиглагдах ба 7-р сараас 9-р сар хүртэл зун намрын хур бороony үер ажиглагдаж, гол элбэг устай байна.[2] Хур бороony үерийн их түвшин шар усны үеийнхээс даруй 1.5-2 дахин их байна. Хур бороony үер дууссаны дараа мөсний үзэгдэл эхлэх хүртэл усны түвшин аажим буурч гачиг үе үргэлжилж байна.



Зураг 45. Жилийн урсцын гидрограф, Туул гол-Улаанбаатар харуул[3]

Туул голын олон жилийн дундаж урсац Тэрэлж гол-Тэрэлжийн амралт харуулд 7.44 м^3/сек, Туул- Босгын гүүр харуулд 9.67 м^3/сек, Туул гол- Улаанбаатар орчимд 24.5 м^3/сек, Туул-Гачуурт орчимд 23.2 м^3/сек байна. Туул гол-Улаанбаатар харуулын хэвийн дундаж буюу норм урсац олон жилийн дундажтай тэнцүү байна.

[2] Г.Даваа, Д.Оюунбаатар, Ус судлал, Монгол улсын шинжлэх ухаан 108 боть цуврал, Дугаар 58, 2010
[3] Эх сурвалж: УЦУОСМХ, Д.Оюунбаатар

Хүснэгт 20. Олон жилийн дундаж урсац[4]

№	Гол, харуулын нэр	Ажигласан хугацаа	Ус хурах		Олон жилийн дундаж урсац			C_v	C_s
			Талбай, $м^2$	Дундаж өндөр, м	Q, $м^3$/сек	q, л/с·$км^2$	h, мм		
1	Тэрэлж-Тэрэлж амралт	1972-2023	1281	1995	7.44	5.81	183	0.40	0.80
2	Сэлбэ-Санзай	1994-2023	33.1	1723	0.11	3.35	106	0.58	1.15
3	Сэлбэ-Дамбадаржаа	1995-2023	192	1650	0.37	1.94	61.3	0.49	0.98
4	Улиастай-Улиастай	1990-2023	209	1840	0.48	2.32	73.2	0.69	1.38
5	Туул-Босгын гүүр	2002-2023	2192	1896	9.67	4.41	116	0.46	0.92
6	Туул-Улаанбаатар	1945-2023	6445	1808	24.5	3.8	120	0.58	1.17
7	Туул-Өндөрширээт	1983-1994	18427	1563	21.1	1.14	36	0.26	0.52
8	Туул-Лүн	1998-2023	23892	1453	-				
9	Туул-Заамар	2014-2023	46920	1388	17.9	0.70	22.1		

Туул гол Улаанбаатар хотоос доош, түүний уртын дагууд олон жилийн дундаж урсцыг УЦУХ-ийн Ус судлалын секторын судлаачид болон Х.Бадарч нарын 2008, 2009, 2010, 2012 онд нэмэлт цэгүүдэд түр харуулаар хийсэн хэмжилт судалгааны үр дүнгээр илэрхийлж болно. Судалгааны 2008-2012 оны 6-р сарын хэмжилтийн үр дүнгээр, Туул голын эхнээс Харзтай хүртэл урсац нэмэгдэж, улмаар Зайсангийн гүүрний орчимд 15%-ийн бууралтаас эхлэн, Биокомбинатад 30%, Шувуут хүрэхэд нийт 55%-ийн алдагдалд хүрч байгаа нь илэрчээ. Харин Туул гол-Шувуутаас Алтанбулаг хүртэлх хэсэгт буцаад урсац 30%-аар нэмэгдэж байгаа нь голын уртын дагуу урсцын алдагдал, сэргэлтийн хоорондын хамаарлыг баталсан байна.[5]

Хүснэгт 21. Сонгосон цэг, харуул хооронд урсац нэмэгдэх ба алдагдах хандлага, %

Сонгосон цэг, харуул	Усны өнгөрөлт								
	2008		2009		2010		2012		Дундаж, %
	$м^3$/с	%	$м^3$/с	%	$м^3$/с	%	$м^3$/с	%	
Туул-Босгын гүүр	2.38		12		11.1		8.14		
Туул-Тэрэлжийн бэлчир	2.8	18	15.7	32	20.6	85	15.1	85	55
Туул-Харзтай	5.37	91	24.7	57	27.9	35	24.8	64	62
Туул-Баянзүрх	4.2	-22	23.1	-7	24.4	-13	21.7	-12	-13
Туул-Зайсан	2.97	-29	20.2	-13	19.6	-20	20.1	-7	-17
Туул-Биокомбинат	2.46	-17	11.7	-42	17.5	-11	12.8	-46	-31
Туул-Шувуут	2.53	3	12.6	8	12.9	-26	9.43	-25	-10
Туул-Алтанбулаг	3.63	43	15.5	23	13.4	-4	14.4	52	30

Энэхүү урсцын алдагдлын зүй тогтол нь Улаанбаатар хотын усны хэрэглээ, газрын доорх усны хэт ашиглалт болон голын уртын дагуух цутгал голуудын нөлөөгөөр үүсэж буйг хэмжилтийн үр дүн баталсан байна. Зайсангийн гүүрнээс доош Туул голын хэсэг хуурайшиж, алдагдалтай байгаа нь хүний үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай бөгөөд энэ нь экосистемд ноцтой аюул учруулах нөхцөл үүсгэж байна. Ийнхүү голын уртын дагууд Улаанбаатар хотын ус хангамжийн худгуудын нөлөөгөөр урсцын алдагдал үүсэж байгаа ч, сав газрын адаг Туул гол-Алтанбулаг, Туул гол-Лүн харуул орчмын олон жилийн дундаж урсац Туул гол-Улаанбаатар харуулын урсцаас төдийлөн буурахгүй болно.

[4] Эх сурвалж: УЦУОСМХ

[5] Х.Бадарч, Д.Оюунбаатар нар, Туул голын уртын дагуух урсцын хуваарилалт ба алдагдал, 2014



Зураг 46. Туул голын уртын дагуух урсцын алдагдал

Хүснэгт 22. Янз бүрийн хангамшил бүхий олон жилийн дундаж урсац, м³/с

Гол, харуулын нэр	Хангамшил P, %								
	1	5	10	25	50	75	90	95	97
Туул-Улаанбаатар	71.8	50.3	41.1	28.9	20.5	14.3	11.9	11.2	10.9
Туул- Гачуурт	62.7	52.6	42.6	30.3	19.2	13.3	8.9	6.9	5.3
Туул-Босгын гүүр	27.0	19.2	15.8	11.4	8.0	11.4	5.2	4.9	4.8
Тэрэлж-Тэрэлж	17.3	12.8	10.9	8.4	6.4	8.4	4.8	4.7	4.6

Туул голын 50 хувийн хангамшилтай урсац Улаанбаатар орчимд 20.5 м³/сек байна. Элбэг устай буюу 5%-ийн хангамшилтай жилд урсац 50 м³/сек хүрч, татруу жилүүдэд 10.9 м³/сек хүртэл буурна.



Зураг 47. Жилийн дундаж урсцын хангамшлын муруй, Туул гол-Улаанбаатар харуул

Хамгийн их болон гачиг үеийн урсац

Гол мөрний усны горим нь тухайн бүс нутгийн уур амьсгалын нөхцөл, газар зүйн онцлогоос хамаарч улирлаас улиралд хэлбэлздэг. Их урсац нь хур бороо ихтэй улирал болон цас хайлах үеэр усны түвшин огцом нэмэгдсэнээс үүсдэг бол харин эсрэгээрээ хуурай улирал буюу хур тунадас багасах, ууршилт нэмэгдэх үед усны түвшин буурч, гачиг үе буюу бага урсац бүрдэнэ.

Их урсац. 2024 оны мэдээг оролцуулан Туул голын 100 жилд нэг тохиох магадлалтай их үерийн хамгийн их урсац Туул голд 1,824 м³/сек, Тэрэлж голд 704 м³/сек байгааг Хүснэгт 23-д нэгтэн үзүүлэв. Гэхдээ үерийн хамгийн их урсац Туул голын урсац бүрдэх бүсийн төгсгөл болох Улаанбаатар хот орчимд хамгийн их хэмжээндээ хүрч, түүнээс доошлох тутам үерийн

долгионы шилжилтийн явцад хэмжээ нь буурдаг. Энэ нь үерийн долгионы уртын дагууд суурь нь уртсаж, тархах зүй тогтлоор тайлбарлагддаг.

Туул голын сав газрын хувьд, ялангуяа түүний цутгал болох Сэлбэ, Улиастай зэрэг жижиг голуудад үерийн хэлбэр нь шовх оройтой, богино хугацаанд бий болдог хэв шинж бүхий онцлогтой. Туул голын сав газрын голуудад шар усны үер сул хүчтэй ажиглагдана. Зуун жилд 1 тохиох магадлалтай шар усны үер Туул голд 480 м^3/сек, Тэрэлж голд 140 м^3/сек тус тус хүрнэ.

Хүснэгт 23. Хур бороoны үерийн их урсац

№	Гол мөрөн-харуул		Янз бүрийн хангамшилтай өнгөрөлт Q (м^3/с), модуль q (л/с·км^2), урсацын давхраа h (см)					
			0.1	1	2	5	10	25
1	Туул-Улаанбаатар	Q	5625	1824	1300	831	592	378
		q	893	290	206	132	94	60
		h	463	150	107	68	49	31
2	Тэрэлж-Тэрэлж	Q	1432	704	615	498	409	292
		q	1118	549	480	388	319	228
		h	-	237	207	168	138	98
3	Сэлбэ-Дамбадаржаа	Q	125	73	62.8	49.4	39.3	25.8



Зураг 48. Туул голын хур бороoны их урсцын хангамшлын муруй, Туул гол –Улаанбаатар харуул

Бага урсац. 1972-2022 оны ажиглалтын хугацаанд хамгийн бага устай 30 хоногийн дундаж өнгөрөлт нийт 3.31 м^3/сек, дулааны улирлын хамгийн бага өнгөрөлт нийт 0.97 м^3/сек тус тус багассан байна. Харин Улаанбаатар харуулд бага урсцын бууралт илүү мэдэгдэхүйц байна. Сүүлийн 76 жилд хамгийн бага устай 30 хоногийн дундаж өнгөрөлт нийт 4.06 м^3/сек, дулааны улирлын хамгийн бага өнгөрөлт нийт 4.68 м^3/сек буурсан нь хотын ус хангамж, үйлдвэрийн ус хэрэглээний нөлөөтэй холбоотой. Туул-Улаанбаатар харуулын хамгийн бага урсцын хандлагыг Зураг 2.6-д үзүүлэв. Голын адаг Лүн харуул орчимд сүүлийн 24 жилд бага урсац нийт 11.3-13.5 м^3/сек багассан нь байгалийн болон хүний хүчин үйл ажиллагааны нөлөөгөөр урсцын багасал илүү эрчимтэй явагдаж буйг илтгэж байна.

Зураг 49. Туул голын хамгийн бага урсцын хандлага, Туул гол –Улаанбаатар

Гачиг үеийн урсац 50 хувийн хангамшилтай жилд голын эхэнд Тэрэлж харуул орчимд 2.56-4.85 м3/с, Улаанбаатар орчимд 6.10-11.1 м3/с бол голын адаг Лүн харуул орчимд 7.90-9.60 м3/с хэлбэлзэж, голын адаг руугаа буурах хандлагатайг Хүснэгт 2.8-д үзүүлэв.

Хүснэгт 24. Гачиг үеийн урсац, м³/с

№	Гол ба харуул	Гачиг үе	Хангамшлын хувь					
			50	75	80	90	95	97
1	Туул гол-Улаанбаатар харуул	Хамгийн бага устай 30 хоногийн дундаж өнгөрөлт	11.0	7.43	6.85	5.19	4.00	2.80
		Дулаан улирлын хамгийн бага өнгөрөлт	6.10	4.06	3.74	2.30	1.00	0.87
2	Туул гол-Тэрэлж харуул	Хамгийн бага устай 30 хоногийн дундаж өнгөрөлт	4.85	2.90	2.70	1.70	0.64	0.50
		Дулаан улирлын хамгийн бага өнгөрөлт	2.56	1.45	1.21	0.70	0.32	0.22
3	Туул гол-Лүн харуул	Хамгийн бага устай 30 хоногийн дундаж өнгөрөлт	9.60	7.50	6.20	3.30	2.81	2.65
		Дулаан улирлын хамгийн бага өнгөрөлт	7.90	5.80	5.70	4.00	2.90	2.55

Усны дулааны болон хүйтний горим

Усан орчин, түүний экосистемд нарны цацрагийн баланс, усны дулааны горим чухал үүрэгтэй. Усны температур эрс нэмэгдэхэд амьтан, ургамлын төрөл, зүйлийн тоо цөөрнө. Жишээ нь, ногоон ургамал усны температур 38^{0}C, цахиур намаг 45^{0}C, хөх ногоон замаг 60^{0}C, бактери 70^{0}C хүрэхэд үгүй болно. Хүрд хорхой, дугариг хорхой, хавч хэлбэртэн, шавж зөөлөн биетэн амьтад 40^{0}C-аас дээш температурт үгүй болно. Усны температур, дулааны балансад нөлөөлөх уур амьсгал, газар зүй, усны баланс, хурдас чулуулаг зэрэг үндсэн хүчин зүйлс байна. Монгол орны гол мөрний усны жилийн дундаж температурын өндрийн шатлуур 100 м тутамд 0.3-0.6^{0}C байна.

Туул голын усны температур хавар 4-р сарын сүүлийн 10 хоногт 1.2^{0}C болж, дунджаар 5-р сард 7.0^{0}C, хамгийн дулаан 7-р сард 15.0^{0}C хүрнэ. Усны хамгийн их температур 7-р сарын 15 орчимд 23oC болно. Үүнээс хойш агаарын температурын буурах явцыг даган усны

температур буурч, орчныг бүлээцүүлэх нөлөө үзүүлсээр намрын мөсний үзэгдэлтэй золгоно. Энэ бүхэн Туул гол болон түүний цутгал голуудын усны байгалийн горим болно.

Хүснэгт 25. Усны температур

Үзүүлэлт	Хавар 0.2⁰C ажиглагдах сар, өдөр	Сарын дундаж							Намар 0.2⁰C ажиглагдах сар, өдөр	Хамгийн их	
		IV	V	VI	VII	VIII	IX	X		Температур	Сар, өдөр
Туул-Босгын гүүр, 1986-2022											
Дундаж	VI.18		5.3	11.4	13.7	12.9	8.0	2.07	X.29	18.3	VII.22
Их (эрт)	IV.1		12.5	15.0	19.4	16.6	11.5	5.5	X.21	23.5	VI.16
Бага (орой)	IV.19		0.2	5.5	9.5	6.7	1.8	0.2	XI.25	13.6	VII.11
Туул-Улаанбаатар, 1945-2022											
Дундаж	IV.17	1.04	7.19	12	15	14	9	3	XI.03	20.9	VIII.08
Их (эрт)	III.19	5.5	13.7	18	19	18	13	10	IX.28	28.9	VI.01
Бага (орой)	V.28	0.1	0.9	8	9	10	3	0	XII.25	14	VIII.25
Тэрэлж-Тэрэлж, 1970-2022											
Дундаж	V.03		3.7	8.49	10.5	9.89	5.75	1.78	X.28	16.4	VII.21
Их (эрт)	IV.06		11.6	12.2	13.9	13	8.9	5.5	X.27	24.6	VI.05
Бага (орой)	VI.13		0.1	2.1	7.3	6.9	1.6	0.2	IX.12	11.4	VIII.22

Туул голын сав газарт усны хамгийн их температур Тэрэлж орчимд жилд дунджаар 0.06 градусаар буурсан бол Улаанбаатар орчимд дунджаар 0.03 градусаар дулаарсан байгааг Зураг 2.15-аас харж болно.



Зураг 50. Туул голын усны хамгийн их температур

Голын голдрилын хэв шинж, цутгал голын нөлөөтэй уялдан сав газар бүрд мөсний үзэгдэл өвөрмөц ажиглагдах ба Туул гол ихэнхдээ өргөргийн дагуу урсах тул голын нийт уртад мөсний үзэгдэл бараг нэгэн зэрэг ажиглагдах онцлогтой. Энэ савд намар дунджаар 10-р сарын 20 орчимд мөсний үзэгдэл эхлэх ба 5 орчим хоногийн дараа зайр гүйж, улмаар 11-р сарын дунд үед мөсөн бүрхүүл тогтоно. Мөсний үзэгдэл үргэлжлэх хугацаа голуудын ус хурах талбайн дундаж өндөр нь 1,000-1,500 м буюу голын адаг хэсэгтээ 170-180 хоног, харин 1,500-2,000 м өндөр байх голын эхэнд 185-200 хоног байна. Мөсөн бүрхүүлтэй байх хугацаа, 1991-2008 оны дунджаас голын эхэндээ 5, адгаараа 2 хонгоор тус тус богиносжээ. Мөсний үзэгдлийн ажиглагдах хугацааг Хүснэгт 2.10-т үзүүлэв.

Хаврын мөсний үзэгдэл Тэрэлж голд 10 хоногоор эрт дуусах хандлагатай байна. Харин хаврын мөсний үзэгдэл дуусах хугацааны өөрчлөлтийн эрчим нь Туул-Улаанбаатар

харуулд орчимд 1990-2008 оны мэдээгээр -0.31 хоног/жил болж өмнөх 1946-1989 оноос 2 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 26. Мөсний үзэгдлийн ажиглагдах хугацаа

Үзүүлэлт	Ажиглагдах сар, өдөр					Хамгийн их			
	Намар мөсний үзэгдэл эхлэх	Намар зайр гүйх	Мөсөн бүрхүүл тогтох	Хавар цөн түрэх	Хавар мөсний үзэгдэл дуусах	Намрын зайр	Хаврын цөн	Мөсөн бүрхүүл	Нийт мөсний үзэгдэл
Туул-Босгын гүүр, 1986-2023									
Дундаж	X/18	X/25	XI/18	IV/23	V/02	8	6	147	196
Их (эрт)	X/01	X/14	XI/02	IV/16	IV/10	22	15	174	217
Бага (орой)	XI/04	XI/10	XII/01	V/01	V/24	1	1	121	165
Туул-Улаанбаатар, 1945-2023									
Дундаж	X/19	X/25	XI/13	IV/21	IV/26	14	6	154	189
Их (эрт)	X/08	X/12	X/28	IV/01	IV/09	44	16	185	209
Бага (орой)	XI/10	XI/17	XII/01	V/07	V/11	1	1	114	160
Сэлбэ-Санзай, 1970-2023									
Дундаж	X/06	X/08	X/21	-	IV/23	4	-	165	199
Их (эрт)	IX/21	X/02	X/09	-	IV/10	4	-	197	219
Бага (орой)	XI/01	X/11	XI/11	-	V/08	3	-	141	166



Зураг 51. Туул голын сав газар дахь голуудын мөсөн бүрхүүлтэй байх хоногийн тоо

Хүснэгт 27. Мөсний зузаан, см

Үзүүлэлт	XI			XII			I	II	III			IV	Хамгийн их	
	10	20	30	10	20	30	31	28	10	20	30	10	см	сар өдөр
Туул-Босгын гүүр, 1986-2022														
Дундаж	30	35	47	60	67	73	89	98	92	86	79	167	113	II.28
Их (эрт)	53	61	75	81	86	90	160	271	196	128	126	110	271	II.28
Бага (орой)	4.0	14	23	41	41	41	61	69	69	61	34	41	75	I.30
Туул-Улаанбаатар, 1945-2022														
Дундаж	17	27	38	46	56	65	86	85	83	80	72	57	98	II.15
Их (эрт)	35	60	91	75	104	122	163	178	157	193	158	145	193	III.20

Бага (орой)	8.0	8.0	9.0	7.0	5.0	11	26	22	21	21	12	10	30	II.21
Сэлбэ-Санзай, 1994-2022														
Дундаж	24	28	31	33	34	34	33	33	34	34	36	37	36	I.20
Их (эрт)	38	48	88	88	88	88	88	88	88	88	88	80	89	XII.31
Бага (орой)	1.0	1.0	1.0	12	13	13	13	13	13	13	13	18	13	XII.20

5.1.2. Туул голын усны нөөцийн хомсдол, барагдалт, чанарын өөрчлөлт

5.1.2.1. Туул голын усны нөөцийн хомсдол, барагдалт

Нийслэл Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн усны хэрэглээг Туул голын хөндийн дагуу байрласан 4 эх үүсвэрээр хангаж байна. Дээрхи эх үүсвэрүүд нь Туул голын хөндийн аллювийн хурдасны уст үеийн усыг олборлон хэрэглэгчдэд түгээж байна. Энэхүү төслийн усан хангамжийн эх үүсвэр нь мөн Туул голын хөндийд байрлана.

Нийслэл хотын хүн ам, үйлдвэр аж ахуйн газруудын өсөлттэй уялдан усны хэрэглээ байнга өсөн нэмэгдэж энэхүү хэрэглээг зөвхөн газрын доорхи усны нөөцөөр хангах боломж багассаар байгаа билээ.

Одоогийн байдлаар нийслэлийн ундны усны хэрэглээ хоногт 268 мянган метр куб/хоног, усны нөөц 278,4 мянган мерт куб/хоног гэж тооцож байна. Эндээс үзэхэд нийслэлийн усны нөөц хүрч байгаа юм шиг боловч усны хэрэглээ нөөцөөсөө даваад байна. Учир нь ус сувгийн тоолуурт холбогдоогүй аж ахуйн нэгж, хувийн худаг олон байдаг.

Туул голын сав газрын ой модыг огтолсон, хөдөө аж ахуй ялангуяа мал аж ахуй төвлөрсөн зэргээс шалтгаалан голын сав газрын урсац бүрдэх, түүнийг зохицуулах чухал ач холбогдол бүхий байгалийн гол гол бүрэлдэхүүн хэсгүүд болох ой мод бэлтгэл, гал түймэр, хортон шавжид идэгдсэн, хөрс, бэлчээр дагтаршснаас болж ус нэвчиц буурч улмаар гадаргын шууд урсац нэмэгдэж, ул хөрсний усны нөөц хомсдох хандлага илэрч байна. Эл шалтгаанаар ус элбэгтэй үе зонхилж байсан 1990-ээд оны эхэн ба дунд үеийн хавар голын ус тасарч байжээ.

Усны горимын өөрчлөлтөд нөлөөлж буй гол хүчин бол ойн нөөцийн багасалт, бэлчээрийн талхдал, хөрс ургамлын доройтол болно.

5.1.2.2. Туул голын усны чанарын өөрчлөлт

Туул голын усны чанарын 2024 оны 1 дүгээр улирлын төлөв байдал

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/02 дугаар тушаалаар, батлагдсан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ЦУОШГ-аас 2024 оны 1-3 дугаар саруудад Туул голын дагуух усны чанарын хяналт шинжилгээний Уубулан цэгээс Хадан хясаа хүртэл 4 цэгээс усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна.

Туул голын усны цахилгаан дамжуулах чанарын сарын өөрчлөлтийг 2022 оны 1-р сараас 2024 оны 3 дугаар сарын байдлаар Зураг 52-д харууллаа.



Зураг 52. Туул голын дагуух зарим цэгийн усны цахилгаан дамжуулах чанар

Шинжилгээний дүнгээр 2024 оны 1-3 дугаар саруудад Улаанбаатар хотоос дээших цэгүүдэд усны цахилгаан дамжуулах чанар (ЦДЧ) 91.1-99 мкСи/см, Улаанбаатар хотоос дооших Сонгино доод цэгээс Хадан хясаа орчимд 1072-1228 мкСи/см хооронд хэлбэлзэж байна.

Хүснэгт 28. Усны гол ионуудын агууламж

Харуул	Хатуулаг, мг-экв/л	Ca, мг/л	Mg, мг/л	K+Na, мг/л	SO_4, мг/л	Cl, мг/л	HCO_3, мг/л	Эрдэсжилт, мг/л
Туул-Уу булан	0.76	11.6	2.2	5.5	13.8	2.8	37.2	73.1
Туул-Налайх	0.68	11	1.6	5.3	9.6	2.5	37.8	67.9
Туул-Баянзүрхийн гүүр	0.96	14.4	2.9	3.3	14.6	3.5	42.1	80.8
Туул-Сонгино доод	3.44	42.5	16.1	184.8	80.2	94.3	396.6	814.5
Туул-Хадан хясаа	3.68	41.7	19.5	142	100.1	70.2	323.4	696.9
MNS4586:98					100	300		

Улаанбаатар хотоос дээш Туул голын гол ионы бохирдуулах үзүүлэлтээс Монгол улсын гадаргын усны стандарт MNS4586:98 дахь хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтүүд ажиглагдаагүй ба хяналт шинжилгээний цэгүүдэд ерөнхий хатуулгыг А.Е.Посоховын ангиллаар авч үзэхэд 0.68-0.96 мг-экв/л буюу “Маш зөөлөн ус”, Сонгино доод цэгээс Хадан хясаа цэгийн орчимд 3.68-3.44 мг-экв/л хооронд хэлбэлзэж “Хатуу ус” ангилалд байна.

Хүснэгт 29. Усны биогенийн нэгдлүүдийн агууламж

Харуул	ph	УХ, мг/л	$БХХ_5$, мг/л	ПИЧ, мг/л	NH_4, мг/л	NO_2, мг/л	NO_3, мг/л	P, мг/л
Туул-Уу булан	0.2	8.62	0.5	1.5	0.01	0.001	0.60	0.002
Туул-Налайх	0.4	8.32	1.4	1.4	0.02	0.001	0.37	0.005
Туул-Баянзүрхийн гүүр	0.8	7.70	1.4	1.5	0.01	0.001	1.14	0.016
Туул-Сонгино доод	135	-	242.6	49.3	48.3	0.042	0.29	3.997
Туул-Хадан хясаа	74	0.46	154	30.8	21.77	0.053	0.25	2.282
MNS4586:98		4<	3	10	0.50	0.020	9.0	0.100

Тайлбар: УХ-Уусан хүчилтөрөгч; $БХХ_5$-Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч

Улаанбаатар хотоос Сонгино дээд цэгээс Хадан хясаа хяналтын цэгүүдэд биогенийн нэгдлүүдийн агууламж Монгол улсын Гадаргын усны стандарт MNS4586:98 дахь хүлцэх агууламжаас Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ5/-ийн агууламж (ХА-3мгО/л) 48.7-106.5 дахин; аммонийн азот (NH_4)-ын агууламж (ХА-0.5мг/л) 41.2.-96.6 дахин; нитритийн азот (NO_2)-ын (ХА-0.02мг/л) 12.5-14.5 дахин, эрдэс фосфорын (PO_4) (ХА-0.100мг/л) агууламж 22.8-39.8 дахин давсан бөгөөд Сонгино доод, Хадан хясаа цэгийн орчимд ууссан хүчилтөрөгчийн горим алдагдаж “онцгой их бохирдолтой” түвшинд байна.

Зураг 53. Усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч ($БХХ_5$)-ийн агууламж

Зураг 54. Усны аммоний азотын агууламж

Улаанбаатар хотын хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжуудын усны хяналт шинжилгээ

2023 оны 1 дүгээр улиралд Улаанбаатар хотын хаягдал ус цэвэрлэх 3 цэвэрлэх байгууламж (ЦБ)-ийн хаягдал бохир ус орж байгаа болон цэвэршүүлээд гаргаж байгаа цэгүүдээс нийт 8 сорьц авч химийн бохирдлыг тодорхойлсон байна.

Цэвэршүүлээд гаргаж байгаа шинжилгээний дүнг “Хаягдал ус MNS4953:2015”-ны стандартад заагдсан хүрээлэн буй орчинд нийлүүлж болох хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/-тэй харьцуулан Хүснэгт 30-д үзүүллээ.

Хүснэгт 30. Улаанбаатар хотын хаягдал бохир ус цэвэрлэх 4 байгууламжуудын биогенийн агууламж

Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж	Сорьц авсан цэг	pH	Ж/б, мг/л	$БХХ_5$, мг/л	ХХХ, мг/л	NH_4, мг/л	NO_2, мг/л	NO_3, мг/л	Цэвэр-шилт, %
Төв ЦБ	орох	6.57	812	904.8	1700.3	-	-	-	69.3
	гарах	6.65	164	277.2	601.8	38.72	0.45	0.072	
Нисэх ЦБ	орох	6.87	178	261.8	897.9	-	-	-	57.1
	гарах	7.19	10	18.5	114.6	28.34	0.27	0.05	
Био орон сууц ЦБ	орох	6.55	200	346.5	726	-	-	-	-
	гарах	6.49	25	35.8	105.1	14.43	0.43	0.026	
Био үйлдвэр ЦЫ	орох	6.92	30	42.4	66.9	-	-	-	25.1
	гарах	6.41	10	31.6	90.7	3.17	0.26	0.034	
MNS 4943:2015		6-9	30.0	20.0	50.0	15.0			

Тайлбар: Ж/б-Жигнэгдэх бодис; $БХХ_5$-Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, ХХХ-Химийн хэрэгцээт хүчилтөрөгч

Шинжилгээний дүнгээс үзэхэд цэвэрлэх байгууламжуудаас гарч байгаа ус нь 25.1-69.3%-ийн цэвэршилттэй байсан бөгөөд Төв ЦБ-ийн хаягдал бохир ус цэвэршүүлэх чадвар 69.3% байна.

Төв ЦБ-аас цэвэршүүлээд гарч буй хаягдал бохир усанд хийсэн шинжилгээний дүнг Хаягдал бохир усны стандарт MNS 4943:2015 харьцуулан үзэхэд биохимийн хэрэгцээт хүчил төрөгч /БХХ$_5$/-ийн агууламж 11.1-13.9 дахин, химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ)-ийн агууламж 8.7-12.0 дахин, жинлэгдэх бодисын агууламж 3.5-5.6 дахин их, нийт азотын агууламж 1.6-3.0 дахин их бохирдолтой усыг Туул голд нийлүүлж байна.

Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар, жинлэгдэх бодисын сарын өөрчлөлтийг 2023 оноос 2024 оны 3 дугаар сарын байдлаар зураг 6-5-д харуулаа.



Зураг 55. Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар



Зураг 56. Төв цэвэрлэх байгууламжийн жинлэгдэх бодис

Дүгнэлт:

Туул голын усанд 2024 оны 1-3 дугаар сард хийсэн хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны ерөнхий эрдэсжилт хотоос дээш болон хот орчимд 73-90 мг/л буюу “Маш бага”, хотоос доош хэсэгт 680-1000мг/л буюу “Их” эрдэсжилттэй байна.

Туул голын Улаанбаатар хотоос дээш усны горим алдагдаагүй цэвэр байсан бол хотоос дооших буюу Сонгино доод, Хадан хясаа хяналт шинжилгээний цэгийн орчимд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ5/-ийн агууламж Монгол улсын гадаргын усны стандарт MNS4586:98 дахь хүлцэх агууламж (ХА-3мгО/л) 48-106 дахин, аммонийн азот /NH4-/-ын

агууламж (ХА-0.5мг/л) 41-96 дахин, нитрит азот /NO2/-ын агууламж (ХА-0.02мг/л) 2.1-2.7 дахин, эрдэс фосфор /Р/-ын агууламж (ХА-0.100мг/л) 22-39 дахин их байсан ба ууссан хүчилтөрөгчийн горим алдагдаж “Онцгой их бохирдолтой” түвшинд ажиглагдаж байна.

Харин Төв болон Нисэхийн цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усны нийт азотын /ЗДХ-15.0 мг/л/ агууламж 1.56-3.0 дахин их бохирдолтой усыг нийлүүлж байгаа нь Туул голын усны чанарт ихээхэн нөлөөлж байна.

Хаягдал ус цэвэршүүлэх байгууламжууд болох Төв ЦБ 57-69%, Нисэхийн ЦБ 92-97%, Био орон сууц ЦБ 90-95 %, Био үйлдвэрийн ЦБ 25 хувийн цэвэршүүлсэн усыг Туул голд 1-3 дугаар саруудад нийлүүлсэн байна.

Гадаргын усны чанарын 2025 оны 1 дүгээр сарын товч тойм

2025 оны 1 дүгээр сарын Туул голын дагуу 6 сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлон Усны чанарын стандарт MNS4586:24 дахь ХА-тай харьцуулахад Хотын төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир ус нийлэхээс өмнө буюу Сонгино дээд цэгийн орчимд аммонийн азот (NH_4)-ын агууламж 895.5 дахин, нитрит азот (NO_2)-ын агууламж 16.6 дахин, эрдэс фосфор (Р)-ын агууламж 43.4 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч ($БХХ_5$)-ийн агууламж ХА-аас 4.5 дахин тус тус их байна.

Сонгино доодоос Хадан хясаа цэг орчимд аммонийн азот (NH_4)-ын агууламж 1127-1328 дахин, нитрит азот (NO_2)-ын агууламж 2.1-4.1 дахин, эрдэс фосфор (Р)-ын агууламж 30.1-44.1 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч ($БХХ_5$)-ийн агууламж ХА-аас 13-51 дахин их байсан ба Ууссан хүчилтөрөгчийн горим алдагдаж “Онцгой бохирдолтой түвшин”-д байна.

5.2. СЭЛБЭ ГОЛ

5.2.1. Сэлбэ голын усны нөөц, горим

Сэлбэ гол нь Туул голын цутгалуудын нэг бөгөөд ус хурах талбай нь (ус судлалын Дамбадаржаа харуулаар) хойт өргөргийн 47º55'-48º15', зүүн уртрагын 106º50'-107º00' хооронд байрлана. Голын нийт ус хурах талбай нь ойролцоогоор 300 км^2 гаруй болно.



Зураг 57. Сэлбэ голын сав газрын зураг

Сэлбэ голын физик газар зүй болон ус зүйн үзүүлэлтүүд: Туул голын сав газрын нэгэн том цутгал Сэлбэ гол нь Хан Хэнтийн салбар уулсын дундаас эх авч хойноос урагшаа чиглэлтэй Улаанбаатар хотын төв дундуур 35 км урсаад Туул голд цутгана. Сэлбэ гол нь

далайн түвшнээс дээш 1510-1620 м өндөрт орших ба Хандгайтын гол, Хайлааст гол, Чингэлтэй гол, Шарга морьт гол, Бэлэхийн гол, Яргайтын горхи, Ар гүнтийн горхи, Шадивлангийн горхи, зэрэг гол горхи цутгадаг байна (Цутгал голуудын 63 хувь нь ширгэж хатсан).

Сэлбэ голын хөндий Дамба харуулаас доош тавиурч урсацын алдагдал ихэсдэг. Сэлбэ гол өргөн нь 7-15 м, урсгалын хурд 2 м/с, урсац нь 1.28 м^3/с, түвшин 21.5 см байсан (1985 он).

Зураг 58. Сэлбэ болон Багабаян голууд

Голын усны горим, тэжээл: Сэлбэ гол хаврын шар усны ба хур бороoны үерийн үеийн горимтой. Сэлбэ голын тэжээлийн 69 хувийг хур бороoны ус, 5 хувийг цас мөсний ус, 26 хувийг ул хөрсний ус эзэлдэг. Хаврын шар усны үер 3-р сарын сүүлээр эхэлж 4 дүгээр сарын дунд үе хүртэл үргэлжлэх ба үүний дараа зуны гачиг үе эхэлнэ. 7, 8, 9-р саруудад зуны хур бороо элбэгшиж, намар болмогц намрын гачиг үе эхэлж 10-р сарын сүүлчээр голын ус хөлддөг тул голын үндсэн тэжээл болох усны түвшин маш тогтворгүй байдаг байна.

Сэлбэ гол нь гол мөрний горимын ангиллын хувьд хаврын шар усны ба дулааны улирлын хур бороoны үертэй голд хамрагдана.

Сэлбэ голын горимын байнгын судалгааг 1985 оноос Дамбадаржаа чиглэлээр ус судлалын харуул байгуулан хийж эхэлсэн. Энэ харуул ажиллах хүн, багаж төхөөрөмжийн дутагдлаас болон 1991 онд хаагдаж, 1994 оноос ус судлалын байнгын шинэ харуулыг Санзай амралтын чиглэлээр байгуулан өнөөдрийг хүртэл ус судлалын сүлжээний үндсэн хөтөлбөрөөр ажиллаж усны түвшин, өнгөрөлт, усны температур, мөсний үзэгдэл, зузаан зэрэг горимын элементүүдийг хэмжиж, ажиглаж байна. Дээрх хоёр харуулын дүрс зүйн зарим үзүүлэлтийг (Хүснэгт 31)-д үзүүлэв.

Ажигласан жилүүдийн материалаас үзэхэд Сэлбэ голын хамгийн их урсац 1990 онд Дамбадаржаа харуулаар 15.1 м^3/сек, 1994 онд Санзай харуулаар 3.56 м^3/сек хүрч байсан байна.

Хүснэгт 31. Сэлбэ голын ай савын дүрс зүйн зарим үзүүлэлт

№	Гол-Харуул	Ус хурах талбай, км^2	Голын урт, км	Дундаж өндөр, м	Голдирлын хэвгий, ‰	Ойн талбай, %
1	Сэлбэ-Санзай	34.2	8.3	1620	21.3	63.7
2	Сэлбэ-Дамбадаржаа	188	26.2	1510	12.4	54.6

Хүснэгт 32. Сэлбэ голын ажиглагдсан жилийн дундаж урсац, м^3/с

Сэлбэ-Дамбад	Сар / Он	4	5	6	7	8	9	10	11
	1987	0,8	0,21	0,27	0,42	0,65	0,34	0,22	-
	1988	0,8	1,04	0,84	0,66	0,41	0,84	0,23	0,04

	1989	0,8	0,21	0,32	0,27	0,36	0,25	0,25	0,01
	1991	2,44	2,14	0,53	1,08	0,42	1,11	0,57	0
	2000	0	0,33	0,08	0,37	1,49	0,56	0	0
	2001	1,51	1,14	0,43	0,25	0,18	0,18	0,17	0
	2003	0,37	0,96	0,17	0,28	1,96	1,1	0,65	0
	2006		1,42	2,57	1,14	0,83	0,78	0,89	0
	2007		0,97	0,94	0,63	0,73	0,75	0	0
	2008		0,31	0,64	0,59	0,12	0,3	0	0
	2009		0,25	0,32	0,43	0,44	0,33	0	0
	2010		0	0,21	0,19	0,29	0,09	0,11	0,02
	Дундаж	0,96	0,75	0,61	0,53	0,66	0,55	0,26	0,01

Хүснэгт 33. Олон жилийн дундаж урсац

№	Гол-Харуул	Ажигласан хугацаа	Олон жилийн дундаж урсац			C_v	C_s
			Q ($м^3/с$)	q ($л/с·км^2$)	h (мм)		
1	Сэлбэ-Санзай	1994-2008	0.1	3.8	120.0	0.7	1.4
2	Сэлбэ-Дамбадаржаа	1985-2008	0.4	2.2	70.5	0.6	1.3

Хүснэгт 34. Хур бороony үерийн их урсац

№	Гол-Харуул		Янз бүрийн хангашилтай өнгөрөлт Q ($м^3/с$), модуль q ($л/с·км^2$), урсацын давхраа h (см)					
			0.1	1	2	5	10	25
1	Сэлбэ-Дамбадаржаа	Q	1002	350	216	113	67.4	25.8
		q	3630	1268	790	409	244	93.5
		h	-	40.0	24.6	27.0	13.5	16.0

Хүснэгт 35. Дулааны улирлын 30 хоногийн хамгийн бага урсцын дундаж модуль, $л/с·км^2$

№	Гол-Харуул	Хангамшлын хувь						C_v	C_s
		50	75	80	90	95	97		
1	Сэлбэ-Санзай	1.28	0.22	0.05	0.00	0.00	0.00	1.53	3.06
2	Сэлбэ-Дамбадаржаа	0.99	0.56	0.49	0.36	0.30	0.28	0.96	1.92

5.2.2. Сэлбэ голын усны чанар

Гуч гаруйхан километр урсдаг энэ гол нь хэдхэн жилийн өмнө маш цэвэр байснаа ихээхэн бохир болж өөрчлөгдсөн нь анхаарал татах асуудал төдийгүй хүний сөрөг нөлөө байгалийн усан орчинд хэрхэн тусч байгааг харуулах бас нэгэн тод жишээ юм. Туул голын сав газрын усны нөөц сүүлийн жилүүдэд нэлээд хомсдож байгаа нь дараах хүчин зүйлүүдээс ихээхэн хамааралтай байна. Үүнд:

- Голын эх ба урсац бүрэлдэх хэсгийн ойг их хэмжээгээр огтолсон, түймэрт олон удаа өртсөн зэрэг нь хөрсөнд ус хуримтлагдах хэмжээг бууруулж, урсацын зохицуулалтыг алдагдуулсан.
- Туулын ай савд хүн малын суурьшил их болсноос усны ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээ эрс нэмэгдсэн.
- Уур амьсгалын нөхцөл өөрчлөгдөж хуурайших, дулаарах хандлага ажиглагдах болсон.
- Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэр аж ахуйн газрууд усыг хяналтгүйгээр ашиглах нь нэмэгдсэн.

Сэлбэ гол нь Санзайн ам ба түүнээс дээшхи хэсэгт маш цэвэр, Салхитын амнаас дээш Шарга морьт хүртэлх хэсэгт бага бохирдолтой, Дамбадаржаа, Долоон буудал орчим бохирдлын зэрэг ихэсч, Арслантай гүүр хүртэл түүнээс доош хэсэгт бохирдол дээд цэгтээ хүрч усны чанар маш муудсан байна.

2020 оны 05-р сарын 19-ний өдөр -Сэлбэ голын эхэн хэсэг, -Бага баян гол, -Сэлбэ гол Бага баян голтой нийлээд урсаж байгаа хэсгээс дээж авч Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн үр дүнгээс үзэхэд Сэлбэ голын эхэн хэсэг болон Бага баян голын ус нь Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна.

Харин Сэлбэ гол Бага баян голтой нийлээд урсаж байгаа хэсгийн ус нь Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна.

Шинжилсэн үзүүлэлтүүдийг “Гадаргын усны цэврийн зэргийн ангилалын норм”-той харьцуулахад Сэлбэ голын эхийн ус нь аммонийн азотын агууламж болон исэлдэх чанарын хэмжээгээрээ “Бага зэргийн бохирдолттой”, Бага баян голын ус “Бохирдолттой“, нийлээд урсаж байгаа Сэлбэ голын ус исэлдэх чанарын хэмжээгээрээ “Бохирдолттой“, аммонийн азотын агууламжаараа “Их бохирдолттой“ гэсэн ангилалд тус тус хамаарч байна

Улаанбаатар хотын дундуур Сэлбэ гол урсахдаа бохирдлын дээд цэгт хүрч, үе үе усны түвшин буурч тасалддаг. Сэлбэ голын эхээр амралт, зуслангууд ихээхэн нэмэгдэж, мал аж ахуй эрхэлдэг айл олноор суурьшснаас ус бохирдох үндсэн голомт үүсэж байна. Энэ бохирдол ялангуяа дулааны улиралд улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Усны химийн болон биологийн бохирдол энэ голомтоос эхлэн урсгалын дагуу улам бүр тархан нэмэгдсээр Арслантай гүүр орчимд ирэхэд Туул голын хамгийн их бохирдсон хэсэг болох Сонгино орчмынхтой адил түвшинд ирж байна.

Улаанбаатар хотын бүх үйлдвэр, аж ахуй, гэр хороолол, орон сууцны хаягдал бохир ус зэрэг бүхий л сөрөг нөлөөллийн дүнд Сонгино орчмын бохирдол маш их байдаг. Сэлбэ голын бохирдол Сонгино орчмын бохирдолтой дүйцэхүйц болсон нь голын оршин буй дэвсгэр нутаг, хотын орчим болон хот дундуур урсан гардагаас дулаан хүйтний аль ч улиралд бохирдуулагч эх үүсвэр байнга байдагтай холбоотой юм.

5.3. ДУНД ГОЛ

Дунд гол нь Улаанбаатар хотын төв хэсэгт байрлах, Сэлбэ голын баруун салаа бөгөөд эцэстээ Туул голд нийлдэг. Ойролцоогоор 20-25 км (урсацын өөрчлөлтөөс хамаарна).

Дархан цаазат Богдхан уулын хойд бэлээс эх авдаг бөгөөд урсах чиглэлийн хувьд Хан-Уул дүүргээс эхэлж Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нутгаар дайрч хотын төвийн баруун хэсэгт Туул голд цутгадаг байна.

Голын усны түвшин:

- Зуны улиралд хур бороноос хамаарч усны түвшин ихэсдэг.
- Өвлийн улиралд бүрэн хөлддөг эсвэл хатах магадлалтай.

Дунд гол нь хотын дундуур урсдаг цөөхөн голуудын нэг бөгөөд экосистемд дараах үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- Гадаргын усны эргэлтийг дэмждэг – Хотын усны системийн нэг хэсэг.
- Амьтан, ургамлын амьдрах орчин – Голын эрэг дагуу бут сөөг, өвс ургамал ургаж, шувууд амьдардаг.
- Үерийн усны хамгаалалт – Борооны улиралд усны илүүдлийг хуримтлуулдаг.

ЗУРГАА. ГАЗРЫН ДООРХИ УС

6.1. ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ, ГОРИМ

Туул голын сав газар дахь газрын доорх усны судалгаа жигд биш боловч харьцангжй сайн хийгдсэн.

Туул голын сав газрын нийт талбайд гидрогеологийн 1:500000-ын , Улаанбаатар хотын орчимд 1:100000-ын зураглал тус тус хийгдсэн.

УБ хот орчмын Туул голын хөндий нь гидрогеологи, инженер-геологийн хурвьд харьцнгуй өндөр нарийвчлалтай судлагдсан, геоморфологи, геологийн тогтоц ерөнхийдөө тодорхой болсон.

Геоморфологи, геологи: Геоморфологийн хувьд Туул голын сав нь ерөнхийдөө уулархаг бүс нутагт хамаарах бөгөөд уул нурууд, тэдгээрийн хормой, бэл, уулс доторх гол, горхийн хөндий, ам, судгаас бүрддэг.

Туул голын сав газрын эх нь Хэнтийн нурууны уулархаг хэсэгт далайн түвшнээс дээш 2600м үнэмлэхүй өндөрт бүрэлдэж байхад голын адаг хэсэг болох Орхон-туулын бэлчирт үнэмлэхүй өндөр нь 800м орчим болж, голын хөндий өргөсдөг.

Тус сав газрыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорх усны тэжээгдлийн бүс, Улаанбаатарын хотгор нь хуримтлал, зөөгдөл, хөлийн бүс болдог. Туул голын хөндий нь өргөссөн, нарийссан хэсэг ээлжилсэн тогтоцтой бөгөөд өргөссөн хэсэг нь газрын доорх усны хуримтлалын бүс, нарийссан хэсэг нь шахагдсан хөлийн бүсболсон шинжтэй байдаг.

Тус сав газрын геологийн тогтоц нькембри, девон, карбоны эрин үед үүссэн тунамал, хувирмал чулуулаг, тэдгээрийг нэвтэлж газрын гүнд царцаж тогтсон юра, триасын настай боржин чулуулаг, эдгээр үндсэн чулуулгийг бүрхэж тархсан цэрдийн эринд үүссэн цайвар саарал өнгийн элсжин, зануужин, гуравдагчийн улаан, улаавтар шар өнгийн хайргатай элсэрхэг болон наанги шавар, шавранцар, элсний нимгэн үе, дөрөвдөгчийн үед үүссэн элс, хайрга, шавар, хайргажин зэрэг хурдас, чулуулгаас бүрддэг.

Гуравдагчийн (Неогени, Палеогени) хурдас нь дунджаар 80 мзузаантай, ихэвчлэн ус үл нэвтрүүлэгч шаварлаг бүтэцтэй байдаг. Туул голын хөндий дагаж тархсан орчин үеийн дөрөвдөгчийн буюу голоцений настай аллювийн, нуурын болон салхины гаралтай хурдас тархсан байдагийн дотроос аллювийн хурдас газрын доорх усны харьцангуй их нөөц агуулдаг.

6.2. ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

Туул голын сав газрын хэмжээнд тархсан хурдас, чулуулгийн ус агуулах шинж төрх, өрөмдлөгийн ажлаар нээгдсэн газрын доорх усны ундарга, тархалтын зүй тогтлыг харгалзан үзэж ус агуулагч үе, үе давхарга, бүсийг ялгав.

1.Ус агуулагч нүх сүвэрхэг үе, үе давхарга:

1.1.Аллювийн гаралтай хурдас дахь ус агуулагч үе давхарга. Ус агуулагч энэ үе давхарга Туул голын хөндийд зонхилж орчин үеийн дөрөвдөгчийн буюу голоцений (qh) настай, аллювийн гаралтай сэвсгэр, нүх сүвэрхэг элс, хайрга,заримдаа элсэнцрийн үетэй хурдсаас тогтжээ. Улаанбаатар хот орчимд Туул голын хөндийд тархсан элс, хайргаас зонхилж тогтсон аллювийн хурдас өндөр ундарга бүхий газрын доорх ус агуулдаг. Газрын доорх ус агуулагч үеийн зузаан 5 метрээс 90 гаруй м хооронд хэлбэлзэнэ.

1.2.Салхины гаралтай хурдас дахь ус агуулагч үе. Ус агуулагч энэ үе зонхилж голоцений (qh) настай, салхины гаралтай сэвсгэр, нүх сүвэрхэг сэвсүүл элсээс тогтоно. Энэ үе нь өндөр ундаргатайгаар багахан талбайд тархаж, эсвэл тун бага юмуу дундаж ундаргатайгаар их талбайд тархсан байна.

1.3.Голоцений настай аллювийн гаралтай хурдас дахь ус агуулагч үе давхарга. Энэ үе давхаргад элс, хайрга, элсэнцэр, шаврын үеэс тогтсон жижиг талбайд өндөр ундаргатай эсвэл их талбайд бага, дундаж ундаргатай ус агуулагч аллювийн хурдсыг оруулсан болно. Мөн газрын доорх усны ашиглалтын хайгуул хийгээгүй голын хөндий дагаж тархсан аллювийн ихэнх хурдсыг тус үе давхаргад хамруулав. Энэ төрлийн устай хурдсыг илрүүлсэн ихэнх цооног нь голын хөндийд байрласан бөгөөд харьцангуй өндөр ундаргатай. Бага талбайд тархсан, өндөр ундаргатай эсвэл их талбайд тархсан бага юмуу дундаж ундаргатай ус агуулсан нүх сүвэрхэг үе давхаргад ангилан оруулсан Голоцений настай аллювийн гаралтай шавранцар, шаврын үетэй элс, хайргаас гарч буй булгуудын ундарга 0.2- 5 л/сек хооронд байна.

1.4.Дөрөвдөгчийн настай, нуурын гаралтай шавар, лаг шавар, элсээс зонхилж тогтсон уст давхарга. Харьцангуй их талбайд тархсан бага юм уу дундаж ундаргатай ус агуулсан нүх сүвэрхэг давхарга харьцангуй тархалт багатай, 0.3-0.8 л/сек ундаргыг усны түвшнийг 11-13.5 м бууруулан шавхалт явуулахад гаргаж байжээ.

1.5.Плейстоцений настай, пролювийн гаралтай хурдас дахь ус агуулагч давхарга. Тус давхарга нь судаг, жалга, уулын бэл хормойгоор тархсан элс, хайрга, элсэнцэр, шавар, шавранцраас тогтоно. Плейстоцений настай, пролювийн гаралтай хурдас дахь ус агуулагч давхарга нэлээдгүй өргөн тархацтай. Плейстоцений настай, пролювийн гаралтай, хязгаарлагдмал талбайд тархсан, өндөр ундаргатай эсвэл их талбайд тархсан бага юмуу дундаж ундаргатай ус агуулсан нүх сүвэрхэг давхарга дотор илэрч буй газрын доорх усны ундарга туршилт судалгааны цооногт 0.3- 16 л/сек, усны түвшний бууралт 0.5- 42 м.

1.6.Зонхилж неогений (N) настай хурдас дахь ус агуулагч давхарга. Энэ давхарга нь элсэрхэг шавар, элс, элсжингээс тогтоно. Ус агуулах чадвар өндөр биш учраас түүний ус төвлөрсөн ус хангамжид ховор ашиглагдана.

1.7.Дээд цэрдийн (c2) настай хурдас дахь ус агуулагч давхарга. Дээд цэрдийн настай уст давхарга энэ бүс нутагт тархалт багатай, ус хангамжийн томоохон эх үүсвэр нээсэн тохиолдол ховор юм.

1.8.Доод цэрдийн (c1) настай, намгархаг эх газрын гаралтай хурдас дахь ус агуулагч давхарга. Доод цэрдийн настай, намгархаг эх газрын гаралтай хурдас дахь ус агуулагч давхарга багаас хязгаарлагдмал ундаргатайгаар тархсан байх нь элбэг тохиолдоно.

1.9. Юра, Триас, Пермийн настай тунамал гаралтай хурдас дахь ус агуулагч давхраадаст-ан цавлаг давхарга. Энэхүү давхарга нь энэ бүс нутагт хязгаарлагдмал тархалттай. Юра, триас, пермийн элсжин, хөрзөн 0.1-1.0 л/сек ундаргатай ус агуулсан байх нь бас элбэг. Усны эрдэсжилт 1.0 г/л орчимд байдаг.



Зураг 59. Гидрогеологийн зураг

Туул голын сав газрын хэмжээнд нүх сүвний (бүрдэл), ан цавын (бүс) гэсэн 2 төрлийн ус агуулагч бүрдэл тархсан ба ан цав-нүх сүвний ус болох рашаан (Улаанбаатар, Ар Жанчивлан зэрэг нүүрс хүчлийн хийтэй хүйтэн рашаан) тархсан байдаг. Нүх сүвэрхэг бүрдэл нь Доод цэрд, Неоген, Дөрөвдөгчийн хурдас дотор, ан цавлаг бүс нь Кембри, Девон, Карбоны тунамал, хувирмал, эсвэл Юра, Триасын түрмэл чулуулаг дотор тус тус бүрэлддэг.

Туул голын сав газрын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литологийн төрлийг ерөнхийд ус агуулагч нүх сүвэрхэг 6 үе, бүрдэл болон ус агуулагч ан цавлаг 2 бүсээр Н.Жадамбаа нар, 2012 онд ялгасан байна. Ус агуулагч нүх сүвэрхэг 6 үе болон бүрдэл, ан цавлаг 2 бүсийн үндсэн мэдээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 36. Сав газрын ус агуулагч үе, бүрдэл болон бүсийн гидрогеологийн зарим үзүүлэлт

№	Ус агуулагч үе, бүрдэл, бүсийн нэр	Өгөмжийг нь ашигласан цооногийн тоо	Усны түвшин (бага-их), м	Түвшний бууралт (бага-их), м	Ундарга, л/с	Эрдэс-жилт, гр/л
1	Голоцений аллювийн үе	300	0.2-6	0.0-23	1.0-105	0.1-0.6
2	Туул голын хөндий дагаж тархсан Плейстоцений пролюв, пролюв-аллювийн үе	200	2.0-11.5	1.9-20.5	0.5-24.1	0.5-1.5
3	Цутгал голуудын хөндий дагаж тархсан Голоцен-Плейстоцений аллюви, пролювийн үе	270	0.2-12	2-40	0.5-8.0	0.3-1.2
4	Неогений хурдас дахь бүрдэл	20	19.37-119	2-40	0.5-3.8	0.5-1.6
5	Цэрдийн хурдас дахь бүрдэл	85	1.5-80	-	0.3-10	-
6	Триас-Юрагийн давхраадаст чулуулаг дахь бүрдэл	45	3-33	1-15	1-1.3	0.2-0.3
7	Палеозойн тунамал, хувирмал, бялхмал чулуулаг дахь бүс	30	3.7-60	4.5-17	0.07-25	0.1-1.2
8	Түрмэл чулуулаг дахь бүс	115	8.6-26.5	2.7-5.1	0.1-4.3	0.1-0.7

6.3. ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ

6.3.1. Нөхөн сэргээгддэг нөөц (Байгалийн нөөц)

Нөхөн сэргээгддэг нөөц гэж жил бүр хур тунадасны нэвчилт, гадаргын усны нэвчилт шүүрэлт, хажуугийн урсцын нөлөөгөөр дахин бүрэлдэх боломжтой усны хэмжээг хэлнэ.



Зураг 60. Туул голын сав газрын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц

Туул голын сав газрын ус хурах нийт талбай 49774.0 км^2 бөгөөд жилд 960.0 сая.м^3 газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц бүрэлддэг байж болох тооцоо гарч байна.

Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн зураг (зураг 54)–аас харахад шинээр баригдах авто замын трассын баруун хойд хэсгийн талбай нь “газрын доорх урсацын түвшин 10-20 мм/жилд” ангилалд, трассын зүүн хойд болон баруун хойд хэсэг “газрын доорх урсацын түвшин 20-50 мм/жилд”, трассын зүүн урд болон баруун урд хэсэг “газрын доорх урсацын хэсэг” ангилалд багтаж байна.

6.3.2. Ашиглалтын баримжаат нөөц

Газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөцийг усны ай сав, ус агуулагч үе, бүрдэл, бүс, талбайн хэмжээнд зураглалын ба балансын гэсэн үндсэн 2 аргыг ашиглан тодорхойлдог.

Туулын савын нийт 49774 км^2 талбайд газрын доорх усны 641 сая.м^3/жил (0.641 км^3/жил) ашиглалтын баримжаат нөөц бүрэлдэж байгаагаас 596 сая.м^3/жил буюу нийт нөөцийн 92.9 хувь, нийт нутгийн 20 хувийг эзэлж байна (Хүснэгт 37).

Хүснэгт 37. Туул голын сав газар дахь газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц

Индекс	Газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөцийн ангилал ба ус агуулагчийн төрөл	Талбай, км^2	Нэгж талбай дахь нөөц, л/сек/км^2	Нэгж талбай дахь нөөц, м^3/жил/км^2	Нөөц, сая ^{3}/жил
1	Их нөөц баялагтай (>10 л/с/1 ам км), чөлөөт гадаргат ус	165.6	10	315360	52
2	Дунджаас их нөөц баялагтай (3-10 л/с/1 ам км), чөлөөт гадаргат ус	3705	3	94608	351

3	Дундаж нөөц баялагтай (1-3 л/с/1 ам км), чөлөөт гадаргат ус	6123	1	31500	193
5	Дунджаас бага нөөц баялагтай (0.3-1 л/с/1 ам км), чөлөөт болон даралтат гадаргат ус	246	0.65	20500	5
6	Дунджаас бага нөөц баялагтай (0.3-1 л/с/1 ам км), дарагдмал даралтат ус	633	0.65	20500	13
7	Бага нөөц баялагтай (0.03-0.3 л/с/1 ам км), ан цав нүх сүвийн чөлөөт болон даралтат гадаргын ус	1278	0.165	5203	6
8	Бага нөөц баялагтай (0.03-0.3 л/с/1 ам км), нүх сүв ан цавын чөлөөт болон даралтат гадаргын ус	2239	0.165	5203	12
9	Тун бага нөөц баялагтай (0.003-0.03 л/с/1 ам км), нүх сүвийн чөлөөт болон даралтат гадаргын ус	49	0.0165	520	0
12	Бага нөөц баялагтай (0.003-0.03 л/с/1 ам км), ан цавын даралтат болон чөлөөт гадаргын ус	12879	0.0165	520	7
13	Маш бага нөөц баялагтай (<0.003 л/с/1 ам км), ан цавлаг үндсэн чулуулаг, олон жилийн цэвдэгт сэвсгэр хурдас эсвэл гидрогеологийн хувьд судлагдаагүй хурдас чулуулаг	22456	0.003	94.6	2
Нийт		49774			641

Хүснэгт 38. Улаанбаатар хотын хэмжээнд нөөц нь батлагдсан газрын доорх усны ордууд

№	Сум	Ордын нэр	Он	Ашиглах жил	Нийлбэр нөөц	Батлагдсан нөөц, л/сек
1	Улаанбаатар хот	Туул голын УБ доод эх үүсвэр	1979	30	7.46	
2		Туул голын УБ дунд эх үүсвэр				6.26
3		Туул голын УБ дээд эх үүсвэр				
4		Улаанбаатар хотын ДЦС-2	2020	25	108	108
5	Сонгинохайрхан	Хүй долоон худаг	1987	25	17.0	17
6		Хүй долоон худаг	2006	25	44.5	44.5
7	Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо	361 гарам	2013	25	20	20
8	Баянзүрх	Өвөр горхийн хөндийн Туул голын савын бэлчир	2004	25	136.0	136
9	Налайх	Налайх дүүргийн - Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк	2015	25	30.0	30
10		Өтгөрүүгийн тохой	2020	25	85.0	85
11	Хан-Уул дүүрэг Яармаг, Нисэх	Яармаг нисэхийн эх үүсвэр	2011	25	303.3	303
12	Гавьжийн шанд, Өлзийт хороо	Өлзийт гавжийн шанд	2012	25	26.86	26.86
13	ХУД 13-хороо Биокомбинат, Шувуун фабрикт	Туул голын доод эх үүсвэр - Үнсгэний хөндий	2014	25	210.0	210
14	Хан-Уул	Улаанбаатар хотын ус хангамж (Шувуун фабрикийн хэсэг)	2019		885	885
15		Улаанбаатар хотын ус хангамж (Био комбинатын хэсэг)	2019		736	736
16		Буянт-Ухаа	2009	25	240.0	261
17		Оргилын нүүрсхүчлийн хийт хүйтэн рашаан	2022			1

Эх сурвалж: Усны газар, 2024 он

6.4. УЛААНБААТАР ХОТ ОРЧМЫН ГАЗРЫН ДООРХ УСНЫ ХИМИЙН НАЙРЛАГА, ЧАНАР

Монгол орны газрын доорх усны нөөц нь жигд бус тархалттай, чанар нь харилцан адилгүй бөгөөд нутаг дэвсгэрийн хувьд баруунаас зүүн тийшлэх, хойноос урагшлах тутам эрдэсжилт нь ихсэх хандлага ажиглагддаг. Энэ нь орох хур тунадасны хэмжээ, агаарын температур,

ууршилт нэмэгдэх зэрэг уур амьсгалын өөрчлөлт болон ус агуулагч хурдас чулуулгийн үндсэн шинж чанартай холбоотой.

Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд УБ хот орчмын газрын доорх усыг чанар, найрлагаар нь ангилахдаа дүүргээр усны химийн найрлагаараа ойролцоо байдлаар нь бүлэглэсэн байна. Тухайлбал, Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүргийн ус өндөр эсдэсжилт, хатуулагтай байхад Хан-Уул дүүргийн ус харьцангуй бага эрдэсжилттэй буюу цэнгэг, зөөлөн ус байх жишээтэй.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн газрын доорх усны эрдэсжилтийн олон жилийн дунджийг дүүргүүдээр ангилж доорх зурагт үзүүлэв.



Зураг 61. Улаанбаатар хот орчмын газрын доорх усны дундаж эрдэсжилт

Улаанбаатар хот орчмын газрын доорх ус нь ихэвслэн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй ангилалд орж байгаа бөгөөд зарим газартаа, давсархаг устай байна.

Улаанбаатар хот орчмын газрын доорх усны хатуулгийн дундаж хэмжээг дүүргүүдээр бүлэглэж, зураг 60-д үзүүлэв.



Зураг 62. Улаанбаатар хот орчмын газрын доорх усны дундаж хатуулаг

Зургаас харахад ихэнх дүүргүүдийн газрын доорх ус зөөлөвтөр байгаа боловч Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийнх харьцангуй хатуу буюу ундны усны стандартын зохимжтой (5 мг-экв/л) болон зөвшөөрөгдөх дээд хэмжээ (7 мг-экв/л)-нээс илүү хатуулагтай байна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх газрын доорх усны орчинг зураг 61-т харуулав.



Зураг 63. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх газрын доорх усны PH

Ундны усны стандартад pH-ыг 6.5-8.5 байхаар заасан бөгөөд Улаанбаатар хот орчмын газрын доорх усны pH нь сулавтар хүчиллэгээс сулавтар шүлтлэг буюу pH=6.5-8.5 байгаа нь ундны усны стандартын шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 39. Газрын доорх усан дахь хүнд металлын агууламж

Дээж авсан газрын нэр	Үзүүлэлтүүд, мг/л						
	Mn	Fe	Cu	Cd	Pb	Zn	Cr
Нисэх байрны бууудлын худаг	<0.01	0.36	0.06	<0.003	<0.02	0.20	<0.01
Чингэлтэй, эцсийн буудлын худаг	<0.01	0.13	0.07	<0.003	<0.02	0.20	<0.01
Зайсан, хүүхдийн хорихын худаг	<0.01	0.09	0.08	<0.003	<0.02	0.04	<0.01
Шархадны эмнэлгийн худаг	<0.01	0.16	0.10	<0.003	<0.02	0.03	<0.01
Дамбадаржаа, сүмийн зүүн талын гүний худаг	<0.01	0.27	0.08	<0.003	<0.02	0.04	<0.01
MNS 900:2005	0.1	0.3	1.0	0.003	0.01	5.0	0.05

Хүснэгт 31-ээс харахад хүнд металлын агууламж ундны усны стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

ДОЛОО. ХӨРСӨН БҮРХЭВЧ

7.1. УЛААНБААТАР ХОТЫН ХӨРСНИЙ ЕРӨНХИЙ ХЭВ ШИНЖ

Улаанбаатар хот орчмын нутаг нь уулын ой тайга болон хээрийн бүсийн зааг дээр оршдог. Хөрсний газарзүйн мужлалаар хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрог[6]-т багтах бөгөөд Туул голын өргөн хөндий, Хэнтийн нурууны салбар уулын энгэр хажуугаар ихэвчлэн Хархүрэн хөрс зонхилно. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хойд хэсгээр Ойн бараан ба Харшироон хөрс, голын хөндийгөөр Аллювийн ширэгт ба хайргархаг хөрс зонхилон тархах бол Богд уулын ар хэсгээр тархана.

Хар хүрэн хөрс: Улаанбаатар хот орчим зонхилон тархсан хөрс болно. Үетэн алаг өвст хээрийн ургамалшил доор (60-80 %-ийн ургамал бүрхэцтэй) тогтворжих бөгөөд харьцангуй зузаан (20-30см) бараан бор ялзмагт давхаргатай. Хэдхэн см-ийн доор карбонат хуримтлалын давхаргатай. Дээд талын ялзмагт “А” үе болон карбонат давхаргын хооронд 10-20 см-ийн зузаантай бор өнгийн “В” буюу шилжилтийн давхарга байдаг. Хайргархаг шавранцар, элсэнцэр механик бүрэлдэхүүн зонхилно, мөн элсэрхэг хөрс ч тохиолдоно.

Хар шороон хөрс: Уулын ар хажуугийн доод хэсэгт ойн хилээс доош 1700-1500 метрт 60-90%-ийн бүрхэцтэй нугат хээрийн ургамалшил доор тогтворжино. Ойгоос урсаж буй гадаргын урсац хөрсний илүүдэл чийгийг үүсгэж, нэвт норж чийглэгдэнэ. Карбонат хуримтлал 80-100 см-ийн гүнд бий болно. Гүн саарал, хүрэн бараан саарал өнгөтэй бөөмөрхөг бүтэцтэй ялзмагт үе тод ялгарна. Ялзмагт давхаргын зузаан нь (А+АВ) голдуу 50-60 см-аас хэтэрдэггүй.

Аллювийн хөрс: Татмын алаг өвс-улалжит ургамалшилтай газраар тархана. Ялзмагт давхаргын зузаан 20-40 см орчим зузаан бүдүүн ялзмагтай, доошоо элсэнцэр, шавранцар ээлжилсэн судал үеүдтэй, хөрс үүсгэгч чулуулаг нь элс хайргархаг аллювийн хурдас болно. Хөрсний дээд хэсэг ялзмагийн агууламж 5-10 % доошлох тусмаа багасдаг. Урвалын орчин саармаг (pH=6.5-7.0). Глейт шинж тод илэрсэн, гүний усны нөлөөгөөр үүссэн төмрийн ислийн зосорхог толбо өнгөртэй[7].

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын суурьшлын бүс нь сүүлийн 400 орчим жилийн түүхэн цаг хугацаанд хүн амын төвлөрөл, хотжилт, техноген нөлөөлөлд өртөж байгалийн үндсэн хэв шинжээ алдсан тул хүний үйл ажиллагаагаар өөрчлөгдсөн Техносол хөрсний шинж чанарт хамааруулан үзэх боломжтой юм. Иймд Улаанбаатар хотын суурьшлын бүсийн техноген нөлөөнд өртсөн хөрсийг 1. Барилга байгууламжид дарагдсан, 2. Гэр хорооллын талхлагдсан, 3. Оршуулгын газрын ухагдаж бохирдсон, 4. Үйлдвэрийн бүсийн талхлагдсан, 5. Уурхайн нөлөөгөөр ухагдаж эвдэрсэн гэсэн үндсэн дэд бүлэгт хуваан авч үзлээ. Мөн түүнчлэн хүнсний ногоо, хүлэмж, ногоон байгууламж зэрэг хүний нөлөөгөөр үүссэн хөрсийг Антросол гэсэн ангилалд хамруулан зураглалаа.

[6] ШУА, Газарзүйн хүрээлэн, Монгол улсын үндэсний атлас, Улаанбаатар хот, 2009
[7] Д. Доржготов, Монгол орны хөрс, Улаанбаатар хот, 2003



Зураг 64. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч

7.2. ХӨРСНИЙ ХИМИЙН ЕРӨНХИЙ ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар хотын суурьшлын бүсээс авсан 242 хөрсний дээжид химийн ерөнхий шинжилгээ тодорхойлсон. Хөрсний урвалын орчин (pH) 90.9% нь сул шүлтлэг, 4.9% шүлтлэг, 0.8% хүчтэй шүлтлэг, 3.3% сул хүчиллэг байна. Ялзмагийн агууламж 43.8% бага буюу маш бага, 48.3% дундаж, 7.8% маш их байна. Хөрсний 44.6% карбонатгүй, 34.2% бага зэрэг карбонаттай, 21% дунд зэрэг карбонаттай. Давсны агууламж буюу (EC) 84.2% нь бага, 12.3% дунд зэрэг, 3.3% давсжилттай байна.

Хүснэгт 40. Хөрсний химийн ерөнхий шинжилгээний дүн

	Max	Min	Mean	SD	Variation	Median
pH (1:2.5)	9.88	6.55	8.62	0.34	0.11	7.63
EC d/sm	9.47	0.05	2.06	1.31	1.71	0.61
OM, %	19.93	0.21	3.67	2.13	4.53	2.37
$CaCO_3$, %	9.45	0.00	2.23	1.77	3.15	0.61

7.3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН БОХИРДЛЫН ТӨВШИН

Улаанбаатар хотын хөрсний бохирдлын судалгааг 1989 оноос хийж эхэлсэн бөгөөд эдгээрээс ШУА-ын Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан П.Оюунбат докторын судалгааны ажлаараа нэлээд дэлгэрэнгүй буюу лабораторын шинжилгээг 300 орчим хөрсний дээж дээр хийж хүнд металлын бохирдлын дэлгэрэнгүй тархалтыг үзүүлсэн байна[8].

[8] П.Оюунбат, "Улаанбаатар хотын хөрсний бохирдол, бууруулах арга зам", Улаанбаатар хот, 2022

Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөнд удаан хугацаагаар хадгалагдаж усаар, агаарын тоосонцроор дамжин мал, амьтан, хүний бие организмыг хордуулдаг. Амьд организмд буюу хүний биед удаан хугацаагаар хуримтлагдсанаас бие организмыг молекулын ба гений түвшинд хордуулдаг. Тиймээс эдгээр элементүүдийн бохирдлын түвшинг бүх шатанд тодорхойлж үнэлгээ өгөх, цаашид бохирдлыг буруулах арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх нь бидний өнөөгийн тулгамдсан асуудлуудын нэг болсоор байна.

Хөрсний хүнд металлыг хүрээлэн буй орчин болон амьд организмд үзүүлэх сөрөг нөлөөллөөр нь Онцгой хортой хүнд металл (хар тугалга Pb, кадмий Cd, хүнцэл As, хром Cr), Хортой био-идэвхт хүнд металлууд (зэс Cu, цайр Zn, никель Ni, ванадий V, стронций Sr, молибден Mo, кобальт Co), Шүлтийн металлууд (кальци Ca, кали K, магни Mg, натри Na), Металлууд (хөнгөн цагаан Al, төмөр Fe, бари Ba, манган Mn) гэж ангилдаг. Энэхүү судалгаанд онцгой хортой болон био-идэвхт металлуудыг онцлон авч үзлээ.

Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхэлд хүргэх аюултай. Харин хортой био-идэвхт хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай.

Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хэмжээнд авсан 334 ширхэг дээжийн шинжилгээний статистик үзүүлэлтээс үзэхэд хүнцэл (As) 0.0-393.2 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 9.2 мг/кг, хар тугалга (Pb) 5.7-1339 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 37.2 мг/кг, хром (Cr) 0.9-10000 хооронд хэлбэлзэж дунджаар 85.4 мг/кг, кобальт (Co) 0.0-16.0 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 1.2 мг/кг, никель (Ni) 0.0-70.9 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 8.8 мг/кг, цайр (Zn) 0.0-441.7 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 88.4 мг/кг, зэс (Cu) 0.0-844.4 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 5.8 мг/кг, молибден (Mo) 0.0-41.9 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 0.7 мг/кг, Ванадий (V) 0.0-110.1 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 52.3 мг/кг, Стронций (Sr) 0.0-1013 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 294.3 мг/кг агууламжтай байна.

Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт (MNS 5850:2019)-аас давсан хөрсний бохирдолтыг нийт дээжид эзлэх хувиар авч үзвэл: As 3.9%, Pb 2.9%, Cr 2.6%, Zn 1.9%, Cu 0.6%, Mo 1.0%, Sr 1.9% тус тус стандартаас их бохирдолтой байна. Харин Кобальт (Co) Никель (Ni), Ванадий (V) стандартаас давсан цэг 0 % буюу бохирдолгүй байна. Байгалийн эрүүл хөрстэй нийт дээжид эзлэх хувиар авч үзвэл Pb 69.7 %, Co 38.1 %, Zn 83.2%, Cu 12.3%, Ni 50%, Mo 42.3%, As 63.5.3%, V 58.1% тус тус их бохирдолтой байна.

Хүснэгт 41. Улаанбаатар хотын хөрсөн дэх хүнд металлын агууламж

Статистик үзүүлэлт	Хүнд металлууд (мг/кг)									
	As	Pb	Cr	Co	Ni	Zn	Cu	Mo	V	Sr
Count	334	334	334	334	334	334	334	334	334	334
Maximum	393.2	1339	10000	16.0	70.9	441.7	844.4	41.9	110.1	1013
Minimum	0.0	5.7	0.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Mean	9.2	37.2	85.4	1.2	8.8	88.4	5.8	0.7	52.3	294.3
SD	24.1	103.4	544.6	2.0	11.9	58.5	47.8	2.4	18.0	116.8
CV	261.8	278.3	637.8	168.3	134.8	66.1	826.3	345.4	34.4	39.7
MNS 5850:2019	20	100	150	50	150	300	100	5	150	800
Стандартаас давсан дүн, %	3.9%	2.9%	2.6%	0%	0%	1.9%	0.6%	1.0%	0%	1.9%

7.3.1. Хөрсөн дэх хүнцэл (As)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд хүнцэл 0.0-393.2 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 9.2 мг/кг байна. Хамгийн их бохирдолтой газрууд нь Баянзүрх дүүрэгт Алтан-Өлгий (100-939 мг/кг), Монел (60-100 мг/кг), Шар хад (40-60 мг/кг), Улиастай (20-40 мг/кг) орчимд MNS 5850:2019 стандартаас их бохирдолтой байна.

Сонгинохайрхан дүүрэгт Орбит (80-100 мг/кг), Нарангийн гол (60-80 мг/кг), Ханын материал (20-60 мг/кг), Сонсголон (40-60 мг/кг) орчимд стандартаас их бохирдолтой байна. Хан-Уул дүүрэгт үйлдвэр комбинат (20-60), III цахилгаан станц (20-40), яармаг (40-60) орчимд их бохирдолтой байна. Баянгол дүүрэгт IV цахилгаан станц (20-40), III, IV хороолол (10-20), вокзал (10- 20), далан давхар (10-20) орчимд харьцангуй их бохирдолтой байна. Чингэлтэй дүүрэгт стандартаас өндөр бохирд илрээгүй ч Баян бүрд, Дэнжийн 1000 орчим харьцангуй их буюу 10-20 мг/кг байна. Харин Сүхбаатар дүүрэгт 5-10 мг/кг ба түүнээс бага агууламжтай байна.

Хүнцэлийн амьд организмд үзүүлэх хорт нөлөөллийн хувьд хүнцэлийн бараг бүх нэгдэл хавдар үүсгэх үйлчилгээтэй байдаг. As(III) болон AsH3 маш хортой химийн бодисын ангилалд багтаж арьс, уушиг, элэг, ходоод гэдэс, тунгалагийн булчирхайн хавдар үүсгэгч болдог. As(III) нь As (V)-тай харьцуулахад илүү хортой үйлчилгээ үзүүлдэг нь тэдгэрийн үүсгэх нэгдлүүдийн уусамтгай чанар, ангижруулагч шинж чанараас хамаардаг.



Зураг 65. Улаанбаатар хотын хөрсөн дэх хүнцлийн агууламж

Органик хүнцэл үндсэндээ эдийн хүнд хэлбэрийн үрэвсэл болон үхжилтийг үүсгэдэг бөгөөд өөрөөр хэлбэл хүнцэл хүхэртэй холбогдсоноор эс, эдийн амьсгал, хуваагдал зогсдог. Ингэснээр организм дахь тос, нүүрстөрөгчийн солилцоо алдагдаж, эдэнд исэлдэх процесс буурдаг. Хүнцэл биологийн идэвхит микроэлемент тул ургамал, амьтны эд, эс шээсэнд бага хэмжээгээр агуулагдаж, хүн амьтны амьдралын үйл ажиллагааг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Организмд хүнцэл дутагдахад гормоны зохицуулга, ферментийн идэвхжил, эдийн амьсгал өөрчлөгдөж, хэт исэлдэлт явагддаг. Хүнцэл илүүдвэл үс унах, хоол боловсруулах эрхтний хямрал, нүдний эвэрлэг бүрхэвч булингартах, хамрын таславч шархлах, хумс хугарамтгай болох, амт үнэр мэдрэмтгий болох зэрэг шинж тэмдэг илэрдэг.

Хүнцэл ихэвчлэн усан уусмалаар дамжин организмд нэвтэрдэг тул хүнцэл агуулсан ус хамгийн аюултайд тооцогддог. Ундны усанд зөвшөөрөгдөх хүнцэлийн агууламж 0.05 мг/л байдаг. Хүнцэлийн хордлого газар зүйн байрлал, амьдралын хэв шинж, онцлогоос хамааран ялгаатай илэрдэг бөгөөд байгалийн бүтээгдэхүүнд агуулагдах хэмжээ ч харилцан адилгүй байна.

Хүнсэнд агуулагдах хэмжээ нь, үр тарианд 0.006-1.2 мг/кг, махан бүтээгдэхүүнд 0.005-0.5 мг/кг, хүнсний ногоо, жимс жимсгэнэд 0.01-0.2 мг/кг, сүүн бүтээгдэхүүнд 0.005-0.01 мг/кг, далайн бүтээгдэхүүнд хамгийн их 0.39-3 мг/кг байдаг. Хүний хүнцлээр хордох тунг 0.01-0.05 г As, үхлийн тунг 0.06-0.2 г As гэж үздэг байна (Войнар, 1960).

7.3.2. Хөрсөн дэх хар тугалга (Pb)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд хүнцэл 5.7-1339 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 37.2 мг/кг байна. Хамгийн их бохирдолтой газрууд нь Баянзүрх дүүрэгт Алтан-Өлгий (100-500 мг/кг), Монел (50-100 мг/кг), Шар хад (100-1200 мг/кг), Амгалан (50-500 мг/кг), XIII хороолол, Жуков (100-500) орчимд MNS 5850:2019 стандартаас их бохирдолтой байна. Баянгол дүүрэгт IV цахилгаан станц (500-1200), III, IV хороолол (50-100) орчимд харьцангуй их бохирдолтой байна. Сонгинохайрхан дүүрэгт Орбит (100-500 мг/кг), Нарангийн гол (50-100 мг/кг), Ханын материал (100-500 мг/кг), Сонсголон, Төв цэвэрлэх байгууламж (100-500 мг/кг), Баянхошуу хөтөл (100-500) орчимд стандартаас их бохирдолтой байна. Хан-Уул дүүрэгт үйлдвэр комбинат (30-50), яармаг (50-100) орчимд их бохирдолтой байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт ерөнхийдөө 30-50 мг/кг ба түүнээс бага агууламжтай байна.

Бохирдлын эх үүсвэр нь авто машины шатах тослох материал түүний зохисгүй хэрэглээ, хуучин сэлбэгийн худалдаа, задгай агуулах, авто засвар үйлчилгээний газрууд болон худалдаа эрхлэгчид, хувь хүмүүсийн хэнэггүй байдал, авто машин, сэлбэг хэрэгслийн тосоо хөрсөнд шууд асгаж бохирдуулж байгаа нь хөрсөн дэх хүнд металлын агууламжийг ихэсгэсээр байна.



Зураг 66. Улаанбаатар хотын хөрсөн дэх хар тугалгын тархалт

Хар тугалга нь амархан хайлдаг, нэвчих болон нягтрах чанар сайн, нар салхины элэгдлээс өнгө үзэмжийг хамгаалдаг, хүнсний хадгалалтын хугацааг удаан барьдаг, боловсруулахад хялбар зэрэг шинж чанаруудыг нь техник технологи, барилга, хүнсний салбарт өргөн ашигладаг. Аккумлятор, нүүрс, бензин, баттерей, будаг (төрөл бүрийн, хүүхдийн тоглоомын гадна талын будаг, хувилах машин болон принтерын хор) гэх мэт зүйлс нь хар тугалгыг хамгийн ихээр агуулдаг байна. Дунд зэргийн аккумляторт 18-25 кг хар тугалга 2-3 литр концентрацтай хүхрийн хүчилтэй байдаг ба ашиглалтын хугацаа дууссан тохиолдолд энэ хэмжээний хорт бодис хаягдана гэсэн үг юм.

Улаанбаатар хотод 365800 гаруй мянган бүртгэлтэй автомашин байна. Тэд бүгд аккумлятор ашигладаг бөгөөд ашиглалтын хугацаа хоёр жил гэж тооцоход жил бүр 3200-4500 тонн хар тугалганы хаягдал хуримтлагдах тооцоо гарч байна.

Монгол улсын шатахууны жилийн хэрэглээ 900 гаруй мянган тонн байдаг. Импортоор оруулж ирж байгаа бензинд 0.002г/л –ээс дээшгүй хар тугалга агуулагддаг байна. Бензинд хольсон хар тугалганы 5% нь автомашины хөдөлгүүрийг сайжруулахад зарцуулагддаг бол үлдсэн 95 хувь нь хөрс, агаар, иргэдийн цусанд шингэж байдгийг дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тооцоолон гаргажээ. Хуруу зай нь найрлагадаа хүний удмын санд нөлөөлөх, сэтгэхүйн болон дотор эрхтнүүдийн хямрал үүсгэх мөн хорт хавдрын эх үүсвэр болдог мөнгөн ус, хар тугалга, кадмий, никель зэрэг байгаль орчинд хортой хүнд металлуудыг агуулдаг бөгөөд зохисгүй буруу хэрэглэснээс болоод өөрсдөө ч хордох аюултай байдаг. Хуруу зайг ямар ч хяналт зохицуулалтгүйгээр хаях нь ус, хөрс, агаарын бохирдлыг үүсгэдэг байна.

Дэлхийн хөгжингүй олон хөгжиж буй орнуудад батарейг тусгай журмын дагуу дахин боловсруулалтад оруулж, зөв технологийн дагуу устгалд оруулж байна. Хар тугалгыг яагаад будганд хэрэглэдэг вэ? Гэхээр будагны өнгөө хадгалах чадварыг нь үлэмж ихээр сайжруулахад оршдог. Будгаас хар тугалганы хамгийн их агуулгатай нь Хятад улсад

үйлдвэрлэгдсэн тод өнгийн (шар, цагаан) будгууд ордог байна. Хар тугалганд хордвол ясны эдийн гэмтэл, цусан дахь уургийн нийлэгжилт саатах, бөөр, мэдрэлийн систем, нөхөн үржихүйн тогтолцоонд хүчтэй нөлөө үзүүлж хорт хавдар үүсгэх, нярай-бага насны хүүхдийн тархины хөгжлийг сааруулж оюун ухааныг доройтуулдаг бөгөөд хар тугалга нь хүний биед агаар, ус, хүнсний бүтээгдэхүүн, хүний амьсгалын эрхтэн, арьсаар дамжин хордуулдаг гэдгийг эрдэмтэд нотолжээ .

7.3.3. Хөрсөн дэх хром (Cr)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд хром (Cr) 0.9-10000 хооронд хэлбэлзэж дунджаар 85.4 мг/кг байна. Хан-Уул дүүргийн II хороо үйлдвэр комбинат, арьс шир боловсруудах үйлдвэрүүд болон харгиа урьдчилан цэвэрлэх байгууламж орчим хамгийн их бохирдолтой (150-18000 мг/кг) буюу MNS 5850:2019 стандартын хүлцэх агууламжаас их хортой, аюултай агууламжын түвшинд хүрсэн байна.

Мөн төв цэвэрлэх байгууламж орчим 100-150 мг/кг агууламжтай байна. Энэ нь “Харгиа” (хуучин нэрээр) цэвэрлэх байгууламжаас арьс ширний үйлдвэрүүдийн хромын давс өндөр агуулсан бохир усыг гүйцэд цэвэршүүлж чадалгүй төв цэвэрлэх байгууламжруу нийлүүлснээс үүдаэн төв цэвэрлэх байгууламжийн хаягдлын санд хуримтлагдсан хром агуулсан лаг ил талбайд хатаж салхины нөлөөгөөр тухайн орчинд тархсан байж болохыг харуулж байна. Энэ нь 2019 онд Оросын эрдэмтдийн хийсэн супдалгааны үр дүнтэй нийцэж байна (Тимофеев, А.И., Шальнова, О.И., 2019).

Хром нь уулын чулуулагт Cr3+ хэлбэрээр тархаж кларк нь 0.0083% байдаг. Харин дунит, тироксенинт зэрэг хэт суурилаг чулуулагт дундажаар 0.2% байдаг. Хром 0-ээс 6 хүртэл исэлдэлтийн хэмийг үзүүлдэг боловч зөвхөн Cr (III) ба Cr (VI) нь хөрсөнд харьцангуй тогтвортой бусад нь тогтворгүй байдаг. Нүүрсний шаталтаар агаарын 50% хүртэл бохирдуулагч хүнд металлуудад Cr, Ni зэрэг элемент ордог.

Хүрээлэн буй орчинд хром үүсэх антропоген эх үүсвэрт арьс ширний үйлдвэр, өнгөт металл ба гангийн үйлдвэр, органик бодисын синтез, цаас эслэгийн үйлдвэр, цемент, бордоо, лак будаг, үл хөлдөөгч шингэн зэргээс үүдэлтэй. Хөрс ихэвчлэн арьс шир, нэхмэл, металл боловсруулах үйлдвэр, будагч бодисын хаягдал, бохир ус, үйлдвэрийн бохир зэргээс хромоор бохирддог.



Зураг 67. Улаанбаатар хотын хөрсөн дэх хромын тархалт

7.3.4. Хөрсөн дэх кобальт (Co)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд кобальт (Co) 0.0-16.0 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 1.2 мг/кг, Харин мах комбинат, улиастай орчим 10-16 мг/кг буюу бага зэрэг өндөр агууламжтай боловч MNS 5850:2019 стандартаас (50 мг/кг) хэдэн арав дахин бага, хотын суурьшлын бүсэд жигд 2-4 мг/кг агууламжтай байна.



Зураг 68. Улаанбаатар хотын хөрсөн дэх кобальтын тархалт

7.3.5. Хөрсөн дэх никель (Ni)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд никель (Ni) 0.0-70.9 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 8.8 мг/кг байна. Хотын суурьшлын бүсийн хэмжээнд ерөнхийдөө 0-10 мг/кг агууламжтай, стандартаас их бохирдолгүй байна. Газар ашиглалт болон техноген нөлөөгөөр алаг цоог хуримтлал үүсэж байна. Тухайлбал Зүүн туруун, Орбит, Шархад, Хайлааст, Дарь эх орчимд 30-50 мг/кг агууламжтай байна.

Никель нь хортой хүнд металлын ангилалд хамаарагдах бөгөөд хүн, амьтан, ургамлын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг, төрөл бүрийн өвчин үүсгэх эх үүсвэр болдог. Никелийн гол хэрэглээ нь металл хайлшийн зэврэлтэд тэсвэртэй чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байдаг. Мөн шилэнд ногоон өнгө оруулах, цахилгааны утас, машины эд анги, зоосон мөнгө, батерей, төрөл бүрийн аккумулятор хийх зэрэгт түүхий эд нь болдог. Дээрх материалуудын элэгдэл хорогдол, төрөлжсөн үйлдвэрийн газраас эх сурвалжтай хот суурин газарт никелийн цэгэн болон талбайн бохирдол үүсдэг. Никель нь хөрсний үе давхаргад тодорхой агууламжтай байдаг. Харин хуримтлал нь үйлдвэр, хөдөө аж ахуйн идэвхтэй үйл ажиллагааны дүнд бий болдог. Энэхүү металл хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг нийтлэг тохиолдол нь харшил, тэр тусмаа арьсны төрөл бүрийн өвчлөл үүсгэх эх сурвалж нь болдог.



Зураг 69. Улаанбаатар хотын хөрсөн дэх никелийн тархалт

7.3.6. Хөрсөн дэх цайр (Zn)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд цайр (Zn) 0.0-441.7 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 88.4 мг/кг байна. Хамгийн их бохирдолтой газрууд нь Баянзүрх дүүрэгт Сансар, Дарь-Эх, Шар хад, Ботаник, XIII хороолол, Жуков орчимд 200-400 мг/кг буюу MNS 5850:2019 стандартын түвшинд хүрсэн бохирдолтой байна. Баянгол дүүрэгт IV цахилгаан станц, III, IV хороолол, зурагт орчимд харьцангуй их буюу 150-400 мг/кг бохирдолтой байна. Сонгинохайрхан дүүрэгт Ханын материал (200-400 мг/кг), Нарангийн гол, Толгойт, Их наран, Таван шар, зүүн туруун орчимд (50-100 мг/кг), Ханын материал, Сонсголон, Төв цэвэрлэх байгууламж орчимд 100-200 мг/кг агууламжтай байна. Хан-Уул дүүрэгт үйлдвэр комбинат, яармаг, III цахилгаан сатнц орчимд 200-400 мг/кг агууламжтай байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгийн суурьшлын бүсэд жигд 100-150 мг/кг агууламжтай байна.



Зураг 70. Улаанбаатар хотын хөрсөн дэх цайрын тархалт

Цайр нь магмын чулуулагт агуулагт 80-120 мг/кг, шаварлаг хурдсанд 40-80 мг/кг, элсэнцэр болон карбонатлаг чулуулагт 10-30 мг/кг агуулалттай байдаг. Zn нь чулуулагт ZnS нэгдлээр оршдог. Өгөршлийн үед ялангуяа хүчиллэг орчинд эрдсийн уусмалд Zn+2 хөдөлгөөнт ион үүсгэдэг. Zn нь органик нэгдлийн адил хялбар адсорбцилогддог. Иймээс хөрсөнд түүний хуримтлал өнгөн үед ажиглагддаг. Zn -ийн антропоген гол эх үүсвэр нь өнгөт металлургийн үйлдвэр, агротехникийн үйлчлэл юм. Цайраар бохирдсон хөрсөнд органик бодис болон шохой хийж бууруулах боломжтой.

7.3.7. Хөрсөн дэх зэс (Cu)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд зэс (Cu) 0.0-844.4 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 5.8 мг/кг байна. Суурьшлын бүсийн хэмжээнд жигд 5-10 мг/кг буюу ерөнхийдөө бага агууламжтай байна. Хамгийн их бохирдолт илэрсэн газар нь Эрдэнэтолгой 500-100 мг/кг агууламжтай байна. Энэ нь харьцангуй өндөрлөг газар тул тухайн хөрс, хурдасын аномаль бохирдол байх талтай. Мөн XIII хороолол, Жуковын замын урд талын гэр хороолол, үйлдвэр комбинат, зайсан, III, IV цахилгаан станц орчимд 25-100 мг/кг агууламжтай байна.



Зураг 71. Улаанбаатар хотын хөрсөн дэх зэсийн тархалт

Зэс болон бусад микро элементүүд нь хөрс үүсгэгч эх чулуулгийн эрдсийн найрлага, органик бодис, хөрсний уусмалд байх ба хөрсний хэв шинж, газар ашиглалтаас хамаарч харилцан адилгүй хэмжээтэй байдаг (С.Ичинхорлоо, 1990).

Зэсийн анхдагч эрдэс болох нийлмэл сульфидэд их хэмжээгээр агуулагддаг. Өгөршлийн үед хялбар уусаж Cu-ийн ион чөлөөлөгддөг. Энэ нь хүчиллэг орчинд явагддаг. Иймээс зэсийн гиперген үйл явцын хамгийн хөдөлгөөнт металлуудын нэг гэж үздэг. Зэс нь Cu+2 үедээ хамгийн их хөдөлгөөнтэй байдаг. Зэс нь дээд ургамал, амьтны маш чухал тэжээл боловч, их хэмжээний зэс нь амьтан, ургамлыг хордуулна. Хөрсний нийт зэсийн 1 орчим хувь нь усанд хлорид, натрид, сульфатын ба зарим органик хүчлийн давсны хэлбэрээр тохиолдоно (Амгалан, Гарьдхүү, Бадарч, 1978).

7.3.8. Хөрсөн дэх молибден (Mo)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд зэс молибден (Mo) 0.0-41.9 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 0.7 мг/кг байна. Суурьшлын бүсийн хэмжээнд жигд 0-1 мг/кг буюу ерөнхийдөө бага агууламжтай. Хамгийн их бохирдолт илэрсэн газар нь Дэнжийн мянга орчимд 20-40 мг/кг агууламжтай байх ба энэ нь тухайн дээж авсан цэг нь хоёрдогч түүхий эд авдаг газартай ойролцоо байсантай холбоотой. Мөн Улиастай, III цахилгаан станцын хаягдал үнсэн сангийн ойролцоо 5-10 мг/кг буюу стандартын хүлцэх агууламжын түвшинд хүрсэн бохирдолтой байна.



Зураг 72. Улаанбаатар хотын хөрсөн дэх молибдений тархалт

7.3.9. Хөрсөн дэх ванади (V)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд Ванадий (V) 0.0-110.1 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 52.3 мг/кг буюу стандартаас өндөр бохирдол илрээгүй. Улаанбаатар хотын суурьшлын бүсийн 50 орчим хувь нь 40-60 мг/кг, 30 орчим хувь нь 60-80 мг/кг, 20 орчим хувь нь 0-40 мг/кг агууламжтай байна. Хамгийн их бохирдолт илэрсэн газар нь Баруун туруун, таван толгой түлш, зүүн туруун, зурагтын эцэс, дэнжийн мянга, ганц худаг, алтан өлгий орчимд 80-100 мг/кг агууламжтай байна.



Зураг 73. Улаанбаатар хотын хөрсөн дэх ванадийн тархалт

7.3.10. Хөрсөн дэх стронци (Sr)-ийн тархалт

Улаанбаатар хотын өнгөн хөрсөнд Стронци (Sr) 0.0-1013 мг/кг хооронд хэлбэлзэж дунджаар 294.3 мг/кг агууламжтай байна. Хамгийн их бохирдолт илэрсэн газар нь зөвхөн төв цэвэрлэх байгууламж орчимд 800-1000 мг/кг буюу стандартаас өндөр бохирдолтой байна. Бусад газруудад жигд тархалттай байх ба газар ашиглалтаас хамаарсан тархалт ажиглагдсан. Тухайлбал гэр хорооллын бүсэд 300-500 мг/кг, орон сууц олон нийтийн бүсэд 200-300 мг/кг, тусгай хамгаалалтын бүсэд 100-200 мг/кг агууламжтай байна.

Хөрсөн дэх Стронций агууламж эх чулуулгын найрлага, уур амьсгалаас хамаардаг. Стронций нь гол төлөв магмын чулуулагт агуулагддаг ба өгөршлийн үед, ялангуяа хүчиллэг орчинд хөдөлгөөнт Sr+2 ионы хэлбэрээр оршдог. Хөрсөн дэх стронцын тархалт хөрсний уусмалын циркуляцыг бий болгодог. Sr-ийн уусмал Ca-тай хамт бохирдсон хөрсөнд их агуулагддаг. Sr-ийн изотоп цөмийн урвалаар үүсдэг. Энэ нь хөрсөнд Ca-тай хамт хялбар шингэж ургамал болон биологийн бохирдуулагч болдог *(Ундрал, 2001).*



Зураг 74. Улаанбаатар хотын хөрсөн дэх Стронцигийн тархалт

7.4. ХӨРСӨН ДЭХ ХҮНД МЕТАЛЛЫН БОХИРДЛЫН ҮНЭЛГЭЭ

Бүх металлын PI индексийн дундаж утга (mean) буурах дарааллаар Ni 2.13 > Pb 1.97 > As 1.76 > Co 1.55 > Zn 1.43 > Sr 1.15 > Cr 1.12 > V 1.06 буюу бүх элемент дунд зэрэг бохирдолтой байна. Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хэмжээнд никель, хар тугалга, хүнцэл, кобальт, цайр, стронцы, хром, ванады зэрэг хүнд металлууд хотжилтын нөлөөгөөр хөрсөнд хуримтлагдсан байна.

Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хөрсөн дэх хүнд металлуудын нийлмэл бохирдлын индекс PLI=0.6-31.8 хооронд хэлбэлзэж дунджаар 1.6 буюу бага зэргийн бохирдолтой байна. Нийлмэл бохирдлын индекс газар ашиглалтын онцлог, техноген нөлөөллөөс шалтгаалж харилцан адилгүй байна. Тухайлбал PLI > 5 буюу маш их бохирдолтой ангилалд Үйлдвэр комбинат буюу арьс шир боловсруулах үйлдвэрүүд орчим, Шар хад орчмын авто худалдаа үйлчилгээний төвүүд, Алтан өлгий, Монел, Дэнжийн мянга, III, IV цахилгаан станц, Орбит орчмын газрууд орж байна

PLI = 4-5 буюу их бохирдолтой ангилалд Нарантуул худалдааны төвийн арын гэр хороолол, III цахилгаан станцын үнсэн сан орчмын газрууд хамрагдаж байна. Да-хүрээ авто худалдааны төв орчмын гэр хороолол, улаанхуаран, 13-р хороолол, хос бэрс орчмын газар PLI = 3-4 буюу дунд зэрэг бохирдолтой ангилалд хамрагдаж байна. Амгалан, Улиастай, Зайсан, 19-р хороолол, төв цэвэрлэх байгууламж, ханын материал, сансар орчимд PLI = 2-3 буюу багаас дунд зэргийн бохирдолтой байна. Суурьшлын бүсийн талбайн 60 орчим хувь нь PLI = 1-2 буюу бага зэргийн бохирдолтой байна. Хотын зах, суурьшлын бүс үүсээгүй газрууд бохирдолгүй байна.



Зураг 75. Улаанбаатар хотын хөрсөн дэх хүнд металлын бохирдлын нэгдсэн үнэлгээ

НАЙМ. УРГАМЛАН НӨМРӨГ

Улаанбаатар хотын 5 дүүргийн нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх “Шинэ тойрог авто зам” төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдлын хээрийн хэмжилт судалгааг 2025 оны 03-р сарын 24-29-ны өдөр хийж гүйцэтгэсэн.

Хээрийн судалгаагаар төслийн талбайтай танилцах, хээрийн хэмжилт бичиглэл хийх, ургамлын суурь мэдээ материал цуглуулах, нөлөөлөлд өртсөн талбайн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж баталгаажуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

8.1. УРГАМАЛ ГАЗАРЗҮЙН МУЖЛАЛ

Улаанбаатар хотын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол Дагуурын уулын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).



Зураг 76. Монгол орны ургамал – газарзүйн мужлал

8.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хээрийн судалгааг хийхдээ 10м х 10м талбайг сонгон авч ургамалжлын судалгааны аргазүй (Х.Буян-Орших, 2005)-н дагуу геоботаникийн бүрэн бичиглэл үйлдэж зүйлийн бүрдэлийг В.И.Грубов (1982) “Монгол орны гуурст ургамал тодорхойлох бичиг”-ээр тодорхойлж, өвслөг ургамлын арвийг О.Друдегийн хувиараар, сөөгний арвийг бодгалийг тоолох аргаар, тусгагийн бүрхэцийг нүдэн баримжааны аргаар, өндөр, үзэгдэлзүйн үе шатыг тэмдэглэж ургацын дээжийг 1 м^2 талбайн ургамлыг газрын хөрстэй тэнцүүлэн 6 давталттай авна. Авсан дээжээ хатааж, жигнэн дундажлаж тухайн талбайн ургацыг тодорхойллоо.

8.3. УРГАМЛАН НӨМРӨГИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Тус нутагт ургамалжлын өндөр уул таг цармын, уулын тайга, уулын хээр буюу уулын ойт хээрийн гэсэн үндсэн 3 бүслүүрийн ургамалжил тохиолдох онцлогтой.

Цармын ой хээрийн болон нугын хэв шинжид хамаарах ургамлан нөмрөгтэй бөгөөд нийт талбай нь 55.8% буюу 22.9 мянган га газрыг ой мод эзэлнэ. Үүнээс шинэс 56.8%, хуш 22.2%, гацуур 15.4%, нарс 1.4%, хус 2.6%, бут сөөг 1 хувийг тус тус эзэлнэ.

Уулын оройн хярын асга, хадны завсар зайгаар бушилз, улалж, боролж зонхилсон цармын бүслүүр илэрнэ. Шинэс, хуш, ой үүсгэгч гол мод бөгөөд гацуур, нарс, хус, улиангар ургадаг. Энд тохиолдох гацууран ой монгол орны ховорхон бүлгэмдэлд тооцогдоно. Хээрийн ургамалжил нь байрлал, зүг зовхисын ялгаа, өндрийн түвшнээс хамааран дэд хэв шинжийн түвшинд босоо бүсчлэл үүсгэнэ.

Уулын тавиу бэл, хормой, өргөн хөндийгөөр хуурай хээр, ойн доод захыг эмжсэн чийглэг хажуугаар нугат хээр, салбар уулсын чулуурхаг орой, хяр, товгор энгэр дагуу уулын хээр байрлана. Уулын хээрт Ленийн ботууль, нугат хээрт том дэгнүүлт хялгануул зонхилж байхад хуурай хээрт дааган сүүл, ерхөг, биелэг өвс, хазаар өвс зэрэг жижиг дэгнүүлт үетэн түгээмэл тохиолдоно. Голын хөндий, гол горхины хөвөө, татам дагуу элдэв өвс сорвоо зонхилсон намгархаг нуга, ширэг улалжит, торлогоор бүрхэгдсэн нугууд ээлжлэн тархана.

Сибирийн шувуун нудрага Polypodium sibiricum, Мөнгөн ойм Aleuritopteris argentea, Турчаниновын Шогшрого Melica turczaniniviana, Уулын сонгино Allium altaicum, Гиенийн хаврын шар Gagea hiensis, Гурвалсан шүрэн үндэс Corallorhiza trifida, Мөлхөө өн цэцэг Goodyera repens, Ногоон хонгилцог Coeloglossum viride, Марцны цахирам Dactylorhiza salina, Хэвлиг булаг өвс Spiranthes amoena, Ганц навчит жирэг Malaxis monophyllos, Улаан үрт Ховолгоно Actaea erythrocarpa, Их шүүдэргэнэ Chelidonium majus, Ягаан Мүгэз Rhodiola rosea, Дөрвөлсөн Мүгэз Rhodiola quadrifida, Сибирь тэс Sorbus sibirica, Шүүсэвчит Ортууз Oxytropis pseudoglandulosa, Намгийн хунчир Astragalus uliginosus, Хос цэцэгт Нил Viola biflora, Хигмэл Нил viola dissecta, Монгол догар Caryopteris mongolica, Байгалын Банздоо Saussurea baicalensis, Хоёр гэрт Булган таваг Antennaria dioica зэрэг 23 зүйл ховор ховордож буй ургамлуудтай

Туул голын хөндий, хөвөө, татам дагуу элдэв өвс сорвоо зонхилсон намгархаг нуга, ширэг улалжит, цахилдагт, дэрст марцлаг нугууд ээлжлэн тархана.



Зураг 77. Улаанбаатар хотын ургамалжилт

8.3.1. Ургамлын бүлгэмдэл, төрөл, зүйлийн бүрдэл

Хэнтийн тайгын ургамлыг экологийн бүлгээр ангилж үзвэл: чийгсэг, чийгсүү хуурайсаг ургамал 324 зүйл (33.16%), намагсаг ургамал 176 зүйл (18.01%), усны ургамал 20 зүйл (2.05%), хүйтсэг ургамал 214 зүйл (21.9%), чулуусаг ургамал 163 зүйл (16.69%) байна. Тайгын зах руу 52 зүйл хуурайсаг (5.32%), 8 зүйл (0.82%) элссэг ургамал нэвтрэн ордог.

Хэнтий уулын захаар бэсрэг, дунд зэрэг өндөрлөгтэй нам уулсын нугархаг хээрт алаг өвс-хялганат, алаг өвс-хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, жижиг дэгнүүлт үетэнталаг өвст, жижиг дэгнүүлт үетэнт, алаг өвс-ботуульт, алаг өвс-үетэн-ботуульт, ботуульалаг өвст, алаг өвс-үетэнт зэрэг бэлчээр зонхилон тохиолдоно. Уулын хоорондох хөндий, хотгорын нугархаг хээрээр алаг өвс-үетэнт, алаг өвс-жижиг үетэнт, алаг өвсботуульт, хялгана-жижиг үетэнт, алаг өвс-улалж-жижиг үетэнт, алаг өвс-үетэндаагансүүлт бэлчээр, уулсын хоорондох голын хөндийн хээржсэн нугын талбайд бургас, улиас бүхий үетэнт, алаг өвс-үетэнт, түнгэт, алаг өвс түнгэт, алаг өвс, буурцагтан-үетэнт, жижиг улалж-үетэнт, үетэн-жижиг улалжит бэлчээр тус тус тархана.

Төслийн талбайн ургамалжлын өнөөгийн төлөв байдал

Судалгааны үед замын трасстай танилцаж 5 цэгт бүрэн бичиглэл хийж зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан бүрхэвч, биомасс зэргийг тодорхойллоо. Төсөл хэрэгжих талбайн 90% нь байгалийн үндсэн ургамал устсан бөгөөд эвдрэлд орж доройтсон байсан.

Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө уулын хээрийн ургамалжилтай бөгөөд ашиглалтын хэлбэрээс хамаарч өөрчлөлтөнд орсон.

Судалгааны цэг -1

Уулын хээр

Зураг 78. Уулын хээрийн агь- хазаар өвст бүлгэмдэл

Уулын хээрийн агь – хазаар өвст бүлгэмдэл. Ургамлын бүрхэц 65%, 29 зүйлийн ургамал (бичиглэл 1) бүртгэгдсэн. Алаг өвснөөс имт гичгэнэ, ширэг улалж, агь, цагаалин гичгэнэ зэрэг ургамлууд үетнээс нангиад түнгэ, хазаар өвс, шивээт хялгана, ботууль, цөөн наст ургамлаас арзгар согсоолж, үмхий шарилж, гялгар шарилж, цэх түмэнтана зэрэг ургамлууд ургасан. Ургац 3,5 ц/га. Ургамлын өндөр 5-15 см, жижиг навчит харгана 40-80см хүртэл өндөртэй ургасан. Бэлчээрийн талхагдал дунд. Цаг уурын хуурайшилт хүний нөлөөгөөр уулын хялганат бүлгэмдэл сукцесст орж хуурайшиж агь- үетэнт бүлгэмдлийг үүсгэсэн.

Хүснэгт 42. Бичиглэл -1

Ургамлын зүйлийн бүрдэл					
№	Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Бүрхэц,%	Ангилаа	Ашигт ургамал
1	Arenaria capillaris	Дэвхэргэн хурданцагаан		Бэлчээр	Элбэг
2	Artemisia adamsii	Үмхий шарилж	1	Хүмүүнсэг	Элбэг
3	Artemisia drancunculus	Гялгар шарилж	1	Хүмүүнсэг	Элбэг
4	Artemisia frigida	Агь	20	Бэлчээр	Элбэг
5	Astragalus adsurgens	Нумраа хунчир		Бэлчээр	Элбэг
6	Bassia dasyphylla	Мананхамхаг		Хүмүүнсэг	
7	Caragana microphylla	Жижиг навчит харгана		Бэлчээр	Элбэг
8	Caragana pygmeae	Алтан харгана		Бэлчээр	Элбэг
9	Carex stenophylla	Нарийн навчит улалж	3	Бэлчээр	Элбэг
10	Chamaerhodos erecta	Цэх түмэнтана	1	Хүмүүнсэг	Элбэг
11	Cleistogenes squarrosa	Дэрвээн хазааргана	25	Бэлчээр	Элбэг
12	Convovulus ammonii	Аммоний сэдэргэнэ		Бэлчээр	Элбэг
13	Heteropappus hispidus	Арзгар согсоолж	1	Хүмүүнсэг	
14	Iris tigrida	Барцоохор цахилдаг		Бэлчээр	Элбэг
15	Koeleria macrantha	Даагансүүл	3	Бэлчээр	Элбэг

16	Leymus chinensis	Нангиад түнгэ	3	Бэлчээр	Элбэг
17	Oxytropis oxyphylla	Шовх навчинцарт ортууз		Бэлчээр	Элбэг
18	Polygonum angustifolium	Нарийн навчит тарна		Бэлчээр	Элбэг
19	Potentilla bifurca	Имт гичгэнэ	1	Бэлчээр	Элбэг
20	Potentilla nivea	Цагаалин гичгэнэ	1	Бэлчээр	Элбэг
21	Pulsatilla turczaninovii	Турчаниновын яргуй		Бэлчээр	Элбэг
22	Salsola collina	Толгодын будраа		Хүмүүнсэг	Элбэг
23	Scorzonera austrica	Нарийн навчит хависгана		Бэлчээр	Элбэг
24	Sibaldiathe adpessa	Налчгар хэрээн хошуу		Бэлчээр	
25	Stelleria dichotoma	Ацан ажигана		Бэлчээр	Ховор
26	Stipa krylovii	Шивээт хялгана	5	Бэлчээр	
27	Thermopsis lancelaota	Тарваган шийр		Бэлчээр	Элбэг
28	Thymus gobicus	Говийн ганга		Бэлчээр	Элбэг
29	Tripolium lupinaster	Гурван навчит хошоонгор		Бэлчээр	

Судалгааны цэг -2

Ногоон байгууламж

Зураг 79. Трассын дагуух тарьсан мод сөөг

Замын трассын дагуу хатуу хучилттай, барилга байгууламж, өрхийн хашаа тохиолдох бөгөөд байгалийн унаган ургамал устаж ногоон байгууламж, мод сөөг тарьж тохижуулсан. Энд модноос Улиас 2-5м хүртэл өндөртэй дасан зохицож ургасан, сөөгнөөс хайлаас, бургас тарьсан. Сэлбэ голын татмын дагуу бургас, улиас тарсан бөгөөд хашаалж хамгаалсан. Энэ хашаанд 20-40см өндөртэй ургамлын хагдтай бөгөөд зүйлийн олон янз байдал нэмэгдэж байгалийн унаган бүлгэдэл үүссэн.

Судалгааны цэг -3

Сэлбэ гол

Зураг 80. Сэлбэ голын татам

Сэлбэ голын эргийн татмын нугаар тархах бөгөөд Улалж- галуун гичгэнэ- үетэнт (Hordeum brevisubulatum, Agrostis trinii) бүлгэмдэлтэй, тусагийн бүрхэц 95-100%, 33 зүйлийн ургамал (бичиглэл-2) бүртгэгдсэн, ургац 4,3 ц/га байсан. Талбайд зонхилогч ургамлын хувьд үетнээс Улаантолгой, нугын биелэг, нангиад түнгэ, алаг өвснөөс Холтсонцэцэг, ширэг улалж, галуун гичгэнэ, цагаан багваахай ургана. Голын дагуу бургас сийрэг тохиолдох бөгөөд 1.5 м - 2.4м хүртэл өндөр тохиолдоно. Голын татам бэлчээрийн нөлөөгүй боловч хүний хүчин зүйлжжс доройтолд орсон.

Хүснэгт 43. Бичиглэл-2

Ургамлан бүлгэмдэл: Бургас бүхий Улалж- галуун гичгэнэ- үетэнт (Hordeum brevisubulatum, Agrostis trinii)				
№	Ургамлын нэр	Ургамлын бүрхэц		Ангилаа
1	Elymus dahuricus	1	2	бэлчээрийн ургамал
2	Medicago falcata		1	бэлчээрийн ургамал
3	Primula farinosa			бэлчээрийн ургамал
4	Odontites vulgaris			бэлчээрийн ургамал
5	Parnasia palustris	2	5	элбэг ашигт ургамал
6	Plantago major	5	5	элбэг ашигт ургамал
7	Poa pratense	10	15	бэлчээрийн ургамал
8	Polygonum aviculare	1		бэлчээрийн ургамал
9	Potentilla anserina	20		элбэг ашигт ургамал
10	Hordeum brevisubulatum	20	15	бэлчээрийн ургамал
11	Halerpestes sarmentosa	3		бэлчээрийн ургамал
12	Ranunculus grandis	1	5	бэлчээрийн ургамал
13	Sausurea salsa			бэлчээрийн ургамал
14	Taraxacum leuncanthum	1	3	бэлчээрийн ургамал
15	Carex enervis	2		бэлчээрийн ургамал
16	Triglochin maritima	1		бэлчээрийн ургамал
17	Puccinella tenuiflora	1		бэлчээрийн ургамал
18	Carex duriuscula	15	20	бэлчээрийн ургамал

19	Agrostis trinii	10		бэлчээрийн ургамал
20	Salix miyabeana			бэлчээрийн ургамал
21	Salix rhamomnifolia			бэлчээрийн ургамал
22	Sanguisorba officinalis			элбэг ашигт ургамал
23	Gentiana aquatica	1		бэлчээрийн ургамал
24	Vicia cracca	2		бэлчээрийн ургамал
25	Carum carvi			бэлчээрийн ургамал
26	Glaux martimata			бэлчээрийн ургамал
27	Cirsium arvense		1	бэлчээрийн ургамал
28	Beckmannia syzigachne			бэлчээрийн ургамал
29	Urtica cannabiana			элбэг ашигт ургамал
30	Artemisia integrifolia	4	15	бэлчээрийн ургамал
31	Astragalus melilotoides			бэлчээрийн ургамал
32	Leymus chinensis		10	бэлчээрийн ургамал

Судалгааны цэг -4

Туул гол

Зураг 81. Хуурай нугын татам

Тус талбай нь Туул голын өргөн хөндийгөөр байрлах бөгөөд уулын хуурай нугын бургас бүхий алаг өвст (Potentilla anserina, Allium senescens, Artemisia frigida)- ширэг улалжит бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 52%, 17 зүйлийн ургамал (бичиглэл-3) бүртгэгдсэн, хаврын ургац 1,9 ц/га байсан. Ургамлан нөмрөгийн өндөр 5 см бөгөөд нэг ярус илэрч байсан. Зонхилогч ургамлын хувьд үетнээс шивээт хялгана, Дэрс, нангиад түнгэ, даагансүүл, алаг өвснөөс ширэг улалж, галуун гичгэнэ, эмийн сөд, агь, мангир, цөөн наст ургамлаас шоргор лууль ургана. Ус урсан талбай хонор хэсгэрээ бургас ургах бөгөөд 1,5-3 м өндөртэй ургаж байсан. Хүн болон техникийн нөлөө их.

Хүснэгт 44. Бичиглэл-3

Ургамлан бүлгэмдэл: алаг өвс улалжит бүлгэмдэл				
№	Ургамлын нэрс	Монгол нэр	Бүрхэц, %	Ангилаа
1	Allium senescens	Мангир	1	элбэг ашигт ургамал
2	Androsace incana	Буурал гандбадраа		элбэг ашигт ургамал
3	Artemisia frigida	Агь	1	элбэг ашигт ургамал
4	Carex duriuscula	Ширэг улалж	25	элбэг ашигт ургамал

5	Festuca lenensis	Ленийн ботуул	1	бэлчээрийн ургамал
6	Iris tigrida	Барцоохор цахилдаг		элбэг ашигт ургамал
7	Koeleria macrantha	Дааган сүүл	5	бэлчээрийн ургамал
8	Oxytropis myriophylla	Түмэннавчит ортууз		бэлчээрийн ургамал
9	Potentilla acaulis	Навтуул гичгэнэ	2	элбэг ашигт ургамал
10	Potentilla anserina	Галуун гичгэнэ	10	элбэг ашигт ургамал
11	Potentilla nivea	Цагаалин гичгэнэ		элбэг ашигт ургамал
12	Potentilla sercea	Торгон гичгэнэ	1	элбэг ашигт ургамал
13	Pulsatilla bungeana	Бүнгийн яргуй		элбэг ашигт ургамал
14	Stipa krylovii	Шивээт хялгана	1	Бэлчээрийн ургамал
15	Taraxacum officinalis	Эмийн багваахай		элбэг ашигт ургамал
16	Thalictrum simplex	Эгэл буржгар	0	элбэг ашигт ургамал
17	Veronica incana	Буурал гандбадраа	0	элбэг ашигт ургамал

Судалгааны цэг -5

Эвдэрсэн газрын ургамалжил

Зураг 82. Эвдэрсэн газрын төрх байдал

Тус хэвшил нь сүүлийн 2-3 жилд ашиглалт явагдаагүй талбай болон айлуудын хашааны зах орчмоор тархах бөгөөд цөөн наст бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 10-90%, 24 зүйлийн ургамал (бичиглэл-4) бүртгэгдсэн, ургац 3,6 ц/га байсан. Талбайд зонхилогч ургамлын хувьд үетнээс нангиад түнгэ, дэрс, алаг өвснөөс арзгар согсоолж, имт гичгэнэ ургана. Цөөн наст ургамлаас ямаан шарилж, цагаанлин лууль, толгодын будраа, царван, ногоон лууль, бага хургалж, ногоон хоног будаа, урвруу гагадай зэрэг эвдэрсэн доройтсон газрыг дүүргэж ургаж байна. Бэлчээрийн талхагдал байхгүй, хүний үйл ажиллагаа, техникийн нөлөөгөөр доройтолд орсон. Талбайн зах, талбай хооронд байгалийн аяасараа нөхөн сэргэж дүүргэгч ургамлууд ургасан.

Хүснэгт 45. Бичиглэл 4

№	Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Хашаалсан талбайд	Ангилаа
1	Achnatherium splendens	Гялгар дэрс	*	бэлчээрийн ургамал
2	Artemisia drancunculus	Гялгар шарилж	*	хүмүүнсэг ургамал
3	Amaranthus retroflexus	Урвуу гагдай	*	хүмүүнсэг ургамал
4	Artemisia adamsii	Үмхий шарилж	*	хүмүүнсэг ургамал

5	Artemisia anetifolia	Божмог шарилж	*	хүмүүнсэг ургамал
6	Artemisia annua	Зуны шарилж	*	хүмүүнсэг ургамал
7	Artemisia frigida	Агь	*	элбэг
8	Artemisia macrocephala	Царван	*	бэлчээрийн ургамал
9	Artemisia pectinata	Шүлхий шарилж	*	хүмүүнсэг ургамал
10	Atriplex sibirica	Сибирь шорной	*	хүмүүнсэг ургамал
11	Bassia dasyphilla	Манан хамхаг	*	хүмүүнсэг ургамал
12	Carex duriuscula	Ширэг улалж	*	бэлчээрийн ургамал
13	Chenopodium acuminatum	Шоргор лууль	*	хүмүүнсэг ургамал
14	Chenopodium aristatum	Сортой лууль	*	хүмүүнсэг ургамал
15	Chenopodium viride	Ногоон лууль	*	хүмүүнсэг ургамал
16	Chloris virgata	Сарваан сүүл	*	хүмүүнсэг ургамал
17	Heteropappus hispidus	Арзгар согсоолж	*	бэлчээрийн ургамал
18	Lappula myosotis	Дурсгалжирхуу зангуу	*	хүмүүнсэг ургамал
19	Leymus chinensis	Нангиад түнгэ	*	бэлчээрийн ургамал
20	Potentilla bifurca	Имт гичгэнэ	*	бэлчээрийн ургамал
21	Reagrostis minor	Бага хургалж	*	хүмүүнсэг ургамал
22	Salsola collina	Толгодын будраа	*	хүмүүнсэг ургамал
23	Setaria viridis	Ногоон хоног будаа	*	хүмүүнсэг ургамал
24	Urtica cannabianna	Олслог халгай	*	хүмүүнсэг ургамал

Тайлбар: * - *тохиолдоно*

8.3.2. Ургамлын ангилал

Ургамлын хээрийн судалгааг 2025 оны 3 сарын сүүлээр хийсэн бөгөөд өмнө хийгдсэн суурь судалгааг харгалзан үзээд трассын дагуу тохиох боломжтой зүйлсийг бүртгэлээ.

Уг судалгаагаар төслийн талбайн болон түүний ойр орчимд 24 овогт хамаарах 63 төрлийн 83 зүйл ургамлыг бүртгэгдсэн. Төрөл зүйлийн тоо бүрхэц, нягтшил нь тухайн жилийн цаг агаарын онцлогоос ихээхэн хамааралтай байдаг учир тухайн жилийн онцлог хээрийн судалгааны цаг үеэс хамаарч ургамлын төрөл зүйлийн тоо бага зэрэг өөрчлөгдөж болно.

Хүснэгт 46. Ургамлын ангилалзүй

Овог	Төрөл	Зүйлийн латин нэр	Зүйлийн монгол нэр
Alliaceae	Allium	Allium odorum	Анхил сонгино
		Allium senescens	Мангир
Amaranthaceae	Amaranthus	Amaranthus retroflexus	Урвуу гагдай
Apiaceae	Buplerium	Buplerium bicaule	Хоёр ишт бэриш
	Sphallerocarpus	Sphallerocarpus gracillis	Үхэр гоньд
Asteraceae	Artemisia	Artemisia adamsii	Үмхий шарилж
		Artemisia annua	Зуны шарилж
		Artemisia anthifolia	Божмог шарилж
		Artemisia drancunculus	Гялгар шарилж
		Artemisia frigida	Агь
		Artemisia glauca	Саарал шарилж
		Artemisia lacinata	Салбант шарилж
		Artemisia leucophylla	Цагаалин шарилж
		Artemisia macrocephala	Царван
		Artemisia pectinata	Шүлхий шарилж
		Artemisia tanacetifolia	Маралхай шарилж

	Heteropappus	Heteropappus hispidus	Арзгар согсоолж
	Inula	Inula britanica	Британы зоосонцэцэг
	Saussurea	Saussurea salicifolia	Бургас навчит банздоо
		Saussurea sp	Банздоо
	Scorzoneria	Scorzoneria ausrtica	Австрийн хависгана
	Senecio	Senecio vulgaris	Эгэл зохимон
	Serratula	Seratula centauroides	Хонгорзулархуу хонгорзалаа
	Taraxacum	Taraxacum mongolicum	Монгол багваахай
	Youngia	Youngia tenuifolia	Нарийн ишт Юнги
Brassicaceae	Dontostemon	Dontostemon integrifolius	Бүхэлнавчит багдай
	Lepidium	Lepidium ruderale	Сүг цангуу
Chenopodiaceae	Atriplex	Atriplex sibirica	Сибирь шорной
	Chenopodium	Chenopodium acuminatum	Шоргор лууль
		Chenopodium aristratum	Сортой лууль
		Chenopodium viride	Ногоон лууль
	Salsola	Salsola collina	Толгодын будраа
Convolvulaceae	Convolvulus	Convolvulus arvense	Хөдөөгийн сэдэргэнэ
Cyperaceae	Carex	Carex duruiscula	Ширэг улалж
		Carex sp	Улалж
Euphorbiaceae	Euphorbia	Euphorbia discolor	Алаг сүүт өвс
Fabaceae	Astragalus	Astragalus adsurgens	Нумраа хунчир
	Medicaga	Medicaga falcata	Шар царгас
		Medicaga ruthenica	Орос царгас
	Thermopsis	Thermopsis dahurica	Дагуур тарваганшийр
	Trifolium	Trifolium lupinater	Шошхойлог хошоонгор
	Vicia	Vicia cracca	Яагаан гиш
Geraniaceae	Eriodium	Eriodium stephanii	Степаний заан таваг
	Geranium	Geranium pratense	Нугын шимтэглэй
		Geranium sibiricum	Сибирь Шимтэглэй
Iridaceae	Iris	Iris bungeana	Бүнгийн цахилдаг
Lamiaceae	Cymbaria	Cymbaria dahiricum	Дагуур хатны цэцэг
	Dracocephalium	Dracocephalium foetidium	Өмхий шимэлдэг
	Linaria	Linaria buriatica	Буриад хонинзажлуур
	Phlomes	Phlomes tuberosa	Туйпланцар
	Scutelleria	Scutelleria sibirica	Сибирь гүүнхөх
	Thymus	Thymus gobicus	Говийн ганга
Linaceae	Linum	Linum sibircum	Сибирь маалинга
Onagraceae	Chamaenerion	Chamaenerion angustifolium	Нарийн навчит хөвөнойт
Plantagoceae	Plantago	Plantago major	Их тавансалаа
Poaceae	Achnatherium	Achnatherium splendens	Гялгар дэрс
	Agropyron	Agropyron cristatum	Саман ерхөг
	Bromus	Bromus inermis	Соргүй согоовор
	Cleistogenes	Cleistogenes squarrosa	Дэрвээн хазаар өвс
	Elymus	Elymus sibiricus	Сибирь хиаг
	Koeleria	Koeleria macrantha	Даагансүүл
	Leymus	Leymus chinensis	Нангиад хиаг
	Poa	Poa attenuatta	Туужууны биелэг
	Reagrostis	Reagrostis minor	Бага хургалж
	Setaria	Setaria viridis	Ногоон хоног будаа
	Silene	Silene repens	Мөлхөө шээрэнгэ
	Stipa	Stipa krylovii	Шивээт хялгана

Polygonaceae	Polygonum	Polygonum alopecuroids	Үнэгэн сүүлхэй тарна
		Polygonum convolvulus	Суман навчит тарна
	Rheum	Rheum undulatum	Намхан гишүүнэ
Primulaceae	Androsace	Androsace incana	Буурал далантовч
	Lappula	Lappula mysotis	Дурсгалжирхуу зангуу
Ranunculaceae	Ranunculus	Ranunculus japonicus	Япон хотсонцэцэг
Rosaceae	Chamaerhodes	Chamaerhodes erecta	Цэх түмэнтана
	Potentilla	Potentilla acaulis	Навтуул гичгэнэ
		Potentilla anserina	Галуун гичгэнэ
		Potentilla bifurca	Имт гичгэнэ
		Potentilla tanacetifolia	Маралзгана навчит гичгэнэ
	Sanguisorba	Sanguisorba officinalis	Эмийн сөд өвс
	Thalictrum	Thalictrum foetidium	Өмхий буржгар
Rubiaceae	Galium	Galium verum	Шар өрөмтүүл
Scrophylluriaceae	Veronica	Veronica incana	Буурал гандбадраа
Urticaceae	Urtica	Urtica cannabianna	Олсслог халгай

8.4. УРГАМЛАН НӨМРӨГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ТАЛХЛАГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хээрийн судалгаа болон боловсруулалтын явцад бүлгэмдэлд зонхилогч, дэд зонхилогч, ерөнхий тусгаг бүрхэц, халцгай газар, хүмүүнсэг ургамлын эзлэх хувь хэмжээг харгалзан үзэж Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын дагуу бэлчээрийг доройтлын зэргээр нь сул, дунд, хүчтэй доройтсон ба доройтоогүй хэвийн соргог бэлчээр гэж ангилдаг ангиллын дагуу тодорхойлсон.

Судалгааны талбайд ургамлан нөмрөг эвдэрсэн газраараа хүчтэй доройтсон, үндсэн бүлгэмдэл их доройтсон байна.

Хүснэгт 47. Ургамлан нөмрөгийн доройтлын зэрэг

Бүлгэмдлийн нэр	Бэлчээрийн хэвшинж	Бэлчээрийн код	MNS 5546:2005
Алаг өвс - үетэнт	Алаг өвст	БТ	Их
Ногоон байгууламж			хүчтэй
Эвдэрсэн газар			хүчтэй

8.5. ХОВОР, НЭН ХОВОР УРГАМАЛ ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

“Монгол орны улаан ном” (2013)-ын ургамлын жагсаалтад орсон нэн ховор, ховор ургамал, “Монголын ургамлын улаан данс ба хамгаалалын төлөвлөгөөний эмхэтгэл” (2012)-д Олон улсад судлагдаагүй, бүс нутгийн ховордлын зэрэглэл, улаан дансанд (Нямбаяр нар, 2012) бүртгэгдсэн ургамал тэмдэглэгдээгүй.

БОАЖЯ-ны сайдын 2022 оны А/603 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт ургамлын жагсаалт”-д орсон ховор статустай 39 зүйл (Agropyron cristatum-Саман ерхөг, Allium senescens-мангир, Amaranthus retroflexus-урвуу гагдай, Artemisia adamsii-Үмхий шарилж, Artemisia annua-зуны шарилж, Artemisia drancunculus-гялгар шарилж, Artemisia frigida-Агь, Artemisia pectinata-шүлхий шарилж, Buplerium bicaule-хоёр ишт бэриш, Convolvulus arvense-хөдөөгийн сэдэргэнэ, Cymbaria dahiricum-Дагуур хатны цэцэг, Dracocephalium foetidium-өмхий шимэлдэг, Galium verum-шар өрөмтүүл, Geranium sibiricum-Сибирь Шимтэглэй, Goniolemon speciosum-гоо юлт, Inula britanica-британы зоосонцэцэг, Iris bungeana-Бүнгийн цахилдаг, Lappula mysotis-Дурсгалжирхуу зангуу, Linaria buriatica-буриад хонинзажлуур, Medicaga falcata-шар царгас, Plantago major-их тавансалаа, Potentilla acaulis-Навтуул гичгэнэ, Potentilla anserina-галуун гичгэнэ, Potentilla bifurca-Имт гичгэнэ, Potentilla

tanacetifolia-Маралзгана навчит гичгэнэ, Rheum undulatum-намхан гишүүнэ, Salsola collina-толгодын будраа, Sanguisorba officinalis-эмийн сөд өвс, Saussurea salicifolia-Бургас навчит банздоо, Scorzoneria ausrtica-Австрийн хависгана, Senecio vulgaris-эгэл зохимон, Seratula centauroides-Хонгорзулархуу хонгорзалаа, Silene repens-Мөлхөө шээрэнгэ, Sphallerocarpus gracillis-үхэр гоньд, Taraxacum mongolicum-монгол багваахай, Thalictrum foetidium-өмхий буржгар, Thymus gobicus-говийн ганга, Urtica cannabianna-олсслог халгай, Veronica incana-буурал гандбадраа,) ургамал тохиолдох боломжтой байна.

8.6. ТОВЧ ДҮГНЭЛТ

“Шинэ тойрог автозам” төслийн трассын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол Дагуурын уулын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Судалгааны үед замын трасстай танилцаж 5 цэгт бүрэн бичиглэл хийж зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан бүрхэвч, биомасс зэргийг тодорхойллоо. Төсөл хэрэгжих талбайн 90% нь байгалийн үндсэн ургамал устсан бөгөөд эвдрэлд орж доройтсон байна.

Ургамлын судалгааг 2025 оны 3 сарын сүүлээр хийсэн бөгөөд талбайн орчимд өмнө хийгдсэн суурь судалгааг харгалзан үзээд трассын дагуу тохиох боломжтой 24 овогт хамаарах 63 төрлийн 83 зүйл ургамлыг бүртгэсэн.

Ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын дагуу доройтлын зэргээр ургамлан нөмрөг эвдэрсэн газраараа хүчтэй доройтсон, үндсэн бүлгэмдэл их доройтсон байна.

БОАЖЯ-ны сайдын 2022 оны А/603 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт ургамлын жагсаалт”-д орсон ховор статустай 39 зүйл ургамал тохиолдох боломжтой байна.

ЕС. АМЬТНЫ АЙМАГ

9.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ АМЬТНЫ АЙМАГ, ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно.

Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (P.domesticus) ба хээрийн (P.montanus) бор шувуу, хөхвөр тагтаа (C.livia), Сохор элээ (Milvus migrans), Шаазгай (Pica pica), Улаан хошуут (Pyrrhcorax pyrrhocorax), Хар хэрээ (Corvus corone), Хон хэрээ (Corvus corax) арай олон үзэгдэнэ.

Хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавьжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог тааралдана.

Хүснэгт 48. Зонхилох амьтны зүйлийн жагсаалт

Шавьжийн анги - *INSECT*

Хатуу далавчтан буюу цохын баг	*Coleoptera*
Жийгээ цохын овог	*Carabidae*
	Taphoxenus laticollis Dej
	Taphoxenus dauricus Fish.
	Amara fodinoe Mannh
	Harpalus ampicollis Men.
	Harpalus cervus Duft.
Илтсэн сахалт цохын овог	*Sarabaeidae*
	Gymnopleurus topsus
	Sarbius sacer
Арьс идэгч цохын овог	*Dermestidae*
	Dermestes dimidiatus Stev.
	Dermestes sibiricus Er.
Няслуур цохын овог	*Elateridae*
	Selatosomus latis F.
Мөлгөр цохын овог	*Buprestidae*
	Sphenoptera canaeiculata Pall.
Бугалаа цохын овог	*Meloidae*
	Epicauta megacephala Gebl.
	Epcauta sibirica Pall.
	Mylabris frolovi Germ.
	Mylabris sibirica F.-W.
Эвэрт цохын овог	*Gerambycidae*
	Eodorcadion carinatus F.
	Eodorcadion humerale Gebl.
Шөвгөр цохын овог	*Urrculionidae*
	Othiorrhynchus cribrosicollis Boh.
	Stephanocleonus oxicisus Rtt
Хайрсан далавчтаны баг	*Lepidoptera*
Дэнгийн эрвээхэйн овог	*Pyralidae*
	Prorophora albidogilvella Roester
	Staudingoria steppicola Curadja
Сарьсан далавчтаны баг	*Hymenoptera*
Шоргоолжийн овог	*Forimidae*
	Tetramorium caespitum L
	Lasius alienus Forst.
	Cataglyphus aenescens Nyl.
Хөхтүрүүний овог	*Tabonidae*
	Haemotopoto turkestanica turkistanica

	Tabonus sobulctorum sobulctorum
Ктырь ялааны овог	*Asilidae*
	Antiphrisson angustifrons Loew.
	Stenopagon maculilentus mongolicus Lher.
Дүнгэнүүр ялааны овог	*Bombylidae*
	Toxophora emeljanovi Zait.
Сирфид ялааны овог	*Syrphidae*
	Paragus haemorrhaus Mg.
Махны ялааны овог	*Sarophagidae*
	Blaesoxiphella brevicornis Vill.
	Servaisia subamericana Rohcl.
	Servaisia panfilovi (Rond. Et Varves)
	Tephromyia grisae (Mg)

Шувууны анги - *AVES*

Шонхор хэлбэртэн	*Falconiformes*
Харцгайн овог	*Accipitridae*
Сохор элээ	*Milvus migrans*
Шонхорын овог	*Falconidae*
Идлэг шонхор	*Falco cherrug Gray*
Тагтаа хэлбэртэн	*Columbiformes*
Тагтааны овог	*Columbidae*
Хадны тагтаа	*Columba rupestris Pall.*
Бор шувуу хэлбэртэн	*Pessriformes*
Болжморын овог	*Alaudidae*
Шоорон алаг болжмор	*Eremophila alpestris L.*
Харагчны овог	*Motacillidae*
Хээрийн шийхнүүхэй	*Anthus richaridii Vieill.*
Талын шийхнүүхэй	*Anthus campestris (L).*
Хэрээний овог	*Corvidae*
Хон хэрээ	*Corvis corax L.*
Турлиах	*Corvis frugilegus*
Алаг шаазгай	*Pici pica*
Жунгаа	*Pyrrhocorax pyrrhorax*
Хөөндэйн овог	*Turdidae*
Адууч чигчоохой	*Oenanyhe oenanthe L.*
Бүжимч чигчоохой	*Oenanyhe pleshanka (Lep.)*
Мяраан чигчоохой	*Oenanyhe isabellina Temm*
Бор шувууны овог	*Passeridae (Ploseidae)*
Хээрийн бор шувуу	*Passer montanus L.*
Хадны бор шувуу	*Perronia petronia L.*
Оронгийн бор шувуу	*Passer domesticus.*

Хөхтний анги - *MAMMALIA*

Орог зусаг	*Phodopus sungotus*
Хэргэлзий оготно	*Microtus gregalis*
Гэрийн хулгана	*Mus musculus*

АРАВ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ, ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛС

Тусгай хамгаалалттай газар нутаг

Тусгай хамгаалалттай газар нутгийг тусгай хамгаалалтад авсан субъектээс нь хамаарч:

- Улсын тусгай хамгаалалттай газар нутаг
- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг гэж ангилна.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 4 ангилна. Үүнд:

1. Дархан цаазат газар
2. Байгалийн цогцолборт газар
3. Байгалийн нөөц газар
4. Дурсгалт газар

Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах Байгаль орчны сайдын 2000 оны 07 дугаар тушаалын журмаар “Орон нутгийн хамгаалалттай газар” гэж тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад авсан газрыг хэлдэг байна. Орон нутгийн хамгаалалттай газар нь газрын нэгдмэл сангийн ангиллаар тусгай хэрэгцээний газрын орон нутгийн тусгай хэрэгцээний газарт хамрагдах бөгөөд дотор нь засаг захиргааны нэгжээр аймаг нийслэлийн, сум дүүргийн гэж ангилна.

Орон нутгийн хамгаалалттай газар нутгийг хамгаалалтанд хамруулсан зорилго, шинж чанараар нь:

1. Ой, амьтан, ургамал, усны нөөц газар;
2. Байгаль, түүхийн дурсгалт газар гэж ангилна.

Төслийн талбай буюу замын трассын талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна (зураг 72).

Түүх соёлын дурсгалт зүйлс

Археологийн судалгаа нь тухайн талбайд археологийн ямар хэв шинж, төрлийн, хэдий тооны дурсгал байгаа эсэхийг тогтоож, шинжлэх ухааны ач холбогдлыг тодорхойлохын хамт аж ахуйн үйл ажиллагааны үед устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах арга хэмжээ авахад чиглэдэг. Түүнчлэн тус талбайд хамгийн ойр орших булш болон бусад эртний дурсгалыг нэгэн адил бүртгэх бөгөөд уг материал нь Монгол орны археологийн нэгдсэн карт зохиох ажлын үндсэн хэрэглэгдэхүүн болдог.

Археологийн судалгааг урьдчилан төлөвлөсөн арга зүйг үндэслэн энгийн болон нарийвчилсан аргаар хийх бөгөөд илэрсэн булшны гэрэл зургийг авч, товч тодорхойлолт хийн, газар зүйн солбицлыг урьдчилан бэлтгэсэн талбайн дэвсгэр зурагт тэмдэглэнэ. Хайгуул судалгаагаар илэрсэн дурсгалуудын он цагийг түүхэн харьцуулалтын аргаар тогтооно. Хайгуул судалгааны явцад шинээр илрүүлэн олсон дурсгалууд Монгол улсын Соёлын өвийн нэгдсэн бүртгэлд орно.

Шинэ тойрог автозам төсөл нь Улаанбаатар хотын 5 дүүрэг 30 хорооны нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх суурьшлын бүсэд хэрэгжиж байгаа бөгөөд трассын талбайд түүх соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.



Зураг 83. Тусгай хамгаалалттай газар нутгийн байршил

АРВАН НЭГ. ГАЗАР АШИГЛАЛТ

Газар ашиглалтын судалгааны ажлын үндсэн зорилго нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдийн судалгаанд хамрагдах талбайд хээрийн хэмжилт судалгаа хийж, хээрийн болон суурин судалгааны дүнд тулгуурлан үр дүнг зураг, тоон үзүүлэлтээр илэрхийлэн харуулахад оршино. Судалгааны ажлыг дараах үе шатаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ***Бэлтгэл ажил:*** Бэлтгэл ажлын үед хээрийн судалгааны ажил хийгдэх талбайн трассын зураг, байршилтай танилцах.
- ***Хээрийн судалгаа:*** Хээрийн судалгааны үед төслийн трассын дагуу талбайн газар ашиглалтийн төрлүүдтэй танилцаж, шаардлагатай цэгүүдэд хэмжилт хийж солбицол тодорхойлов.

Хүснэгт 49. Зургийн проекцийн өгөгдөл

PROJECTION:	Universal Transverse Mercator
SPHEROID:	WGS 84
DATUM:	WGS 84
UNITS:	Meters
ZONE	48
FALSE EASTING /Meters/:	500000
FALSE NORTHING /Meters/:	0
SCALE FACTOR	0.9996

- ***Материал боловсруулалт, зураглал:*** Хээрийн судалгааны ажлын бичиглэл хэмжилтийн үр дүн болон өмнөх судалгааны мэдээлэлүүдэд үндэслэн судалгааны талбайн газар ашиглалтын зургийг ArcGIS 10.5 программын ArcMap дээр Esri Map-ийн 0.8 м растер зураг, Sentinel 10 метрийн нарийвчлалтай растер зураг, 1:100000-ын байрзүйн зураг, ашиглан судалгааны зургуудыг боловсруулав. Зургийн проекцийн өгөгдлийг дараах байдлаар тооцон зураглав. Үүнд:
  - Газар зүйн байршил буюу солбилцолыг GPS ашиглан WGS84 нэгжээр градус° минут’ секунд” форматаар тэмдэглэв. Судалгааны талбайгаас болон холбогдох мэдээллийн сангаас авсан солбилцол газар ашиглалтын талаар 2022 оны мэдээг боловсруулан замын трасст хамрагдсан дүүргүүдийн газар ашиглалтын зургийг боловсруулав.



Зураг 84.Шинэ тойрог автозамын трассын дагуух дүүргүүдийн газар ашиглалтын төрлүүдийн байршил

Автозамын трассын төв шугамаас хоёр тийшээ тус бүр 150 м буюу нийт 300 м зайд байрлах газар ашиглалтын төрлийг 5 дүүрэг тус бүрээр гаргаж нэгж талбарын тоо хэмжээг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 50. Автозамын трассын дагуу байрлах нэгж талбарын тоо

Газар ашиглалтын төрөл	Баянгол	Сонгинохайрхан	Чингэлтэй	Сүхбаатар	Баянзүрх
Төрийн захиргааны байгууллага	-	15	2	2	11
Боловсролын байгууллага	2	6	1	1	7
Эрүүл мэндийн байгууллага	7	-	-	-	2
Нам, олон нийтийн байгууллага	-	5	-	-	
Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	-	30	1	-	13
Автомашины гараж	-	104	1	-	2
Шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах, ШТС	-	1	-	-	2
9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	-	1	-	-	5
Гэр, орон сууцны хашааны газар	35	2986	1179	720	3014
Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	4	2			9
Нийт нэгж талбарын тоо	48	3150	1184	723	3065

Автозамын трассын дагуу хоёр тал руу тус бүр 150 м газар хамруулан газар ашиглалтын судалгаагаар нийт 8170 нэгж талбар хамрагдаж байна. Үүнээс Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамгийн олон буюу 3150 нэгж талбар, Баянзүрх дүүрэгт 3065 нэгж талбар хамрагдсан (хүснэгт 50, зураг 84).

АРВАН ХОЁР. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Судалгааны талбайд хамрагдах 5 дүүрэг, 30 хорооны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг энэхүү бүлэгт тусгав. Үүнд:

- Баянгол дүүргийн 29-р хороо
- Сонгинохайрхан дүүргийн 17, 23, 39, 6, 7, 40, 9, 10, 28-р хороод
- Чингэлтэй дүүргийн 20, 22, 21, 13, 14-р хороод
- Сүхбаатар дүүргийн 13-р хороо
- Баянзүрх дүүргийн 29, 21, 27, 31, 32, 19, 24, 17, 8, 38, 12, 37, 36, 26-р хороод хамрагдсан.

12.1. БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Нутаг дэвсгэр, байгаль орчин

Баянзүрх дүүрэг нь БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1965 оны 4-р сарын 14-ний өдөрийн 79 дүгээр зарлигаар Найрамдлын район нэртэйгээр анх байгуулагдсан нийслэлийн ууган 4 дүүргийн нэг. Улаанбаатар хотын зүүн талд байрлах Баянзүрх дүүрэг нь нийслэлийн хамгийн том дүүрэг бөгөөд Богдхан уулын Бага тэнгэр, Богино хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төр хурах ам болон Хар усан тохой зэрэг үзэсгэлэнт байгалийг цогцлоон нийт 124.4 мянган га газрыг хамарч оршдог.

Хүн ам, засаг захиргаа

2023 оны байдлаар 127339 өрхийн 434976 хүн (209223 эрэгтэй, 2125753 эмэгтэй) амьдарч байгаа бөгөөд Улаанбаатар хотод 1 км^2 нутаг дэвсгэрт 351.1 хүн ногдож байна. Засаг захиргааны нэгжийн хувьд 43 хороотой. Гэр хороололд 104764 өрх, байр хороололд 80037 өрх тус тус амьдарч байна.

Хүн амын ажил эрхлэлт

Дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2023 оны 8 сард 301 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 71 хүнээр (30.9 хувь) өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 76 (25.2 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Эрүүл мэнд

2023 оны 8 сард дүүргийн эмнэлэгт 4912 хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 160 хүүхдээр (3.4%) нэмэгдсэн байна. Нас баралт 1112 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8 хүнээр (0.7%) буурсан үзүүлэлттэй байна. Халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 4332 болж өмнөх оны мөн үеэс 36462 хүнээр (89.4%) буурсан байна. Баянзүрх дүүргийн хэмжээнд 2023 оны 8 сард 10000 хүн амд ногдох халдварт өвчний тоо 109.3 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 976.3 хувиар буурсан байна. Бэлгийн замын халдварт өвчнөөс тэмбүү 215, заг хүйтэн 64, трихомониаз 116 тус тус бүртгэгдсэн.

Нийгмийн даатгал, халамж

2023 оны байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 336.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 154.3 тэрбум төгрөгөөр (84.5%) өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлогын 78.3 хувийг тэтгэврийн даатгалын сангийн, 11.9 хувийг эрүүл мэндийн даатгал, 5.1 хувийг тэтгэмжийн даатгал, 3.7 хувийг ҮОМШӨ-ний даатгал, 1.0 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус бүрдүүлсэн байна. 2023 оны 8 сард нийгмийн даатгалын сангийн зарлага 273.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс 12.3 тэрбум төгрөгөөр илүү буюу 285.4 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн халамж: 2023 оны 8 сард нийгмийн халамжийн сангийн нийт зарлагын 73.6 хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмжид, 8.6 хувь нь халамжийн тэтгэвэрт, 4.0 хувь нь 0-3 хүртэлх

насны хүүхэд асарсны тэтгэмжид, 7.8 хувь нь асаргааны тэтгэмжид, 2.3 хувь нь амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид, 1.9 хувь нь ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, 0.6 хувь нь хүнс тэжээлийн хөтөлбөрт, 0.5 хувь нь жирэмсэн эхийн тэтгэмжид, 0.7 хувь нь бусад тэтгэмжид тус тус зарцуулагдсан байна.

Аж ахуй нэгж

Баянзүрх дүүрэгт Монгол Улсын Шинжлэх ухааны академи, түүний харьяа 6 хүрээлэн, Оросын соёл шинжлэх ухааны төвөөс гадна хүүхэд залуучууд эх түүхийн жимээр аялах боломжтой Монгол цэргийн музей, Жуковын музей, Оюун ухааны музей тус тус байрладаг.

Мөн Эрүүл мэндийн томоохон байгууллагууд болох ХӨСҮТ, ХСҮТ, Хоёрдугаар эмнэлэг, Цэргийн Госпиталь, Амгалан амаржих газар, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг Баянзүрх дүүрэгт байдаг бөгөөд иргэддээ нарийн мэргэжлийн болон суурь, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Дүүргийн Засаг даргын тамгын газарт төрийн үйлчилгээний үндсэн 10 хэлтсээс гадна засаг захиргааны анхан шатны нэгж болсон 43 хороотой, дүүргийн төр захиргааны 29 хэлтэстэйгээр засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж болон ажиллаж байна.

Нарантуул Олон улсын худалдааны төв, Өгөөмөр, Да хүрээ авто худалдаа, техникийн зах, Баянзүрх, Амгалан зах зэрэг нийт 180 мянга гаруй аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Аж үйлдвэр

Дүүргийн аж үйлдвэрийн салбар нь 2023 оны эхний 8 сард 1427.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1704.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үйлдвэрлэлт 587.5 тэрбум төгрөгөөр (69.9%), борлуулалт 653.3 тэрбум төгрөгөөр (62.5%)-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 846.2 тэрбум төгрөгийг (59.3%) уул уурхайн салбарын газрын түүхий тос болон хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал, алт, элс, хайрга, шороо олборлолт, 409.4 тэрбум төгрөгийг (28.7%) хүнс ундаа, 95.9 тэрбум төгрөгийг (6.7%) хувцас, гутал, нэхмэл, ноос, ноолуур боловсруулах болон бусад боловсруулах үйлдвэрлэлт, 1.2 тэрбум төгрөгийг (0.1%) цахилгаан, хий, уур, агааржуулалт үлдсэн 74.6 тэрбум төгрөгийг (5.2%) бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа тус тус эзэлж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлтөд хүнсний үйлдвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл, арьс арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад үйлдвэрлэлт нөлөө үзүүлсэн байна.

Газар тариалан

Баянзүрх дүүргийн хэмжээнд 2023 оны байдлаар 0.0354 га талбайд төмс, 1.7768 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 2023 оны эхний 8 сард урьдчилсан байдлаар 0.474 тонн төмс, 27.73 тонн хүнсний ногоо хураан авсан байна.

Эдийн засаг

2023 оны 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр дүүргийн төсвийн орлого 131.9 тэрбум төгрөг, төсвийн зарлага 74.8 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 57.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Төсвийн орлого: 2023 оны 8 сарын төсвийн гүйцэтгэлийн урьдчилсан мэдээгээр нийт дүүргийн төсвийн орлогын 127.6 тэрбум төгрөгийг (96.7%) татварын орлого, 1.6 тэрбум төгрөгийг (1.2%) татварын бус орлого, 2.8 тэрбум төгрөгийг (2.1%) орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлого тус тус эзэлж байна. Төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 33.0 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Үүнд татварын орлого 33.3 тэрбум төгрөгөөр (20.7%) дутуу бүрдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Төсвийн зарлага: 2023 оны 8 сарын урьдчилсан гүйцэтгэлийн мэдээгээр дүүргийн төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 40.3 хувийг (74.8 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 59.7 хувийг (110.8 тэрбум төгрөг) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна. Төсвийн зарлагыг бүтцээр нь авч үзвэл 13.4 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, 2.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалын санд төлөх шимтгэл, 9.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 11.8 хувийг хангамж бараа материалын зардал, 13.7 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, 30.2 хувийг урсгал шилжүүлэг, 18.9 хувийг бусад зардлууд тус тус эзэлж байна.

Мал, аж ахуй

2024 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 55470 толгой мал тоологдсон байна. Үүнээс адуу 14410, үхэр 17180, хонь 14160, ямаа 9720 тус тус тоологдсон байна.

Хэрэглээний үнэ

Хэрэглээний үнийн индекс 2023 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 15.5 хувь, согтууруулах ундаа, тамхины үнэ 5.8 хувь, Хувцас, гутал, бөс барааны үнэ 9.6 хувь, гэр ахуйн бараа, тавилгын үнэ 8.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 8.4 хувь, Холбооны үйлчилгээний үнэ 2.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын барааны үнэ 7.3 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 21.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үнэ 18.7 хувь, бусад бараа үйлчилгээ 2.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 5.1 хувиар тус тус өссөн ба тээврийн үйлчилгээний үнэ 0.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Баянзүрх дүүргийн хороод

29 дүгээр хороо

Тус хороо нь анх 2022 онд байгуулагдсан. 128.275 га газар нутагтай. Тус хороо нь 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар 6665 хүн амтай. Нийт хүн амын 9 хувь нь орон сууцанд, 91 хувь гэр хороололд амьдардаг гэсэн судалгаа бий.

29 хороонд ерөнхий боловсролын 102 дугаар сургууль, Даянхүү цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг. Дарь Эх зах, Юу Комбини, Шинэ буудал зэрэг худалдааны төв байрладаг.

21 дүгээр хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын хойд хэсэгт, Баянзүрх дүүргийн төв хэсгээс баруун хойд тийш байрладаг. 450 га газар нутагтай. 2023 оны байдлаар 8117 хүн амтай. Хорооны төв болон орон сууцны хорооллын орчимд жижиг бизнес, худалдааны төвүүд зэрэг худалдаа, үйлчилгээний төвүүд үйл ажиллагаа явуулж байна.

27 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын зүүн хэсэгт, Баянзүрх дүүргийн төв хэсгээс зүүн тийш байрлах хороо юм. Ойролцоогоор 500 га газар нутагтай. 27-р хорооны баруун талд 26-р хороо, өмнөд хэсэгт 28-р хороо, хойд хэсэгт тус дүүргийн 10-р хороодтой тус тус хиллэнэ. 2023 оны байдлаар 11210 хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц, гэр хороолол, жижиг бизнесийн бүсүүдэд амьдардаг. Хорооны төв болон орон сууцны хорооллын орчимд жижиг бизнес, худалдааны төвүүд, зах зэрэг худалдаа, үйлчилгээний төвүүд үйл ажиллагаа явуулж байна.

31 дүгээр хороо

Нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн “Хороо байгуулах, өөрчлөх тухай ” Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн шинээр 15 хороо байгуулагдсан. Баянзүрх дүүргийн 31-р хороо нь 2021.04.01 -нд байгуулагдсан. 164 га газар нутагтай.

Тус хороо нь 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 10599 хүн амтай. Нийт хүн амын 95 хувь нь гэр хороололд амьдардаг байна.

32 дугаар хороо

Улаанбаатар хотын баруун хойд хэсэгт, Баянзүрх дүүргийн төв хэсгээс баруун хойд тийш орших хороо юм. 450 га газар нутагтай. Тус хороо нь 2023 оны байдлаар 8953 хүн амтай.

Баянзүрх дүүргийн 32-р хорооны зүүн талд тус дүүргийн 31-р хороо, баруун өмнөд хэсэгт 33 хороо, хойд хэсэгт 20-р хороодтой хиллэнэ. Хорооны төв болон орон сууцны хорооллын орчимд жижиг бизнес, худалдааны төвүүд зэрэг худалдаа, үйлчилгээний төвүүд үйл ажиллагаа явуулж байна.

19 дүгээр хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт, Баянзүрх дүүргийн төв хэсгээс баруун хойд тийш орших хороо юм. Энэ хороо нь орон сууц, гэр хороолол, дунд оврын бизнесийн бүсүүдийг агуулсан бөгөөд хотын төвтэй ойрхон байрладаг. Ойролцоогоор 500 га газар нутагтай. Тус хорооны баруун хойд хэсэгт Баянзүрх дүүргийн 18-р хороо, зүүн хойд хэсэгт 20-р хороо, баруун өмнөд хэсэгт 21-р хороо тус тус хиллэнэ.

2023 оны байдлаар 12887 хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц, гэр хороолол, жижиг бизнесийн бүсүүдэд амьдардаг

24 дүгээр хороо

Тус хороо нь НИТХТ-ийн 2007 оны 2 сарын 28-ны өдрийн 27-р тогтоолоор БЗД-ийн 19-р хорооноос хуваагдан шинээр зохион байгуулагдсан. Баянзүрх дүүргийн 9,17,19 дугаар хороодтой хиллэн 26,8 га нутаг дэвсгэртэй, 2382 өрхийн 9035 хүн амтай ,14 хэсэгтэй. Хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг 90 аж ахуй нэгж, байгууллагатай, улсын болон хувийн сургууль байхгүй, улсын 1 цэцэрлэгтэй бөгөөд дан гэр хороллоос бүрддэг хороо юм.

17 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт, Баянзүрх дүүргийн төв хэсгээс баруун өмнөд тийш орших хороо юм. Энэ хороо нь орон сууц, гэр хороолол, жижиг бизнесийн бүсүүдийг агуулсан бөгөөд хотын төвтэй ойрхон байрладаг. Баянзүрх дүүргийн 16, 18,17-р хороодтой хиллэн ойролцоогоор 380 га талбайтай.

8 дугаар хороо

Тус хороо нь анх 1960-аад онд цэргийн анги, нэгтгэлүүд байрлан, цэргийн ахуй үйлчилгээ, оёдлын үйлдвэр төвлөрснөөс үүдэн цэргийн ажилчид, ар гэрийнхэн голчлон амьдарч эхэлсэнээр Улаанхуаран нэртэйгээр гэр хороолол үүсч, 1968 оноос Найрамдлын районы 8 дугаар хороо болж албан ёсоор үүсгэн байгуулагдсан. Монгол улс 1992 оны 1 дүгээр сарын 13-нд шинэ Үндсэн хууль баталж чөлөөт ардчилсан нийгэмд шилжсэнээр засаг захиргааны бүтцэд өөрчлөлт оруулж БЗД-ийн 8 дугаар хороо болж өргөжиж өнөөдрийг хүртэл төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэн ажиллаж байна.

НИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/36 дугаар тогтоолын дагуу 8 дугаар хороог 3 хувааж 38, 39 дүгээр хороо болон хуваагдаж газар нутгийн хэмжээ 96 га болон багассаж нийт өрх 3297, хүн ам 11471 болсон байна.

Тус 8 хороонд Ерөнхий боловсролын Амгалан цогцолбор сургууль, 92 дугаар сургууль, хувийн хэвшлийн Турк Эмпати дунд сургууль, Улсын тэргүүний 32 дугаар цэцэрлэг, 301 дүгээр цэцэрлэг, Төмөр замын харъяа 177 дугаар цэцэрлэг тус тус үйл ажиллагаа явуулдаг.

38 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт, Баянзүрх дүүргийн төвөөс баруун өмнөд хэсэгт байрладаг хороо юм. 2019 оны 8 дугаар хорооноос хуваагдан байгуулагдсан бөгөөд нийт 1011 өрх, 3033 хүн амтай, 5 хэсэгтэй. Хорооны нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгжүүдийн тоо 73, үүнээс төрийн байгууллага 3, бизнесийн үйлчилгээ эрхэлдэг 65, их дээд сургууль 3, хувийн хэвшлийн цэцэрлэг 1, СӨХ 3 байна.

12 дугаар хороо

Тус хороо нь анх 1985 онд байгуулагдсан 140 га газар нутагтай. 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 7063 хүн амтай байна. Нийт хүн амын 36.2 хувь нь орон сууцанд, 63.8 хувь гэр хороололд амьдардаг.

Тус хороонд 12 дугаар хороонд Ерөнхий боловсролын 147-р сургууль, АШУҮИС, 20-р цэцэрлэг, Эрхэм эрдэм цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг. Мөн Wellmart супермаркет, Оргил хайпермаркет, Оргил жейд хүнсний зах зэрэг томоохон зах худалдааны төв байрладаг.

37 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хойд хэсэгт, Баянзүрх дүүргийн төвөөс баруун хойд хэсэгт байрлах хороо юм. Энэ хороо нь орон сууц, гэр хороолол, аж ахуйн нэгжүүдийг агуулсан бөгөөд амьдрах орчин нь холимог, хөгжилтэй бүсүүдийн нэг юм. Баянзүрх дүүргийн 38, 36, 39-р хороодтой хиллэн 520 га газар нутагтэй. 2023 оны байдлаар тус хороо нь 10431 хүн амтай.

36 дугаар хороо

Баянзүрх дүүргийн 36-р хороо нь Улаанбаатар хотын баруун хойд хэсэгт байрладаг бөгөөд Улаанбаатар хотын төвөөс харьцангуй хол оршдог. Энэ хороо нь орон сууц, гэр хороолол, аж ахуйн нэгжүүдийг агуулсан бөгөөд амьдрах орчин нь холимог, хөгжилтэй бүсүүдийн нэг юм. Баянзүрх дүүргийн 37, 38, 35-р хороодтой хиллэн ойролцоогоор 550 га газар нутагтэй. 2023 оны байдлаар тус хороо нь 15574 хүн амтай.

26 дугаар хороо

Нийслэлийн Иргэдийн хурлын 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6/48 тоот тогтоолоор Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооноос 536 өрх, 1456 хүн амтай 26 дугаар хороо болон байгуулагдаж байсан.

Тус хороо нь 2023 оны 01 сарын 1-ний байдлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/36 дугаар тогтоолоор 26-р хорооноос 36-р хороо шинээр байгуулагдсан. 26-р хороо нь 22767 хүн ам,6754 өрхтэй болсон. Дан орон сууцны хороо юм.

Маршалын гүүрний хойд тэнхлэгээс эхлэн хойшоо Хүннүгийн гудамжаараа урагш Маршалын гүүрний хойд тэнхлэг хүрнэ. Хорооны баруун талын хил хязгаар Home plaza худалдааны төв хүртэл, зүүн талруугаа Баянзүрхийн гүүр хүртэл, урд хязгаар нь Туул голын эрэг хүртэл, хойшоогоо Хүннүгийн гудамж. Газар нутгийн хэмжээ 934 га газар нутагтай.

12.2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Нутаг дэвсгэр, байгаль орчин

Чингэлтэй дүүрэг нь Монгол Улсын Их Хурлын 1992 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор анх үүсгэн байгуулагдсан. Улмаар Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын 1992 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж болох 18 хороотойгоор зохион байгуулагдсан. Дүүрэг нь нийт 8.93 мянган га газар нутагтай. Үүнээс ойн сан бүхий газар 37.1 %, хөдөө аж ахуйн эдэлбэр газар 30.3 %, хот тосгон, зам, шугам суурин 27.0%, усан сан бүхий газар нутаг 4.5%-ийг тус тус эзэлж байна.

Хүн ам, засаг захиргаа

2023 оны байдлаар 37736 өрхийн 140264 хүн (67326 эрэгтэй, 72938 эмэгтэй) амьдарч байгаа бөгөөд Улаанбаатар хотод 1 км^2 нутаг дэвсгэрт 1526 хүн ногдож байна. Засаг захиргааны нэгжийн хувьд 19 хороотой. Гэр хороололд 28486 өрх (104264 хүн ам), байр хороололд 9250 өрх (36000 хүн ам) тус тус амьдарч байна.

Эрүүл мэнд

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2024 оны эхний 9 сард 1439 эх амаржиж, 1458 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 292 (16.9%)-аар, мэндэлсэн хүүхэд 283 (16.3%)-аар тус тус буурсан байна. 2024 оны эхний 9 сард 590267 хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 39815 (7.2%)-аар өссөн байна. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 5323 болж 1445 (21.4%) хүнээр буурчээ. Бэлгийн замын халдварт өвчин 235 байгаа нь нийт халдварт өвчний 25.6 хувийг эзэлж байна. Ковид-19 халдварт өвчлөл гараагүй байна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 9 сард 435.4 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 47.2 (12.1%) сая төгрөгөөр өсөж, сангийн зарлага 189.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 56.5 (42.4%) сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 32.7 (10.4%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 1.2 (19.1%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 5.8 (18.3%) сая төгрөгөөр, ҮОМШӨ–ний даатгалын сангийн орлого 7.4 (21.4%) сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна. Сангуудын зарлага өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 59.9 (52.5%) сая төгрөгөөр, ҮОМШӨ–ний даатгалын сангийн зарлага 0.2 (23.4%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 0.8 (19.6%) сая төгрөгөөр өсөж, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 4.4 (32.0%) сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамжийн сангаас 2024 оны 9 сард 113.9 мянган хүнд 75.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 1028 (0.9%) мянган хүнээр, олгосон тэтгэвэр, тэтгэмж 6100.7 (8.8%) сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2024 оны 9 сарын байдлаар 2459 хүн хамрагдаж 7478.9 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 20 (0.8%)-иар буурсан бол олгосон мөнгөн тэтгэвэр 1405.7 (23.1%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 70704 хүн хамрагдаж 53942.7 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 514 (0.7%) хүнээр, олгосон тэтгэмж 1304.1 (2.5%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Боловсрол

Дүүргийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуульд суралцагчдийн тоо 30229 болж өмнөх оны мөн үеэс 543 (1.8%) хүүхдээр нэмэгдсэн байна.2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд нийт 10 251 хүүхэд хамрагджээ.

Аж ахуй нэгж

Чингэлтэй дүүрэгт төрийн өмчийн 23, хувийн өмчийн 13, нийт 36 цэцэрлэг байдаг бөгөөд төрийн өмчийн 13, хувийн өмчийн 9, нийт 22 ерөнхий боловсролын сургуульд 25 мянга гаруй хүүхэд суралцаж, боловсролын салбарт 1167 багш, ажилчид ажиллаж байна. Мөн Хөдөлмөрийн дээд сургууль, Улаанбаатар Эрдэм-Оюу, Улаанбаатар Эрдэм-Судлал, Соёлын коллеж, Соёл урлагийн их сургуулиуд байрладаг. Дүүргийн нутаг дэвсгэрт Үндэсний түүхийн музей, Байгалийн түүхийн музей, Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей, Тэнгис кино театр зэрэг түүх соёлын үзвэр үйлчилгээний газрууд байдаг.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 35.0 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 119364.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26711.6 (28.8%) сая төгрөгөөр өссөн. Үүнд: Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар 36106.0 (2.2 дахин) сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 1080.8 (16.4%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 46088.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10475.2 (18.5%) сая төгрөгөөр буурсан байна. Аж үйлдвэрийн салбарын 2024 оны 9 дүгээр сарын борлуулалт 122069.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 42442.4 (53.3%) сая төгрөгөөр өсөхөд уул уурхай, олборлолт 26711.6 (28.8%) өссөн нь нөлөөлсөн байна.

Газар тариалан

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2024 оны байдлаар 0.04 га талбайд төмс, 0.15 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 2024 оны байдлаар 0.71 тонн төмс, 3.55 тонн хүнсний ногоо хураан авсан байна.

Эдийн засаг

Дүүргийн төсвийн нэгдсэн тэнцэл 2024 оны 9 дугаар сард 2.7 тэрбум төгрөг гарсан байна. Дүүргийн төсвийн нийт орлого 2024 оны 9 дүгээр сард 159.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 9.7 тэрбум төгрөгөөр (5.8%) дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 95.2 хувийг татварын орлого, 4.1 хувийг татварын бус орлого, 0.7 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна. 2024 оны 9 сард дүүргийн татварын орлого 151.4 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 13.6 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар, татварын бус орлого 6.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 4.0 тэрбум төгрөгөөр 2.6 дахин дутуу бүрдсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2024 оны 9 дүгээр сард 161.7 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 29.7 тэрбум төгрөг (15.5%) буурсан байна. Төсвийн нийт зарлагын 5.7 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.6 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 24.1 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал, 59.5 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Хэрэглээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өслөө. 2024 оны 09 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 5.2 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар өссөн байна. Хэрэглээний үнийн индекс 2024 оны 09 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 5.2 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгий үнэ 6.0

хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 6.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 4.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 7.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 3.8 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 4.9 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 19.7 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 8.2 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

Чингэлтэй дүүргийн хороод

20 дугаар хороо

Тус хороо нь 2022 оны 04 дүгээр сард Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооноос хуваагдаж одоогийн байдлаар 149 дүгээр сургуулийн 204 тоот ангид байрлаж байна. Тус хороо нь хойд талаараа СХД-ийн 28 дугаар хороо, зүүн талаараа ЧД-ийн 22 дугаар хороо, баруун урд талаараа БГД-ийн 11 дүгээр, зүүн урд талаараа ЧД-ийн 7 дугаар хороотой хиллэдэг. 157 га нутаг дэвсгэртэй 1392 өрхийн 5223 хүн амтай.

Хорооны хэмжээнд улсын 149 сургууль, 224 дүгээр цэцэрлэг, 291 дүгээр цэцэрлэг, хувийн Аавуудын цэцэрлэг, Сервис центрийн дэд бүтцийн төв 1, 6 нэрийн хүнсний дэлгүүр 5, 8-нэрийн хүнсний дэлгүүр 12, сүм 3, худаг 4, авто угаалга болон засвар 6, нийтийн байр 3 нийт 36 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Тус хороо нь хүн ам ихтэй, газар нутгийн хувьд сийрэг том, хөдөө орон нутгаас шилжин ирэхсэд ихтэй болон шилжилт хөдөлгөөн ихтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх, эмзэг бүлгийн иргэд олонтой хороо юм. Цаашид хүн ам ихээр суурьших төлөвтэй байна.

22 дугаар хороо

Тус хороо нь 16 дугаар хорооноос тусгаарлаж, 2023 оны 01 сарын 16-наас шинэчлэн байгуулагдсан. Тус хороо нь 1039 өрхийн 4021 хүн амтай.

Зүүн, зүүн хойд хэсгээр ЧД-ийн 16-р хороо, зүүн урд хэсгээр ЧД-ийн 15 хороо, урд хэсгээр ЧД-ийн 21 хороо, баруун урд хэсгээр ЧД-ийн 20 хороо, баруун хойд хэсгээр Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэдэг, хорооны 6 хэсэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Мөн хорооны нутаг дэвсгэрт 14 аж ахуйн нэгж байгууллага, 6 худгаар ундны усаар ханган үйлчилж байна.

21 дүгээр хороо

Тус хороо нь 2022 онд 12 дугаар хорооны нутаг дэвсгэрээс салж 21 дүгээр хороо болон байгуулагдсан. Хотын төв болон дүүргийн ЗДТГ-аас 5 км зайд байрладаг. Баруун талаараа дүүргийн 7 дугаар хороо, хойд талаараа 16 дугаар хороо, урд талаараа 12 дугаар хороотой хиллэдэг. Тус хороо нь 178.6 га газар нутагтай 827 өрхийн 6957 хүн амтай.

Хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын түр оршин суугч нийт 176 өрхийн 6541 хүн ам амьдарч байна.

21 дүгээр хороо нь 18-22 хүртэл дугаарласан 95 гудамж, 1397 хашаатай, ЕБ-ын 138 дугаар бага сургууль болон 220, 154 дүгээр цэцэрлэгүүд, Мон кара ХХК, Зам гүүрийн авто бааз, нэрийн 17 дэлгүүр, 6 нэрийн 5 дэлгүүр нийтийн байр 4 гэх мэт нийт 28 аж ахуй нэгжтэй.

13 дугаар хороо

Тус хороо нь 1970 онд Сүхбаатарын районы 21 дүгээр хороо гэж анх үүсэн байгуулагаж, 1992 оноос газар нутгийн байршил хүн амын нягтрал, төвлөрлөөс шалтгаалан Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо болон байгуулагдсан.

Хорооны нутаг дэвсгэр урд болон баруун талаараа Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, хойд буюу зүүн талаараа Чингэлтэй дүүргийн 14,15 дугаар хороотой хил залгаа оршдог.

Тус хороо нь 72 га нутаг дэвсгэртэй, 1761 өрхийн 6983 хүн амтай. Нийт иргэдийн 13% ахмад настан, 37% 0-18 настай хүүхэд багачууд, 50%-19-55/60/ насны иргэд эзэлдэг томоохон гэр хороо юм. Багачууд хүнс ОНӨҮГ, Батсежү бээлийний үйлдвэр, Ub-17, Тэлмэн импекс, хүнсний дэлгүүрүүд зэрэг хувийн хэвшлийн 60 гаруй аж ахуйн нэгж байгууллага, иргэд үйл ажиллагаа явуулдаг. Мөн 7 төрийн байгууллага байрладаг.

14 дүгээр хороо

Тус хороо нь 1965-1972 он хүртэл одоогийн Сүхбаатар дүүргийн 21 дүгээр хорин, 1972-1978 онуудад 24 дүгээр хорин, 1978-1992 онуудад 18 дугаар хороо, 1992 оны 8 дугаар сараас засаг захиргааг өөрчлөн зохион байгуулахад Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо нэртэй болсон түүхтэй. Тус хороо нь 9 га газар нутагтай.

Хойд талаараа Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, баруун талаараа Чингэлтэй 15 дугаар хороо, Зүүн талаараа Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, урд талаараа Чингэлтэй 13 дугаар хороотой хиллэдэг. Тус хороо нь 2022 оны статистикийн хүн амын тоон мэдээллээр 1674 өрх, 6461 хүн амтай бөгөөд үүнээс 3238 эмэгтэй, 3223 эрэгтэй хүн байна. Уулархаг биш нам дор газар байрладаг, суурьшмал хүн ам ихтэй, гэмт хэрэг зөрчил харьцангуй бага гардаг, тайван хороо юм. Улсын сургууль 1, улсын цэцэрлэг-2, хувийн цэцэрлэг-1, өрхийн эрүүл мэндийн төв-1, аж ахуйн нэгж байгууллага-53, ус түгээх байр -8 байна.

12.3. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

Нутаг дэвсгэр, байгаль орчин

Сонгинохайрхан дүүрэг нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 124,3 мянган га газар нутагтай, нийт газар нутгийн 77 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 20 хувийг ойн сав 3 хувийг зам, шугам сүлжээ бүхий газар тус тус эзэлдэг. Сонгинохайрхан дүүрэгт Улаанбаатар хотын нийт хүн амын 20.8 хувь, газар нутгийн 25.50 орчим хувь харъяалагддаг, нийслэлд хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ хамгийн томд ордог. Хатуу хучилттай авто зам 254.6 км, явган хүний зам 174 км тавигдсан. Гэрэлтүүлгийн тоо 22978, хөшөө дурсгалын тоо 13 байна. Дүүргийн нийт талбайн 124.7 га-д ногоон байгууламж байгуулсан.

Хүн ам, засаг захиргаа

2023 оны байдлаар 95895 өрхийн 341390 хүн (168593 эрэгтэй, 172797 эмэгтэй) амьдарч байгаа бөгөөд Улаанбаатар хотод 1 км^2 нутаг дэвсгэрт 369.1 хүн ногдож байна. Засаг захиргааны нэгжийн хувьд 43 хороотой.

Гэр хорооллын 66830 өрхөд 237370 хүн, байр хорооллын 29065 өрхөд 104020 хүн амьдарч байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2019 онд 227434 байсан бол 2023 онд 228535 болж 1101(0.5%) хүнээр өссөн байна. Ажиллагсдын тоо 2019 онд 105850 байсан бол 2023 онд 116961 болж 11111(10.5%) хүнээр нэмэгдсэн байна. Ажил хайгч иргэдийн тоо 2019 онд 3000 байсан бол 2023 онд 669 болж 2331(77.7%) хүнээр буурсан байна. 2023 онд хөдөлмөрийн насны хүн амын тоо 238.2 болж өмнөх оны мөн үеэс 2.6 (1.1%) мянган хүнээр өссөн байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 49.0 болж 2019 оноос 1.3 (2.6%) пунктээр буурсан байна.

Аж ахуйн нэгж байгууллага

Тус дүүрэгт 27 мянга гаруй аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг томоохон дүүргийн нэг билээ. Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2023 онд 27371 болж 2019 оноос 4084(17.5%) –өөр аж ахуйн нэгж, байгууллагаар өсөн нэмэгдсэн байна. 2023 онд бүртгэгдсэн нийт аж ахуйн нэгж байгууллагын 23623(86.3%) нь аж ахуй нэгжүүд, 3748(13.7%)

нь төсөвт болон төрийн бус байгууллага байна. 2023 онд хязгаарлагдмал хариуцлагатай компаний тоо 22697 болсон нь 2019 оноос 4659(25.8%) - өөр нэмэгдсэн байна.

Эдгээрээс Алтан тариа, Сүү, Өгөөж, Мах импекс, Ган хийц, Талх чихэр, Монос, Саван трейд зэрэг талх чихэр, мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг томоохон үйлдвэрүүд, авто тээврийн томоохон байгууллагууд болох Цахилгаан тээвэр ХК, Автобус-2 ХК, Авто-5 ХК, Монгол тээх зэрэг компаниуд байрлаж, нийслэлийн хүн амд үйлчилж байна.

Боловсрол

2023 оны хичээлийн жилд 3 дээд сургуульд 3771 оюутан, СӨБ-ын 115 (төрийн өмчийн 67, хувийн өмчийн 48) байгууллагад 25304 хүүхэд, ЕБС-ийн 34 (төрийн өмчийн 27, хувийн өмчийн 7) сургуульд 66428 суралцагч суралцаж төгссөн байна.

Эрүүл мэнд

2023 онд улсын эмнэлэг 4, өрхийн эмнэлэг 26, орны тоо 843 байна. Эмнэлэгийн ажиллагсдын тоо 354 байгаа бөгөөд энэ нь 2019 оноос 48(11.9%)-аар буурсан байна. 2023 оны байдлаар эмнэлэгийн нийт ажиллагсдын 24.6 хувь нь их эмч байгаа нь 2019 оноос 22 (20.2%)-оор буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2023 онд 6 342 эхээс 6 376 нярай төрсөн байгаа нь 2019 оноос 903 (12.5%) -аар төрсөн эх, нярайн тоо буурсан байна.

2023 онд Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо 2022 оноос 4792 (4.2%)-аар, чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо 15912 (16.2%)-аар буурсан бол элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдсан хүний тоо 1 897 (13.6%)-аар өссөн байна.

Амбулаторийн үзлэгээр 2023 онд 93 321 халдварт бус өвчлөл бүртгэгдсэн нь 2022 оноос 36 882(28.3%)-аар буурсан бөгөөд нийт өвчлөлийн 57 940(62.1%) нь шинээр бүртгэгдсэн байна. Халдварт өвчлөлийн тоо 2560 байна.

Эдийн засаг

2019 онд тус дүүргийн орон нутгийн төсвийн орлого 32916.4 сая төгрөг байсан бол 2023 онд 109201.2 сая төгрөг болж 3.3 дахин өссөн байна. Нийт орон нутгийн төсвийн орлогын 82.8 хувийг татварын орлогоос бүрдүүлсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 2023 онд 93383.7 сая төгрөг байгаа нь 2019 оноос 3.2 дахин өссөн байна. 2023 оны нийт зарлагын 13896.2(14.8%) сая төгрөг нь цалин, урамшуулал, нэмэгдэлийн зардал байна. Энэ нь 2019 оноос 8936.8 сая төгрөг буюу 2.8 дахин нэмэгдсэн байна.

Статистикийн албан ёсны мэдээнд хамрагддаг аж үйлдвэрийн газруудын дүнгээр 2022 онд 1216440.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2023 онд 1717920.3(41.2%) сая төгрөг болж өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 2022 онд 1517911.7 сая төгрөг байсан бол 2023 онд 2178349.5(43%) сая төгрөг болж өссөн байна. Хүнсний аж үйлдвэрийн газрууд 2022 онд 696982.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2023 онд 1191996.7 сая төгрөг буюу 71.0 хувиар, хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2022 онд 519457.2 сая төгрөг болсон бол 2023 онд 525923.6 сая төгрөг буюу 0.01 хувиар тус тус өссөн байна.

Ажил эрхлэлт

2019 онд ажил хайгч иргэдийн тоо 3000 байгаагаас 1546 (51.5%) нь эмэгтэй байна. 2019 онд 63 иргэн ажилд зуучлагдан орж байсан бол 2023 онд 1261 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Ажил хайгч иргэдийн 578(2.6%) нь шилшин суурьшсан, 109(2.9%) нь сургууль төгссөн, 3(0.4%) цэргээс халагдсан, 13(0.5%) нь сургуулиа орхисон, 661(22.0%)- н иргэн цалин орлого хүрэлцэхгүй байгаа, 175(5.8%) нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх, 185(6.2%) нь одоо эрхэлж байгаа ажилаа солих хүсэлтэй, 68(2.3%) нь өрхийн болон хувийн аж ахуй нь орлогогүй болсон шалтгаанаар ажил хайж байгаа иргэд байна.

2023 онд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 8(1.2%) нь тэтгэвэрт гарсан, 108(16.1%) нь орон тооны цомхотголоос, 121(18%) нь эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон, 45(6.7%) нь байгууллага татан буугдсан шалтгаанаар ажилгүй болсон байна.

Мал, аж ахуй

2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 73824 толгой мал тоологдсон байна. Энэ нь 2019 оноос 3056(4.1%) толгой малаар өссөн байна.

Газар тариалан

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 2024 оны байдлаар 81.0 га талбайд төмс, 415.0 га талбайд тэжээлийн ургамал, 365.0 га талбайд ногоон тэжээл, 50 га талбайд даршны ургамал, 50 га талбайд эрдэнэшиш, 101.7 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 2024 оны байдлаар 992 тонн төмс, 897.3 тонн хүнсний ногоо хураан авсан байна.

Дэд бүтэц

43 хорооноос 12 хороо нь дан орон сууцны хороод байдаг бөгөөд гэр хорооололд зөөврийн ус хэрэглэдэг 66830 өрх байна. Энэ нь 2019 оноос 67 (0.1%)-өрхөөр буурсан байна. Ус түгээх цэгийн тоо 2019 онд 243 байсан бол 2023 онд 44 (18.5%)-цэгээр нэмэгджээ.

Барилгын салбарт 2019 онд 161281.1 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил гүйцэтгэсэн бол 2023 онд 188094.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна. Энэ нь 2019 оноос 26813.4(16.6%) сая төгрөгөөр өссөн байна.

2023 онд дүүргийн нутаг дэвсгэрт 86 шатахуун түгээх цэг байрлаж байна. Энэ нь 2019 оноос 24(38.7%) – цэгээр нэмэгдсэн бөгөөд дүүргийн автомашины тоо 2023 онд 84 850 байгаа нь 2019 оноос 23817 (39%)-оор нэмэгдсэн байна.

Нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 275 үйлчилгээний газар байгаа нь 2019 оноос 18(6.1%)-оор цөөрсөн байна.

Сонгинохайрхан дүүрэгт хүнсний жижиг дунд үйлдвэрийн тоо 146 байгаа нь 2019 оноос 60(69.7%)-аар, мах махан бүтээгдэхүүний үйлдвэр 57 байгаа нь 2019 оноос 26(83.8%)- аар нэмэгдсэн бол талх нарийн боовны үйлдвэр 18 байгаа нь 2019 оноос 5(21.7%)-аар цөөрсөн байна.

Сонгинохайрхан дүүргийн хороод

17 дугаар хороо

Тус хороо нь Сонгинохайрхан дүүргийн төв хэсэгт байрладаг. Хороо нь орон сууцны хороолол, үйлчилгээний газрууд, худалдаа үйлчилгээний төвүүдтэй. Тус хороо нь 5809 хүн амтай.

Хороо нь олон орон сууцны хороололтой бөгөөд нийтдээ 4-5 орон сууцны хороолол (жишээ нь, *Сонгинохайрхан-1*, *Сонгинохайрхан-2* гэх мэт) байршиж, нийтдээ 2000 гаруй айл амьдарч байна. Хороо нь ойролцоогоор 300 га талбайг эзэлж байгаа бөгөөд орон сууц, жижиг аж ахуй, үйлчилгээний газруудыг хамарсан. Хороонд 5 км гаруй гол зам бий бөгөөд энэ зам нь орон сууцны хорооллууд болон худалдааны төвүүдийг холбодог.

17-р хорооонд ерөнхий боловсролын 2 сургууль байрладаг, эдгээр сургуулиудад 1500 орчим сурагч суралцдаг. 4 цэцэрлэг ажиллаж байгаа бөгөөд нийтдээ 600 гаруй хүүхэд цэцэрлэгт хамрагддаг. Хороонд 1 өрхийн эмнэлэг болон 1 хувийн эмнэлэг бий. Өдөрт 300-500 хүн эрүүл мэндийн үйлчилгээг авахад ашигладаг.

Хороонд 3 томоохон худалдааны төв байрладаг ба жижиг болон томоохон 20-30 бизнесийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

23 дугаар хороо

Тус хороо нь Сонгинохайрхан дүүргийн баруун хойд хэсэгт байрладаг бөгөөд ойролцоо Гачуурт, Баянзүрх дүүрэгтэй хиллэдэг ба 5776 хүн амтай.

23-р хороо нь төвөөс холгүй орших бөгөөд 5-7 км зам нь нийтийн тээвэр болон хувийн тээврийн хэрэгслүүдээр зорчих боломжийг хялбаршуулахаас гадна гол замуудтай холбогдсон. 2-3 автобусны чиглэл хорооноос явж байгаа бөгөөд өдөрт 1000 гаруй хүн тээвэрлэгдэж байна.

Тус хороо нь 1-2 ерөнхий боловсролын сургуультай бөгөөд эдгээр сургуулиудад нийтдээ 1000 гаруй сурагч суралцдаг. 3 цэцэрлэгтэй нийтдээ 300-400 хүүхэд хүлээн авдаг. Хороонд 1 өрхийн эмнэлэг болон хувийн эмнэлэг бий. Өдөрт 200-300 хүн эрүүл мэндийн үйлчилгээ авдаг. Хорооны нутагт 3-4 томоохон худалдааны төв байрладаг бөгөөд жижиг болон дунд бизнесийн төвтэй бөгөөд 20-30 жижиг худалдаа үйлчилгээний газар ажиллаж байна.

39 дүгээр хороо

Тус хороо нь тус дүүргийн баруун хэсэгт байрладаг. Хорооны нутаг дэвсгэр нь Баруун 4 зам, Гачуурт болон Баянзүрх дүүрэгтэй хиллэдэг. Хороо нь нийслэлийн төвөөс 10-15 км-ийн зайд байрладаг бөгөөд гол зам болон нийтийн тээвэрт холбогдсон байна. Өдөрт ойролцоогоор 2000 орчим хүн нийтийн тээвэр ашиглан зорчдог. 39-р хороо нь 12,000-15,000 орчим хүн амтай. Орон сууцны хэд хэдэн хороололтой бөгөөд нийтдээ 3,000 орчим айл амьдардаг. Хороонд 7-8 км орчим гол зам байгаа бөгөөд нийтийн тээвэрт зориулсан 3 автобусны чиглэлтэй. Өдөрт 1000-1500 хүн нийтийн тээврээр зорчиж байна.

Хорооны хэмжээнд ерөнхий боловсролын 1 сургуультай 800-1000 сурагч суралцаж байна. Мөн 2 цэцэрлэг ажиллаж байгаа бөгөөд эдгээр нь 250-300 хүүхэд хүлээн авч сургаж байна. 39-р хороо нь 1 өрхийн эмнэлэг болон хувийн эмнэлэгтэй. Өдөрт 200-300 хүн эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой.

Тус хороонд 2 томоохон худалдааны төв болон жижиг худалдааны дэлгүүрүүдтэй. 20 орчим жижиг бизнесийн байгууллага ажиллаж байна.

6 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт, Сонгинохайрхан дүүргийн төвөөс баруун тийш байрладаг. Энэ хороо нь орон сууц, гэр хороолол, үйлчилгээний төвүүдийг агуулсан нутаг дэвсгэртэй. Сонгинохайрхан дүүргийн төв хэсэг, Улаанбаатар хотын төвөөс баруун тийш 5 км орчим зайд байрлана. Ойролцоогоор 760 га талбайтай. Тус хороо нь Сонгинохайрхан дүүргийн хүн амын дунд томоохон хорооны нэг бөгөөд 10227 орчим хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц болон гэр хорооллын бүсүүдэд амьдардаг. Харш, Хархорин зах зэрэг худалдааны төвүүд болон жижиг дунд бизнес эрхлэгчид болон химийн болон хүнсний үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрүүдийг агуулсан аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

7 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт, Сонгинохайрхан дүүргийн төв хэсгээс баруун тийш байрладаг. Сонгинохайрхан дүүргийн төв хэсгээс баруун тийш 3-4 км орчим зайд байрлана. Ойролцоогоор 650 га талбайтай. Тус хороо нь Сонгинохайрхан дүүргийн хүн амын дунд дунд хэмжээний хорооны нэг бөгөөд 9597 орчим хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц болон гэр хорооллын бүсүүдэд амьдардаг. Хархорин зах болон жижиг худалдааны төвүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

40 дүгээр хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт байрладаг ба Улаанбаатар хотын төвөөс баруун тийш оршдог. Ойролцоогоор 920 га талбайтай. 40-р хороо нь Сонгинохайрхан дүүргийн хүн амын дунд томоохон хорооны нэг бөгөөд 8325 орчим хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц болон гэр хорооллын бүсүүдэд амьдардаг. Бизнесийн талбайн өргөтгөл болон зах, дэлгүүрүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

9 дүгээр хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт Сонгинохайрхан дүүргийн төв хэсгээс баруун тийш 4-5 км орчим зайд байрлана. Ойролцоогоор 680 га талбайтай. 9-р хороо нь Сонгинохайрхан дүүргийн хүн амын дунд дунд хэмжээний хорооны нэг бөгөөд 6632 орчим хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц болон гэр хорооллын бүсүүдэд амьдардаг. Зах, дэлгүүрүүд болон жижиг худалдааны төвүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

10 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт, Сонгинохайрхан дүүргийн төв хэсгээс баруун хойд тийш 5-6 км орчим зайд байрлана. Ойролцоогоор 670 га талбайтай, тус хороо нь Сонгинохайрхан дүүргийн хүн амын дунд томоохон хорооны нэг бөгөөд 10012 орчим хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц, гэр хороолол, жижиг бизнесийн бүсүүдэд амьдардаг.

28 дугаар хороо

Тус хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт, Сонгинохайрхан дүүргийн төв хэсгээс баруун хойд тийш 6-7 км орчим зайд байрлана. Ойролцоогоор 750 га талбайтай. 28-р хороо нь Сонгинохайрхан дүүргийн хүн амын дунд дунд хэмжээний хорооны нэг бөгөөд 7367 орчим хүн амтай. Хорооны хүн амын нягтаршил харьцангуй өндөр бөгөөд оршин суугчид нь орон сууц, гэр хороолол болон жижиг бизнесийн бүсүүдэд амьдардаг. Зах, дэлгүүрүүд болон жижиг худалдааны төвүүд зэрэг аж ахуй нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

12.4. БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Нутаг дэвсгэр, байгаль орчин

1965 онд Улаанбаатар хотын засаг захиргааны үндсэн нэгж болох Сүхбаатар, Октябрь, Найрамдал, Ажилчин гэсэн 4 районыг байгуулсан бөгөөд Баянгол дүүргийн үүсэл хөгжил нь Октябрын район нэртэйгээр эхэлсэн. Нийслэлийн Баянгол дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нэг бөгөөд 2949 га газар нутагтай. Зүүн талаараа Чингэлтэй, Сүхбаатар, урд хэсгээрээ Хан-Уул, баруун болон хойд талаараа Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэдэг, газар нутгийн хэмжээ бага ч хүн ам ихээр төвлөрсөн дүүрэг юм.

Хүн ам, засаг захиргаа

2023 оны байдлаар 69519 өрхийн 252979 хүн (123959 эрэгтэй, 129020 эмэгтэй) амьдарч байгаа бөгөөд Улаанбаатар хотод 1 км^2 нутаг дэвсгэрт 8578.5 хүн ногдож байна. Засаг захиргааны нэгжийн хувьд 34 хороотой.

Мөн дүүргийн нийт өрхийн 82.7 хувь нь орон сууцны хороололд, 17.3 хувь нь гэр хороололд амьдардаг.

Аж ахуйн нэгж байгууллага

Баянгол дүүргийн ЗДТГ нь 11 нэгжтэй, 25 харьяа хэлтэстэй бөгөөд үүнд Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн I, II хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Хүүхэд, залуучуудын соёлын ордон, Гэр бүл, ёслолын ордон, Албан бус-Насан туршийн боловсролын төв, Ахмадын хороо, Биеийн тамир, спортын хороо, Дотоод Аудитын алба, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Онцгой байдлын хэлтэс, Статистикийн хэлтэс, Улаан заламгайн хороо, “Усан спорт сургалтын төв” ОНӨТҮГ, Хүүхдийн зуслан, “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ, “Баянгол Шинэ өргөө” ОНӨААТҮГ зэрэг орж байна.

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт Монгол Улсын эрчим хүчний хамгийн том үйлдвэр болох ДЦС-4” ТӨХК, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур болсон Монгол–Оросын хамтарсан ХНН “УБТЗ”, улсын чанартай томоохон эмнэлгүүд болох ЭХЭМҮТ, Улсын гуравдугаар төв эмнэлэг, ГССҮТ ЭХЭМҮТ байдгаас гадна МҮОНРТ, UBS зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагууд мөн МҮСТО, Төмөр замын дуу бүжгийн чуулга зэрэг урлаг соёлын томоохон байгууллагууд, Монголын хамгийн эртний түүхэн дурсгалт газрын нэг болох Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд байрладаг юм.

Түүнчлэн Баянгол дүүргийг худалдаа, үйлчилгээний газрууд төвлөрсөн дүүрэг бөгөөд “Хархорин”, Барс” зах болон 3, 4 дүгээр хороолол дагасан худалдааны төвүүд үйл ажиллагаа явуулдаг юм.

Боловсрол

Баянгол дүүрэгт 2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 20, төрийн бус өмчийн 28, нийт 48 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 1733 бүлэгт 56868 суралцагч хамрагдаж байна. Үүнээс бага боловсролын түвшинд 30814, суурь боловсролын түвшинд 18090, бүрэн дунд боловсролын түвшинд 7964 суралцагч байна. Мөн төрийн өмчийн сургуульд 2113, төрийн бус өмчийн сургуульд 508 нийт 2621 үндсэн багш ажиллаж байна.

Эрүүл мэнд

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт улсын чанартай томоохон эмнэлгүүд болох ЭХЭМҮТ, Улсын гуравдугаар төв эмнэлэг, ГССҮТ, Хүүхдийн төв сувилал, Наркологийн эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг.

Мөн Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв нь ЭМЯ, НЭМГ, НЗДТГ, дүүргийн ЗДТГ-ын бодлого чиглэл, тушаал, шийдвэрүүдийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих, хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн II дахь шатлалын тусламж үйлчилгээ болон харьяа дүүргийн хүн амд эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлдэг юм.

Түүнчлэн засаг захиргааны анхан шатны нэгж болох 34 хороонд ӨЭМТ үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдэд цаг алдалгүй хүргэж байна.

Газар тариалан

Баянгол дүүргийн хэмжээнд 2024 оны байдлаар 2.0 га талбайд төмс, 6.5 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 2024 оны байдлаар 28.2 тонн төмс, 406.8 тонн хүнсний ногоо хураан авсан байна.

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо

Баянгол дүүргийн 29-р хороо нь Улаанбаатар хотын баруун хэсэгт байрладаг бөгөөд Толгойт орчмын бүсийг хамардаг. Энэхүү хороо нь 2022 онд байгуулагдсан бөгөөд хотын аж үйлдвэрийн бүс, гэр хороолол, шинэ орон сууцны хороолол зэрэг төрөл бүрийн бүсүүдийг нэгтгэдэг. Тус хороо нь Тамирын гүүрийн баруун хэсэг, Сонсголон, Толгойт

орчимд байрлана. Ойролцоогоор 850 га газар нутагтай, 2023 оны байдлаар 7817 орчим хүн амтай.

Хорооны төв хэсэгт аж үйлдвэрийн хэсэг төвлөрдөг. Химийн болон хүнсний үйлдвэр, барилгын материалын компаниуд болон жижиг бизнесүүд болон "Хархорин зах", "Шинэ Сандэй", "Барс 2" худалдааны төвүүд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тус хорооны баруун хэсэг нь гэр хорооллын бүс болон шинэ орон сууцны хороололтой (Өнөр хороолол, Эрин хороолол). Төрийн болон хувийн 3-4 цэцэрлэгүүд үйл ажиллагаа явуулдаг.

12.5. СҮХБААТАР ДҮҮРЭГ

Нутаг дэвсгэр, байгаль орчин

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 04-р сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж болох 10 хороог хуваах, 4 дүүрэг (тухайн зарлигт район гэж нэрлэсэн байдаг) болгон зохион байгуулсаны нэг нь Сүхбаатар дүүрэг (район) билээ. Тус дүүрэг нь өнөөдөр 21.8 мянган га газар нутагтай. Зүүн талаараа Баянзүрх, урд хэсгээрээ Хан-Уул, баруун талаараа Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй дүүргүүдтэй хиллэдэг.

Хүн ам, засаг захиргаа

2023 оны байдлаар 39984 өрхийн 141990 хүн (69575 эрэгтэй, 72415 эмэгтэй) амьдарч байгаа бөгөөд Улаанбаатар хотод 1 км^2 нутаг дэвсгэрт 679.2 хүн ногдож байна. Засаг захиргааны нэгжийн хувьд 20 хороотой.

Мөн дүүргийн нийт өрхийн 54.0 хувь нь орон сууцны хороололд, 44.0 хувь нь гэр хороололд амьдардаг

Боловсрол

Сүхбаатар дүүрэгт Монгол Улсын анхны ерөнхий боловсролын 1,2,3 дугаар сургууль, 1,2 дугаар цэцэрлэг, улсын анхны их дээд сургууль Монгол Улсын Их сургууль, Боловсролын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулиуд байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг Өнөөдөр дүүргийн хэмжээнд боловсролын байгууллагууд өргөжин хөгжиж ерөнхий боловсролын төрийн өмчийн 22, төрийн бус өмчийн 30 сургуульд 32138 хүүхэд, төрийн өмчийн 26, төрийн бус өмчийн 39 цэцэрлэгт 10064 хүүхэд багачууд сурч хүмүүжиж байна. Мөн их дээд сургууль, коллеж мэргэжлийн боловсролын сургуулиуд олноор байгуулагдаж 60000 оюутан залуус суралцаж байна.

Эрүүл мэнд

Дүүргийн эрүүл мэндийн төв нь нэгдсэн эмнэлэг, 18 өрхийн эмнэлэгийн хамт иргэдэд эмнэлэгийн анхан болон 2 дах шатлалын тусламж үйлчилгээг үзүүлж байна. Сүхбаатар дүүрэгт Монгол Улсын анхны эрүүл мэндийн байгууллагууд Улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, нэг, хоёрдугаар амаржих газрууд байрлахын зэрэгцээ нийслэлийн төвийн дүүргийн хувьд 100 гаруй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмийн сангууд ажиллаж иргэдэд эмнэлэгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Ажилгүйдэл

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2022 оны байдлаар өмнөх онтой харьцуулахад 134 хүнээр буюу 47.6 хувиар буурсан байна. Бүртгэлгүй ажилгүй иргэдээс 2022 оны жилийн эцсийн дүнгээр 637 иргэн ажилд зуучлагдан орсон нь өмнөх оны мөн үеэс 403-аар буюу 38.8 хувь буурчээ.

Аж үйлдвэр

Сүхбаатар дүүрэгт бүртгэлтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүд 2022 онд нийт 4075.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 10964.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Үүнд: Уул уурхай, олборлох үйлдвэрлэл 18.5 хувиар, боловсруулах салбарын үйлдвэрлэл 13.5 хувиар, цахилгаан, дулаан, эрчим хүч, усан хангамж үйлдвэрлэл 65.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Төсөв

Дүүргийн нийт төсвийн орлого 2022 оны жилийн эцсийн байдлаар 297.8 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 100.3 хувиар биелсэн. Төвлөрсөн орлогийн 96.7 хувийг урсгал орлого, 3.3 хувийг төсвийн урсгал санхүүжилтийн орлого эзэлж байна. Харин урсгал орлогын 99.0 хувийг татварын орлого, 1.0 хувийг татварын бус орлого бүрдүүлжээ. Төсвийн нийт зарлага: 2022 оны 12 дугаар сарын байдлаар төвлөрсөн орлогын 98.7 хувийг урсгал зардалд зарцуулаад байна. Урсгал зардлын дийлэнх буюу 99.7 хувийг бараа үйлчилгээний, 0.3 хувийг бусад зардал эзэлж байна. Бараа үйлчилгээний зардлын дийлэнх буюу 76.2 хувийг нийслэлд төвлөрүүлсэн орлогод, 2.0 хувийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалд, 0.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд, 21.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулагджээ.

Газар тариалан

Сүхбаатар дүүргийн хэмжээнд 2024 оны байдлаар 0.2 га талбайд төмс, 0.7 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 2024 оны байдлаар 2.9 тонн төмс, 11.5 тонн хүнсний ногоо хураан авсан байна.

Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны харъяа газар нутгийг 4 районд хуваарилжээ. Тэр үед тус хороо нь Орон сууц гудамжны 23 дугаар хороо нэртэйгээр байгуулагдаж байсан. Тухайн үед одоогийн Чингэлтэй дүүргийн 13-р хорооны сургуулийн гудамжууд тус хороонд харъяалагдаж нийт 50 гаруй гудамжтай байлаа.

2005 оны 12 сарын 16-ны өдрийн хорооны Иргэдийн Нийтийн Хурлын 06 тоот тогтоолоор айл өрхийн хашааны дугаарыг дахин шинэчлэн зохион байгуулж 11 хэсгийн нийт 25 гудамжтай (Хангайн 23, 24, Рашааны 1-16, Ногооны талбайн 1-7) болжээ. Хойд талаараа СБД-ийн 14-р хороо, зүүн талаараа БЗД-ийн 2-р хороо, урд талаараа дүүргийн 12-р хороо, баруун талаараа ЧД-ийн 13, 14-р хороотой тус тус хиллэдэг. 148 га газар нутагтай, 2014 оны эцсээр 2241 өрхийн 8636 хүн ам тоологдсон. Хороо нь олны нэрлэж заншсанаар 32-ын автобусны буудлаас Засвсрын буудал хүртэл 1.6 км зам дагуу оршдог. Хорооны нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нь намгархаг хөрстэй. Тус хороо нь 150-р цэцэрлэг, Санколл өрхийн эмнэлэг, Жасиун төв, Макс-Хүнс ХХК-ны салбар, Тод оймс ХХК, Бадруун төв, Алтдын гол ХХК зэрэг 51 байгууллага аж ахуйн нэгжүүдтэй. Ихэнх аж ахуйн нэгжүүд нь худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Б.Жамбаажамц “Монгол орны уур амьсгал” ном. 1989.УБ.
2. Гомболүүдэв П. (2014).“Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн төсөөлөл”.УАӨҮИ
3. Монгол орны уур амьсгалын лавлах I.II боть.УБ.1971
4. “Монгол орны уур амьсгалын лавлах” Бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлт ба цаг агаарын гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлэх арга технологийг боловсронгуй болгох төслийн тайлан. ШУТС. 2006он
5. Мижиддорж Р. (2002). Уур амьсгалын өөрчлөлт. тогтвортой хөгжлийн асуудал. Улаанбаатар. Монгол улс. х201-219.
6. Мижиддорж Р. (2007). Монголын түүхэн үеийн уур амьсгалын өөрчлөлт. түүний онцлог. УЦЭХ-ын ЭШБ тусгай дугаар. х46-53.
7. Намхайжанцан Г. (2001). Эх газрын хэрэглээний уур амьсгал. Жэмр хэвлэл. х182-200.
8. Цаг уур. орчны хяналт шинжилгээний заавар: Цаг уурын ажиглалт. хэмжлийн технологийн заавар. 2014.
9. Буян-Орших, Х. (2005) Геоботаник. Улаанбаатар.
10. Грубов В. (2008) Монгол орны гуурст дээд ургамал таних бичиг. Улаанбаатар
11. Малын тэжээл, тэжээллэг судлал 50 жилд, 2011
12. Өлзийхутаг. Н, (1989) Монгол орны ургамлын аймгийн тойм. Улаанбаатар
13. Ургамал.М ба бусад, Conspectus of the vascular plants of Mongolia. УБ, 2014 он
14. Юнатов.А.А., БНМАУ-ын ургамлан нөмрөгийн үндсэн шинжүүд. УБ, 1977 он
15. CITES-ийн лавлах. (2001). Улаанбаатар
16. ШУА, Газарзүйн хүрээлэн, Монгол улсын үндэсний атлас, Улаанбаатар хот, 2009
17. Д.Доржготов, Монгол орны хөрс, Улаанбаатар хот, 2003
18. П.Оюунбат, "Улаанбаатар хотын хөрсний бохирдол, бууруулах арга зам" Улаанбаатар хот, 2022.
19. “Ньюгидро проект” ХХК-ий мэдээллийн сан
20. https://met.gov.mn/
21. https://www.1212.mn/
22. Arcgis

Хавсралт 5. Зам тээврийн судалгааны тайлан

“НЭГДҮГЭЭР ТОЙРОГ ЗАМ” ТЭЗҮ, концепц дизайн

Тайлбар бичиг Боть I. Инженерийн тайлан

Улаанбаатар хот

2025 он

Агуулга

1. Үндэслэл 4
2. Судалгааны тойм 4
2. Нэгдүгээр тойрог замын хэрэгцээ, шаардлага 5
2.1. Дэд төвүүдийг хөгжүүлэх хэрэгцээ болон шаардлага 5
2.2. Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөх хэрэгцээ ба шаардлага 6
3. Нэгдүгээр тойрог замын хөдөлгөөний эрэлтийн загварчлал ба арга аргачлал 7
3.1. Замын хөдөлгөөний шинжилгээний бүс (TAZ)-ийн бүрдүүлэлт ба өгөгдлийн нэгтгэл 7
3.2. TransCAD программ хангамж 8
3.3. Суурь судалгааны мэдээллийн эх сурвалжийг дараах байдлаар 8
4. Улаанбаатар хотын авто замын ачааллын өнөөгийн байдал 10
4.1. Тээврийн хэрэгслийн өсөлтийн чиг хандлага 10
4.2. Авто замын тээврийн одоогийн нөхцөл байдлын шинжилгээ 11
4.3. Авто замын хөдөлгөөний нөхцөл байдлын дүн шинжилгээ 13
4.3.1 Оргил ачаалалтай үеийн хөдөлгөөний урсгалын хэмжээ 13
4.3.2 Өглөөний оргил цагийн зорчих хөдөлгөөний дүн шинжилгээ 20
4.3.3 Өдрийн оргил цагийн зорчих хөдөлгөөний дүн шинжилгээ 20
4.3.4 Оройн оргил цагийн зорчих хөдөлгөөний дүн шинжилгээ 21
4.3.5 амын түгжрэлийн онцлог ба шинж чанаруудын дүн шинжилгээ 21
5. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний загварчлал 27
5.1. Төлөв байдлын шинжилгээ: 28
6. “Нэгдүгээр тойрог зам” төслийн хөдөлгөөний эрэлтийн макро загварчлал 29
6.1. Программын танилцуулга 29
6.2. Тээврийн хэрэгцээний шинжилгээ ба хөдөлгөөний хуваарилалтын үр дүн 29
6.3. Өсөлтийн хувь 30
6.4. Замын хөдөлгөөний хуваарилалтын үр дүн 51
6.5 2028 оны замын хөдөлгөөн хуваарьлалтын төсөөлөл 54
6.6. Урьдчилсан тооцоолсон 2030 оны замын хөдөлгөөний хуваарилалт 57
6.7. Урьдчилан тооцоолсон 2035 оны замын хөдөлгөөний хуваарилалт 60
6.8. Урьдчилан тооцоолсон 2040 оны замын хөдөлгөөний хуваарилалт 63
6.9. Урьдчилан тооцоолсон 2044 оны замын хөдөлгөөний хуваарилалт 66
6.10. Нэгдүгээр тойрог замын хөдөлгөөний эрчмийн урьдчилсан таамаглал 69
6.11. Нэгдүгээр тойрог зам ашиглалтад орсны дараах Улаанбаатар хотын замын сүлжээний тээврийн эрэлтэд үзүүлэх нөлөөлөл 71
6.12. Нэгдүгээр тойрог замын хувилбар сонголтын үндэслэл 76
6.13 Шинэ тойрог замын гол уулзваруудын хөдөлгөөний зохион байгуулалтын төлөвлөлт 76
6.13.1 Олон түвшний уулзварын төлөвлөлт 76
6.13.2 Нэг түвшний уулзваруудын төлөвлөлт 82
6.13.3 Шинэ тойрог зам төслийн замын хөдөлгөөн зохицуулалтын төлөвлөлт 84
7. “Нэгдүгээр тойрог зам” төслийн 2028, 2030, 2040 болон 2044 оны тээврийн хэрэгцээний урьдчилсан тооцоо 84
7.1 2028 оны замын хөдөлгөөний загварчлалын дагуух хөдөлгөөний эрчмийн төсөөлөл . 84

7.1.1 Шинэ тойрог зам төсөл хэрэгжихээс өмнөх замын сүлжээний хөдөлгөөний эрчмийн төсөөлөл 84
7.1.2 Шинэ тойрог зам төсөл хэрэгжсэний дараах замын хөдөлгөөний эрчмийн үзүүлэлт 86
7.1.3 Шинэ тойрог зам төсөл хэрэгжсний дараах замын хөдөлгөөний эрчмийн өөрчлөлт 87
7.2 2030 оны Замын хөдөлгөөний эрэлтийн загварчлалын хөдөлгөөний эрчмийн урьдчилсан таамаглал..... 89
7.3 Нэгдүгээр тойрог зам хэрэгжсэний дараах замын хөдөлгөөний эрчмийн урьдчилсан таамаглал..... 90
7.4 Нэгдүгээр тойрог замыг хэрэгжүүлэхээс өмнөх болон хэрэгжүүлсний дараах замын хөдөлгөөний урсгалын өөрчлөлт 92
7.5 Замын хөдөлгөөний эрэлтийн загварчлалд үндэслэн 2040 он хүртэлх замын хөдөлгөөний урсгалын төлөв 94
7.6 2044 оны хөдөлгөөний эрэлтийн загварчлалын үндэслэсэн Замын хөдөлгөөний урсгалын таамаглал..... 99
7.7 Улаанбаатар хотын 2028 оны авто замын сүлжээний хөдөлгөөний урсгал ба нэвтрүүлэх чадварын харьцаа “VCR”-ийн өөрчлөлтийн шинжилгээ..... 105
7.7.1 Шинэ тойрог зам төсөл хэрэгжүүлэхээс өмнө хөдөлгөөний урсгал ба хөдөлгөөн нэвтрүүлэх чадвар VCR шинжилгээ 105
7.7.2 Шинэ тойрог зам төсөл хэрэгжүүлсэний дараах хөдөлгөөний урсгалын үзүүлэлтүүд..... 106
7.7.3 Шинэ тойрог зам төсөл хэрэгжсэний дараах замын хөдөлгөөний урсгалын өөрчлөлт..... 108
7.7.4 2028 оны тухайн замын хэсгийн хөдөлгөөний урсгал, хөдөлгөөн нэвтрүүлэлтийн өөрчлөлтийн шинжилгээ 110
7.8 Улаанбаатар Улаанбаатар хотын 2030 оны авто замын хөдөлгөөний урсгал ба хөдөлгөөн нэвтрүүлэх чадвар “VCR” шинжилгээ 111
- 2030 оны нийт замын ханалтын өөрчлөлтийн шинжилгээ:.....117
7.9 Улаанбаатар хотын 2040 оны авто замын хөдөлгөөний урсгал ба хөдөлгөөн нэвтрүүлэлтийн чадварын харьцаа “VCR” өөрчлөлтийн шинжилгээ 118
7.10 Улаанбаатар хотын 2044 оны замын хөдөлгөөний урсгал ба хөдөлгөөн нэвтрүүлэлтийн чадварын харьцаа “VCR”-ийн өөрчлөлтийн шинжилгээ..... 125
7.11 2028 2030 он, 2040 он болон 2044 оны авто машины хурдны судалгаа..... 132
8. Улаанбаатар хотын нийтийн тээврийн шугам сүлжээний судалгаа..... 144
8.1. Улаанбаатар хотын нийтийн тээврийн хүртээмжийн судалгаа, шинжилгээ 144
8.2. Улаанбаатар хотын нийтийн тээврийн зорчилтын зайны сайжруулалт..... 146
8.3. Улаанбаатар хотын нийтийн тээврийн хурдны өөрчлөлт..... 147
8.4. Чухал замуудын хэсгийн нийтийн тээврийн дундаж хурдны өөрчлөлтийн шинжилгээ 152
8.5. Нийт замуудын нийтийн тээврийн дундаж хурдны өөрчлөлтийн шинжилгээ 157
9. Дүгнэлт..... 158
9.1 Замын хөдөлгөөний эрчмийн судалгааны үр дүн 158
9.2 Замын хөдөлгөөний загварчлал, тооцоололоор гарсан үр дүн..... 159

9.3 Шинэ тойрог замын хөдөлгөөний эрчмийн төсөөлөл 160

1. Үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын "Алсын хараа - 2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны Нийслэл Улаанбаатар хотын “Нэгдүгээр тойрог зам”-ыг барьж байгуулах тухай 476 дугаар тогтоол болон Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/720 дугаартай захирамжийг тус тус үндэслэн нийслэл хотын нийтийн тээвэр, зам гүүрэн байгууламжид томоохон шинэчлэл хийж замын хөдөлгөөний түгжрэлийг тодорхой хувиар бууруулах зорилгоор "Нэгдүгээр тойрог зам 1” төслийн Техник Эдийн Засгийн Үндэслэл, Зураг Төсөв (Концепц дизайн) боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн УТ2402804435 дугаартай гэрээний хүрээнд хийж хэрэгжүүлэв. Нэгдүгээр тойрог зам төслийг хэрэгжүүлэх нийгмийн болон эдийн засгийн хэд хэдэн хэрэгцээ шаардлагууд үүссэн. Жишээлбэл, Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, хотод бүртгэлтэй автомашины тоо 80%- иар өссөн бол замын сүлжээ дөнгөж 19%- иар тэлсэн нь замын хүчин чадал эрс дутагдахад хүргэв.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 500–610 мянга орчим тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд идэвхтэй оролцдог ба энэ нь одоо байгаа замуудын хүчин чадлаас хоёр дахин их ачаалалтай байгааг илтгэж (НЗДТГ, 2024). Үүний дүнд замын түгжрэл нийслэл хотын хэмжээнд хүндэрсэн ба оргил цагуудад автомашины дундаж хурд 7–13 км/цаг болон буурч түгжрэлийн урт нийтдээ 97 км-т хүрсэн. Энэхүү нөхцөлд тойрог замын шинэ сүлжээ байгуулж, хотын төвийг тойруулан тээврийн урсгалыг дамжуулах нь түгжрэлийг бууруулах гол шийдэл ба ЖАЙКА олон улсын байгууллагаас 2022 онд хийсэн судалгаагаар Улаанбаатарын түгжрэлийн нэг үндсэн шалтгаан нь замууд хоорондын холбоос дутмаг, сүлжээ тасралттай байдал гэж дүгнэсэн байна. Одоогоор бүрэн гүйцэд тойрсон хурдны зам байхгүй, гол чиглэлүүдийн зам уулзварууд хотын төвд огтлолцож байгаа нь ачааллыг төвлөрүүлэхэд хүргэдэг.

2. Судалгааны тойм

“Нэгдүгээр тойрог зам” төслийн ТЭЗҮ болон Концепц диазайны ажлын хүрээнд нийслэл хотын автозамын хөдөлгөөний эрчим, хурд, иргэдийн зорчилт хөдөлгөөн болон иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа зэргийг хийж Нэгдүгээр тойрог замын эгнээ, уулзварын шийдэл, замын дээд хурдны хязгаар, төлбөрийн систем болон хөрөнгө оруулалтын өгөөж зэргийг тооцоолоход хэрэгцээтэй нэн чухал тоон болон чанарын мэдээллүүдийг судалгааны хүрээнд гаргасан.

Улаанбаатар хотын авто замын ачааллын өнөөгийн байдал: Нийслэл хотын хүн амын өсөлт сүүлийн 20 жилд хурдацтайгаар явагдаж байгаа ба 2014 оноос 2024 он хүртэлх хугацаанд хүн ам 1,362,974-өөс 1,768,151 болж, 29.73 хувиар эрс өссөн байна. Үүний зэрэгцээ, бүртгэлтэй автомашины тоо 443,793-аас 796,989 болж, 79.95 хувиар нэмэгджээ. Тээврийн хэрэгслийн хурдны судалгаагаар оргил цагийн үед Улаанбаатар хотын гол замуудын дундаж хурд ихэвчлэн 25 км/ц-аас доош байгаа бөгөөд зарим замын хэсгүүдийн дундаж хурд 5 км/ц-аас ч бага байна. Замын хөдөлгөөний эрчмийн судалгаагаар оргил ачааллын үед Улаанбаатар хотын уулзваруудын үйлчилгээний түвшин (LOS) ихэвчлэн “E” эсвэл “F” зэрэгтэй байгаа нь хэт ачаалалтай, түгжрэлийн байдалд орсныг илтэж байна. Эдгээр тоон үзүүлэлтүүд нь замын сүлжээний нэвтрүүлэх

чадвар ноцтой дутагдалтай байгааг харуулж байгаа бөгөөд одоогийн хөдөлгөөний ачаалал нь түүнийг даах хязгаараас аль хэдийн давсан болохыг тодорхой харуулж байна.

Улаанбаатар хотын авто замын ачааллын хэтийн төлөв: Хотын хүн амын жигд бус суурьшилт, авто замын нягтрал хангалтгүй, тээврийн хэрэгслийн тоо ихсэх, нийтийн тээврийн хамрах хүрээ бага, замын хөдөлгөөнд оролцогчдын соёл сул, газрын замбараагүй төлөвлөлт, дэд бүтцийн хоцрогдол зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан 2025 онд хотын авто замын ачаалал одоогийн байдлаас улам доройтох төлөвтэй байна.

Хүснэгт 1. Замын түгжрэлийг бууруулах арга хэмжээ авахгүй бол 2030 онд хүлээгдэж буй нөлөөллийн урьдчилсан тооцоо

Хүчин зүйл	2030 он （Хэрэв ямар нэгэн арга хэмжээ авахгүй тохиолдолд）
Хүн амын тоо	2.1 сая
Бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо	1,136,187

Тайлбар: *Хэрэв “замын сүлжээг өргөтгөх, их багтаамжтай нийтийн тээвэрийг хөгжүүлэх болон бусад тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалт”-ын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхгүй бол 2030 он гэхэд Улаанбаатар хотын хүн ам 2.1 саяд хүрч, автомашины тоо 1,136,187 болж нэмэгдэх төлөвтэй байна. Харин одоогийн замын сүлжээнд ямар ч өөрчлөлт оруулахгүй тохиолдолд түгжрэлийн байдал улам даамжрах болно.*

2. Нэгдүгээр тойрог замын хэрэгцээ, шаардлага

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын үнэлгээний хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ; Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө; Гэр хорооллын бүсийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн төлөвлөгөө зэргийг үндэслэн, мөн тэдгээрт тусгасан хэрэгцээ шаардлагыг мөрдлөг болгог судалгааг гүйцэтгэв.

Монгол Улс 1992 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа Улаанбаатар хотод хүн амын хэт төвлөрлөөс болж хотын орон сууцны системд “гэр хороолол” (инженерийн дэд бүтцэд холбогдоогүй хороолол) үүссэн. Хот байгуулалтын тулгамдсан асуудал, төлөвлөлтийн арга хэмжээ 1992 оноос хойш нийслэлд хүн амын хэт төвлөрлөөс үүдэлтэй авто замын түгжрэл, орчны бохирдол, гамшгийн эрсдэл жилээс жилд нэмэгдэж, Монгол Улсын Үндсэн хуулиар иргэдэд олгосон “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”-д ноцтойгоор халдаж байна. Энэ асуудлын гол үндэс нь Улаанбаатар хотын нэг төвтэй шугаман болон нэг тойрогт хотын бүтэцтэй холбоотой юм.

2.1. Дэд төвүүдийг хөгжүүлэх хэрэгцээ болон шаардлага

Улаанбаатар хот олон төвт хотын тогтолцоог бий болгохын тулд хүн амын хуваарилалтыг оновчтой болгох, авто замын түгжрэл, орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хотын 14 хотын төвийг байгуулах бодлого зорилтыг хэрэгжүүлж байна. Төлөвлөж буй замууд нь хойд нутгийн олон бүс нутаг, хотын 6 дэд төвийг босоо хоёр коридороор холбох ба Өнөр, Баянхошуу, Сэлбэ, Чингэлтэй, Дарь-Эх, Буянт-Ухаа хотыг холбосон нийт 24.793 км урт тойрог замын төсөл нь нийслэлд хэрэгжүүлж буй урт хугацааны бодлоготой уялдсан нэн тэргүүнд тавигдаж буй зорилтуудын нэг болсныг харуулж байна.



Зураг 1. 14 хотын төвүүдийн төлөвлөлтийн зураг

2.2. Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөх хэрэгцээ ба шаардлага

(1) Тээврийн эрэлт хурдацтай өсч байна: 2014-2024 оны хооронд Улаанбаатар хотын хүн ам болон автомашины тоо эрс нэмэгдсэн. Мянган хүнд ногдох автомашины тоо 326-аас 451 болж өссөн нь иргэдийн тээврийн хэрэгцээ тасралтгүй нэмэгдэж байгааг харуулж байна. Үүнийг дараах хүснэгтэд үзүүлэв.

(2) Замын сүлжээний даац хангалтгүй байна: Google газрын зургийн бодит цагийн замын хөдөлгөөний шинжилгээнд үндэслэн Улаанбаатар хотод түгжрэл өглөөний оргил цагаар эхэлж, өдрийн турш үргэлжлэн нэмэгдэж, оройн оргил цаг өнгөрсний дараа бага зэрэг буурч байгаа нь тогтоогдсон. Энэхүү үзэгдэл нь одоогийн замын сүлжээ иргэдийн өдөр тутмын зорчих хэрэгцээг хангаж чадахгүй байгааг тодорхой илэрхийлж байна. Үүнийг доорх Зураг 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. 2014 ба 2024 он дахь Улаанбаатар хотын автомашины тоо болон хүн амын өөрчлөлтийн харьцуулалт

Он	Бүртгэлтэй автомашины тоо	Хүн амын тоо	Мянган хүнд ногдох автомашины тоо (хүн/тээвэр)
2014	443,793	1,362,974	326
2024	796,989	1,768,151	451

Зураг 2. Улаанбаатар хотын ажлын өдрүүдийн түгжрэлийн түвшний цаг хугацааны өөрчлөлтийн график

3. Нэгдүгээр тойрог замын хөдөлгөөний эрэлтийн загварчлал ба арга аргачлал

Судалгаанд төслийн багийнхан математик загварчлал болон ТрансКАД, мөн ажиглалтын, хэлэлцүүлэг, асуумжийн аргуудыг ашигласан ба замын хөдөлгөөний бодлого төлөвлөлтийн математик загварчлал гэдэг нь тээврийн дэд бүтэц, замын хөдөлгөөний ачаалал хоорондын харилцан үйлчлэлийг математик аргаар тайлбарлах, тээврийн системийн үйл ажиллагаанд нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн үзүүлэлтүүд хэрхэн нөлөөлж байгааг загварчлах үйл явц юм. Математик загварчлал нь хот төлөвлөлтийн үйл ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тээврийн бодлогыг боловсруулахад тооцооллын судалгаанд үндэслэн тоон мэдээллийн дэмжлэг үзүүлдэг. GIS-тэй нэгдсэн замын хөдөлгөөний төлөвлөлтийн программын хувьд TransCAD-ыг ашигласан бөгөөд энэ нь олон төрлийн тээврийн загварчлалыг (дөрвөн үе шаттай арга, Logit загвар, ABM гэх мэт) гаргахад нэн тохиромжтой юм. Мөн их хэмжээний өгөгдөл, замын динамикийг шинжлэхэд энэхүү арга нь тохиромжтой ба автобусны маршрут, логистикийн замыг оновчтой болгож, цахим системээр дамжуулан үр дүнг хянах боломжтой. Үүний гол давуу тал нь GIS болон замын хөдөлгөөний загваруудыг нарийн нягт нэгтгэж, хөдөлгөөнд оролцогчдын хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх алгоритм, зэрэгцээ тооцоолох хурдатгал зэрэг чухал өгөгдлүүдийг гаргаж авахад оршино.

Хүснэгт 3. Дөрвөн шатлалт замын хөдөлгөөний төлөвлөлтийн загварчлал

Хэсэг	Функциональ тодорхойлолт
Зорчих хөдөлгөөний үүсэл	OD матриц (зорчих эхлэл–дуусгалтын матриц)-т үндэслэн бүс тус бүрийн зорчих хөдөлгөөний үүсгэх болон татах хэмжээг тодорхойлно.
Зорчих хөдөлгөөний тархалт	Янз бүрийн бүсүүдийн хоорондын зорчих хөдөлгөөний хэмжээ, урсгалын тархалтын загварыг боловсруулна.
Тээврийн хэрэгслийн төрлөөр ангилалт	Хувийн автомашин, нийтийн тээвэр, явган зорчих зэрэг өөр өөр тээврийн хэрэгслийн хэлбэрүүдийн тээвэрлэлтийн хувь хэмжээг тодорхойлно.
Замын хөдөлгөөний хуваарилалт	Урьдчилан тооцоолсон зорчих хөдөлгөөний хэмжээг тодорхой замын сүлжээнд хуваарилж, замын даац ба нэвтрүүлэх чадварыг үнэлнэ.

3.1. Замын хөдөлгөөний шинжилгээний бүс (TAZ)-ийн бүрдүүлэлт ба өгөгдлийн нэгтгэл

Замын хөдөлгөөний загварчлалын үндсэн бүрэлдэхүүн нь Замын Шинжилгээний Бүс (Traffic Analysis Zone, TAZ) бөгөөд TAZ-ийн нарийвчилсан тоон өгөгдөл нь тээврийн

загварчлалын тооцоонд тулгуур үүрэг гүйцэтгэдэг. TAZ-ийн хуваагдал нь газарзүйн онцлог, зам сүлжээний бүтцэд тулгуурлан бүсчилсэн төлөвлөгөөнд суурилдаг.Энэхүү судалгаанд Улаанбаатар хотыг замын хөдөлгөөний шинжилгээний 213 бүсэд хуваажаж, дараах гурван төрлийн суурь өгөгдлийн шинж чанараар ангилан нэгтгэв. Үүнд:

1. Хүн амын статистик шинж чанар: Хүн амын суурьшлын нягтрал (хүн/км²), насны бүтцийн хуваарилалт (хүүхэд/ажиллах хүч/ахмад настны хүн амд эзлэх хувь), нэг өрхөд ногдох тээврийн хэрэгслийн дундаж тоо.

2. Нийгэм, эдийн засгийн шинж чанарууд: ажлын нягтрал (ажлын байр/га), нэг хүнд ногдох орлого (ам. доллар/жил), гол үйлдвэрлэлийн төрөл (үйлдвэр/ худалдаа/ үйлчилгээний салбарын эзлэх хувь).

3. Газар ашиглалтын шинж чанар: орон сууцны талбайн эзлэх хувь, худалдааны үйлчилгээний байгууламжийн нягтрал (худалдааны төв/оффисын барилгуудын тоо), нийтийн үйлчилгээний байгууламжийн хамрах хүрээ (сургууль/эмнэлэг/парк).



Зураг 3. Хөдөлгөөний шинжилгээний бүсийн хуваарийн бүдүүвч диаграм

3.2. TransCAD программ хангамж

Энэхүү судалгаа нь дөрвөн үе шаттай замын хөдөлгөөний төлөвлөлтийн аргачлалаар болон дээрх үндсэн үзүүлэлтүүд (LOS, VCR, тээврийн хэрэгслийн хурд)-тай хослуулан Улаанбаатар хотын авто замын одоогийн ачааллын түвшин, хэтийн хөдөлгөөний эрэлт, урт хугацааны түгжрэлийн хандлагыг тоон байдлаар урьдчилан таамаглаж байна.

3.3. Суурь судалгааны мэдээллийн эх сурвалжийг дараах байдлаар

(1) Уулзварын хөдөлгөөний урсгалын мэдээллийн эх сурвалж: Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний урсгалыг судлах хүрээнд 23 уулзварыг сонгон газар дээр нь ажиглалт хийсэн. Ажлын болон амралтын өдрүүдэд өглөөний 5:00 цагаас шөнийн

24:00 цаг хүртэл 15 минут тутамд уулзвар бүрийн орох чиглэл тус бүрийн тээврийн хэрэгслийн урсгал (зүүн эргэх, баруун эргэх, шулуун явах чиглэлүүдээр, төрлөөр нь ангилан) статистикийг бүртгэв. Ихэнх уулзварууд “E”, “F” зэрэг үйлчилгээний түвшинд буюу хэт ачаалалтай (oversaturated) байгаатай холбоотойгоор TransCAD программын симуляцын үр дүн нь бодит хэмжилтээс өндөр гарч болзошгүй.

(2) Замын хурдны мэдээллийн эх сурвалж: Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хурдыг тодорхойлох судалгааны хүрээнд GPS төхөөрөмжийг суурилуулж, бодит хөдөлгөөний мэдээлэл цуглуулан боловсруулсан. Мэдээлэлд ажлын болон амралтын өдрүүдийн өглөө, өдөр, оройн оргил цагуудын хурдны үзүүлэлтүүдийг хамруулсан бөгөөд энэ нь мэдээллийн иж бүрэн байдал, төлөөлөлтэй байдлыг хангаж байна.

(3) 2022 ба 2025 оны OD судалгаа: 2022 оны OD судалгаагаар нийт 15,000 өрхийн зорчих хөдөлгөөний мэдээллийг цуглуулсан. Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нийт 394,391 өрхөөс санамсаргүй түүврээр 15,000 өрхийг сонгон судалгаа хийжээ.
2025 оны OD судалгаа нь нийт 2,600 өрхийг хамарсан. Шинээр байгуулагдах тойруу замын дагуу болон ойролцоох 50 тээврийн жижиг бүс тус бүрт 52 судалгааны хуудсыг тарааж, нийт 2,600 өрхөөс судалгаа авч, мэдээллийг цуглуулсан.
“Иргэдийн зорчилт хөдөлгөөний Origin-Destination (OD) матриц боловсруулах өрхийн судалгааны тайлан”-д 2022 ба 2025 оны OD судалгааны үр дүнг харьцуулсан дүн шинжилгээ хийсэн байдаг.

(4) Замын нэвтрүүлэх чадварын загварчлал: Замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг тооцохдоо “Бээжингийн замын нэвтрүүлэх чадварын гарын авлага”-г суурь болгон авч, Улаанбаатар хотын замын хөдөлгөөний бодит нөхцөл байдалд тохируулан зохих бууруулалт хийж, загварчилсан. Хүснэгт 4-т Улаанбаатар хотын замын сүлжээний тооцоолсон нэвтрүүлэх чадварыг үзүүлэв.

Хүснэгт 4. Замын нэвтрүүлэх чадвар

Нэршил	Хэт ачаалалтай үеийн хөдөлгөөн нэвтрүүлэлт (pcu/h)
Нэг урсгалтай 3 эгнээ гол гудамж зам	4550
Нэг урсгалтай 2 эгнээ туслах зам	1400
Рамп (шилжих хэсгийн зам)	1200

Үзүүлэлтийн тодорхойлолт: Энэхүү судалгаагаар одоогийн замын ачааллыг дараах үндсэн үзүүлэлтүүдээр (KPI) үнэлэв.

Хүснэгт 5. Үзүүлэлт тодорхойлох хүснэгт

Үзүүлэлт	Тодорхойлолт
VolumePrT	Моторт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим (тээврийн хэрэгсэл/цаг)
VolumePuT	Нийтийн тээврийн зорчигчдын хөдөлгөөний эрчим (зорчигч/цаг)
LOS	Үйлчилгээний чанарын зэрэглэл (A-F, замын нэвтрүүлэх чанар)
VCR	Замын хөдөлгөөний эрчим болон хөдөлгөөн нэвтрүүлэх чадамжийн судалгаа（Volume to Capacity Ratio）
Travel speed	Замын хэсгийн автомашины дундаж хурд (км/цаг)

Хүснэгт 6. Хөдөлгөөний үйлчилгээний чанар (LOS) ба хөдөлгөөний эзлэхүүн-багтаамжийн харьцаа (VCR) -ийн тодорхойлолт

Үйлчилгээний түвшний үнэлгээ (LOS)	VCR- ийн хүрээнд	Тодорхойлолт	Замын хөдөлгөөнд оролцогчдын тээврийн хэрэгслийн байдал
A	0.00 - 0.35	Чөлөөт урсгал: Тээврийн хэрэгслийн хоорондын харилцан үйлчлэл багатай хөдөлгөөний оновчтой нөхцөл. Тээврийн хэрэгсэл чөлөөтэй зорчиж, төлөвлөсөн хурдаа хадгалж, тээврийн хэрэгслийн хоорондох зайг их байлгах боломжтой.	Тээврийн хэрэгсэл хоорондын зай их, дараалал байхгүй, жолооч нар эгнээгээ чөлөөтэй сольж болдог.
B	0.35 - 0.58	Тогтвортой урсгал: Тээврийн хөдөлгөөнд бага зэрэг хязгаарлалт орсон, автомашинуудын хооронд нөлөөлөл мэдрэгдэх төлөвт орно. Хөдөлгөөний үр ашиг өндөр боловч гүйцэж түрүүлэх давтамж нэмэгддэг.	2-5 тээврийн хэрэгсэл богино дараалал үүсгэдэг бөгөөд жолооч нар хурдаа идэвхтэй тохируулах шаардлагатай байдаг нь хөдөлгөөний ая тухыг бага зэрэг бууруулдаг.
C	0.58 - 0.75	Чухал урсгал: Хөдөлгөөний урсгал ихээхэн хязгаарлагдаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд нэмэлт төлөвлөлт шаардлагатай. Гүйцэж түрүүлэх нь хэцүү болж, тээврийн хэрэгслийн хурд буурч, жолоочийн тав тух мэдэгдэхүйц буурдаг.	5-14 тээврийн хэрэгсэл тасралтгүй дараалал үүсгэж, эгнээ солих боломж багасч, тээврийн хэрэгслийн хурд тооцоолсон утгын 70%-80% хүртэл буурч байна.
D	0.75 - 0.90	Тогтворгүй урсгал: Замын хөдөлгөөн маш нягт, эгнээ солих, эргэх чадвар эрс хязгаарлагдмал. Урт дараалал нь хэвийн үзэгдэл., Замын хөдөлгөөний үр ашиг огцом буурсан.	Хөдөлгөөн байнга эхэлмэгц зогсдог, гүйцэж түрүүлэх нь бараг боломжгүй, тээврийн хэрэгслийн хурд тооцооны утгын 50%-60% хүртэл буурч, уулзвар дээрх саатал ихээхэн нэмэгддэг.
E	0.90 - 1.00	Шахалтат урсгал: Замын даац ханасан, хөдөлгөөний урсгал маш тогтворгүй. Урт дараалал нь уулзварын түгжрэл үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.	Тээврийн хэрэгслийн хурд 30 км/цаг-аас бага, зам нь өдрийн цагаар түгжрэл ихтэй, саатал нь аяллын /хөдөлгөөний/ 40 гаруй хувийг эзэлж байна.
F	>1.00	Урсгалын уналт: Хөдөлгөөний нэвтрүүлэлт нь замын даацаас хол давж, тээврийн систем доголдож, осол гарах магадлал нэмэгдэж, тээврийн хэрэгсэл "зогс- хөдөл" горимд шилжиж байна.	Тээврийн хэрэгслийн хурд 15 км/цаг хүрэхгүй, зам бүрэн хаагдсан, аяллын цаг нь тааварлашгүй, онцгой байдлын машинууд өнгөрөхөд хүндрэлтэй байсан.

4. Улаанбаатар хотын авто замын ачааллын өнөөгийн байдал

4.1. Тээврийн хэрэгслийн өсөлтийн чиг хандлага

2024 оны байдлаар Монгол Улсад бүртгэлтэй нийт авто тээврийн хэрэгслийн тоо 1,339,005 автомашин байгаагаас 796,989 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Тээврийн хэрэгслийн өсөлтийн чиг хандлага дараах байдалтай байна. 2014-2024 оны хооронд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл 443,793-аас 796,989 болж, жилийн дундаж өсөлт 7.96% тус тус байна. Мөн манай улс дахь тээврийн хэрэгслийн насжилтын хувьд 80 орчим хувь нь 10-с дээш жилийн настай байгаа нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл өндөр байж болзошгүйг харуулж байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Тээврийн хэрэгслийн насжилт

Тээврийн хэрэгслийн насжилт	Тээврийн хэрэгслийн тоо	Эзлэх хувь
0-3 жил	48,667	6.1%
4-6 жил	36,490	4.6%
7-9 жил	78,522	9.9%

10- аас дээш жил	633,310	79.5%

4.2. Авто замын тээврийн одоогийн нөхцөл байдлын шинжилгээ

Энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын авто замын ачааллыг үнэлэх зорилгоор олон улсын жишигт нийцүүлэн төлөвлөгдсөн тойрог зам дагуу болон ойр орчмын 2600 айл өрхийн замын зорчилт хөдөлгөөний судалгааг хийсэн. Судалгааны үр дүнд аялал жуулчлалын зорилгын ангилал, ажилдаа явах 46.52%, гэртээ харих 33.31%, сургуульд явах 2.87%, хүүхэд авах 9.43%, такси жолоодох 0.89%, амралт зугаалгаар 4.13% , албан ёсны эсвэл эрүүл мэндийн зориулалт 2.85%- ийг тус тус эзэлж байна.



Зураг 4. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний бүсжилтийн хуваарь

Хүснэгт 8. Улаанбаатар хотын өглөөний цагийн оргил ачааллын төвийн бүсийн замын хөдөлгөөний матриц

Замын хөдөлгөөний Дүүрэг	1-Хотын төвийн Их тойруугийн бүс	3-Хотын хойд бүс	4-Хотын зүүн бүс	5-Хотын урд бүс	6-Хотын баруун урд бүс	7-Хотын баруун хойд бүс	8-Хотын зах хэсгийн баруун бүс	21-Хотын төвийн хэсгийн баруун бүс	22-Хотын төвийн хэсгийн зүүн бүс
1-Хотын төвийн Их тойруугийн бүс	2656	1667	1713	714	282	1748	267	824	553
3-Хотын хойд бүс	3047	1585	725	1095	457	2100	375	1168	293
4-Хотын зүүн бүс	3256	1512	1339	548	325	1781	203	783	994
5-Хотын урд бүс	731	421	241	155	309	754	166	394	108
6-Хотын баруун урд бүс	1423	982	608	381	837	1629	563	1265	190
7-Хотын баруун хойд бүс	2344	3239	1356	703	1281	4626	1075	2432	319
8-Хотын зах хэсгийн баруун бүс	177	415	113	117	526	928	694	386	59

21-Хотын төвийн хэсгийн баруун бүс	1301	1479	711	438	424	1558	413	2163	303
22-Хотын төвийн хэсгийн зүүн бүс	962	301	644	198	77	358	61	236	139

Хүснэгт 9. 2025 оны үдийн оргил ачаалалтай үеийн матриц

Замын хөдөлгөөний дүүрэг	1-Хотын төвийн Их тойруугийн бүс	3-Хотын хойд бүс	4-Хотын зүүн бүс	5-Хотын урд бүс	6-Хотын баруун урд бүс	7-Хотын баруун хойд бүс	8-Хотын зах хэсгийн баруун бүс	21-Хотын төвийн хэсгийн баруун бүс	22-Хотын төвийн хэсгийн зүүн бүс
1-Хотын төвийн Их тойруугийн бүс	4794	2073	1686	1216	500	2621	221	2201	813
3-Хотын хойд бүс	2283	4041	632	784	583	1164	195	2286	303
4-Хотын зүүн бүс	1994	1146	964	259	309	584	90	687	1082
5-Хотын урд бүс	1984	820	88	176	159	1233	100	405	16
6-Хотын баруун урд бүс	565	628	206	309	1844	895	383	551	51
7-Хотын баруун хойд бүс	1601	1845	712	1059	695	4342	981	1962	198
8-Хотын зах хэсгийн баруун бүс	306	177	83	152	332	599	742	199	49
21-Хотын төвийн хэсгийн баруун бүс	2286	3499	454	849	413	1393	228	4842	144
22-Хотын төвийн хэсгийн зүүн бүс	614	518	693	60	75	159	60	182	559

Хүснэгт 10. Улаанбаатар хотын оройн цагийн оргил ачааллын төвийн бүсийн замын хөдөлгөөний матриц

Замын хөдөлгөөний дүүрэг	1-Хотын төвийн Их тойруугийн бүс	3-Хотын хойд бүс	4-Хотын зүүн бүс	5-Хотын урд бүс	6-Хотын баруун урд бүс	7-Хотын баруун хойд бүс	8-Хотын зах хэсгийн баруун бүс	21-Хотын төвийн хэсгийн баруун бүс	22-Хотын төвийн хэсгийн зүүн бүс
1-Хотын төвийн Их тойруугийн бүс	4237	2914	1839	849	444	2266	149	1847	331
3-Хотын хойд бүс	1955	1465	1609	868	431	2703	342	1034	518
4-Хотын зүүн бүс	1457	1847	1167	219	255	1479	114	952	742

5-Хотын урд бүс	812	588	137	156	317	683	153	488	54
6-Хотын баруун урд бүс	1452	1128	433	379	837	1343	531	1055	104
7-Хотын баруун хойд бүс	2243	2457	1614	621	1323	4762	1049	1946	435
8-Хотын зах хэсгийн баруун бүс	186	405	108	94	540	904	694	200	46
21-Хотын төвийн хэсгийн баруун бүс	1594	1676	708	462	465	2457	560	2257	233
22-Хотын төвийн хэсгийн зүүн бүс	302	678	1728	73	51	297	30	160	320

4.3. Авто замын хөдөлгөөний нөхцөл байдлын дүн шинжилгээ

1982 онд Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн Палеолитын дурсгал судлах анги Улаанбаатараас баруун тийш 50 км-т орших Хавчуугийн ам хүртэл Туул I, Ia, II, III, IV, Улаан хад буудал, Шувууны ам зэрэг нийт 7 газраас 80 гаруй чулуун зэвсэг олж цуглуулан бөгөөд Туул гол, Хар шугуй, Таван толгой, Дуганы хөтөл, Хавчуугийн ам, Улаан хад, Шувууны ам, Улаан хужир орох замд 11 газар 70 гаруй булш хиргисүүр бүртгэснээс Дуган хөтлийн зүүн талд Түрэгийн үеийн хоёр тахилын онгон малтан шинжилжээ. Мөн Шувууны ам орчмын хаданд босоо зураас, нисэж буй шувууны дүрс бүхий ихэд бүдгэрсэн зосон зураг байгааг тайландаа тэмдэглэсэн байна.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр, Туул голын эргийн дагуу нэгэн хэрэмт барилгын туурь бий. Үүнийг археологич Х.Пэрлээ анх нийтлэхдээ Чингис хааны III орд буюу Хар-түнийн орд, Бүхэгийн голын адгийн балгас хэмээн нэрлэсэн байдаг. Тэрээр уг балгасыг Киданы үеийн балгас, Хэрэйдийн Тоорил хааны ордон гэх зэргээр нэрлэж байсныг 1997 онд Японы эрдэмтэн Н.Шираиши, Монголын судлаач Б.Энхбат нар хэмжилт, судалгааны ажил хийн, дэвсгэр зургийг нарийвчлан үйлдэж, мөн илэрсэн олдвор хэрэглэгдэхүүн зэрэгт тулгуурлан Х.Пэрлээгийн Хар Түнгийн орд гэсэн саналыг дэмжжээ. Ингэхдээ тэд уг балгасыг Киданы үед баригдсаныг Ван хан үргэлжлүүлэн ашиглаж байсан байж болохыг тэмдэглэсэн байна.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид 2021-2023 онд уг дурсгалыг малтан судалсан бөгөөд тус дурсгалын архитектурын онцлог, он цагийг нарийвчлан тогтоож, хотын ойролцоо хүн, малын үйлчлэл ихтэй газар буй газрыг харгалзан тус соёлын өвийн хүрээ хязгаарын хэмжээг тогтоон хамгаалах арга зүйг боловсруулах зэрэг олон асуудлыг тодруулан судлах зорилтыг тавьсан юм. Тус дурсгалт газрыг 2002 онд НИТХ-ын 8 дугаар тогтоол, 2008 онд Нийслэлийн Засаг Даргын 357 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн

хамгаалалтад, Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор баталсан “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д “Туулын хар түнийн ордны туурь” хэмээх нэрээр тус тус бүртгэж хамгаалалтад авсан байна.

Тус хүрээлэнгийн 2021 оны малтлага судалгаагаар дурсгалын агаарын зургийг авч, нарийвчилсан хэмжилт, тодорхойлолт, хотын туурийн хэрэм болон түүний дотор орших төв барилга, жижиг барилга байгууламжуудын бүтэц, рельефийг харуулсан дэвсгэр зураг хийх ажлыг гүйцэтгэжээ. Хотын хэрмийн хэсэгт бүтэц, он цагийг тодорхойлох зорилгоор 2 х 26 м сувгийн малтлага гүйцэтгэж, 4 м өргөн, 70 см өндөр шавар үелэн дагтаршуулсан шороон хэрэм, түүний гадна талаар 4 м өргөн, 60 см гүн сувагтай байгааг тогтоов. Уг сувгийг ус нэвчихээс сэргийлэн улаан өнгийн шавраар нямбайлан доторлосон нь хэрмийн гадуур ус зайлуулах суваг зориуд хийсэн инженерийн байгууламж болохыг илтгэж байна. Хэрмийн дотор талд мал, амьтны ясны хаягдал бүхий нүх илэрсэн нь лабораторийн нарийвчилсан шинжилгээ хийх, хэрмийн он цагийг баттай тогтоох чухал хэрэглэгдэхүүн болж байна. Хэрмийн дотор орших төв ордны дээд хэсгийг бүрэн цэвэрлэж, дэвсгэр зургийг үйлдэж, суурийн хэсэгт зүсэлт явуулж бүтэц зохион байгуулалтыг тодорхойлов. Уг ордны туурь нь шороон хэрмийн ерөнхий тэг, чиглэлтэй давхцахгүй байгаа нь өөр цаг үед холбогдохыг шууд илэрхийлж байна. Ордныг байгуулсан шороон суурь нь 34 х 18.5 м хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй бөгөөд цайвар өнгийн шавар дагтаршуулан дэлдэж 2.5 м өндөр шороон тавцан үүсгэн, шатаасан тоосгоор нямбайлан шалласан болохыг тодорхойлов. Шалны тоосгон өрлөгөөс үзэхэд уг барилга нь үүдний угтах хэсэг болон хэд хэдэн томоохон тасалгаанаас бүрдэх бөгөөд барилгын материал болох дээврийн ваар, нүүр ваар, тоосго, барилгын гоёл чимэглэл багагүй илэрч байгаа нь нарийн мэргэжлийн урчуудын оролцоотой, инженерийн хэмжилт тооцоо, төлөвлөлтийн дагуу баригдсан архитекторын уран тансаг шийдэлтэй, гоёмсог хийцтэй ордон байсныг илэрхийлж байна. Малтлагын явцад ордны шалыг тоосгоор шахаж хийснээс гадна хээ чимэглэл бүхий шигтгэмэл (мозаика) шалны арга зүйгээр үйлдсэн болохыг анх удаа илрүүлсэн нь эрдэм шинжилгээний хувьд ховор тохиолдох баримт хэрэглэгдэхүүн болж байна. Ордны суурийн зүсэлтийн малтлагаар он цаг тогтоох модон байгууламжийн үлдэгдэл илэрч олдоод байна. Малтлага судалгаанд үндэслэн ордныг тухайн үеийн байдлаар нь сэргээн зурах ажлыг эхлүүлж уг дурсгалын хамгаалалтын бүсийг тогтоосон бөгөөд дурсгалын хадгалалт хамгаалалт, ил үзмэр, мэдээллийн төв, үйлчилгээний хэсгийг харуулсан төлөвлөлт бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох урьдчилсан эскиз зураг гаргах ажлыг хийж гүйцэтгэжээ.

ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монголын Бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэн хамтран “Голомт банк”-ны дэмжлэгээр 2022 оноос хэрэгжүүлж буй “Өв соёлын голомт” археологийн судалгааны төслийн хүрээнд уг дурсгалт газар малтлага судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэжээ. 2021 онд эхэлсэн малтлагын хүрээг өргөтгөн ажилласан ба 2022-2023 оны малтлага судалгаанаас гарсан хэд хэдэн дээжид он цагийн хамаарал тогтоох шинжилгээ хийгдэж буй бөгөөд барилгын чимэглэл хэсгүүд, чулуу шигтгэж хийсэн болон тоосгон шалны хэсэг, тосгуур, нөмрөг, нүүр ваараан чимэглэлүүдийн хийц загвар, урлалын онцлогийг нарийвчлан судлах ажил үргэлжилж байна.

Нөгөө талаар Ван ханы нутаг Туулын хар түний байршлыг тодорхойлох нэгэн баримт нь Монголын нууц товчооны III-115-р зүйлд: …Тоорил хан няцруун (буцахдаа) Бурхан Халдуны гэрүгээр Өхөртү Жубур дайран, Гацуурт сүбчид, Улиастай сүбчид дайран гөрөө ину авлаад Туулын хар түнийг зорин няцав хэмээн өгүүлдэг. Зөвхөн үүнээс үзэхэд одоогийн Улиастай, Гацууртын амнаас

доош Туул гол дагуу Бөхөг Түргэний гол хүртэл ойролцоогоор 20-25 км орон зайд Ван ханы нутагладаг байсан Хар Түнийг баримжаалж болох юм.

Археологийн хүрээлэнгийн малтлага судалгааны үр дүнд дээр дурдсан орон зайн доод төгсгөл хэсэгт хамаарах Түргэний голын балгасаас XII-XIII зууны үед хамаарах олдвор хэрэглэгдэхүүн илэрсэнгүй, зарим дээжид хийсэн шинжилгээний дүн ч өөр он цагийн хамаарлыг зааж байгаа тул Туулын хар түний Ван ханы ордын үлдэц, ул мөрийг хайж тодруулах ажил цаашид үргэлжлэхээр үлдэж байна.

О.Намнандорж “Соёл, түүх дурсгалын зүйлийг нандигнан хямгадъя” нийтлэлдээ Нийслэл хот дахь хүрээ хийд, Тоньюкукийн гэрэлт хөшөө, Их Тэнгэр, Зайсан, Чулуут, Хүрхрээ, Жаргалантын ам, Алдар толгой, Толгойтын Баянхошуу, Хүн чулууны хонхор дахь түүх, соёлын дурсгалын талаар дурдсан байна [Намнандорж, 1959; 2003. Тал 370-374].

Улаанбаатар хотын дүүрэг (хотын төвөөс зүүн тийш 25 км орчим зайтай) Гачууртын аманд Гачууртын голын баруун талын зүүн тийш харсан хадан хясаанаа хадны улаан зосон зургийг 1960 онд А.П.Окладников илрүүлэн олж нийтэлжээ [Окладников, Запорожская, 1970].

1981, 1982 онд МЗТСХЭ Туул голын хөндийд ажиллахад Зүүн богинын амны зүүн хэсэг төгөл (Зуун модны) модны баруун хойд гангын баруун энгэрт нэг монгол булш малтаж толгойг баруун хойш харуулж, авсгүйгээр оршуулж зүүн гар талд үйсэн хоромсого түүн 6 ширхэг хавтгай төмөр зэв, болон нас барагчийн хөлд том жижиг 2 дөрөө тавьж зүүн ташаанд нь төмөр хутга, баруун талд төмөр цагариг бүхий төмөр амгаа зэрэг зүйлс олжээ [Наваан, 1982].

1982 онд Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн Палеолитын дурсгал судлах анги Улаанбаатараас баруун тийш 50 км-т орших Хавчуугийн ам хүртэл Туул I, Ia, II, III, IV, Улаан хад буудал, Шувууны ам зэрэг нийт 7 газраас 80 гаруй чулуун зэвсэг олж цуглуулан бөгөөд Туул гол, Хар шугуй, Таван толгой, Дуганы хөтөл, Хавчуугийн ам, Улаан хад, Шувууны ам, Улаан хужир орох замд 11 газар 70 гаруй булш хиргисүүр бүртгэснээс Дуган хөтлийн зүүн талд Түрэгийн үеийн хоёр тахилын онгон малтан шинжилжээ. Мөн Шувууны ам орчмын хаданд босоо зураас, нисэж буй шувууны дүрс бүхий ихэд бүдгэрсэн зосон зураг байгааг тайландаа тэмдэглэсэн байна.

Судлаач Г. Мэнэс МЗТСХЭ-ийн бүрэлдэхүүнд ажиллахдаа Налайхын Тоньюкукын цогцолбор, түүний ойр орчимд буй дурсгалууд, Төв аймгийн Дэлгэрхаан сумын Их хөшөөт, Туулын Улхын булан зэрэг нэлээд тооны дурсгалыг шинжилж нарийн тодорхой зураг үйлдэн эрдэм шинжилгээний үүднээс тодорхойлж, түрэгийн тахилын онгон малтан судлах ажлыг гүйцэтгэж ирэв [Мэнэс, 1983].

1993 онд Монгол-Солонгосын хамтарсан ″Дорнод Монгол″ төслийн гишүүн, профессор Сон По Ги, археологич З. Батсайхан нар Туул голын хөндий Баруун Хайрхан ууланд хоёр булш малтсаны нэг нь тоногдоогүй байжээ [Сон По Ги, Батсайхан, 1993, 143-144].

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүннүгийн археологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан доктор, дэд профессор Ч.Амартүвшин, докторант Ч.Ерөөл-Эрдэнэ, Н.Батболд, магистрант Б.Жаргалан нар 2009 оны 04 дүгээр сарын 22-нд Улаанбаатар хотоос зүүн хойш Сэлбэ голын эхэнд бэсрэг хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэжээ [Амартүвшин, Ерөөл-Эрдэнэ, Батболд, Жаргалан, 2009].

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Археологийн дурсгалыг авран хамгаалах секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Батдалай, мөн тус секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистрант Д.Бөхчулуун нар 2012 оны

02-р сарын 15-ны өдөр Улаанбаатар хотын нутагт Хан уул дүүргийн нутагт орших “Алтан тойг” ХХК-ийн “Хайрга” хэмээх талбайд археологийн бэсрэг хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ [Батдалай, Бөхчулуун, 2012].

Түүнчлэн археологич Д.Наваан 2005-2006 онд энд бага хэмжээний малтлагын ажил зохион явуулжээ. Үүний дараа 2009 онд МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхимийн багш, археологич У.Эрдэнэбат оюутны хээрийн дадлагын хүрээнд тус хэрэмт барилгын тууриас, барилгын материалын үлдэгдэл түүвэрлэн, гүймэг шинжлэн хэмжилт хийж, өөрсдийн саналаа нэгэн сэдэвт бүтээлдээ тусгасан байдаг. Тус бүтээлд бичсэнээр, “Уг суурины үлдэгдэл голдоо нэг том, түүний эргэн тойрон хэд хэдэн жижиг туслах барилгын суурь бүхий дөрвөн тал шороон хэрэм аж. Хэрмийн хойд, урд, зүүн тал тодорхой мэдэгдэх бөгөөд харин баруун талынхыг Туул голын үерээс хамгаалах даланг барих гэж шороог хусаж ашигласнаас бүрмөсөн эвдрэн алга болжээ. Хэрмийн үлдэгдэл дунджаар 4 м орчим өргөн, зарим газраа 1 м хүртэл өндөр. Хэрмийн хойд тал 120 м, баруун тал 250 м, урд тал 120 м орчим хэмжээтэй. Өмнө талдаа 8 м орчим өргөн хоёр хаалгатай байсан бололтой. Хэрмийн ерөнхий тэнхлэг ертөнцийн дөрвөн зүг дагуу бус. Хойд урд чиглэлтэй хэрмийн үлдэгдэл зүүн хойш 200 орчим чиглэлтэй байна. Гэтэл хэрмийн төв гол хэсэгт байгаа барилгын үлдэгдэл ерөнхий тэнхлэгээрээ хүрээлсэн хэрмийнхээ чиглэлээс зөрүүтэй байх бөгөөд ертөнцийн зүгээр хойд-урд, баруун-зүүн талыг баримтлан байгуулжээ. Гол барилгын туурь 34 м х 18.6 м. Одоогийн өндөр 2 метр орчим шороо овоолон дагтаршуулсан суурин дээр цогцлоожээ. Өмнө талдаа нэг хаалгатай, хоорондоо дамжин ордог том бага гурван гол танхимтай байжээ”.

2005-2006 онд НСИСОУХ, Монголын үндэсний түүхийн музей, БНХАУ-ын ӨМӨЗО-ны соёлын өв, археологийн хүрээлэн хамтран манай улсын төв, зүүн, өмнө зүгийн аймгуудын 40 гаруй сумдын нутгаар археологийн хайгуул, судалгаа хийж олон тооны дурсгалыг давтан болон шинээр бүртгэн баримтжуулан нийтлүүлсэн байна. Энэ хайгуулын ажлын хүрээнд Улаанбаатар хот орчмын зарим дурсгалуудыг хамруулжээ. Үүнд, Их тэнгэрийн ам, Гачууртын амны зосон зураг, Хуайндайн амны дурсгал, Нарстын хүннү булш, Түргэний голын баруун эрэг дэх хүрлийн үеийн булш зэрэг дурсгалт газрууд багтжээ.

2000-аад оны дундуур “Чингис хаан” дээд сургуулийн оюутны хээрийн дадлагын үеэр Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Баянзүрх хайрхны Их өвөлжөөний ам хэмээх газар дундад эртний үеийн дөрвөн булш малтсан тухай мэдээлэл бий. Мөн тэр орчимд чулуун зэвсгийн дурсгал олддог тухай тэмдэглэжээ.

2006 онд Сонгинохайрхан дүүргийн 21–р хорооны нутаг, Нарийны саалийн фермд иргэн Б.Энх-Амгалан өөрийн хашаандаа ногоо даршлах нүх ухаж байгаад хоёр метр гаруй гүнд буй нэгэн булшийг санамсаргүй олжээ. Дээрх булшийг Монголын үндэсний түүхийн музейн судлаачид авран хамгаалах малтлага судалгаа хийж, тэр орчмын 50 гаруй дурсгалыг бүртгэж авсан байна.

2008 онд МУИС-ын Антропологи-Археологийн тэнхимийн оюутны хээрийн дадлагыг Улаанбаатар хотын Сонгино хайрхан уул, Төв аймгийн Алтанбулаг, Лүн сум гэсэн чиглэлд хийсэн байна. Хээрийн дадлагаар Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт Дарцагтын ам, Цоохорын аманд археологийн хайгуул хийж хүрэл, хүннү, монголын үед холбогдож болох 19 дурсгал илрүүлэн олжээ. Эдгээрээс монголын үед хамаарах 2 булшийг сонгон малтан судалж, хүн, малын яс, ясан чимэг болон алтан эдлэл, сувс, ясан зорх илрүүлэн олжээ.

Мөн онд Улаанбаатарын их сургуулийн археологийн тэнхимийн оюутны танхимд үзсэн хичээлийг бататгах дадлагыг Улаанбаатар хот- Нисэх, Сонгино, Шувуун фабрик, Туул голын хөндий, Төв аймаг, Алтанбулаг сумын Полигоны

хөндий, Эмгэнтийн шанд зэрэг газруудаар хийснээс Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр Эмгэнтийн шанд хэмээх газраас бүлэг хүннү булш илрүүлэн олж бүртгэсэн байна.

2013 онд ШУТИС-ийн НТС-ийн багш нар СХД-ийн Баянхошуу, Зүүн салаа, БЗД-ийн Гачуурт, Хуандайн ам, 22-ын товчоо зэрэг газарт хайгуулын ажлыг зохион байгуулж Хүннүгийн үеийн 27 булш, хүрэл зэвсгийн үеийн булш, хиргисүүр 6 олж илрүүлэн эрдэм шинжилгээний тайлан бичсэн байна [Болдбаатар, Эрдэнэболд, Хатанбаатар, Бямба-Очир, Ванчигдаш, 2013].

2013-2014 онд доктор Я.Цэрэндагва ШУА-ийн “Эрдэм” сонинд “Улаанбаатар хот орчмын археологийн дурсгал” хэмээх өгүүллийн цуврал байдлаар хэвлүүлсэн байна [Цэрэндагва, 2013; 2014]. Тэрээр Зайсан толгой, Маахуур толгой, Залаагийн ам, Залаатын ам, Буянт ухаа, Сонгино гэсэн 6 газарт буй чулуун зэвсгийн дурсгалын талаарх тодорхойлолт, зарим зураг сэлтийн хамт хэвлүүлсэн байна.

2014 онд Б.Цогтбаатар, Ч.Амартүвшин нарын судлаачид ССАЖЯ-ны захиалгаар “Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдлын эрсдэлийн үнэлгээ” төслийн хүрээнд хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байдаг [Цогтбаатар, Амартүвшин нар, 2014].

2014 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс “Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдлын эрсдэлийн үнэлгээ” төслийг ССАЖЯ-ны дэмжлэгээр хэрэгжүүлсэн байна. Төслийн хүрээнд Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалын газарзүйн мэдээллийн санд түүх, соёлын өвийн байршил, урьд өмнөх судалгааны тойм, олдвор, дурсгалт газрын бүртгэл мэдээллийг хайж цуглуулах, боловсруулан, уг мэдээллийн санд түшиглэн судлаачид зүүн болон баруун бүс гэсэн хоёр хэсэгт хуваагдан археологийн ерөнхийлсөн хайгуулын арга зүйг ашиглан тандалт судалгааг гүйцэтгэжээ. Хайгуул судалгааны явцад Хан-Уул, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн нутгуудаас хүрэл, хүннү, монголын үед холбогдох олон булш, хиргисүүр, Түрэгийн тахилын онгон, хадны зураг, бурхны хөрөг зэрэг 41 дурсгалт газрыг давтан болон шинээр баримтжуулан, мэдээллийн санд бүртгэжээ. Улаанбаатар хотын бүх нутаг дэвсгэрийг хамарсан 1:100 000 масштабтай байр зүйн зургийг ArcGIS программд тулгуурлан дурсгалт газруудын тархалтын зургийг боловсруулан төслийн үр дүнг найман хэсэгт тусгасан эрдэм шинжилгээний тайлан бичжээ.

Мөн онд ШУТИС-ийн Археологийн судалгааны баг Монгол цэргийн музейтэй хамтарсан "Туулын хөндийн соёлын өвийн судалгаа" төслийн хүрээнд 2014 онд Улаанбаатар хотын Налайх дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ сумын нутгийн зааг Бишрэлтийн даваану арын аманд байх Хүннүгийн жирийн иргэдийн бүлэг дурсгал дээр ажиллажээ. Тэд Бишрэлтийн даваанаас Туул гол, Налайхын аэродромоос Ар Жанчивлан хүртэлх талбайд хайгуул хийж хүрэл, хүннү, түрэг, монголын үеийн дурсгалуудыг илрүүлэн бүртгэхийн зэрэгцээ Бишрэлтийн амны Хүннүгийн оршуулгын газрын дэвсгэр зургийг үйлдэж нэг булш сонгон малтсан байна. Дээрх судалгааг үргэлжлүүлэн 2016 онд зургаа, 2018 онд нийт найман булш малтсан байна.

2013-2014 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Я.Цэрэндагва ШУА-ийн “Эрдэм” сонинд “Улаанбаатар хот орчмын археологийн дурсгал” хэмээх нийтлэлийг цуврал байдлаар хэвлүүлжээ. Тэрээр Зайсан толгойн суурин, Маахуур толгой, Залаагийн ам, Буянт ухаа, Сонгино гэсэн чулуун зэвсгийн дурсгалт газрууд, Гачууртын амны зосон зураг, Их тэнгэрийн хадны зураг болон Хуайндайн амны дурсгал, Түргэний голын булш, Түр (Төр) Хурхын амны хүннү булш, Агуйт уулын

булш, Майхан толгойн хүннү булш, Хүрхрээгийн амын булш зэрэг газруудын талаарх тодорхойлолт, зарим гар зураг зэргийг нийтлүүлжээ.

2015 онд Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого”-д нийслэлийн 9 дүүргийг хамарсан дүн мэдээгээр 217 дурсгалт газрын 479 ширхэг үл хөдлөх дурсгал хамрагджээ. Үүнээс археологийн дурсгалд хамаарах 67 дурсгалт газрын 237 дурсгал бүртгэгдсэн байна.

2016 онд Ч.Амартүвшин, Д.Бөхчулуун нар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт орших Өвөр гүнтийн хөндийд тавих 11 км замын шугамын дагууд, Соёлын өвийг хамгаалах хуулийн хүрээнд, “Арцат суварга” ХХК-ны хүсэлтээр археологийн хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ [Амартүвшин, Бөхчулуун, 2016].

2016 онд Б.Гүнчинсүрэн, Н.Эрдэнэ-Очир, Н.Баярхүү нар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт орших Өвөр гүнтийн хөндийд тавих 11 км замын шугамын дагууд, Соёлын өвийг хамгаалах хуулийн хүрээнд, “Арцат суварга” ХХК-ны хүсэлтээр археологийн малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ [Гүнчинсүрэн, Эрдэнэ-Очир, Баярхүү 2016].

2017 онд Ц.Амгалантөгс нар Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны 4-25 тоот байрлах зуслангийн хашаанд нь дугуй хүрээтэй нэгэн хиргисүүр байна түүнийг зайлуулж өгнө үү гэсэн иргэн Б.Гэрэлчулууны хүсэлтийн дагуу Соёлын өвийг хамгаалах хуулийн хүрээнд археологийн малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ [Амгалантөгс 2017].

Мөн Ц.Амгалантөгс нар 2017 онд Улаанбаатар хотын Сонгино хайрхан уулын зүүн хойд аманд 1937 оны улс төрийн хэлмэгсэдийн үеийн “Анхны 14”-ийн хэрэгт холбогдсон хүмүүсийн цогцсыг олж илрүүлэх зорилготой археологийн малтлага судалгааг тэдгээрийн ар гэр, үр хүүхдүүдийн хүсэлтийн дагуу явуулжээ [Амгалантөгс 2017].

2018 онд Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын музейгээс эрхлэн нийслэл хотод орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын танилцуулга хийсэн бөгөөд түүнд 2015 онд орон даяар явагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогод хамрагдсан нийслэлийн зургаан дүүргийн нутаг дэвсгэрт орших 61 археологийн дурсгалт газрын бүртгэлийг нийтлүүлжээ.

2018-2019 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын санхүүжилтээр ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны нутаг Рашаант уулын өвөр, Шарга морьтын аманд орших Улсын Их дагина Дондогдуламын түүх, намтартай холбогдох нэгэн байгууламжийг малтан шинжилсэн байна. Малтлагаар 130 гаруй олдвор илрүүлсэн бөгөөд дээрх байгууламж нь “Брадигабудын суварга” байсан болохыг тогтоожээ.

2020 оны 3 дугаар сард иргэдээс ирүүлсэн мэдээллийг шалгах зорилгоор “Соёлын өвийг хамгаалах хамтын ажиллагааны төв” ТББ-ын зардлаар Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн багш Э.Мижиддорж, Ж.Эрдэнэ, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Очир, Соёлын өвийн үндэсний төвийн Авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа нар Хан-Уул дүүргийн 12, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт эрсдэлд орсон зарим дурсгалыг баримтжуулах ажлын зэрэгцээ тэр чиглэлд хайгуул хийж дөрвөн газраас 5 төрлийн 31 тооны археологийн дурсгал бүртгэж тайлан бичсэн байна.

2020 оны 5 дугаар сард Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газрын хүсэлтээр Монголын үндэсний музейн судлаачид тус дүүргийн нутаг дэвсгэрт орших “Ван ханы орд” (Туулын хар түн) хэмээх эртний хэрэмт хотын балгасыг

тухайлан судалж, Сонгинохайрхан уулын өврөөр хайгуул хийж 13 дурсгалыг бүртгэн баримтжуулж, анхан шатны тодорхойлолт, он цаг, ач холбогдлыг тогтоох ажлыг гүйцэтгэжээ.

Улаанбаатар хотод орших музей, их сургуулиудын сан хөмрөг, үзүүлэнд хэд хэдэн хөшөө дурсгалууд хадгалагдаж байдаг билээ. Тодруулбал, Монголын Үндэсний музейн өмнө талбайд хоёр буган чулуун хөшөө, нэг хүн чулуун хөшөө бий. Буган чулуун хөшөөний нэгийг 2000 онд Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгойгоос зөөж авч ирсэн бол нөгөө буган чулуун хөшөөг Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Сөртийн дэнжийн (найман буган хөшөөтэй) буган хөшөөний цогцолбороос 2006 онд зөөж авч ирсэн дөрвөн буган чулуун хөшөөний нэг бөгөөд үлдсэн гурван буган чулуун хөшөөний нэг нь тус музейн сан хөмрөгт, нөгөө хоёр нь Улаанбаатарын Их сургуулийн өмнө талбайд бий. Харин хүн чулуун хөшөөг Ховд аймгийн Булган сумын Ягшийн хөдөө хэмээх газраас зөөж авч ирсэн байна. Тус хүн чулуун хөшөө нь Монгол нутгаас илэрч олдоод байгаа Чемурчекийн (хэмцэгийн) соёлд хамаарах цөөхөн хүн чулуун хөшөөний нэг болно. Мөн Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд Архангай аймгийн Батцэнгэл сумын нутагт орших Тоглохын талын цогцолбор дурсгалаас зөөж авч ирсэн Түрэгийн үеийн хоёр хүн чулуун хөшөө, чулуун хонь, буган хөшөө болон хаанаас хэзээ авч ирсэн нь үл мэдэгдэх нэн сонирхолтой хүн чулуун хөшөө зэрэг хэд хэдэн чулуун дурсгал бий.

Тэрчлэн, Улаанбаатар хотын түүх, шинэчлэлийн музейд хэзээ, хаанаас, хэн авч ирсэн нь үл мэдэгдэх нэгэн буган чулуун хөшөө хадгалагдаж байна. Мөн Богд хааны ордон музейн хашаанд хадгалагдаж байсан түрэгийн үеийн нэгэн хүн чулуун хөшөөг 2014 онд тус музейд шилжүүлэн байршуулсан байна. Мөн сүүлийн жилүүдэд манай улсад газрын харилцаа, тэр дундаа уул уурхай, ашигт малтмалын лиценз олгох, шинээр суурьшлын бүс бий болгож, газар олгох, автозам шинээр тавих зэрэг үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байна. Нийслэл хот орчимд ч дээрх үйл ажиллагаа идэвхтэй өрнөсөөр байна. Дээрх үйл ажиллагааг явуулахын өмнө Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Тавдугаар бүлгийн 27.8.-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна”, 27.9-д “Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна”, мөн 27.10.-т “Урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно” хэмээн тус тус заасан байдаг.

Хуулийн дээрх заалтын дагуу дагуу археологийн судалгаа хийх зөвшөөрөл бүхий эрдэм шинжилгээний байгууллагууд Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр олгогдсон ашигт малтмалын лицензийн талбай, шинээр тавих замын трасс, шинээр олгогдож байгаа суурьшлын бүс зэрэгт авран хамгаалах хайгуул хийсэн байна. Үүнд, ШУА-ийн Археологийн хүрээлэн 2012 онд 3 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөлтэй талбайгаас 4, 2013 онд 10 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөлтэй талбайгаас 246, 2014 онд 3 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөлтэй талбайгаас 27, Налайх дүүрэгт замын трасс-т өртсөн нэг дурсгалыг малтан шинжилсэн, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Улаанбаатарын их сургуулийн Археологийн тэнхим 2015 онд нэг аж ахуй нэгжийн 1449 бар, ШУТИС-ийн Хүмүүнлэгийн салбар, МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхим хайгуул судалгаа хийж олон арван

археологийн дурсгал илрүүлэн олж, эрдэм шинжилгээний тайландаа тусгасан байна.

Хайгуул судалгаанаас гадна зарим тусгай зөвшөөрөлтэй талбайд малтлага хийсэн байна. Үүнд, 2017 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн судлаачид Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр Улиастайн Бага аманд орших Бурхант хошуу хэмээх газар иргэн Цогтсайханы эзэмшлийн талбайд орших нэгэн хиргисүүрийг малтан шинжилсэн байна. Мөн 2017 онд МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн судлаачид Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших Богд хаан уулын дархан цаазат газрын Арцатын аманд “Тулгын Өндөр” ХХК-ийн эзэмшлийн талбайд таван дагуул бүхий нэгэн хиргисүүр, дугуй хэлбэрийн чулуун дараастай дөрвөн булш илрүүлэн, тус тус малтан судалсан байна.

2023 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор (Ph.D), дэд профессор Я.Цэрэндагва, магистр С.Далантай, “Сан хөмрөг лабораторийн салбар”-ын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ, Л.Дэлгэрмаа нар “Үнэн Хөлөг Констракшн” ХХК-ийн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 23-р хороо, Богдхан уулын дархан цаазат газар нутаг Нүхтийн аманд орших аялал жуулчлалын зориулалттай талбайд археологийн авран хамгаалах малтлага судалгааны хүрээнд нийт 8 дурсгал малтан судалжээ. Үүнд, хөгжингүй хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр 2 (1,6-р дурсгал), хүрэл зэвсгийн үеийн булш 1 (3-р дурсгал), булш оршуулгын дурсгалд холбогдох тахил тайлгын байгууламж 4 (2, 4, 5, 7-р дурсгал), он цаг тодорхойгүй булш 1 (8-р дурсгал) тус тус багтаж байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Арга зүй, аргачлал

Археологийн хайгуулын арга зүй, аргачлал

Ямарваа нэгэн зүйлийг зохион байгуулалтайгаар эрэн хайж, олж тогтоох үйлдлийг хайгуул гэдэг билээ. “Хайгуул” гэдэг нь ихэвчлэн шинжлэх ухааны үг хэллэгд өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь геологи, палеонтологи, биологи, археологи зэрэг шинжлэх ухааны салбарт түгээмэл ойлголт билээ. Хайгуул нь археологийн судалгааны хамгийн эхний шатны бөгөөд хариуцлагатай ажил юм.

Ангилал. Археологийн хайгуул судалгаа нь эртний түүх соёлын дурсгалыг эрэн хайж, илрүүлэн олох, тодорхойлон, судлан, шинжлэх зорилготой өөрийн гэсэн арга зүйд тулгуурласан судалгааны ажлын нэгэн хэлбэр юм. Археологийн хайгуул судалгааны ажлыг дотор нь нэгдүгээрт, нарийвчлалтай хайгуул, хоёрдугаарт, энгийн, гуравдугаарт хялбаршуулсан гэж гурав хуваан авч үзэж болно.

Нарийвчлалтай хайгуул гэдэг нь хөндий, тэгш тал газар хайгуул судалгаа хийх арга зүй юм. Энэхүү арга зүйг уртраг, өргөргийн дагуу шугаман хайгуулыг гүйцэтгэхэд ашиглах бөгөөд овор хэмжээтэй дурсгалыг хайж олохоос гадна газрын хөрсөн дээр буй хүний нүдэнд тэр бүр ажиглагдахгүй чулуун зэвсэг, шавар савны хагархай, зарим жижиг эд өлгийн зүйлсийг илрүүлэн олоход чиглэгдэнэ [Lightfoot, Kent. 1986].

Ямарваа нэгэн зүйл олсон тохиолдолд түүний байршлын солбицлыг тогтоох, тухайн олсон зүйлийн талаар тодорхойлолт бичих, олдворыг баримтжуулах зэрэг ажлыг гүйцэтгэж дараагийн шатанд өргөтгөсөн малтлага хийх эсэх талаар зөвлөлдөнө.

Энэхүү хайгуулын арга зүйг уул уурхайн компанийн ашиглалтын талбай болон хайгуулын талбайд хэрэглэх хэрэгтэй юм. Учир нь ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын талбай нь хэмжээний хувьд том, жижиг янз бүр байх боловч тодорхой хүрээнд хязгаарлагдсан байдгаас гадна цаашид энэ газар нь эвдэгдэх, бүрэн устах магадлалтай учир илүү нарийвчлалтай хийх нь зүйтэй.

Энгийн хайгуул. Энэхүү хайгуулын арга зүйг тачир өвстэй уулын бэл, голын дагуух довцог, хуурай сайрд хайгуул хийхэд ашиглахад тохиромжтой. Хайгуулын энэхүү арга зүй нь ямар нэгэн бүс нутагт хайгуул болон дурсгалын талаар тодорхой хэмжээний туршлага мэдээлэл хуримтлуулсны үндсэн дээр хайгуулыг илүү хурдан, олон хүнийг хамарсан байдалтай хийхэд чиглэгдэнэ. Мөн газрын зургийн хүрэлцээ муу буюу тухайн бүсийн нарийвчлалтай газрын зураг байхгүй тохиолдолд агаарын зургийг ашиглан хайгуулыг хийхэд хэрэглэнэ. Учир нь агаарын зураг тодорхой өндрөөс авсан гэх боловч зарим тохиолдолд зургийн алдаа, чанар зэргээс хамаарч газар орчин сайн харагдахгүй, шугамын талаар нарийн мэдээлэл байхгүй зэрэг дутагдалтай байдаг.

Хайгуулын ажлын хамгийн эхэнд агаарын зургийн тусламжтайгаар сонгосон талбайн дөрвөн захын цэгийг GPS багажаар тодорхойлно. Дараа нь хүн тус бүрийн хоорондын зайг хэлэлцэн тогтоно. Талбайн аль нэгэн захаас тогтсон

зайгаар явж нөгөө зах хүрэх зэргээр нааш цааш уртраг, өргөргийн дагуу хайгуулыг хийж гүйцэтгэнэ. Ингэснээр нэг шугамд эгнэн хайгуул гүйцэтгэж байсан хайгуулын хэсэг нь хэд хэдэн хэсэг болон задарч хайгуулын талбайд өөрсдийн сонголтоор хийж гүйцэтгэх боломжтой болно. Хайгуулын хэсэг болгон өөрсдийн хайгуулын мэдээллийн дэвтэр, дурсгалын ерөнхий дэвсгэр зураг үйлдэх дэвтэр, фото аппарат, GPS зэрэг багаж хэрэгслийг хэрэглэнэ.

Хялбаршуулсан хайгуул. Энэ хайгуулын арга зүйг сонгож авсан хайгуул хийх талбай болон түүнээс гадагш харьцангуй хол талбайд хайгуул хийхэд хэрэглэнэ. Гол болон уулсын хоорондох битүү мод бүхий хайгуулын талбайд тухайн хайгуулын хэсэг ямар нэгэн зайд баригдахгүй, хүн явах боломжтой газраар явж шалгаж үзнэ. Ийм уулын бүсэд археологийн дурсгал ховор байдаг боловч хайгуулын гол зорилго бол сонгосон талбайдаа ямар нэгэн газрыг үлдээлгүй, олон янзын арга зүйгээр хайгуулд хамруулах явдал билээ. Мөн өөр нэгэн зүйл бол сонгосон хайгуулын талбайгаас гадагш ойролцоо зарим газрыг үзэж танилцах, өөрсдийн талбайтай харьцуулах зайлшгүй шаардлага урган гарна. Талбай илүү том, зам урт учир үүнийг автомашинаар хийж гүйцэтгэж болдог. Автомашин явах боломжтой ам, хөндийгөөр орж дурсгалтай танилцах, тэдгээрийн баримтжуулалтыг хийнэ.

Хайгуулд хэрэглэгдэх багаж, хэрэгсэл. Археологийн хайгуулыг хийж гүйцэтгэхэд олон тооны багаж, компьютерын хэрэгслийг өргөн ашигладаг билээ. Үүнд, газрын байршлыг тодорхойлох GPS багаж, GPS багажаар хэмжсэн хэмжилтийг компьютерт оруулан газрын зурагт тэмдэглэх GIS буюу Archview программууд багтана.

Дурсгалын баримтжуулалт. Дурсгалын баримтжуулалт нь мэдээллийн сан бүрдүүлэх, цаашдын судалгааг тодорхойлох, дүн шинжилгээ өгөх, хадгалах, хамгаалах талаарх зөвлөмж гаргахад хамгийн чухал шаардлагатай ажил юм.

Хайгуулын явцад ямар нэгэн дурсгал илрүүлэн олсон тохиолдолд доорх баримтжуулалтыг гүйцэтгэсэн болно. Үүнд,

1. Шугаман хайгуул гүйцэтгэж буй хайгуулын багийн гишүүн дурсгал олсон тохиолдолд бусад оролцогчдыг дуудан хамтран тухайн дурсгалыг бүртгэх ажлыг гүйцэтгэнэ.
2. Дурсгалын дугаарлалт
   - Дурсгалыг дугаарлахдаа хайгуул гүйцэтгэж байгаа талбай болон газрын нэрийг бүтнээр нь буюу товчилсон үгээр илэрхийлээд (Жишээлбэл, Оюу толгой-01, ОТ-01 гэх мэт) ард нь нэгээс эхлэн дугаарлана. Гэхдээ энэ нэр нь цаашид мэдээллийн санд өгөгдөл болон орох тул өмнөх хайгуулын нэр болон цаашид хийх хайгуулын нэрийг бодолцох нь зүйтэй.
3. Тодорхойлолт бичих
   - Тодорхойлолтыг тусгайлан бэлдсэн дэвтэрт дэс дугаарын дагуу бичнэ. Дэвтрийн эхний нүүрэнд тухайн тодорхойлолт бичих хүнд зориулан чухам ямар мэдээлэл оруулахыг санууулсан товч асуултууд бэлдэнэ.

- Газрын ерөнхий байдлыг тодорхойлно. Дурсгалтай ойрхон байгаа уул, гол, нуур зэрэг газруудын нэрийг тодорхойлно. Дурсгалын гадаад байдал, дурсгалын эвдрэл гэмтэл тодорхойлох
- Дурсгалын хэмжээг авна. Үүнд анхаарах нэг зүйл байдаг. Энэ бол ямар ч дурсгалыг хойноос урагш, зүүнээс баруун тийш буюу уртраг, өргөргийн дагуу хэмжинэ. Нэгдсэн нэг аргачлалтай хэмжилт нь хайгуулын мэдээнд тулгуурласан харьцуулсан судалгаа хийхэд тус болдог.
- Солбицлыг тодорхойлох. Энэ нь мэдээллийн сангийн нэгэн чухал хэсэг бөгөөд солбицлыг UTM эсвэл Lat/Lon hddd.ddddd° форматаар сануулж WGS84 гэсэн солбицлын тохиргоог анхаарах нь зүйтэй.

4. Гэрэл зураг авах. Энэ ажил нь дурсгалын талаарх мэдээллийг бүхэлд хамруулан гэрэл зурагт буулгаад цаашид мэдээллийн сангийн чухал нэгэн эх сурвалж болно.
   - Дурсгалын дугаар, хайгуулын талбайн дугаар, он сар өдрийг бичсэн самбарыг бэлдэнэ.
   - Самбарыг дурсгалын гадаад зохион байгуулалтыг халхлахгүйгээр тохиромжтой газар тавиад гэрэл зураг авна. Самбар дээр бичсэн зүйлс нь дурсгалыг мэдээллийн санд оруулахад чухал зүйл учир харагдахуйц бичих хэрэгтэй.
   - Самбарын урд талд хойд зүгийг заасан тэмдэглэгээ тавих. Энэ нь хожим тухайн дурсгалын гадаад зохион байгуулалт, хэлбэрийн ангилал, газар нутгийн тодорхойлолт хийхэд тус болдог.
   - Хэмжээс тавих. Хэмжээсийг харагдахуйц газар уртраг, өргөргийн дагуу хандуулан тавина. Том дурсгалд 100-200 см, жижиг дурсгалд 20-50 см хэмжээтэй хэмжээсийг тавивал илүү тохиромжтой. Энэ нь тухайн дурсгалын талаар хожим хэмжээний талаар мэдээлэл авахад хэрэг болох болно.
   - Гэрэл зураг авахдаа дурсгалыг гол цэгээ болгох нь дамжиггүй боловч цаад талд харагдаж байгаа уул, гол, жалга зэрэг зүйлсийг ямар нэгэн хэмжээгээр оруулан авах хэрэгтэй.
   - Олдвор түүвэрлэх. Энэ нь чулуун зэвсэг, ваарын хагархай, төмөр зэсийн баас гэх мэт жижиг хэмжээтэй олдворыг түүвэрлэх ажил юм. Тухайн газарт хамгийн эхэнд хийх ажил бол олдворын тархалтыг тодорхойлох юм. Үүнийг гүйцэтгэхдээ олдворын дэргэд тод өнгийн зориулалтын туг, дарцаг хатгана. Ингэснээр тархалтыг нүдээр харах боломжтой болох юм. Уртраг, өргөргийн дагуу тархалтыг хэмжин тодорхойлолтод тусгана. Тархалтыг тодорхойлсны дараа хамгийн нягтрал ихтэй газрыг сонгон 1 м.кв талбайд хэчнээн олдвор ноогдож байгааг тэмдэглэнэ. Олдвор бүхий дурсгалт газраас дээж болгон заримыг түүвэрлэн авч болох боломжтой боловч цаашид сорилтын малтлага болон дараа дараагийн судалгаанд зориулан тухайн газарт нь олдворуудыг үлдээх нь зүйтэй.

Хэрэв олдвор түүвэрлэх зайлшгүй шаардлагатай бол зориулалтын уутанд хамт дурсгалын дугаар, хайгуулын талбайн дугаар, солбицол зэрэг мэдээллийг бичиж хийнэ.

5. Дэвсгэр зураг үйлдэх. Энэ баримтжуулалтын ажил нь гэрэл зураг дээр гарах боломжгүй илүү мэдээллээр хангах зорилготой хийдэг.
   - Дэвсгэр зургийг тойм байдлаар зурна. Учир нь тухайн дурсгал нь хөрсөнд Илрэл-1даж анхны төрхийг тодруулах боломжгүй, хайгуул нь цааш үргэлжлэх хугацааг хэмнэхээр тооцоолж буй хэрэг юм.
   - Хайгуулын багийнханд тодорхойлолт бичих дэвтэр, дэвсгэр зураг зурах гэсэн хоёр дэвтэр байна.
   - Дэвсгэр зургийг үйлдэхдээ масштабыг дэвтэртээ тааруулахаас гадна, хожим ойлгомжтой байх зорилтыг анхаарах хэрэгтэй.
   - Дурсгалын хойд урд тэнхлэгийн дагуу метр тавьж зурна. Том хэмжээтэй дурсгал дээр тойм төдий зургийг зурж болно.
   - Тэнхлэгийн дагуу масштабаар жижгэрүүлэн дурсгалын ерөнхий хэлбэрийг зөв гаргана.
   - Мөн зарим тохиолдолд олон дурсгалтай газарт уул, жалга, гол зэрэг онцгой газруудыг тэмдэглэн нүдэн баримжаагаар дурсгалуудын байршлыг зурж болно.
6. Хөрсний шалгалт. Энэ арга зүйг өндөр өвсөөр хучигдсан газарт ашиглана. Тухайн газарт олдвор хүний нүдэнд тодорхой сайн харагдахгүй, хөрсөн доор байх магадлалтай хэмээн үзэж хайгуулд оролцогчид тодорхой зайд, тодорхой хэмжээний газрыг сонгон хүрзээр малтах ажил юм.
   - Хайгуул оролцогчид уртраг, өргөргийн дагуу самнах шугаман хайгуулыг хийхдээ хүрз болон шигшүүртэй гүйцэтгэнэ.
   - Хайгуулд дунджаар 6 хүн оролцож байгаа тохиолдолд 3 хүн хүрз, 3 хүн шигшүүртэй солбин явах бөгөөд шигшүүртэй оролцогч зүүн талд, хүрзтэй оролцогч баруун талд нь гэх мэтээр зохион байгуулж болно.

Шугаман хайгуулын 100м тутамд (үүнийг хайгуулыг ахалж байгаа оролцогч GPS багажийн зай хэмжүүрийн тусламжтайгаар тодорхойлж, бусад оролцогчдод хөрсний шалгалт хийхийг сануулна) нийт хайгуулд оролцогчид зэрэг буюу хүрз авч яваа хүн дунджаар 50х50 см хэмжээтэй, 20-30 см гүнтэй нүхийг малтана. Үүнд зүүн талд яваа шигшүүртэй оролцогч ирж хөрсийг бүрэн шигшиж, ямар нэгэн олдвор байгаа эсэхийг шалгана. Хэрэв шигшүүрээс 5 болон түүнээс дээш олдвор гарсан тохиолдолд дурсгал хэмээн үзэж баримтжуулалт хийнэ. Харин 5-аас доош олдвор гарсан тохиолдолд хайгуулын мэдээнд оруулаад хайгуул цааш үргэлжилнэ.

Хээрийн судалгааны зорилго ба ажлын төлөвлөгөө

“Си эс си и си айком консалтантс” ХХК нь Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу Улаанбаатар хотын нутаг дэвсгэр “Шинэ тойрог авто зам” төслийн хүрээнд авто замын трассын дагуу археологийн хайгуул судалгааны ажил хийлгэх хүсэлт гаргасан юм. Уг хүсэлтийн дагуу археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 14-өөс 17-ны өдрүүдэд тус хүрээлэнгийн Сан хөмрөг, лабораторийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Ц.Амгалантөгс, магистр Н.Нандинцэцэг, Дундад зууны салбарын эрдэм шинжилгээний ажилтан Л.Мөнхбаяр, жолооч Г.Төмөр нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэв.

Энэхүү хайгуул судалгааны ажлын гол зорилго нь захиалагч талаас өгсөн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд /замын трасс шугамын дагуу/ болон түүний ойролцоох зайд түүх соёлын ямар нэг дурсгал бий эсэхийг шалган тогтоох, дурсгал илэрсэн тохиолдолд байршлын цэгийг тогтоож, эрдэм шинжилгээний товч тодорхойлолт хийж тайланд хавсаргах юм.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх “Шинэ тойрог авто зам” төслийн хүрээнд шинээр барих замын трассын дагуу талбайд археологийн энгийн хайгуулын арга зүйг ашиглан хийж гүйцэтгэсэн болно.

Хийгдэх ажлууд	**Гэрээ зурагдсанаас хойших хоног**
Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	2025 оны 05-р сарын 13-ны өдөр
“Шинэ тойрог авто зам” төслийн замын трассад хайгуул судалгаа хийх	2025 оны 05-р сарын 14-ны өдөр
“Шинэ тойрог авто зам” төслийн авто замын трассын дагуу хайгуул судалгаа хийх	2025 оны 05-р сарын 15-ны өдөр
“Шинэ тойрог авто зам” төслийн авто замын трассын дагуу хайгуул судалгаа хийх	2025 оны 05-р сарын 16-ны өдөр
Хайгуулын ажлын тайлан бичих, редакцын зөвлөл хянах	2025 оны 05-р сарын 17-ны өдөр
Зохиогчдын гар бичмэлийн эрхтэй судалгааны тайлан, дүгнэлтийг захиалагчид хүлээлгэн өгөх	2025 оны 05-р сарын 19-ний өдөр

3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль хүрээнд “Си эс си и си айком консалтантс” ХХК нь Улаанбаатар хотын “Шинэ тойрог авто зам” төслийн хүрээнд авто замын трассын дагуу археологийн хайгуул судалгааны ажил хийлгэх хүсэлт гаргасан юм. Иймд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хайгуул судалгааны баг тус компанийн дээрх талбайд археологийн дурсгал бий эсэхийг шалгах хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэв.

Хээрийн судалгаа нь доорх хууль журмын заалтыг даган мөрдөх, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэв. Үүнд, “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан байдаг. Мөн түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилготой Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль бий. Энэхүү хуулийн 5 дугаар бүлгийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулна”, 27.9-д “Урьдчилан хайгуул хийлгэх, илэрсэн түүх соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна” хэмээн тус тус заасан байдаг.

Археологийн хайгуул судалгаа нь эртний түүх соёлын дурсгалыг эрэн хайж, илрүүлэн олох, тодорхойлон, судлан, шинжлэх зорилготой өөрийн гэсэн арга зүйд тулгуурласан судалгааны ажлын нэгэн хэлбэр юм. Археологийн хайгуул судалгааны ажлыг дотор нь нэгдүгээрт, нарийвчлалтай хайгуул, хоёрдугаарт, энгийн, гуравдугаарт хялбаршуулсан гэж гурав хуваан авч үзэж болно.

Улаанбаатар хотын Баянзүрх, Сүхбаатар, Сонгино хайрхан Хан-Уул, дүүргүүдийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх “Шинэ тойрог авто зам” -ын трасс нь байшин барилга, гэр хорооллын суурьшлын бүсэд он удаан жил орж байсан ба өнгөн хөрс нь ихэд талхлагдсан тул ил харагдах археологийн дурсгалууд байх боломжгүй болсон байна. Археологийн хайгуул судалгааг энгийн арга зүйг ашиглан хийж гүйцэтгэсэн. Гэрэл зургийг тухайн замын нөхцөл байдалд үндэслэн ерөнхий байдлаар авч дүгнэлтэд хавсаргав. Тус талбайд археологийн хайгуул хийж гүйцэтгэхэд тус талбайгаас ямар нэгэн археологийн дурсгал илрээгүй болно.

Хэдийгээр хайгуул судалгааны ажлын явцад археологийн дурсгал илрээгүй, газрын гадарга дээр мэдэгдэх шинж тэмдэггүй ч газрын гүнд хадгалагдан үлдсэн түүх, соёлын дурсгал байхыг үгүйсгэхгүй тул ямарваа нэг үйл ажиллагаа явуулахдаа анхаарал, болгоомжтой ажиллаж, түүх, соёлын дурсгал эсвэл олдвор илэрсэн тохиолдолд нэн даруй мэргэжлийн байгууллагад мэдэгдэхийг зөвлөж байна.

НОМ ЗҮЙ

Амартүвшин Ч., Ерөөл-Эрдэнэ Ч., Батболд Н., Жаргалан Б. Сэлбэ голын хөндийд хийсэн археологийн бэсрэг хайгуул судалгааны тайлан. УБ., 2009. ШУА. АХГБСХ

Амартүвшин Ч., Батдалай Б., Бөхчулуун Д. 2012 онд явуулсан археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны товч үр дүн // Монголын археологи-2012. УБ., 2013. Т.105; Батдалай Б., Бөхчулуун Д. Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг: “Эрдэс Плазм” ХХК-ны 14755Х дугаартай “Мааньт” тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайлан. УБ., 2012; Батдалай Б. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг: “Топмаунтайн” ХХК-ны “Намуун” хайгуулын талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан. УБ., 2012

Амартүвшин Ч., Батдалай Б., Бөхчулуун Д. 2013 онд явуулсан археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны товч үр дүн // Монголын археологи-2013. УБ., 2014. т.133-134

Амартүвшин Ч., Батдалай Б., Бөхчулуун Д. 2014 онд явуулсан археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны товч үр дүн // Монголын археологи-2014. УБ., 2015. т.179; Энхтөр А.нар.., “HNC” ХХК-ийн Налайх-Агуйтын хөтөл чиглэлийн 11 км хатуу хучилттай авто замын дагуух малтлага судалгаа (Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан). УБ., 2014

Амгалантөгс Ц., Амарболд Э., Түвшин Э. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Улиастайн Бага аманд орших Бурхант хошуунд иргэн Цогтсайханы талбайд хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайлан. УБ., 2017

Анхсанаа Г. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого-2015 // Соёлын өвийн мэдээ, мэдээлэл. 2014-2019/1 №1. УБ., 2019

Баярсайхан Ж., Баяндэлгэр Ч., Эрдэнэбаяр Б., Буян-Орших Б. “Ван ханы орд” хэмээх эртний хэрэмт хотын балгас, Сонгинохайрхан уулын урд аманд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. УБ., 2020

Ванчигдаш Ч., Төгссайхан Р., Анхсанаа Г. Бишрэлтийн амны хүннү булшны малтлага судалгаа // Археологийн судалгаа I. Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн сургууль. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль. (2010-2014 оны Эрдэм шинжилгээний тайлан, хэлэлцүүлгийн эмхэтгэл). УБ., 2014. т.119-133.

Даваацэрэн Б. Нийслэлийн түүхэнд холбогдох хүн чулуун хөшөөний тухай // Нүүдэлчдийн өв судлал Tom XVI, Fasc 11. 2015 т.106-109

Идэрхангай Т., Мижиддорж Э. Улаанбаатарын Их сургуулийн Нийгмийн ухааны факультетын Археологийн 2-р ангийн оюутнуудын Археологийн судалгааны арга зүй хичээлийн бататгах дадлагын тайлан. УБ., 2008

Ковалев А.А., Рукавишникова И.В., Эрдэнэбаатар Д. Оленные камни-это памятники-кенотафы (по материалам новейших исследований в Монголии и Туве) // Древние и средневековые извияния Центральной Азии. Барнаул. 2014. С. 41-54. рис.1

Мөнхсайхан Н. Баянзүрх хайрханы Их өвөлжөөтийн аманд малтсан зарим булшны тухай // Эртний түүх, соёлын дурсгалуудыг хамгаалах асуудалд (Туулын сав, Баянзүрх хайрханы орчмын судалгаа) Түүхийн дурсгалуудын цуврал III дэвтэр. УБ., 2009. т.60-64.

Мижиддорж Э., Цэнд Д. Улаанбаатарын их сургуулийн археологийн тэнхимийн авран хамгаалах хайгуул судалгаа // Монголын археологи-2016. УБ., 2017. т.339

Наваан Д. Дундад зууны үеийн Монголчуудын оршуулах зан үйлийг судлах асуудалд. // Археологийн судлал. Том XI, Fasc.1. УБ., 1986. т.7-8;

Наваан Д., Ойдов Ц. Эртний монголчуудын бүс эрхэмлэх ёс //Доржпаламын Наваан. Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, дурсамж. Бүтээл туурвилын эмхэтгэл II боть. Эрхлэн хэвлүүлсэн Д.Заяабаатар. Эмхэтгэж хэвлэлд бэлтгэсэн У.Эрдэнэбат, Ч.Амарбилэг, Д.Содномжамц. УБ., 2018. т.44-45

Наваан Д., Эрдэнэ Б. 2008 оны Археологи-антропологийн II ангийн оюутны хээрийн дадлагын тайлан. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Антропологи-археологийн тэнхимийн номын сан. УБ., 2008

Одбаатар Ц., Баярсайхан Ж., Аюуш Ц. Нарийны аманд ажилласан археологийн хайгуул, судалгааны ангийн ажлын тайлан. УБ., 2007

Очир Б., Мижиддорж Э., Эрдэнэ Ж., Анхсанаа Г. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 13 хорооны нутагт хийсэн археологийн хайгуулын тайлан (Туул голын ай сав дахь археологийн дурсгал). УБ., 2020

Өлзийбаяр С., Очир Б. “Хасгуа” ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг 14710Х тоот хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 26,479 га талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгаа явуулсан тайлан. УБ., 2012

49 Мижиддорж Э., Цэнд Д. Улаанбаатарын их сургуулийн археологийн тэнхимийн авран хамгаалах хайгуул судалгаа // Монголын археологи-2016. УБ., 2017. т.339

Пэрлээ, Монгол ард улсын эрт, дунд үеийн хот суурины товчоон. УБ., 1961: 97-98, 144

Саруул Н., Мөнхзул Ж., Цэрэнбямба Х., Хандмаа Ц., Гоомарал Д. Г.Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 2012. т.9, 19-20

Сэр-Оджав Н. Монгол-Унгарын хамтарсан эртний судлалын шинжилгээний ажлын тухай // Археологийн судлал. Том II, Fasc.3. УБ., 1963. т.31-38

Цогтбаатар Б., Амартүвшин Ч., Батболд Н., Ерөөл-Эрдэн Ч., Эрдэнэ-Очир Н., Батдалай Б., Галдан Г., Пүрэвжал Х., Одсүрэн Д., Ишцэрэн Л. Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдлын эрсдэлийн үнэлгээ” төслийн тайлан. УБ., 2014; Цогтбаатар Б. Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалд ашиглах боломж (археологийн дурсгалын жишээгээр). “Хот байгуулалтын түүхэн үйл явц: өнгөрсөн, одоо, ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2020. т.155-166

Цэвээндорж Д., Васильевский Р.С. 1982 оны МЗТСХЭ-ийн палеолитын дурсгал судлах ангийн тайлан. УБ., 1983 // Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан (1981-1983) IV. УБ., т.2016. 242-243, 246-247

Цэрэндагва Я. Улаанбаатар хот орчмын археологийн дурсгал. ШУА-ийн “Эрдэм” сонин. 2013. оны арван хоёрдугаар сар №12 (178), 2014 оны хоёрдугаар сар. №01, 02 (179, 180), 2014 оны дөрөвдүгээр сар. №03, 04 (181, 182)Улаанбаатар хотын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын товч танилцуулга (Улаанбаатар хотын музейгээс Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Өнгөрснийг ирээдүйтэй уулзуулах нь” төслийн хүрээнд хэвлэв). Эрхэлсэн Гэрлийн Очбаяр. УБ., 2018

Төв аймгийн Алтанбулаг сум Морин толгойн археологийн дурсгал // Монгол-Солонгосын хамтарсан судалгааны тайлан II. 2000. т.268.

Цэрэнбямба Х. Нэгэн чулуун хөргийн тухай өгүүлэх нь // Нүүдэлчдийн өв судлал Том. XV, Fasc 10. УБ., 2013. т.84-96

Эрдэнэбаатар Д., Ковалев А.А. Монгол Алтайн бүс нутгийн археологийн соёлууд // Mongolian Journal of Anthropology Archaeology and Ethnology. Official Journal of the National University of Mongolia. Volume 3 №.1 (287) December 2007

Эрдэнэбаатар Д., Ковалев А.А. Чемурчекийн соёл” түүний тархалтын тухай зарим баримт // Нүүдэлчдийн өв судлал Том. XI, Fasc 5. УБ., 2011. т. 70-84.

Эрдэнэбат У., Содномжамц Д. Тулгын Өндөр” ХХК-ийн захиалгаар Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 4-р хорооны нутаг Богдхаан уулын ДЦГ-ийн Арцатын аманд орших 0160760 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд явуулсан археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын тайлан, дүгнэлт. УБ., 2017

Эрдэнэбат У. “Бдалт” ХХК-ий захиалгаар Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 13-р хорооны нутаг “Үнсгэний хөндий” хэмээх газар орших ашигт малтмалын 15121Х тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын тайлан, дүгнэлт. УБ., 2014;

Эрдэнэбат У. Дундад зууны Монгол оронд .... 2009. т.43. 22 Монгол-БНХАУ-ын хамтарсан “Монгол улсын нутаг дахь эртний нүүдэлчдийн соёл иргэншлийн хайгуул, малтлага судалгаа” төслийн тайлан I. Монгол Улсын нутаг дахь археологийн хайгуул судалгаа (2005-2006 он). БНХАУ-ын Соёлын өв хэвлэлийн хороо. 2008

Эрдэнэболд Л. Кей Жи си ЮУ Юу ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт орших 13438Х тоот тусгай зөвшөөрөлтэй талбай дахь археологийн хайгуул судалгааны товч тайлан. УБ., 2012;

Эрдэнэболд Л., Бямба-Очир Ц., Ванчигдаш Ч., Очирпүрэв Д. Өнөрбулган хэрлэн ХХК-ийн Улаанбаатар хотын, Баянзүрх дүүргийн нутагт орших 16/R065 тоот тусгай зөвшөөрөлтэй Майхан уулын өвөр хэмээх түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд археологийн урьдчилсан хайгуул судалгаа явуулсан дэлгэрэнгүй тайлан. УБ., 2016;

Эрдэнэболд Л. Лаймстоун ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших 16/К076 тоот тусгай зөвшөөрөлтэй “Баян” хэмээх түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайд археологийн урьдчилсан хайгуул судалгаа явуулсан дэлгэрэнгүй тайлан. УБ., 2017;

Эрдэнэболд Л. Монгол мөнгө ХХК-н Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших 16/Р073 тоот тусгай зөвшөөрөлтэй “Зуун мод” хэмээх түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайд археологийн урьдчилсан хайгуул судалгаа явуулсан дэлгэрэнгүй тайлан. УБ., 2017

Энхтөр А., Нацагням Ч., Хүрэлсүх С., Батболд Г., Далантай С., Буянхишиг Ц. Эх дагина Дондогдулам хатны дурсгалт газар. УБ., 2020

Түмэн Д., Болормаа С., Ванчигдаш Ч. Грийнтренд ХХК-ийн захиалгаар Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумд, Улаанбаатар хотын Налайх, Хан-уул дүүргүүдийн нутгаар дайруулан тавихаар төлөвлөсөн хийн хоолойн шугамын дагуу антропологи, археологийн урьдчилсан хайгуул судалгаа явуулсан дэлгэрэнгүй тайлан. УБ., 2017

Түмэн Д., Болормаа С., Ванчигдаш Ч. Грийнтренд ХХК-ийн захиалгаар Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумд, Улаанбаатар хотын Налайх, Хан-уул дүүргүүдийн нутгаар дайруулан тавихаар төлөвлөсөн хийн хоолойн шугамын дагуу антропологи, археологийн урьдчилсан хайгуул судалгаа явуулсан дэлгэрэнгүй тайлан. УБ., 2017

Shiraishi, 1997: 3-4 20 Наваан Д. Хэрэйдийн Тоорил ван хааны ордыг судалж эхэллээ (Чингэсийн III орд) // Чингис хаан судлал. Боть 9, Дэвтэр 20, УБ., 2006. т.73-74

ХАВСРАЛТ ЗУРАГ



Зураг 1. “Шинэ тойрог авто зам”

Замын трассын эхлэл цэг, “Шинэ тойрог авто зам”

Замын трассын дунд хэсэг “Шинэ тойрог авто зам”

Замын трассын төгсгөл хэсэг “Шинэ тойрог авто зам”

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Архивд
археологийн авран хамгаалах хээрийн шинжилгээний ангийн
тайлан хүлээлгэн өгсөн баримт

Доктор (Ph.D) Ц.Амгалантөгс, магистр Л.Мөнхбаяр, Н.Нандинцэцэг нарын 2025 оны 05-р сарын 14-өөс 05-р сарын 17-ыг дуустал Улаанбаатар хотын нутаг дахь “Си Эс Си И Си Айком Консалтантс” ХХК-Ийн “Шинэ тойрог авто зам” төслийн замын трассын дагуу археологийн хайгуул судалгааны ажил гүйцэтгэсэн тухай авран хамгаалах хээрийн шинжилгээний ангийн тайлан. УБ., 2025. 27 тал.

Хүлээлгэн өгсөн: Доктор (Ph.D) Ц.Амгалантөгс

Хүлээн авсан: Референт О.Даш

2025-05-19